

БИБЛИЙН ХӨРВҮҮЛГИЙН ЗАРЧМУУД

Shepherds Global Classroom нь дэлхий даяар өсөн нэмэгдэж буй христитгэлт удирдагчдад зориулсан сургалтын хөтөлбөрөөр дамжуулан Христийн Биенийг сургаж бэлтгэх зорилготой үйлчлэл юм. Бид дэлхийн улс орон бүрийн сүнслэг сургагч багш нарын гар дээр 20 курс хөтөлбөрийг хүргэх замаар тухайн орон нутаг, уугуул иргэдийн сургалтын хөтөлбөрийг олшруулж нэмэгдүүлэхийг зорьж байна.

Энэхүү хичээлийг дараах холбоосоор үнэгүй татаж авах боломжтой: <https://www.shepherdsglobal.org/courses>

Курс хичээлийг боловсруулсан: Др. Рэндэлл Д. МкЕлвэйн

Зохиогчийн эрх © 2024 Shepherds Global Classroom

Англи хэл дээрх Гурав дахь хувилбараас Монгол хэлнээ орчуулсан Л. Амартүвшин, А. Хүслэн

Бүх эрх хуулиар хамгаалагдсан.

Гуравдагч талын материалууд нь тус тусын зохиогчийн эрх болон зөвшөөрөлтэй.

Бүх эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи 2019 хувилбараас ашиглав.

Зөвшөөрөлтэй холбоотой заавар:

Дараах зааврын дагуу энэхүү курс хичээлийг хэвлэмэл болон цахим хэлбэрээр үнэ төлбөргүйгээр хэвлэж, тараах боломжтой. Үүнд: (1) Хичээлийн агуулгыг ямар ч байдлаар өөрчилж болохгүй; (2) Олшруулж хэвлэхдээ ашгийн төлөө зарж болохгүй; (3) Боловсролын байгууллагууд сургалтын төлбөр авч болох ч энэхүү хичээлийг үнэгүй ашиглах/олшруулж хэвлэх боломжтой; (4) Shepherds Global Classroom байгууллагын зөвшөөрөл, удирдамжгүйгээр хичээлийг орчуулж болохгүй.

Гарчиг

Курсын тойм.....	5
(1) Библийн хөрвүүлгийг танилцуулах нь.....	7
(2) Ажиглалт: Эшлэлийг харах	17
(3) Ажиглалт: Томоохон хэсгүүдийг харах нь.....	33
(4) Хөрвүүлэг: Танилцуулга	51
(5) Хөрвүүлэг: Хам сэдэв	59
(6) Хөрвүүлэг: Утга зохиолын хэлбэрүүд.....	69
(7) Хөрвүүлэг: Үгийн судлал	97
(8) Хөрвүүлэг: Ерөнхий зарчмууд	107
(9) Хэрэгжүүлэлт.....	117
(10) Бичвэрийн хэсгийг судлах дасгал ажил.....	127
Библи судлалын багаж хэрэгсэл.....	139
Санал болгох эх сурвалжууд.....	143
Даалгаврын тэмдэглэл.....	145

Курсын тойм

Энэ курс нь Библийн хөрвүүлгийн үндсэн зарчмуудыг танилцуулдаг. Тус курсын ихэнх хичээлүүд нь Howard ба William Hendricks-ийн *Living by the Book* хэмээх алдартай сурах бичигт үндэслэгдэж бичигдсэн. Хэрэв та энэ номыг унших боломжтой бол тухайн хичээл дээр заасан зарчмуудыг хэрэгжүүлэх дасгал ажлуудыг болон зарчим бүр дээрх хэлэлцүүлгийг олж харах болно. Гэхдээ энэ курсэд сурах бичиг шаардлагагүй. Шаардлагатай бүх материалыг эдгээр хичээлүүдэд багтаасан.

Суралцагчид ангид ирэхээс өмнө хичээл бүрийг уншсан байх ёстой. Хичээл бүрд 90-120 минут зарцуулах, дээр нь нэмээд хичээлээс гадуур хийх даалгавруудыг төлөвлөх хэрэгтэй. Энэ курс нь үндсэндээ практик үйл ажиллагаанд суурилсан учраас хичээлийг нэгээс олон уулзалтад хуваах боломжтой. Энэ нь суралцагчдад дасгал ажил хийх нэмэлт цаг хугацаа байх болно.

Ихэнх хичээлүүдэд тухайн хичээл дээр заасан зарчмуудыг хэрэгжүүлэх хэд хэдэн **үйл ажиллагаа** багтсан байгаа. Суралцагчдын хувьд эдгээр үйл ажиллагааг анхааралтай хийхэд хангалттай цаг гаргах нь чухал юм. Эдгээр дасгал ажлуудыг Бичвэрийн өөр өөр олон эшлэл дээр явуулна. Хичээлээ дуусгах гэж битгий яараарай. Эдгээр үйл ажиллагааны ихэнх нь суралцагчдын хувьд шинэ зүйл учраас ангид цаг гарган, суралцагч бүр дасгал ажлуудаа хэрхэн гүйцэтгэхийг ойлгосон эсэхэд анхаарал хандуулаарай. Гол зорилго нь тодорхой хариулт олж авах биш юм. Харин Библийг судалж, хөрвүүлэх чадвараа хөгжүүлэх нь үндсэн зорилго юм.

Курсын төгсгөлд суралцагч Бичвэрийн хэд хэдэн багц хэсгийг анхааралтай судалсан байх болно. Суралцагч бүр хичээлийн тэмдэглэлээ цаашид ашиглахын тулд компьютерт болон дэвтэртэй сайн хадгалах хэрэгтэй. Энэ курсээр хийсэн ажил нь номлол болон Библийн хичээл бэлтгэхэд тустай.

Хэлэлцүүлгийн асуултууд болон **ангийн үйл ажиллагааг** ► тэмдгээр тэмдэглэсэн. Хэлэлцүүлгийн асуултуудын дагуу суралцагчдад хариултаа ярилцах боломж олгоорой. Суралцагч болгоныг хэлэлцүүлэгт оролцуулахыг хичээгээрэй. Шаардлагатай бол та суралцагчийг нэрээр нь дуудаж яриулж болно.

Суралцагч бүр курсын туршид нэг **курсын төсөл** дээр ажиллана. 10-р хичээлийн дараа тэд ангид танилцуулга хийх эсвэл ангийн удирдагчид бичгийн ажлыг хүлээлгэж өгнө. Танилцуулга болон бичгийн ажлын талаарх зааврыг 10-р хичээлийн даалгаврууд хэсэгт өгсөн байгаа.

2 болон 7-р хичээлийн төгсгөлд **бусад даалгавруудыг** багтаасан. Суралцагчид хийж гүйцэтгэсэн ажлаа ангийн удирдагчид үзүүлэх шаардлагатай бөгөөд харин ажлынхаа хуулбарыг өөртөө хадгалж авч үлдэнэ.

1-р хичээл

Библийн хөрвүүлгийг танилцуулах нь

Хичээлийн зорилго

- (1) Христэд итгэгчийн хувьд Библийг гүнзгий судлах нь яагаад чухал болохыг мэдэх.
- (2) Библийг судлахад шаардлагатай гурван алхмыг нэрлэж чаддаг болно.
- (3) Бичвэрийн багц хэсгийг анхааралтай судлах үйл явцыг эхлүүлнэ.
- (4) Библийг хөрвүүлэхэд Ариун Сүнсний гэрэлтүүлэг чухал болохыг үнэлж сурна.

Танилцуулга

Энэхүү курсын нэг зорилго нь Бичвэрийн хэрэгжүүлэлт болон бие даан судлах тал дээр өсөхөд тань туслах юм. Үүний эхний сайн алхам нь одоо Библи уншиж байгаа дадал хэвшлээ шударгаар үнэлэх билээ.

► Одоо байгаа Библи унших дадал хэвшлийнхээ талаар хэдэн минут ярилцаарай. Энэ нь бие биенээ шүүмжлэх цаг биш, харин “Би Бурханы Үгийг хэрхэн уншиж байна вэ?” гэсэн асуултын талаар эргэцүүлэн бодох цаг юм. Энд таны бодлыг хөглөх хэдэн асуулт байна. Үүнд:

- Би Библийг хэр тогтмол уншдаг вэ?
- Би Библийг уншихдаа хэр их цаг зарцуулдаг вэ?
- Би унших багц эшлэлүүдээ хэрхэн сонгодог вэ?
- Би юу уншиж байгаагаа ойлгож байна уу?
- Би уншсан зүйлээ санадаг уу?
- Би амьдралдаа хэрэгжүүлэлт болгож чадаж байна уу?
- Библийг илүү уншихад саад болж буй 2-3 шалтгаан юу вэ?

Тайвань улсын иргэн, итгэгч Самуел нь Христэд итгэгч болоод 15 жил өнгөрсөн ч, сүнслэг төлөвшилтийн шинж тэмдэг түүнд бага байв. Тэр өөрийн сүнслэг өсөлтдөө сэтгэл дундуур явдаг байжээ. Нэгэн Ням гарагийн цуглааны дараа тэрээр ихэд бухимдан “Пастораа, та надад Библиэ унш, Бурхан Үгээрээ дамжуулан чамтай ярина гэж байнга хэлдэг. Би ч хичээсэн. Өглөө бүр Библийг уншсан ч надад Тэр юу ч хэлдэггүй, яагаад тэр вэ?” гэж асуулаа.

Харин пастор нь түүнд “Самуел аа, чи Библиэ **хэрхэн** уншдаг талаараа надад хэлээч” гэж хариулав. Самуелын хариултаас тэр яагаад бүтэлгүйтсэнийг харах боломжтой байв. Тэр “Би өглөө бүр ажилдаа явахын өмнө Библиэ нээгээд, нэг эшлэл уншдаг” гэж хариулжээ. Пастор нь лавшруулан “Чи Библиэ цааш үргэлжлүүлэн уншихдаа бүтэн ном эсвэл бүтэн бүлгийг уншдаггүй байсан юм уу?” гэж асуухад, тэр “Үгүй ээ, би зүгээр л өглөө бүр Библиэ нээхэд таарсан нэг эшлэлийг л уншдаг. Гэхдээ энэ нь надад бараг тус болдоггүй!” гэж хариулсан юм.

Самуелд Библийг ийм маягаар уншихад тулгарч буй бэрхшээлийг ойлгоход нь туслахын тулд пастор нь түүнээс Библиэ нээж, таарсан анхны эшлэлийг уншихыг хүслээ. Самуел “Дараа нь Есавын уулыг негевчүүд, Филистийн талыг шефелачууд эзэмших болно. Тэд Ефраимын нутаг, Самарийн нутгийг эзэмших бөгөөд Гилеадыг Бениамин эзэмших болно” (Обадиа 1:19) гэсэн хэсгийг уншив.

Дараа нь пастор Самуелаас хэдэн асуулт асуув. “Негев хаана байдаг вэ? Шефела хаана байдаг вэ? Ефраимын нутаг хаана байдаг вэ? Самари, Бениамин, Гилеад хаана байдаг вэ?” гэж асуухад тэр “Би мэдэхгүй” гэж хариулсан. Дараагийн долоо хоногт нь тэд “Библийг хэрхэн унших вэ” сэдэвтэй Библийн хичээл эхлүүлжээ. Үүний дараагийн хэдэн долоо хоногт Самуел Библийг хөрвүүлэх зарчмуудаас суралцаж эхлэв. Улмаар тэр Бичвэр өнөөдөр хэрхэн бидэнд ярьдагийг ойлгож суралцсан юм.

Энэхүү курсын зорилго нь Библийн хөрвүүлгийн зарчмуудыг сурч, хэрэгжүүлэхэд тань туслах юм. Эдгээр хичээлүүд болон дасгалуудаар дамжуулан та Бурханы Үгийг ойлгох, амьдралдаа хэрэгжүүлэх, бусдад заахад туслах арга хэрэгслүүдийг олж авах болно.

Би яагаад Библийг судлах ёстой вэ?

Зарим хүмүүс Библийг ойлгоход дэндүү хэцүү гэж үздэг учраас уншихаас зайлсхийдэг. Библийг Бурханы Үг гэж итгэдэг олон хүн үүнийг хэрхэн хөрвүүлж, хэрэгжүүлэхээ мэддэггүй. Библийг судлах нь хэцүү ажил юм. Харин үүний төлөө хөдөлмөрлөх нь үнэ цэнтэй зүйл мөн үү? Бид яагаад Библийг судлах ёстой вэ?

Бурхан Бичвэрээр дамжуулан өөрийгөө илчилдэг

Бичвэр бидэнд Бурхан гэж хэн болохыг харуулдаг. Бурханы Үг нь Бурханы мөн чанарын илэрхийлэл юм (Дуулал 119:15, 27). Бурхан хэрхэн боддог, Түүнд юу чухал, Тэр хүмүүстэй хэрхэн харилцаж, хүн төрөлхтний түүхэнд хэрхэн ажилладгийг Бичвэр бидэнд харуулдаг. Бурханы хууль (Түүний шаарддаг зүйл) нь Түүний зан чанар, шударга ёс, мэргэн ухааныг тусган харуулдаг (Дуулал 119:137). Бид Библийг унших бүрдээ энэ нь Бурханы талаар бидэнд юуг харуулж байгаад анхаарлаа хандуулах ёстой юм.

Бурханыг мөргөн хүндэлдэг нэгэнд Бичвэр Бурханыг илчилдэг. Энэ нь мөргөн хүндлэгчдийн Бурханд хандах хандлагыг зааварлан чиглүүлж, бидний амьдрах ёстой арга замыг харуулдаг.

Библи бол дэнлүү юм

Дуулаач Бурханы Үгийг бидний амьдрах замыг чиглүүлдэг дэнлүүтэй зүйрлэсэн байдаг (Дуулал 119:105). Библи бол бидэнд хэрхэн бодож, амьдрахыг заадаг Бурханы үнэн билээ.

► Дуулал 19:7-11, Дуулал 119:160, болон 2 Тимот 3:16-17 эшлэлийг унших.

Бурханы Үг нь зөв онол сургаалын эх сурвалж юм. Библи нь аврал болон ариун байдалд шаардлагатай бүх мэдлэгийг агуулдаг. Энэ зарчим нь бид өөр тусламжгүйгээр Бичвэр дэх бүх зүйлийг ойлгож чадна гэсэн үг биш юм. Энэ нь мөн уламжлал чухал биш гэсэн үг ч биш. Харин энэ нь Бурханы Үг бол итгэгч хүний эцсийн эрх мэдэл гэсэн утгатай.

Бурханы Үг нь үнэний эх сурвалж учраас Бичвэрийн мэдлэг нь биднийг үйлчлэлд бэлтгэж, сургадаг. Бид Бурханы Үгийг үнэн зөвөөр заахдаа Бурханы эрх мэдлээр зааж сургадаг. Үнэн бол Түүнийх болохоос биднийх биш билээ.

Библи бол сүнслэг сүү юм

Шинэ төрсөн хүүхэд сүүг хүсдэг шиг итгэгчид Библийг хүсэх ёстой гэж элч Петр хэлжээ (1 Петр 2:2). Хүүхэд бие бялдрын хувьд өсөхийн тулд сүү хэрэгтэй шиг Христэд итгэгч хүн сүнслэг байдалд өсөхийн тулд Бичвэр хэрэгтэй юм. Бурханы Үгийг тогтмол хэрэглэхгүй бол бид хэзээ ч сүнслэг төлөвшилд хүрч чадахгүй.

Бид Библийг хөрвүүлэх үр дүйд болон Бурханы Үгээс үнэнийг ялган таних чадварт суралцсанаар төлөвшдөг (Еврей 5:14). Бусдад заахдаа Бурханы Үгийг ашиглах чадвар маань хөгждөг.

Библи бол зөгийн бал мэт амттай

Дуулаач Бурханы Үгийг зөгийн балтай зүйрлэсэн байдаг (Дуулал 19:10, Дуулал 119:103). Зөгийн бал нь эрүүл бөгөөд маш амттай. Бидний хувьд Бурханы Үгийг судлах нь дургүй ажил биш, харин баярлууштай зүйл байх ёстой. Дайны талбарт буй цэрэг эр гэр бүлийнхнээсээ захидал аваад баярладаг шиг, Бурхан хүүхдүүддээ бичсэн захидал болох Библийг уншихдаа бид баярлан догдлох учиртай.

Еврей хүүхдүүд багаасаа Хуулийг уншиж сурахын тулд багш нь хичээлийн эхний өдөр цагаан толгойн эхний үсгүүд дээр зөгийн бал түрхэж, хүүхдүүдээр хуудсыг долоолгосноор амтлаг амтыг мэдрүүлдэг. Багш энэхүү биет хичээлээр “хүүхэд баярлан догдлох болон сайхан амтыг [Хуультай] холбон заадаг ажээ.”¹

Библи бол Сүнсний сэлэм юм

Библи нь сүнслэг тулаанд бидний зэр зэвсэг болдог (Ефес 6:17). Есүс цөлд сорилттой тулгарахдаа Дэд хууль номоос эш татан, Сатаны дайралтад хариулсан юм (Матай 4:1-11).

Бичвэр биднийг сүнслэг ялалт болон үр нөлөөтэй үйлчлэлд хүчирхэгжүүлдэг. Библи судлалаар дамжуулан бид хуурамч сургаалд хариулах, үнэн зөв сургаалын дагуу чуулганаа байгуулж, өнөөгийн ертөнцөд үр дүнтэй үйлчлэхэд бэлэн болдог.

¹ Efraim Rubin, “Honey in Jewish Law, Lore, Tradition, and More,” 2023 оны 11 сарын 15-нд хандсан https://www.chabad.org/library/article_cdo/aid/2697265/jewish/Honey-in-Jewish-Law-Lore-Tradition-and-More.htm

Бичвэрийг судлах зохисгүй шалтгаанууд

► Еврей 4:12-13 эшлэлийг унших.

Бичвэрийг судлах олон сайн шалтгаан байдаг ч, заримдаа хүмүүс буруу сэдлээр Бичвэрийг унших болон судлах нь бий.

Зарим хүмүүс зөвхөн үзэл бодлоо хамгаалахын тулд нотлох баримт цуглуулах зорилгоор Бичвэрийг судалж болох юм. Магадгүй тэд өөрсдийн нөлөөн дор байгаа хүмүүсийг хянахын тулд мэдлэгийг ашиглахыг хүсдэг ч байх боломжтой.

Зарим хүмүүс бардамналын шалтгаанаар Бичвэрээс суралцаж болох юм. Магадгүй тэд сүнслэг байдлыг олж авснаар бусад хүмүүсээс давуу байх болно гэж боддог байх. Магадгүй өөрсдийнх нь ололт амжилтын төлөө хүмүүс тэднийг сайнаар бодоосой гэж боддог ч байж мэднэ. Эсвэл тэд Бичвэрээс суралцах нь Бурханы тааллыг хүртэхэд тусална гэж боддог ч байж магадгүй.

Эдгээр нь бүгд Бичвэрийг унших болон судлах буруу шалтгаанууд юм. Еврей 4:12-13 эшлэлд Бичвэрт хандах зөв хандлагын талаар өгүүлдэг. Хувиа хичээсэн зорилгодоо хүрэхийн тулд Бичвэрийг ашиглахын оронд энэ нь биднийх биш, Бурханы Үг гэдгийг санах хэрэгтэй юм. Бид үүнийг Бурханыг эмээн хүндэтгэсэн хандлагаар судлах учиртай. Библи нь бидний эрх мэдэл бөгөөд бид үүнд захирагдах ёстой. Бид үүнийг бусдад заахдаа даруу байдлаар зааж сургах учиртай.

Бид Бурханы Үгийг ийнхүү судалж, заах үед энэ нь бидний амьдрал дахь нүгэл эсвэл алдааг илчилж, түүнээс хэрхэн эргэхийг бидэнд харуулдаг. Энэ нь бидний болон бидний үйлчилж, удирдаж буй хүмүүсийн амьдралыг өөрчилдөг.

Би Библийг хэрхэн судлах ёстой вэ?

► Та Бичвэрийн багц хэсгийг судлахдаа одоогоор ямар үйл явцыг ашиглаж байна вэ? Библийн текстийн утгыг ойлгохын тулд хийх тодорхой алхмуудын талаар ярилц.

Самуел Библи судлах нь чухал гэдэгтэй санал нийлсэн. Гэсэн хэдий ч тэр Бичвэрээс хэрхэн суралцахаа мэддэггүй байлаа. Түүнд аргачлал хэрэгтэй байв.

Энэ курс нь Библи судлах үр нөлөөтэй аргачлалыг танилцуулах зорилготой юм. Пасторууд номлолд бэлтгэхдээ эдгээр алхмуудыг ашиглах боломжтой. Библийн багш нар ч Библийн хичээл бэлтгэхдээ эдгээрийг ашиглаж болно. Итгэгч бүр хувийн сүнслэг өсөлтийнхөө төлөө энэ аргыг хэрэглэхдээ ашиг тусыг нь хүртэж чадна.

Энэ курсын дагуух аргачлал нь гурван алхмаас бүрдэнэ.

Ажиглалт

Энэ алхмаар бид “Би Библиэс юу харж байна вэ?” гэж асуудаг. Энэ үе шатанд бид Бичвэрийн талаар аль болох олон нарийн ширийн зүйлсийг ажигладаг. Маш олон тооны

уншигчид энэхүү ажиглалт алхмыг алгасаад шууд хөрвүүлэг шат руу шилждэг. Бид энэ нь юу гэж хэлж байгааг сайтар ажиглахаас нааш Бичвэрийн жинхэнэ утгыг ойлгож чадахгүй. Ажиглалт алхмаар бид Бичвэрийн текст дэх нарийн ширийн зүйлсийг хардаг. Бид Бичвэрийн сургаалд чухал ач холбогдолтой нарийн ширийн зүйлсийг тодорхойлж сурах болно. Ялангуяа нэр томьёо, бүтэц, утга зохиолын хэлбэр, хам сэдвийг судална.

Нэр томьёо

Библийн номыг судлахдаа тухайн номын туршид хэд хэдэн удаа дурдагдсан үгсийг хайж олдог. 1 Иохан захидлын 5 бүлэгт “мэдэх” гэдэг үгийн зарим хэлбэрийг 30 гаруй удаа ашигласан байдаг. Иоханы захидлыг судлахдаа номын туршид давтагдсан эдгээр үгсээс эхлэн мөшгин суралцах боломжтой. Иохан захидалдаа “мэдэх” гэдэг үгийг дурдсан хэсгүүд нь түүний сургаалыг хөрвүүлж эхлэхэд бидэнд туслах болно. Иоханы захидлыг ойлгохын тулд “Иохан биднийг юуг мэдэж чадна гэж хэлсэн бэ?”, “Тэдгээр таньж мэддэг хүмүүсийн шинж чанарууд нь юу вэ?” гэж асууж болно.

Бүтэц

Библийн номууд нь Ариун Сүнсний онгодоор маш хянуур байдлаар бүтсэн. Та Иоханы Сайнмэдээ шиг номыг судалж байхдаа Иохан Сайнмэдээгээ Есүс гэж хэн болохыг харуулдаг долоон тэмдгийн эргэн тойронд өрнөж буйгаар бичсэнийг олж мэдэх болно. Номын бүтцийг ажигласнаар энэ нь бидэнд Иоханы зорилгыг илүү сайн ойлгох боломжийг олгодог.

Бид нэг багц хэсгийг судлахдаа бүтэц нь тухайн хүүрнэлийн үргэлжлэл байгааг харж болох юм (Лук 9:28-36-д өгүүлдэг шиг). Энэ нь магадгүй дүгнэлт хийх үндэслэл ч байж болно (Ром 6:1-13-д дурдсан шиг). Энэ нь гол санаануудыг харуулахын тулд нарийн ширийн зүйлсийг ч дурдсан байж болно (Ефес 6:13-18-д хэлсэн шиг). Мөн өөр төрлийн бүтэц ч бий.

Утга зохиолын хэлбэр

Паул дээд цэгт нь тултал мэтгэлцээн өрнүүлж буй хуульчтай адил, санаагаа нотлох маш нарийн зохион байгуулалттай захидлыг бичсэн байдаг. Ром эсвэл бусад захидлыг сайн ойлгохын тулд Паулын логикийг анхааралтай дагах хэрэгтэй болдог.

Харин эсрэгээр, Иона ном нь бүх хүмүүсийн төлөөх Бурханы хайрыг харуулахын тулд бичигдсэн богино түүхэн хүүрнэл юм. Үүнийг сайн ойлгохын тулд бид “Юу нь үүнийг гайхмаар, ер бусын түүх болгож байна вэ?” хэмээн асуух хэрэгтэй. Үүний дараа та “Энэ түүхийн нарийн ширийн зүйлс нь ямар утга учиртай вэ?” гэж асууснаар Иона номыг хөрвүүлэхэд бэлэн болох болно.

Хам сэдэв

Энэ хүрээнд бид “Паул баяр хөөрийн сургаал бүхий Филиппой захидлыг бичих үедээ хаана байсан бэ?” гэх зэрэг асуултуудыг асуудаг. Тэр энэ үед Ромд байсан бөгөөд шүүх хурал болон болзошгүй цаазын ялыг хүлээж байлаа. Нөхцөл байдал нь биднийг Паул

баяр хөөртэй байсан гэж хэлсэн шалтгааныг олж харахад хүргэдэг. Учир нь тэрээр хувь хүнийхээ хувьд муу нөхцөл байдалд байсан ч энэхүү баяр хөөрийг мэдэрч байсан юм.

“Илчлэл номд Бурханы мөнхийн төлөвлөгөөг илчлэхээр тэнгэр нээгдэх үед элч Иохан хаана байсан бэ?” Тэр Патмос арал дээр цөллөгт байжээ. Хавчлагын цаг үе нь Бурханы ялалтын тухай сургаалыг итгэлийн агуу урам зориг болгосон юм.

Хөрвүүлэг

Энэ алхмаар бид “Библи юу гэсэн утгатай вэ?” гэж асуудаг. Бид аль болох олон ажиглалт цуглуулсны дараа Бичвэрийн дамжуулж буй сургаалыг хайдаг. Бид бие даасан эшлэл болон бүлгүүдийг нэг ном болгон нэгтгэж буй сургаалын томоохон сэдвүүдийг олж сурах болно. Бид “Энэ номын анхны уншигчдад зориулсан сургаал нь юу байсан бэ?” гэж асуух болно. Бид бүх цаг үе, бүх газар орон, бүх соёлд үнэн байх зарчмуудыг эрж хайна.

Хэрэгжүүлэлт

Энэ алхмаар бид “Би Библийг өнөөдөр амьдрал, үйлчлэлдээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?” гэж асуудаг. Амьдралдаа хэрэгжүүлэхгүйгээр үүний утга учрыг ойлгох нь хангалтгүй юм.

Howard Hendricks сурах бичигтээ хэрэгжүүлэлтийн талаар хоёр асуултыг өгсөн байдаг.²

1. Энэ нь надад хэрхэн хэрэгжих вэ? Энэ нь Бичвэрийн миний амьдрал дахь хэрэгжүүлэлтийг харуулдаг.
2. Энэ нь бусдад хэрхэн хэрэгжих вэ? Энэ нь миний үйлчилж буй хүмүүсийн амьдрал дахь Бичвэрийн хэрэгжүүлэлтийг харуулдаг.

Англи улсад чуулганы түүх заадаг нэгэн нэр хүндтэй их сургуулийн профессор байжээ. Эрдмийн хувьд тэр Библийг маш сайн мэддэг байсан ч, хувь хүнийхээ хувьд тэрээр Бурханд болон Бурханы Үгэнд итгэх талаарх аливаа итгэл үнэмшлийг үгүйсгэдэг байж. Энэ хүний хувьд ажиглалт болон хөрвүүлгийн талаар ихийг мэддэг ч харамсалтай нь, хэзээ ч Бичвэрийн үнэнийг амьдралдаа хэрэгжүүлж байсангүй.

Иаков ийм хүний талаар “Учир нь үгийг сонссон атлаа эс үйлдэгч нь төрөлх царайгаа толинд харж байгаа боловч, өөрийгөө харчхаад эргэхдээ ямар байснаа даруй мартдаг хүнтэй адил юм” (Иаков 1:23-24) гэж өгүүлсэн. Англи профессорын жишээ нь хэтрүүлэгтэй байж болох ч, Бичвэрт юу гэж хэлснийг мэддэг ч өдөр тутмын амьдралдаа үүнийг хэрэгжүүлдэггүй олон хүн байдаг. Библийг жинхэнээсээ судалж мэдсэн бол үр дүнд нь практик хэрэгжүүлэлт бий болдог.

² Howard G. Hendricks and William D. Hendricks, *Living by the Book* (Chicago: Moody Publishers, 2007)

Хөрвүүлэг дэх Ариун Сүнсний үүрэг оролцоо

► Үл итгэгч хүн Бичвэрийн утгыг ойлгож чадах уу?

Энэ асуултын хариулт нь “Тийм, гэхдээ зөвхөн хэсэгчлэн.” Энэхүү курсээр бид хөрвүүлгийг чиглүүлэх үйл явцыг судлах болно. Эдгээр алхмууд нь Бурханы Үгийн дамжуулж буй сургаалыг ойлгоход бидэнд тусална. Библи нь бусад номын адил уншсан хүндээ маш их үнэнийг илчлэн харуулах болно.

Гэсэн хэдий ч, Ариун Сүнсний гэрэлтүүлэггүйгээр хүний ойлголт үргэлж хязгаарлагдмал байдаг. Оюуны судалгаа нь дангаараа хэзээ ч сүнслэг үнэнийг илчилж чадахгүй. Паул бичихдээ:

Хүний бодлыг доторх сүнснээс нь өөр хэн мэдэх билээ? Түүнчлэн Бурханыхыг Бурханы Сүнснээс өөр хэн ч эс мэднэ. Бурханы бидэнд бэлэглэсэн юмсыг мэдэхийн тулд бид ертөнцийн сүнсийг бус, харин Бурханы Сүнсийг хүлээн авсан юм. Бид үүнийг хүний мэргэн ухааны сургасан үгсээр бус, харин Сүнсний сургасан үгээр ярьдаг бөгөөд сүнслэг зүйлсийг сүнслэг хүнд тайлбарладаг юм. Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Ийм хүнд эдгээр нь мунхаглал бөгөөд сүнслэгээр тунгаан цэгнэх учиртай зүйлсийг тэр мэдэж чадахгүй (1 Коринт 2:11-14).

Үл итгэгч хүн Бичвэрийн зарим сургаалыг ойлгож чаддаг ч, Библийн гүн гүнзгий үнэнүүд Ариун Сүнсний гэрэлтүүлгээр илчлэгддэг. Бичвэрийг судлах нь мэдээлэл олж авахаас илүү зүйл бөгөөд энэ нь итгэл, дуулгавартай байдлыг шаарддаг. Биднийг Бурханы Үгийн эрх мэдэлд захирагдах хүртэл Бурханы Сүнс амьдралд маань өөрчлөлт авчрах ажлыг хийж чадахгүй. Учир нь:

1. Бид Бичвэрийг судлахын өмнө залбирах ёстой. Биднийг суралцахад удирдан чиглүүлэхийг Ариун Сүнснээс бид хүсэн гуйдаг. Иаков “Харин та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5) гэжээ.
2. Бид Бичвэрийг судалсныхаа дараа хувьчлан хариу үйлдэх ёстой. Библийг судлах зорилго нь оюуны мэдээлэл авахаас илүү бөгөөд энэ нь хувийн өөрчлөлт юм. Хэрэв бид судлах явцдаа өөрчлөгдөөгүй бол суралцах зорилгоо алдсан гэсэн үг. Энэхүү өөрчлөлт нь зөвхөн Ариун Сүнсээр дамжуулан ирдэг.

Тариачин ба үрийн тухай заасан Есүсийн сургаалт зүйрлэлд зарим үр зам дагуу унахад шувууд тэдгээрийг иддэг. Зарим үр нь үндэсгүй учир нар төөнөхөд хатаж орхидог. Зарим үрийг зэрлэг ургамал боомилж орхидог. Гэсэн ч зарим үр нь сайн хөрсөнд унаж, үр жимсээ ургуулдаг. Сайн хөрс бол Үгийг сонсож ойлгодог хүн хэмээн Есүс тайлбарлажээ (Матай 13:3-23). Энэ сургаалт зүйрлэл нь Үгийг ойлгохгүйгээр сонсох боломжтойг харуулдаг. Бид Ариун Сүнсний дуу хоолойд зүрх сэтгэлээ нээх үед л Бурханы Үгийг бүрэн ойлгож ухаардаг.

1-р хичээлийн гол санаанууд

(1) Библийг судлах шалтгаанууд:

- Бурхан Бичвэрээр дамжуулан өөрийгөө илчилдэг.
- Библи бол дэнлүү юм.
- Библи бол сүнслэг сүү юм.
- Библи бол зөгийн бал мэт амттай.
- Библи бол Сүнсний сэлэм юм.

(2) Библийг судлах үйл явц гурван алхамтай.

- Ажиглалт: Би Библиэс юу харж байна вэ? Судлахдаа:
 - Нэр томьёо
 - Бүтэц
 - Утга зохиолын хэлбэр
 - Хам сэдэв
- Хөрвүүлэг: Библи юу гэсэн утгатай вэ?
- Хэрэгжүүлэлт: Би Библийг өнөөдөр амьдрал, үйлчлэлдээ хэрхэн хэрэгжүүлэх вэ?
Асуух:
 - Энэ нь надад хэрхэн хэрэгжих вэ?
 - Энэ нь бусдад хэрхэн хэрэгжих вэ?

(3) Библийг судлахад бидэнд Ариун Сүнсний гэрэлтүүлэг хэрэгтэй. Учир нь:

- Бид Бичвэрийг судлахын өмнө залбирах ёстой.
- Бид Бичвэрийг судалсныхаа дараа хувьчлан хариу үйлдэх ёстой.

1-р хичээлийн даалгавар

Дараах Бичвэрийн хэсгээс нэгийг сонгоод хөрвүүлэх үйл явцыг эхлүүлээрэй.

- Дэд хууль 6:1-9
- Иошуа 1:1-9
- Матай 6:25-34
- Ефес 3:14-21
- Колоссай 3:1-16

Та энэхүү курсын туршид энэ Бичвэрийг судлах болно. Энэ эхний хичээлийн хувьд Бичвэрийг анхааралтай уншаарай. Гурван хэсэг дээр тэмдэглэл хийх:

1. Ажиглалт: Сонгосон Бичвэрийн багц хэсгийнхээ нарийн ширийн зүйлсийг аль болох дэлгэрэнгүй бич. Бичвэрийн багц хэсгээс хамааран нарийн ширийн зүйлс нь харилцан адилгүй байх болно. Танд тусалж болох зарим асуултууд:
 - Энэ Бичвэрт тэмдэглэгдсэн үйл явдлууд хаана болсон бэ?
 - Энэ Бичвэрийн дүрүүд нь хэн хэн бэ?
 - Энэ Бичвэр юу гэж тушааж байна вэ?
 - Энэ Бичвэрт ямар үгс давтагдсан бэ?
2. Хөрвүүлэг: Энэхүү багц хэсгийн анхдагч мэдээ сургаалыг 2-3 өгүүлбэрт хураангуйлан бичнэ үү.
3. Хэрэгжүүлэлт: Та Бичвэрийг амьдрал болон үйлчлэлдээ хэрэгжүүлэх 2-3 арга замыг бичнэ үү.

2-р хичээл

Ажиглалт: Эшлэлийг харах

Хичээлийн зорилго

- (1) Бичвэрийг анхааралтай уншихын ач холбогдлыг ойлгох.
- (2) Судалж байгаа эшлэл бүр дээр асуулт тавих.
- (3) Бичвэрийг системтэйгээр судлах төлөвлөгөө гаргах.
- (4) Сонгосон эшлэл дээрээ нарийвчилсан ажиглалт хийх дасгал хийх.

Танилцуулга

► Энэхүү курс хичээлд суухаар ирсэн аялал, замынхаа талаар ангийн нэг эсвэл хоёр суралцагч тайлбарлан ярина. Ингэхдээ аль болох анзаарсан нарийн ширийн зүйлсээ багтаана. Та ямар нэгэн ресторан, чуулганы барилга, бизнесийн төвийн хажуугаар өнгөрсөн үү? Замдаа та хэдэн гэрлэн дохио болон замын тэмдэгтэй таарсан бэ? Хэдэн удаа эргэлт хийсэн бэ? Таны замд тэр бүр таараад байдаггүй ямар нэг хачирхалтай зүйлтэй таарсан уу? Хүн тус бүр ярьсны дараа хэр зэрэг ажиглалт хийсэн болон анзааралгүй өнгөрөөсөн зүйлийн талаар ярилцаарай.

“Таны хуулийн гайхамшигт зүйлсийг надад харуулахаар нүдийг минь нээгээч!”
- Дуулал 119:18

Гэрлээ Библийг уншихдаа оюун санаандаа дүрслэн уншдаг. Хэрэв та Марк 1:29-31 эшлэлийг уншиж, нэгтгэн дүгнэхийг Гэрлээгээс асуувал тэр “Есүс дөрвөн дагалдагчийнхаа хамт (Симон, Андрей, Иаков, Иохан) Галил дахь синагогаас гарч явсан байна. Хадам эх нь халуурч өвчтэй байсан Симоны гэрт тэд очжээ. Есүс түүний гарыг барьж өндийлгөхөд тэр даруй халуунгүй болов. Түүний бие маш сайн болсон тул тэр тэдэнд унд хоол бэлдсэн. Түүнд амарч, тэнхрэх цаг ч хэрэггүй байлаа!” гэж хэлэх болов уу.

Харин Тайвнаа Библийг уншихдаа үгсийг уншдаг бөгөөд нарийн ширийн зүйлсийг тэр бүр олж хардаггүй. Хэрэв та Тайвнаагаас Марк 1:29-31 эшлэлийг уншиж, нэгтгэн дүгнэхийг асуувал тэр “Есүс Симоны гэрт зочилж, хэн нэгнийг эдгээжээ” гэж хариулах байх.

Эдгээр уншигчдын хэн нь ажиглалт хийсэн бэ? Аль уншигч энэ түүхийг удаан санах вэ? Энэ түүхийг хөрвүүлэхэд аль уншигч нь илүү мэдээлэлтэй байх вэ? Хариулт нь ойлгомжтой байна. Гэрлээ Марк 1:29-31 эшлэлд юу өрнөж байгааг харсан бол, Тайвнаа энэ бүлгийг уншсан ч тэр ажигласангүй.

Библийг судлах эхний алхам бол ажиглалт юм. Энэ алхмаар бид “Би Библийн энэ хэсгээс юу харж байна вэ?” гэж асуудаг. Библийг үр нөлөөтэй хөрвүүлэх түлхүүр бол аль болох их зүйлийг ажиглах юм. Энэхүү хичээлээр бид эшлэл дэх чухал нарийн

ширийн зүйлсийг ажиглаж сурна. Үүнийг хийхдээ тэвчээртэй байгаарай. Та хэдий чинээ их ажиглана, төдий чинээ их хөрвүүлэг хийх материалтай болно.

Эшлэлд ажиглалт хийх

Үйлс 1:8:

Харин Ариун Сүнс та нар дээр ирэхэд
та нар хүчийг хүлээн аваад,
Йерусалим,
бүх Иудей,
Самари
тэр байтугай дэлхийн хязгаарт хүртэл
Миний гэрч болно гэв.

Энэ эшлэлээс бид юу ажиглаж болох вэ?

Эхний үг нь ямар үг вэ?

“Харин.” *Харин* гэдэг холбох үг нь өмнөх эшлэлийг зааж байна. Үйлс 1:6-д дагалдагчид “Эзэн минь, энэ цагт Та Израилд хаанчлалыг сэргээх үү?” гэж асуусан. Та нэгэнт үхэгсдээс амилсан тул хаанчлалаа байгуулах үү? Есүс хоёр зүйлийг тэдэнд хэлсэн:

“Эцэг Өөрийн эрх мэдлээр тогтоосон тэр цаг, үеийг мэдэх нь та нарын хэрэг биш” (Үйлс 1:7). Энэ нь Эцэгийн хариуцлага.

“Харин... та нар хүчийг хүлээн аваад... Миний гэрч болно.” Энэ нь та нарын хариуцлага.

Үүнд хэн оролцох вэ?

“Та нар.” Есүс хэнд хандан ярьж байна вэ? Элч нарт (Үйлс 1:2, 4). “Эдгээр элч нар хэн байв?” гэж асуугаарай. Элч нарын талаар мэддэг бүхнээ жагсаан бич. Энэ эшлэл хэний талаар өгүүлж байгаа нь Пентэкостын өдрийн гайхамшигтай хувьсган өөрчлөх хүчийг харуулдаг.

- Тэд иудей хүмүүс байсан. Есүс тэднийг Самари руу илгээж байна!
- Тэд муу сүнсэнд эзэмдүүлсэн хүүг эдгээх хүчгүй байсан (Марк 9:14-29). Тэд хүчийг хүлээн авах болно.
- Есүсийг баривчлах үед тэд айж зугтацгаасан (Матай 26:56). Тэд дэлхийн хязгаар хүртэл Түүний гэрчүүд байх болно.

Өгүүлбэрт байгаа үйл үг нь ямар үг вэ?

“Хүлээн аваад.” Үйл үг бидэнд юу тохиолдож байгааг хэлдэг. Энэ тохиолдолд үйл үгийн цаг нь ирээдүйд хүлээн авах зүйлийг зааж байна.

Тэд юуг хүлээн авах вэ?

“Хүч.” Үйлс ном элч нарын үйлчлэл дэх хүчийг харуулдаг.

► Та эндээс эхэлж болно. Бусад эшлэл дээр ажиллаж, дараах асуултуудад хариулаарай:

- **Тэд хэзээ хүчийг хүлээн авах вэ?**
- **Хэн тэдэнд хүчийг өгөх вэ?**
- **Хүч чадлын үр дүнд юу болох вэ?** (Хүч нь гэрчлэхийн өмнө байдаг. Энэхүү хүч чадлын жам ёсны үр дүн нь сайнмэдээг бусдад хуваалцах хүсэл байх болно.)
- **Тэд хэний гэрч болох вэ?**
- **Тэд хаана гэрчлэх вэ?** (Та эдгээр дөрвөн байршлын талаар юу мэдэх вэ? Самари нь юугаараа онцлог вэ? Эдгээр иудей элч нар тийшээ очихыг хүссэн үү?)

Ажиглалт хийх чадвараа сайжруулах нь

Энэрэл хараа муу хүүхэд байлаа. Сургуульд байхын тэр багшийгаа сайн харж чаддаггүй байв. Тэр самбар дээрх үгсийг уншиж чадахгүй байсан учраас шил зүүх болжээ. Гэтэл гэнэт бүх зүйл тодроод, өмнө нь хэзээ ч харж байгаагүй зүйлсийг олж харав! Тэр багшийнхаа царайг тод харж байв. Самбар дээр бичсэн зүйлийг амархан уншиж чадсан. Тэр үнэхээр догдолж сэтгэл нь хөдөлжээ!

Анхааралтай ажиглалт хийх нь харахгүй байгаа нүдэндээ шил тааруулахтай адил юм. Бичвэрийг хэрхэн ажиглаж сурах нь Бичвэрт юу хэлж байгааг ойлгох ойлголтыг тань сайжруулдаг.

Үйлс 1:8 эшлэл дээр хийсэн дасгал нь таны уншиж буй зүйлээ хэр сайн ажиглаж байгааг харуулна. Ажиглалт хийх чадвараа сайжруулах хэдэн аргыг сурцгаая. Та Бичвэрийг илүү ойроос тод харахад туслах асуултуудыг асууж сурна. Улмаар та бусад эшлэлийг уншихдаа эдгээрийг хэрэгжүүлэх болно.

Та Библийн эшлэлийг уншиж байхдаа “Би энэ эшлэлийг аль хэдийн мэдсэн!” гэж хэлэхийн оронд, Түүний Үгийг шинээр олж харахын тулд нүдийг минь нээгээч хэмээн гуйгаарай. Энэ хичээлийн арга хэрэгслүүд нь шинэ ойлголтоор уншихад тань тусална.³

Ойлгохын тулд унших

10 настай нэгэн хүү Библийг жилд бүтэн уншина гэж шийджээ. Энэ нь сайн шийдвэр байсан ч харамсалтай нь тэр Библийг хэрхэн үр дүнтэй уншихаа мэдэхгүй байв. Өдөр бүр хэр их унших ёстойг харуулсан хуваарь түүнд байсан ч, уншиж чадахгүй хоцрох нь

³ Энэ хичээлийн алхмуудыг Howard G. Hendricks ба William D. Hendricks нарын *Living by the Book*, (Chicago: Moody Publishers, 2007) номын 8-17-р бүлгээс авч ашигласан. Та тайлбар болон дасгал ажлын талаар нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл эдгээр бүлгүүдийг үзнэ үү.

их байлаа. Ням гарагийн үдээс хойших цагийг тэрээр уншлагаа гүйцээхийн тулд гаргахыг оролдож үзэв. Унших хуваариа шалгах болгонд 20 бүлгээр хоцорч яваагаа харна (Леви номыг уншиж байв). Тэгээд бүхэл бүтэн Леви номыг нэг өдрийн хугаст уншив. Тэрээр аль болох хурдан уншиж дуусгахыг хичээлээ. Уншиж дуусаад 10 минут ч болоогүй байхад тэр Леви номын сургамжийг хэлж чадахгүй байлаа. Тэр юу ч ойлгохгүйгээр уншжээ.

Ойлгохын тулд унших нь хэцүү ажил юм. Үнэний төлөөх эрэл хайгуулыг Библид ийнхүү дүрсэлсэн байдаг: “Цалин цагаан мөнгө мэт үүнийг эрж, нууц эрдэнэ мэт түүнийг хайваас ЭЗЭНээс эмээхүйг чи ойлгоно Бурханы тухай мэдлэгийг олж авна” (Сургаалт үгс 2:4-5). Бичвэрийг анхааралтайгаар унш. Асуулт асуу. Тэмдэглэл хөтөл. Оюунаа дайчлан унш.

Заримдаа Бичвэрийг уншаад өөрийн үгээр буулгах үед шинэ ойлголтыг олж авдаг. Хэдийгээр таны буулгасан үгс судалгаа шинжилгээний орчуулга биш ч, энэ нь текстийн утгын талаар гүн гүнзгий бодож тунгаахад тусалдаг.

Уншиж байхдаа асуулт асуух

Оюунаа дайчлан унших гол түлхүүр нь асуулт асуух юм.

► Энэ хэсгийг үргэлжлүүлэхээсээ өмнө Лук 24:13-35 эшлэлийг унш. Хичээлийг уншиж байхдаа асуулт болгонд хариулахын тулд Лук 24-р бүлэг рүү буцаж очоорой.

(1) Хэн?

Текстэд дурдагдсан хүмүүс нь хэн байна вэ? Хүн тус бүрийн талаар та юу мэдэх вэ?

Лук 24:13-35 эшлэлд ямар хүмүүс дурдагдсан бэ? Амиллын өдөр Клеоп нэр нь дурдагдаагүй хамтрагчийн⁴ хамт Еммау тосгон руу явж байв. Тэд Есүсийн гайхамшиг болон сургаалыг нь мэддэг дагалдагчид байжээ. Энэхүү Ням гарагт тэд Христийн зовлон ба амиллын талаар Есүсээс өөрөөр нь тайлбарлуулсан анхны хүмүүс болсон юм. Тэд амиллын эхэн үеийн гэрчүүд болцгоожээ.

(2) Юу?

Текстэд ямар үйл явдал өрнөж байна вэ? Хэрэв энэ нь түүхэн текст бол ямар үйл явдал тохиолдож байна вэ? Хэрэв энэ нь захидал бол бичигч юуг заахыг зорьж байна вэ?

Лук 24-р бүлэгт Есүс өөрийгөө илчилжээ. Энэ хоёр хүний нүд Есүсийн амиллын бодит байдалд нээгдсэн юм (Лук 24:31).

⁴ Нэгэн уламжлалд нэр нь дурдагдаагүй хамтрагчийг Лук байсан гээд тиймдээ ч тэр түүхийн нарийн ширийн олон хэсгүүдийг тайлбарласан гэж үздэг.

(3) Хэзээ?

Өмнөх асуултын нэгэн адил цаг хугацаа нь бидний уншлагын хам сэдвийг бүрдүүлж өгдөг. Библи судлалын ажиглалт алхмаар бид текстэд буй цаг хугацааны талаарх нарийн ширийн зүйлсийг анхаарч хардаг. Лук 24:13 эшлэлээс бид Еммау руу хийсэн аялал нь хоосон булш олдсон тэр өдөр тохиосныг мэдэж авсан.

Булш хоосон олдсоноос хэдхэн цагийн дараа энэ хоёр дагалдагч Есүстэй уулзжээ. Энэ нь тэд хоорондоо болж өнгөрсөн үйл явдлын талаар ярьж хэлэлцэх үедээ ямар мэдрэмжтэй байсныг бидэнд хэлж өгдөг (Лук 24:15). Сүүлийн гурван өдрийн дотор энэ хоёр хүний сэтгэл хөдлөл дээд болон доод цэгтээ хүрснийг бодож үзээрэй.

Пүрэв гарагт нь тэд Есүсийг баривчлагдахыг хараад цөхрөлд автсан. Баасан гарагт нь Есүс эцсийн амьсгалаа гаргаснаар тэдний Мессиагийн хаанчлалын итгэл найдвар нуран унажээ. Одоо Ням гараг бөгөөд булш хоосон байв. Тэд Еммау руу явах замдаа энэхүү дараалсан нууцлаг хэрэг явдлуудыг ойлгохыг хичээж явлаа.

(4) Хаана?

“Энэ нь хаана болсон бэ?” гэж асуух нь ихэвчлэн тус болдог. Библийн атлас танд энэ асуултын хариултыг олоход тусалж чадна. Зарим Библийн ар талд газрын зураг багтсан байдаг.

Лук 24-р бүлэгт Клеоп болон түүний хамтрагч Йерусалим хотоос баруун тийш 11 км зайд орших Еммау тосгон руу явж байна. Тэднийг замдаа алхан явж байх үед хэдийн орой болжээ. Гэсэн хэдий ч нүд нь нээгдсэний дараа эдгээр хүмүүс баяр хөөртэйгөөр Йерусалим руу буцсан юм. Энэ мэдээг сонсоод дахин нэг өдөр хүлээх нь боломжгүй байжээ!

(5) Яагаад?

Бид цаг хугацааны асуултад хариулахдаа эдгээр дагалдагчид яагаад тэгж их урам хугарсан байсныг олж мэддэг. Есүс нас барснаар Мессиагийн талаарх тэдний бүх найдвар тасарч, тэд урам хугарчээ.

(6) Хэрхэн?

Энэ уулзалтаар эдгээр дагалдагчдын амьдрал хэрхэн өөрчлөгдсөн бол? Тэд Есүсийг үхэгсдээс амилсан гэдэгт итгэл төгс Йерусалим руу буцжээ. Энэ явдлаас хойш тэдний ижил сая сая хүмүүсийн амьдрал амиллаар үүрд өөрчлөгдсөн юм.

Тухайн номыг эсвэл багц эшлэлээ олон удаа унших

G. Campbell Morgan 20-р зууны агуу номлогчдын нэг байжээ. Morgan хэзээ ч Библийн сургуульд сураагүй ч, маш үр нөлөөтэй Библийн багш болсон юм. Номлохоосоо өмнө тэрээр сонгосон текстийг агуулсан Библийн номыг бүхэлд нь дор хаяж 40 удаа уншдаг байжээ. Энэ үйл явцаар дамжуулан Morgan эшлэл бүр хэрхэн номын бүх хэсэгтэй зохицож байгааг сурдаг байв. Тэр номын чухал сэдвүүдийг мэдсэн. Тэр бичигчийн мэдээ

сургаалыг ойлгосон байв. Morgan нэгэнтээ “Библи хэзээ ч залхууралд автуулахгүй” хэмээн хэлжээ. Библийг судлах нь хүнд хэцүү ажил юм.

Та “Би Библийн номыг яаж 40 удаа унших юм бэ? Ингэвэл би хэзээ ч Библийг уншиж дуусгахгүй” гэж хэлж магадгүй. Гэхдээ энэ нь таны бодож байгаа шиг хэцүү биш ч байж болох юм. Ихэнх насанд хүрэгчид минутад 200 үг уншдаг. Тэд нэг цагт 12,000 үг уншиж чадна. Библийн 44 ном 12,000 хүрэхгүй үгсийн сантай. Үүнд Паулын захидлууд, Ерөнхий захидлууд, Бага эш үзүүлэгчид, Рут, Езра, Нехемиа, Естер болон Даниел зэрэг Хуучин гэрээний номууд багтана. Өдөр бүр нэг цагийг гаргахад та Ефес, Филиппой, Колоссай, 1 ба 2 Тесалоник зэрэг номуудыг 40 хоногт 40 удаа унших боломжтой.

Номыг бүхэлд нь уншсанаар тухайн ном хэрхэн зохион байгуулалттай бичигдсэнийг харж болдог. Өмнө нь бид Үйлс 1:8 эшлэлийг уншсан бөгөөд дагалдагч нар Йерусалим, Иудей, Самари болон дэлхийн хязгаар хүртэл гэрч байхаар илгээгдсэн. Үйлс номыг дахин давтан унших тусам энэ нь номыг бүхэлд нь хамарсан загвар болохыг харж болно. Үйлс номын эхэн үед тохиосон хавчлага нь дагалдагч нарыг Йерусалимаас Иудейн бусад газрууд руу аваачсан. Харин Үйлс 8-р бүлэгт Филип сайнмэдээг Самарид хүргэсэн. Үйлс номын төгсгөл хэсэгт Паул Ромд номлосон бөгөөд тэндээс сайнмэдээ мэдэгдэж буй дэлхийн хязгаарт хүрэх болно.

Дахин давтан унших зарим аргууд

- 1. Библиэ чангаар унших эсвэл хэн нэгэн уншсаныг сонсох.** Бичиг үсгийн соёлоос хамааралтай болсон хүмүүс бид эртний Христэд итгэгчдийн ихэнхийнх нь Библи уншлага нь *сонсох* байсан гэдгийг мартдаг. Ефес дэх чуулган Паулын захидлыг хүлээн авахдаа гишүүн бүрд хувилсангүй! Нэг удирдагч захидлыг бусад гишүүддээ уншиж өгнө. Түүхийн ихэнх цаг хугацаанд Бурханы Үгийг уншсанаас хамаагүй олон хүн сонсоод хүлээн авсан байдаг. Паулын захидлуудыг чуулгануудад уншдаг байсан. Эш үзүүлэгчид сургаалыг дамжуулж байв. Та захидлыг чангаар унших эсвэл аудио ном шиг сонссоноор эртний чуулган Бичвэрийг сонссонтой адил Бурханы Үгийг сонсох болно.⁵
- 2. Библийн олон янзын орчуулгыг унших (таны хэл дээр нэгээс олон орчуулга байдаг бол).** Зарим орчуулга нь мэргэжлийн үг хэллэгийг ашигласан бол, зарим нь илүү хялбар ойлгоход энгийн байдлаар орчуулагдсан байдаг. Нэгээс олон орчуулгыг уншсанаар та мэдээ сургаалын талаар шинэ ойлголтыг авах боломжтой. Хэрэв та нэгээс олон хэл мэддэг бол Бичвэрийг хоёр дахь хэлээр унших нь ч тустай.⁶

⁵ www.faithcomesbyhearing.com вебсайтад 700 гаруй хэл дээр аудио Библиуд байдаг.

⁶ www.biblegateway.com вебсайт нь олон хэл дээрх Библийн орчуулгуудыг үнэ төлбөргүй ашиглах боломжийг өгдөг.

3. Унших бүрдээ өөр өөр зүйлд анхаарлаа хандуул. Жишээлбэл, Эхлэл 3-р бүлгийг долоо хоногийн турш өдөр бүр нэг удаа уншиж болно. Ингэж унших бүрдээ өөр өөр өнцгөөс харах боломжтой:

Даваа: Эхлэл 3-р бүлгийг тэнгэрлэг Эцэгийн өнцгөөс харж унш. Эцэг хүүхдүүдийнхээ нүглийг хараад ямар санагддаг бол?

Мягмар: Энэ бүлгийн хамгийн чухал эшлэл нь аль вэ?

Лхагва: Эхлэл 3-р бүлгийг Сатаны өнцгөөс харж унш. Хүүхдүүдтэйгээ харилцах Бурханы харилцааг тэр хэрхэн эвдэхийг оролддог вэ?

Пүрэв: Эхлэл 3-р бүлгийг Есүсийн загалмай дээрх золиосын талаар эргэцүүлж унш.

Баасан: Эхлэл 3-р бүлгийг Адам Ева хоёрын өнцгөөс харж унш. Бурханы шүүлтийг сонсоод тэд юу мэдэрсэн бол?

Бямба: Эхлэл 3-р бүлгийг Библийг анх удаа нээгээд уншиж байгаа хүний нүдээр унш. Энэ түүх Библийн бусад хэсгийг ойлгоход хэр чухал вэ?

Жилийн дотор Библийг унших боломжтой төлөвлөгөө сонголтуудыг www.bible.com хаягаас авах боломжтой. Библийн номыг сард олон удаа унших боломжтой G. Campbell Morgan-ы загварт үндэслэсэн өөр нэг төлөвлөгөө ч бий. Библийн 44 номыг өдөр бүр нэг цаг эсвэл түүнээс бага хугацаанд унших боломжтой юм. Ингэж өдөр бүр нэг цаг уншвал та нэг номыг нэг сард 30 удаа уншиж чадна. Хэдийгээр энэ нь удаан мэт санагдаж болох ч, номыг дахин давтан унших нь Бурханы Үгийн талаар гүн гүнзгий ойлголтыг өгдөг. Ингэж уншсанаар та Библийг бүхэлд нь зургаан жилийн дотор 30 удаа унших боломжтой.⁷

Хэлзүйн дүрмийг судлах

Бурхан бидэнтэй олон янзаар, гол төлөв бичиг үсгээр дамжуулан харилцдаг. Та Бичвэрийг ойлгохын тулд хэл шинжлэлийн мэргэжилтэн байх албагүй ч, бичгийн хэлийг сайн ойлгох тусам Бурханы Үгийн гүн гүнзгий үнэнийг илүү сайн ойлгох боломжтой.

Жишээ болгон бид Паулын хамгийн алдартай эшлэлүүдийн нэгийг хэлзүйн талаас судалж үзье. “Иймд ах дүү нар аа, Бурханы өрөвч сэтгэлээр та нараас хичээнгүйлэн гуйя. Өөрсдийн биеийг Бурханд тааламжтай, амьд, ариун тахил болгож өргө. Ингэх нь та нарын сүнслэг мөргөл мөн” (Ром 12:1). Текстийн дүрмийг судлахдаа бид:

⁷ Урт номуудыг Филемон болон Тит зэрэг богино номуудтай зэрэгцүүлэн, тэнцвэртэй байдлаар уншихад хэдхэн өдрийн дотор 30 гаруй удаа уншиж чаддаг.

Үйл үг

Үйл үг нь байх болон үйл хөдлөлийг илэрхийлдэг. Үйл хөдлөлийг илэрхийлж буй хоёр үйл үг Ром 12:1-д бичигдсэн байна:

- **Хичээнгүйлэн гуйя** гэдэг нь “гуйх” эсвэл бүр “өвдөг сөгдөн гуйх” гэсэн утгатай. Паулын хүсэлт нь маш яаралтай байгааг та мэдэрч байна уу? Энэ нь санаандгүй хэлсэн санал төдий биш, харин өөрсдийгөө Бурханд бүрэн зориулахыг Паул уншигчдаасаа гуйж буй гүн сэтгэгдлээр бичигджээ.
- **Өргө** гэдэг нь идэвхтэй үйл үг. Энэ нь зориулалтыг шаарддаг. Паул уншигчдыг “Өөрсдийн биеийг” Бурханд өргө хэмээн уриалжээ.

Нэр үг

Ром 12:1-д гарч буй нэр үгс нь бидний судлалд чухал юм:

- **Ах дүү нар.** Паул итгэгч хүмүүст хандан бичиж байна. Тэр нүгэлтнүүдийг итгэлд ирэхийг энд уриалаагүй, харин итгэгчдийг илүү гүн гүнзгий ариусалд дуудаж байна.
- **Бие.** Ром 12-р бүлгийн бусад хэсгээс бие нь биднийг бүхэлд нь төлөөлдөг болохыг харж болно. Бид үүнийг “Өөрийгөө бүхэлд нь өг” хэмээн буулгах боломжтой.
- **Өрөвч сэтгэл.** Паулын дуудлага нь Бурханы нигүүлсэлд үндэслэгддэг. Энэ эшлэлийн өмнөхөн Бурхан бүх хүмүүст, иудейчүүд болон харь үндэстнүүдийн аль алинд нь өршөөл нигүүлслээ үзүүлдэг хэмээн Паул өгүүлжээ (Ром 11:32).
- **Тахил.** Мосегийн хуулийн дагуу мөргөл өргөгч нь ямар нэг амьтныг тахил болгон авчирдаг байсан. Харин Христийн хаанчлал дотор бид өөрсдийгөө бүхэлд нь амьд тахил болгон өргөхөөр дуудагдсан.

Тодотгол

Тэмдэг нэр болон үйлт нэр нь “тодотгож буй үгсийнхээ утга санааг дэлгэрүүлж”⁸ тодорхойлдог үгс юм. Ром 12:1-д тахил гэдэг үгийг олон үгээр тодотгосон байна.

- Бидний өргөл тахил нь **амьд**. Бид үхсэн амьтнаар тахил өргөхөө больсон бөгөөд харин бид өдөр бүр буулт хийн амьдралаа зориулдаг.
- Бидний өргөл тахил нь **ариун** байх ёстой. Хуучин гэрээний үед мөргөл хүндэтгэл өргөгч нь согогтой эсвэл зэрэмдэг амьтныг тахил болгон өргөх ёсгүй байсан. Шинэ гэрээний итгэгч нь цэвэр бус, дуулгаваргүй амьдралаа өргөл болгон зориулж чадахгүй.

⁸ Howard G. Hendricks ба William D. Hendricks, *Living by the Book* (Chicago: Moody Publishers, 2007), 121

- Бүрэн бөгөөд хүсэмжит өргөл тахил л **Бурханд тааламжтай**.

Угтвар үг

Угтвар үг нь *дээр, доор, дотор, дэргэд, өмнө, хойно, дунд, хажууд, дээрээс, д, т, аар-4, аас-4, руу, рүү, тай-4* гэх зэрэг үг үсэг юм. Эдгээр жижиг үг үсгүүд нь том утга санааг агуулдаг. Ром 12:1-д хоёр чухал угтвар үг үсэг байна:

- “Бурханы өрөвч сэтгэлээр” гэсэн нь Паулын гуйж буй үндэслэлийг бидэнд харуулж байна. Энэ нь дайсныхаа өмнө дуртай дүргүй бууж өгөх цэрэг хүн шиг биш, харин хайртай эцгийнхээ хүсэлд баяртайгаар буулт хийж байгаа хүүхэд адил юм.
- Бидний өргөл тахил нь “Бурханд” тааламжит байх ёстой. Христэд итгэгч хүний хувьд Бурханы таалал нь хамгийн дээд шагнал байдаг.

Холбох үг

“Бөгөөд” эсвэл “харин” зэрэг холбох үг нь маш хүчтэй үгс юм. Нэг зохиолч холбох үгсийг тоосгонуудыг барьцалдуулдаг зуурмагтай зүйрлэсэн байдаг.⁹ Үйлс 1:8-д “харин” гэдэг холбох үг дагалдагчдын буруу ойлголтыг заасныг бид өмнө нь харсан.

Ром 12:1-д буй “иймд” гэсэн үг өмнөх бүлэг рүү хандуулж байна. Хэрэв та Ром номыг бүхэлд нь уншвал хоёр том хэсгээс бүрдсэн болохыг төвөггүй анзаарна:

- Ром 1-11-р бүлэгт нүглийг буруутгаж, итгэлээр зөвтгөгдөх, итгэгч хүний ариусал, өөрийн хүүхдүүдийн төлөөх Бурханы туйлын зорилго нь алдаршуулал бөгөөд энэхүү зорилгыг гүйцэлдүүлэх Бурханы арга хэрэгсэл нь сонголт болох талаарх онол сургаалуудыг заадаг.
- Ром 12-16-р бүлэгт энэхүү онол сургаалын практик хэрэгжүүлэлтийг харуулдаг. Бид Бурханы өмнө зөвт болгогдсон учраас ийнхүү амьдардаг. Бидний итгэдэг зүйл (Ром 1-11) учраас бид үүнийг хэрэгжүүлдэг (Ром 12-16). Холбох эшлэл нь Ром 12:1 юм.

“Иймд” гэдэг үг Паулын олон захидлуудад чухал тэмдэглэгээ болж бичигдсэн байдаг. Зөвхөн итгэлээр зөвтгөгдөх тухай гайхалтай үнэнийг Галатын итгэгчдэд сануулсны дараа Паул тэднийг өдөр тутмын амьдралдаа зөвтгөлөө харуулж амьдрахыг уриалсан байдаг. “Христ биднийг эрх чөлөөтэй болгохын тулд чөлөөлсөн юм. Иймд бат зогс...” (Галат 5:1). Паул ефесчүүдэд Христ Есүс дотор тэд сонгогдсон тухай гайхалтай сургаалыг заасны дараа тэднийг энэхүү дуудлагынхаа дагуу зохистой амьдрахыг уриалжээ “Иймд та нар дуудагдсан тэрхүү дуудлагадаа зүй зохистой явахыг Эзэний хоригдол би хичээнгүйлэн ятгая” (Ефес 4:1). Паул колоссайчуудад хандан тэднийг үхсэн бөгөөд тэдний амьдрал Христтэй хамт Бурханы дотор нуугдсан хэмээн хэлсэн

⁹ J. Scott Duvall and J. Daniel Hays, *Grasping God's Word* (Grand Rapids: Zondervan, 2012), 59

байдаг. Үүний үр дүнд тэд хэрхэн амьдрах ёстой вэ? “Тиймд та нар газар дээрх эрхтнүүдийг үхүүл” (Колоссай 3:5).

Текст дэх онцгой нарийн ширийн зүйлсийг олж харах¹⁰

Библийн бичигчид текст дэх чухал санааг тэмдэглэхдээ ашигладаг арга техникийг олж таних нь таны судлалд шинэ ойлголтыг авчрах болно. Харах ёстой нарийн ширийн зүйлс нь:

Давтагдсан үгс

Бичигч нэг үгийг ахин дахин давтах нь чухал санааг илтгэнэ. Ажиглалт хийх алхмаар та давтагдсан үгсийн гүн гүнзгий утгыг бүгдийг нь ухааж харахгүй байж болох ч, тухайн үгийг тэмдэглэж аваад “Яагаад энэ үг давтагдсан бэ?” гэж асуух боломжтой.

► Дараах багц эшлэлийг уншаад давтагдсан үгсийг тэмдэглэ:

2 Коринт 1:3-7. Энэ хэсэгт *тайвшрал* гэдэг үг хэдэн удаа давтагдсан бэ? Энэ хэсгийн давталтыг анзаараад та дараах асуултуудыг асуух боломжтой:

- “Тайвшрал” гэдэг үг дурдагдах бүрд адилхан хэрэглэгдсэн үү? (Заримдаа нэр үгээр, заримдаа үйл үгээр бичигдсэн).
- Ямар ямар тодотгох үгсийг ашигласан бэ? (*бүх тайвшрал; бидний тайвшрал; та нарын тайвшрал*).

Иохан 15:1-10. Энэ хэсэгт *дотор байх (орших)* гэдэг үг хэдэн удаа давтагдсан бэ? Энэ хэсгийн давталтыг анзаараад та дараах асуултуудыг асуух боломжтой:

- Түүний дотор байх (*орших*) ямар нөхцөл тавигдаж байна вэ?
- Энэ хэсгийн сэрэмжлүүлэг нь Түүний дотор байхгүй (*орших*) байх боломжтой гэсэн үг үү?
- Түүний дотор байхгүй (*орших*) байхын үр дагавар юу вэ?
- Түүний дотор байхын (*орших*) ерөөл нь юу вэ?

Эсрэгцэл

Библийн олон бичигчид хүмүүс болон аливаа санааг хооронд нь эсрэгцүүлсэн байдаг. Хэрэв та эшлэлийн дунд байгаа “харин, гэвч” гэсэн үгийг харвал энэ нь эсрэг тэсрэг хоёр санааг холбосон байх боломжтой. Олон сургаалт зүйрлэлд энэ төрлийн эсрэгцлийг ашигласан байдаг.

¹⁰ Энэхүү жагсаалтыг J. Scott Duvall ба J. Daniel Hays, *Grasping God's Word* (Grand Rapids: Zondervan, 2012) номоос авсан.

- Шүүмжлэгч нэгэнд хоёр янзаар хариулж болно: “Бодлогогүй яриа нь илдээр дүрэх мэт, **харин** мэргэн хүний хэл илаарьшлыг авчирна” (Сургаалт үгс 12:18).
- Хоёр янзаар төлөвлөж болно: “Ёрын мууг сэдэгсэд төөрөгдөлд хүрэх бус уу? **Харин** сайныг сэдэгсэд хайр энэрэл ба үнэнийг олно” (Сургаалт үгс 14:22).
- Өгөөмөр байх нь ерөөлийг, харин хувиа хичээх нь зовлон зүдгүүрийг авчирдаг: “Ядууст өгдөг хүн хэзээ ч, үл дутагдана. **Харин** нүүр буруулагч хүн олонтоо зүхэгдэнэ” (Сургаалт үгс 28:27).

Шинэ гэрээний бичигчид мөн энэхүү эсрэгцлийг ашигласан байдаг. Паул бидний хуучин амьдрал (харанхуй) болон шинэ амьдралын (гэрэл) ялгааг харуулжээ “Урьд нь харанхуй байсан та нар өдгөө Эзэн дотор гэрэл...” (Ефес 5:8).

1 Иохан 1:5-7-д Иохан харанхуй ба гэрлийг хоёр янзаар эсрэгцүүлсэн байна:

- “Бурхан бол гэрэл, Түүний дотор харанхуй огт үгүй...”
- Бид Бурхантай нөхөрлөвөл харанхуйд биш, харин гэрэлд алхах болно.

Харьцуулалт

Эсрэгцэл нь ялгааг харуулдаг бол, харьцуулалт нь ижил төстэй байдлыг харуулдаг.

- “Залхуу хүн заран илгээгч нартаа шүдэнд орсон цуу, нүдэнд орсон утаа **мэт**” (Сургаалт үгс 10:26).
- “Алс газраас ирэх сайн мэдээ ангасан хүнд хүйтэн ус өгөхтэй **адил**” (Сургаалт үгс 25:25).

► Иаков 3:3-6 эшлэлийг унших. Хэл яриаг ямар гурван зүйлтэй харьцуулсан бэ? Та харьцуулалтаас юу сурч байна вэ?

► Сургаалт үгс 26:7-11 хэсгийн эшлэл болгонд “адил”, “мэт” гэсэн үг оржээ. Эшлэл бүр дэх харьцуулалтыг судал. Жишээлбэл, Сургаалт үгс 26:7-г та хараад: “Мунхгийн аман дахь сургаалт үгс доголон хүний тэгш бус хөлтэй адил” **учир нь** гээд өөртөө хэлж болох юм. Мунхаг хүний хэлсэн сургаалт үг, доголон хүний хөл хоёроос ямар ижил төстэй зүйлийг харж болох вэ?

Жагсаалт (тоочих)

Та Библийг уншиж байхдаа жагсаалтыг тодруулж, чухал шинж чанаруудыг нь судлах хэрэгтэй.

► Хичээлээ үргэлжлүүлэхийн өмнө дараах жагсаалтыг уншицгаая:

- 1 Коринт 3:6-д Паул Коринт дахь үйлчлэлд нь юу юу багтаж байсныг харуулдаг.
- 1 Иохан 2:16-д Эцэгээс бус ертөнцөөс ирдэг зүйлсийг жагсаажээ.
- Галат 5:19-21-д нүгэлт мөн чанарын үйлсийг жагсаасан.
- Галат 5:22-23-д Сүнсний үр жимсийг жагсаасан байна.

Зорилго заасан өгүүлбэр

Ийнхүү, ингэж, ингэснээр, иймд, тулд, зэрэг үгс нь (монгол хэлний өгүүлбэр зүйн бүтцээс шалтгаалж өөр үг, үсгээр илэрхийлэгдэх боломжтой) аливаа үйлийг хийх сэдэл, үйлийн үр дүнг голдуу тодорхойлдог. Зорилго ба үр дүнгийн хоорондох хамаарлыг анхаарахад цаг гаргаарай. Бичвэр яагаад энэ зааврыг өгч байгааг асуу.

- “Та нар Намайг сонгоогүй, харин Би та нарыг сонгосон.” (Яагаад?) “Та нарыг явж, жимс гаргаж, үр жимс чинь үүрд байгаасай **гэсэндээ...**” (Иохан 15:16).
- “Үгийг тань зүрхэндээ би хадгалав,” (Яагаад?) “Таны эсрэг нүгэл хийхгүйн **тулд**” (Дуулал 119:11).
- “Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Христ дотор сонгосон юм” (Яагаад Тэр биднийг сонгосон бэ?) “Түүний өмнө биднийг ариун бөгөөд гэм зэмгүй байлгах**аар...**” (Ефес 1:4).

Бусад тохиолдолд өгүүлбэр нь зорилгоо хэрхэн гүйцэлдүүлэхийг харуулах болно:

- “Залуу хүн зам мөрөө хэрхэн цэврээр хадгалах вэ? Таны үгийг сахисна**ар** хадгална” (Дуулал 119:9).
- Бид амьдралдаа хэрхэн баталгаатай байх вэ? “Харин та нар Сүнс**ээр** биеийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно” (Ром 8:13).

Нөхцөл заасан өгүүлбэр

“Хэрэв” гэж эхэлсэн өгүүлбэрүүд ихэвчлэн нөхцөл заадаг. Заримдаа уншигчид Библийн амлалтуудыг нөхцөл хамаарахгүйгээр биелнэ гэж хүлээдэг. Гэхдээ нөхцөл шаардсан амлалт нь тодорхой нөхцлийг биелүүлэхэд үндэслэгддэг. Энэ нь ихэвчлэн нөхцөл заасан өгүүлбэрээр илэрхийлэгддэг.

Нөхцөл: “Хэрэв та нар Түүнийг хайвал...”

Үр дүн: “Тэрээр та нарт олдоно” (2 Шастир 15:2)

Нөхцөл: “Хэрэв чи өөрийн Бурхан ЭЗЭНд дуулгавартай байвал...”

Үр дүн: “энэ бүх ерөөл чам дээр бууж, чамд хүрнэ” (Дэд хууль 28:2).

Залбиралтайгаар унших

Энэхүү сүүлчийн заавар ойлгомжтой мэт санагдаж болох ч, энэ нь их чухал юм. Христэд итгэгч хүний хувьд Библи судлах болон залбирлын амьдралыг хэзээ ч салгах боломжгүй. Библи унших, залбирахыг салгах нь Бурхантай харилцах өдөр бүрийн ярианыхаа хоёр талыг салган хувааж буй хэрэг юм.

Мэргэн ухаан дутагдсан үед бид Бурханаас тусламж гуйж чадна гэдгийг Иаков батлан хэлсэн байдаг “Харин та нарын хэн нэг нь мэргэн ухаанаар дутвал, бүх хүнд өгөөмрөөр, буруушаалгүй өгөгч Бурханаас гуйг. Тэгээд түүнд өгөгдөх болно” (Иаков 1:5). Энэ нь

Бурханы Үгийг ойлгохын тулд Түүний тусламж хэрэгтэй байх тэр л үед хамгийн гайхалтай амлалт юм.

Дуулал 119-д Бичвэр болон залбирлын хоорондын холбоо хамаарлыг харуулсан байдаг. Дуулаач Бурханы Үгийг судлахдаа чиглүүлэхийг Түүнээс ахин дахин хүсдэг. Үүнтэй адилаар бид суралцаж байхдаа Бурханы тусламжийг эрэлхийлж чадна.


“Таны хуулийн гайхамшигт зүйлсийг надад харуулахаар нүдийг минь нээгээч” (Дуулал 119:18).

“Тушаалуудынхаа замыг ухааруулаач” (Дуулал 119:27).

“Аяа ЭЗЭН, зарлигуудынхаа замыг надад заагаач” (Дуулал 119:33).

Бичвэрийн үгсийг залбирал болгон хэлэхийг олон хүн сурсан байдаг. Эдгээр багц эшлэлийг хувийн залбирал болгон хэлж үзээрэй:

- Дуулал 23 – Бурханы удирдамж ба хамгаалалтын төлөөх залбирал
- Исаиа 40:28-31 – Бурханы хүч чадлын төлөөх залбирал
- Филиппой 4:8-9 – Бурханлаг оюун бодлын төлөөх залбирал



- * Бурхан бол гэрэл, харанхуй бий
- * Бид гэрэлд алхах ёстой, харанхуйд бий
- Δ Түүнтэй нөхөрлөх
- Δ Бие биентэйгээ нөхөрлөх

Давталт: Гэрэл, харанхуй, нөхөрлөх, алхах

Эсрэгцэл: харанхуйд алхах эсвэл гэрэлд явах

Жагсаалт (тогтоох): Бидний (Иохан)... сонссон бөгөөд тунхаглах
Бид... нөхөрлөх, ... Есүсийн цус биднийг... цэвэрлэгдэг.

2-р хичээлийн гол санаанууд

(1) Нэг эшлэлийг судалж, ажиглалт хийх үйл явцыг эхлүүл. Эшлэлтэй холбоотой аль болох олон асуулт асуугаарай.

(2) Ажиглалт хийх чадвараа сайжруулах алхмууд нь:

- Ойлгохын тулд унших.
- Уншиж байхдаа асуулт асуух.
 - Хэн?
 - Юу?
 - Хэзээ?
 - Хаана?
 - Яагаад?
 - Хэрхэн?
- Тухайн номыг эсвэл багц эшлэлээ олон удаа унших.
- Хэлзүйн дүрмийг судлах. Ажиглах үгс:
 - Үйл үг
 - Нэр үг
 - Тодотгол
 - Угтвар үг
 - Холбох үг
- Текст дэх онцгой нарийн ширийн зүйлсийг олж харах. Ажиглах үгс:
 - Давтагдсан үгс
 - Эсрэгцэл
 - Харьцуулалт
 - Жагсаалт (тоочих)
 - Зорилго заасан өгүүлбэр
 - Нөхцөл заасан өгүүлбэр
- Залбиралтайгаар унших.

2-р хичээлийн даалгаврууд

(1) Иошуа 1:8 эшлэл дээр ажиглалтын жагсаалт гаргаарай. Эшлэлийг бичсэний дараа “Хэн? Юу? Хэзээ? Хаана? Яагаад? Хэрхэн?” гэсэн асуултуудыг асууж эхэл. Энэхүү хичээлийн сүүлийн хэсэгт өгсөн жишээ болон зааврыг ашиглан аль болох олон ажиглалт хий. Энэ үе шатанд та эшлэлийг хөрвүүлэх эсвэл номлолын тоймыг хараахан бэлтгэхгүй. Та зүгээр л эшлэл дэх нарийн ширийн зүйлсийг ажиглах юм.

(2) Илүү их дасгал хийхийн тулд Матай 28:18-20 эшлэл дээр ижил үйл явцыг эхлүүл.

3-р хичээл

Ажиглалт: Томоохон хэсгүүдийг харах нь

Хичээлийн зорилго

- (1) Бичвэрийг уншихад хам сэдэв чухал болохыг ойлгох.
- (2) Номд онцолсон нарийн ширийн зүйлсийг ажигласнаар Библийн бичигчдийн зорилго, санаа бодолд улам бүр мэдрэмжтэй хандах.
- (3) Бичвэрийн томоохон хэсгүүдэд ажиглалт хийж дадлагажих.
- (4) Цаашдын судалгаанд зориулж мэдээллийг хүснэгт байдлаар цуглуулах.

Танилцуулга

Зарим уншлага ямар ч ач холбогдолгүй байдаг. Бид аялж явахдаа цаг өнгөрөөхийн тулд роман уншдаг. Зарим уншлага бага ач холбогдолтой байдаг. Бид дэлхий ертөнцөд болж буй зүйлсийн талаар мэдээлэл авахын тулд сонин уншдаг. Гэтэл зарим уншлага мөнхийн ач холбогдолтой байдаг. Бид Бурханы дуу хоолойг сонсохын тулд Библи уншдаг. Бичвэр нь заах, зэмлэх, залруулах, зөвд чиглүүлэхэд тустай хэмээн Паул бичжээ (2 Тимот 3:16-17). Иймд бид Бурханы ярьж буйг сонсохын тулд Библийг анхааралтай уншдаг.

2-р хичээлээр бид эшлэл тус бүр дээр ажиглалт хийсэн. Энэ хичээлээр бид илүү томоохон багц хэсгүүдийг судлах болно. Эдгээр нь догол мөр, бүлэг, эсвэл бүхэл бүтэн ном байх боломжтой. Түүхэн хүүрнэлд томоохон хэсэг нь бүхэл бүтэн түүх байж болно. Сайнмэдээний номуудаас бид сургаалт зүйрлэл, гайхамшиг эсвэл сургаалыг судлах боломжтой. Захидалд томоохон багц хэсэг нь нэг сэдэвт төвлөрсөн хэсэг байж болно.

Библи анх бүлэг, эшлэлд хуваагддаггүй байсан. 13-р зуунд Stephen Langton судалгааг хялбарчлахын тулд Библийг бүлгүүдэд хуваажээ. 16-р зуунд Robert Estienne Библийг эшлэлүүдэд хуваан хэвлэжээ. Бүлэг, эшлэлийн хуваарилалт нь Библи судлахад тусалдаг хэдий ч, тэдгээр нь текстийн төрөлх хуваалттай үргэлж тохироод байдаггүй. Бүлгийн хуваарилалт таны судалгааг хянаж чиглүүлэхэд битгий их анхаарал хандуулаарай. Логик хэсгүүд дэх текстийн төрөлх хуваалтыг дагаарай.

Энэ хичээлээр бид Нехемиа 1:4-11 багц хэсгийг судлах болно. Энэ нь таны цаашдын судалгаанд загвар болно. Бид нэг багц хэсгийг хэд хэдэн аргаар судлах болно. Судалгааны төрлүүд нь ном болгонд харилцан адилгүй байдгийг анзаараарай. Энэ хичээл танд ашиглах багаж хэрэгслийг өгөх болно. Библийн номыг судлахдаа та "Энэ номд аль багаж хэрэгсэл нь хамгийн тохиромжтой вэ?" хэмээн сонгох хэрэгтэй болно.

Багц хэсгийн хам сэдвийг олох нь

Нехемиа 1:4-11:

Энэ үгсийг сонсмогц би доош суун уйлж, хэдэн өдрийн турш гашуудан, тэнгэрийн Бурханы өмнө мацаг барин ийнхүү залбирлаа.

Аяа, тэнгэрийн Бурхан ЭЗЭН минь! Аугаа хийгээд сүрдэм Бурхан минь! Танд хайртай, тушаалуудыг тань сахигч хүмүүст өршөөл ба гэрээгээ сахигч ЭЗЭН минь! Сонор тань соргог, мэлмий тань нээлттэй байж, зарц нар тань болох Израилын хөвгүүдийн өмнөөс, Таны өмнө өдөр шөнөгүй залбирч байгаа зарцынхаа залбирлыг сонсооч. Танд, би болон миний эцгийн гэр тэрсэлсэн. Таны эсрэг тэрсэлсэн өөрсдийн нүглийг болон Израилын хөвгүүдийн гэм нүглийг улайж байна. Зарц Моседоо тушаасан тушаал, зарлиг болон шүүлтийг тань сахиагүй нь бид билээ. Танд хорон хандсан нь бас бид билээ. Зарц Моседоо тушаан айлдсан үгээ Та санаач. Та "Хэрэв та нар үнэнч бус байвал Би та нарыг ард түмнүүдийн дунд тараана. Харин та нар Над руу эргэж, Миний тушаалуудыг сахин мөн үйлдвэл, та нар тэнгэрийн хамгийн алс хэсэгт туугдан тараагдсан байсан ч Би та нарыг тэндээс цуглуулж, нэрээ байлгах гэж Өөрийн сонгосон тэр газартаа аваачна" гэсэн билээ. Таны аугаа хүч болон хүчирхэг мутраараа золин аварсан ард түмэн тань, зарц нар тань тэд билээ.

Эзэн минь ээ! Таны сонор зарцынхаа залбиралд болон нэрийг тань эмээн хүндлэхийг хүсэгч зарц нарынхаа залбиралд соргог байж, зарцдаа зориулан энэ өдрийг амжилттай болгон, энэ хүний өмнө нигүүлслийг олуулаач гэв. Тэгэхэд би хааны сөнч байв.

Багц хэсгийг судлахдаа энэ хэсэг ямар хам сэдэвтэй холбогдож байгааг бид тодорхойлох хэрэгтэй. Нехемиа 1:4 эшлэл нь багц хэсгийн эхлэлийг зааж байна.

Энэ үгсийг сонсмогц би....

"Энэ үгс" гэсэн хэллэг нь Нехемиа **ямар үгсийг** сонсоод ийнхүү хариу үйлдсэнийг мэдэхийн тулд өмнөх эшлэлүүд рүү харахыг шаардаж байна.

Нехемиа 1:1 эшлэл нь Нехемиа номын хам сэдвийг харуулдаг:

Хакалиагийн хүү Нехемиагийн үгс оршвой. Хорьдугаар оны Хислев сард намайг Суса цайзад байх үед...

2-р хичээл дээр бид эшлэлийг судлахдаа асуух асуултуудыг үзсэн.

Хэн? "Хакалиагийн хүү Нехемиа." Энэ номын дараагийн бүлгүүдэд өөр нэг Нехемиа дурдагдсан байдаг (Нехемиа 3:16). Овгийн нэр нь ("Хакалиагийн хүү") энд аль Нехемиагийн тухай ярьж байгааг тодруулж байна.

Хэзээ? "...Хорьдугаар оны Хислев сард." Библийн толь бичгээс үзэхэд Хислев хэмээх еврей сар нь арваннэгдүгээр сараас арванхоёрдугаар сар хүртэлх хугацаатай

тохирдог.¹¹ “Хорьдугаар онд” гэдэг нь бичигч Нехемиагийн амьдралын хорьдугаар жил, ямар нэгэн түүхэн үйл явдлын хорьдугаар жил эсвэл өөр ямар нэгэн зүйлийг хэлж байгаа эсэх нь тодорхойгүй тул бид сайн мэдэх боломжгүй байна. Ийм үед бид энэ хэллэгийн хажууд асуултын тэмдэг тавьж болох юм. Нехемиа 2-р бүлгээс бид хариултыг мэдэх боломжтой “Артаксеркс хааны хорьдугаар оны.” Нехемиа Артаксеркс хааны хаанчлалын хорьдугаар оны арваннэгдүгээр/арванхоёрдугаар сард эхлүүлжээ.

Хаана? Нехемиа "Суса цайзад" байжээ. Библийн толь бичиг эсвэл атласаас үзэхэд Перст хоёр ордон байсныг мэдэж болно. Зуны ордон нь Ек-батана хотод байрладаг байв. Харин өвлийн ордон нь Сусад байх тансаг харш юм. Нехемиаг хаан Артаксеркстэй хамт Суса өвлийн ордонд байгаагаар тус ном эхэлдэг.

Хэрэв та текстийг компьютер ашиглан судалж байгаа бол өгүүлбэр бүрийн хоорондын хамаарлыг харуулахын тулд багц хэсгийг дахин байрлуулах нь тустай байж болно. Ингэснээр багц хэсэг (Нехемиа 1:1) дараах байдалтай харагдана:

Хакалиагийн хүү Нехемиагийн үгс оршвой.
Хорьдугаар оны Хислев сард
намайг Суса цайзад байх үед...

1-р эшлэл Нехемиа номын үйл явдал өрнөх газрыг зааж байна. 2, 3-р эшлэлд Нехемиагийн залбирлын нөхцөл байдлыг харуулж байна. Нехемиаг Сусад байх үед "миний ах дүүсийн нэг болох Ханани, Иудагийн хүмүүстэй хамт ирцгээлээ." Нехемиа хоёр зүйлийн талаар асуусан.

Амь мултрагсад, олзлолоос үлдсэн иудейчүүдийн
талаар мөн Йерусалимын байдлыг
би тэднээс асуулаа.

Хариуд нь Иудагаас ирсэн хүмүүс хоёр асуудлын талаар тайлагнажээ:

- “Олзлолоос үлдэгсэд, аймагтаа туйлын зовлон зүдүүр, басамжлал амсаж.”
- “Йерусалимын ханан хэрэм нурж, гулдан хаалганууд нь галд шатсан гэв.”

Энэ нь Нехемиаг залбирахад хүргэсэн асуудлуудыг харуулж байна. Залбирлын хам сэдвийг судалсны дараа бид тухайн залбирал дээр ажиглалт хийхэд бэлэн болно.

¹¹ *International Standard Bible Encyclopedia*, 'Kislev', 2023 оны 10-р сарын 6-нд хандсан, <https://www.studydrive.net/encyclopedias/eng/isb/k/kislev.html>.

Багц хэсгийг уншихдаа юуг ажиглах вэ?

Нэг багц хэсэгт хийх таны ажиглалт уг хэсгийн бичлэгийн хэв маягаас шалтгаална. Түүхэн хүүрнэлд *хэн, юу, хэзээ, хаана* гэсэн асуултууд багтана. Онол сургаалын хэсэгт зааж сургахтай холбоотой асуултууд багтана.¹²

Нехемиа 1:5-11 эшлэл нь залбирал юм. Түүний залбиралд дараах зүйлс багтсан байна:

- **Магтаал** "Аугаа хийгээд сүрдэм Бурхан... гэрээгээ сахигч" Нэгэнд зориулагджээ.
- **Гэм нүглээ улайх** "Таны эсрэг тэрсэлсэн өөрсдийн нүглийг болон Израилын хөвгүүдийн гэм нүглийг улайж байна."
- Түүний **гуйлт** хүсэлт Бурханы амлалтад үндэслэгджээ. "Харин та нар Над руу эргэж... Би та нарыг тэндээс цуглуулж, нэрээ байлгах гэж Өөрийн сонгосон тэр газартаа аваачна."

Энэ үе шатанд тус багц хэсгийн содон хачирхалтай, нарийн ширийн зүйлсийг тэмдэглэх нь чухал. Нехемиагийн залбирлын дараа түүний намтартай холбоотой нарийн ширийн зүйлсийг өгүүлдэг: "Тэгэхэд би хааны сөнч байв." Энэ нь эхэндээ тийм ч чухал санагдахгүй байж болох ч, хүүрнэл цааш өрнөх тусам энэ нь чухал болно.

Хэрэв бид Библийн толь бичгээс "сөнч" гэсэн үгийг харвал,¹³ сөнч нь зүгээр л зарц биш, харин өндөр албан тушаалтай, хааны итгэлт хүн байсан гэдгийг мэдэх боломжтой.¹⁴

Багц хэсгээс бид ямар зүйлсийг ажиглах хэрэгтэй вэ? Дараах зүйлсийг анзаарна уу:

Ерөнхийгөөс тодорхой руу чиглэх харилцаа

Олон багц хэсэг ерөнхий тойм байдлаар эхэлж, улмаар тодорхой нарийн ширийн зүйлсээр хөгжин дэлгэрүүлэгддэг. Эдгээр нарийн ширийн зүйлс нь ерөнхий агуулгыг цаашид дэмжих байдлаар тайлбарлагддаг.

Ерөнхийгөөс тодорхой руу чиглэх харилцаа нь Паулын захидлуудад түгээмэл тохиолддог. Галат 5:16 эшлэлд Сүнс доторх амьдралыг махбод доторх амьдралтай эсрэгцүүлсэн байдаг. "Харин би та нарт хэлье. Сүнсээр яв, тэгвэл та нар махбодын хүслээ гүйцэлдүүлэх гэхгүй." Энэ ерөнхий агуулгыг цаашид өгүүлэх хэд хэдэн тодорхой санаанууд дэмждэг. Галат 5:19-21 эшлэл нь махбодын үйлсийг тодорхойлдог. Харин Галат 5:22-23 эшлэл нь Сүнсний үр жимсийг тодорхойлдог.

¹² Энэ хэсгийн ихэнх материалыг J. Scott Duvall ба J. Daniel Hays нарын *Grasping God's Word* (Grand Rapids: Zondervan, 2012) номын 4-р бүлгээс авсан.

¹³ *Holman Bible Dictionary*, 'Cupbearer', 2023 оны 10-р сарын 6-нд хандсан, <https://www.studydrive.org/dictionaries/eng/hbd/c/cupbearer.html>.

¹⁴ J. D. Douglas, *New Bible Dictionary*, (2nd edition), (Wheaton: Tyndale House, 1982)

Зарим хүүрнэл ерөнхийгөөс тодорхой руу чиглэсэн хэв маягтай байдаг. Эхлэл 1 ба 2-р бүлэг нь ерөнхий агуулгаас тодорхой нарийн ширийн зүйлс рүү шилжин, энэ хэв маягтай адил бичигдсэн байна. Энэ нь гурван алхмаар явагддаг:

1. Эхлэл 1:1 эшлэл ерөнхий агуулгыг танилцуулж байна: "Эхэнд Бурхан тэнгэр ба газрыг бүтээжээ."
2. Эхлэл 1:3-31 эшлэл нь бүтээлийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг өгдөг. Эхний өдөр Бурхан гэрлийг бүтээсэн. Хоёр дахь өдөр Бурхан усыг тэнгэрээс салгасан гэх мэт.
3. Эхлэл 2-р бүлэг илүү тодорхой зүйлсийг өгүүлдэг. Өгүүлэгч ертөнц хэмээх ерөнхий бүтээлээс хүн хэмээх тодорхой бүтээл рүү шилждэг. Түүх бүхэл бүтэн ертөнцөөс тодорхой газар нутаг болох Еден цэцэрлэгийн сэдэв рүү нарийсдаг. Бурханы нэр хүртэл өөрчлөгддөг. Эхлэл 1-р бүлэгт хүч чадлыг илтгэсэн нийтлэг нэр болох *Бурхан* гэдэг нэрийг ашигласан. Харин Эхлэл 2-р бүлэгт *ЭЗЭН Бурхан* гэдэг нэрийг ашигласан бөгөөд энэ нь Адам Ева хоёртой харилцах Түүний ойр дотно харилцааг харуулсан хувийн нэр юм.¹⁵

Бичлэгийн энэ хэв маяг нь ихэвчлэн ерөнхийгөөс тодорхой руу шилждэг. Заримдаа эсрэгээрээ, тодорхойгоос ерөнхий рүү шилждэг. 1 Коринт 13-р бүлэгт Паул 1-12-р эшлэлд хайрын талаарх тодорхой шинж чанаруудыг өгүүлсэн байдаг. Харин тус бүлэг Паулын сургаалыг нэгтгэн дүгнэсэн "Эдүгээ итгэл, найдвар, хайр гурав үлддэг ч хамгийн агуу нь хайр мөн" гэсэн ерөнхий агуулгаар төгсдөг.

Асуулт ба хариултын хэсгүүд

Хэрэв багц хэсэг асуултаар эхэлж байгаа бол асуулт нь тухайн багцлалын үлдсэн хэсгийн ач холбогдлыг харуулдаг. Ром номд энэ хэв маяг түгээмэл гардаг. Нигүүлсэл нь нүгэлт амьдралын хэв маягийг зөвтгөдөг гэж маргадаг хүмүүст Паул "Тэгвэл бид юу гэх вэ? Нигүүлслийг ихэсгэх гээд бид нүгэлдээ байсаар байх уу?" (Ром 6:1) хэмээн асуусан байдаг. Дараа нь тэрээр Бурханы нигүүлсэл нь Христэд итгэгч хүнд нүглийг ялах хүч өгдөгийг баталж, "Огт үгүй! Нүглийн хувьд үхсэн бид цаашид яахан түүн дотроо амьдрах билээ?" (Ром 6:2) хэмээн хариулсан.

Маркийн Сайнмэдээ энэ бүтцийг байнга ашигладаг. Марк 2:1–3:6 нь таван хэсэг асуултаар эхэлсэн байдаг. Дөрвөн удаа эсэргүүцэгчид асуулт тавьсан. Тэр болгонд Есүс өмгөөлж хариулсан байдаг. Сүүлчийн хэсэгт Есүс фарисайчуудын хариулах боломжгүй асуултыг асуусан. Энэ нь томоохон хэсэгт ямар бүтэц бий болгож байгааг анзаараарай. Үүнгүйгээр бид таван тусдаа түүхийг унших байсан. Асуулт, хариултаар бүрэлдсэн

¹⁵ Еврей хэлний *Элохим* гэдэг нэрийг англи Библиүдэд *Бурхан* хэмээн орчуулдаг. Энэ нь бүх дэлхийг хамарсан, эрхэмсэг нэр юм. Еврей хэлний *Иавэ* гэдэг нэрийг англи Библиүдэд "*ЭЗЭН*" гэж орчуулдаг. Энэ нь Гэтлэл 3:14 эшлэлд илчлэгдсэн Түүний хувийн нэр юм.

бүтцийг харах үед энэхүү таван түүх нь Хүний Хүүд аврах эрх мэдэл байгааг гэрчлэн харуулдаг.

1. Саа өвчтэй хүнийг эдгээсэн (Марк 2:1-12)

Асуулт: "Гагцхүү Бурханаас өөр хэн нүглийг уучилж чадах билээ?"

Хариулт: Есүс саа өвчтэй хүнийг эдгээж эрх мэдлээ харуулсан.

2. Нүгэлтнүүдтэй хамт хооллосон (Марк 2:13-17)

Асуулт: "Тэр яагаад татвар хураагчид ба нүгэлтнүүдийн хамт хооллож байдаг билээ?"

Хариулт: "Би зөвтийг бус, нүгэлтнүүдийг дуудахаар ирсэн юм гэлээ."

3. Мацаг барих нь (Марк 2:18-22)

Асуулт: "Иоханы шавь нар ба фарисайчуудын шавь нар байнга мацаг барьдаг, харин Таны шавь нар яагаад мацаг барьдаггүй юм бэ?"

Хариулт: "Хүргэнтэй хамт байхдаа тэд мацаг барьж болохгүй."

4. Амралтын өдрийн хууль (Марк 2:23-28)

Асуулт: "Хараач, тэд яагаад Амралтын өдөр хууль бусыг үйлдэнэ вэ?"

Хариулт: "Хүний Хүү Амралтын өдрийн Эзэн мөн."

5. Амралтын өдөр эдгээх нь (Марк 3:1-6)

Асуулт: "Амралтын өдөр сайныг үйлдэх эсвэл мууг үйлдэхийн... аль нь хуульд нийцэх вэ?"

Хариулт: Есүсийг эсэргүүцэгчид хэлэх үггүй болжээ.

Харилцан яриа

Сайнмэдээний номуудад Есүс болон түүний эргэн тойрны хүмүүс хоорондын яриаг олонтоо дүрсэлсэн байдаг. Дараах асуултуудыг тавьснаар бид Есүсийн сургаалыг илүү сайн ойлгох боломжтой:

- Харилцан ярианд хэн хэн оролцож байна вэ?
- Харилцан яриаг ямар ажиглагчид сонсож байна вэ? Тэд хэрхэн хариулж байна вэ?
- Ямар зөрчил эсвэл нөхцөл байдлын улмаас харилцан яриа үүсэх болов?

Матай 21:23–22:46-д Есүс болон Түүнийг эсэргүүцэгчдийн хоорондын цуврал харилцан яриаг өгүүлсэн. Хэсэг бүлэг хүмүүс тус бүрдээ Есүсийг унагах зорилготой асуултуудыг тавьжээ.

- Эхлээд шашны удирдагчид Түүний эрх мэдлийн талаар асуусан (Матай 21:23-46).
- Фарисайчууд болон Херодын талынхан (ихэвчлэн бие биедээ дайсагнадаг) татварын талаар асуулт тавьж, Түүнийг унагахын тулд нэгдэцгээв (Матай 22:15-22).
- Саддукайчууд (амиллыг үгүйсгэдэг) амиллын дараах гэрлэлтийн талаар асуулт тавьжээ (Матай 22:23-32).
- Фарисайчууд тушаалуудын талаар асуулт тавьж, дахин туршив (Матай 22:34-40).
- Эцэст нь Есүс тэдний хариулж чадахгүй асуултыг тавьж, мэтгэлцээнийг дуусгав (Матай 22:41-46).

Олон түмэн тэдгээр хэсэг бүлэг хүмүүс Есүсийг хуурахаар оролдож буйг болон Есүс асуусан болгоныг хэлэх үггүй болгож байгааг харж байлаа. “Үүнийг сонсоод ард олон, сургаалыг нь гайхаж байлаа” (Матай 22:33).

Харилцан яриа нь Иов номыг ойлгоход чухал ач холбогдолтой. Энэ номд Бурхан ба Сатан, Иов ба түүний найзууд, Иов ба Бурханы хоорондох харилцан яриаг өгүүлдэг.

Хабаккук ном бүхэлдээ эш үзүүлэгч болон Бурханы хоорондох харилцан ярианаас бүрддэг. Ном нь дараах бүтэцтэй байна:

Хабаккукын асуулт: Бурхан Иудагийн нүглийг яагаад тэвчдэг вэ (1:1-4)?

Бурханы хариулт: Вавилон Иудаг ялах болно (1:5-11).

Хабаккукын асуулт: Бурхан Иудаг шүүхдээ бузар муу Вавилоныг хэрхэн ашиглах вэ (1:12-2:1)?

Бурханы хариулт: Хабаккук Бурханы зорилго дотор итгэлээр амьдрах ёстой (2:2-20).

Сэтгэл хөдлөлийн өнгө аяс

Сэтгэл хөдлөлийн өнгө аяс гэдэг нь бичигчийн илэрхийлж буй сэтгэл хөдлөлийг хэлнэ. Бичвэр нь хийсвэр мэдээллээс илүүтэйгээр хайрладаг Бурхан болон Түүний бүтээсэн хүмүүс хоорондын харилцааны түүх юм. Ийм дотно харилцаанд сэтгэл хөдлөл багтдаг. Анхааралтай уншигчид бичигчийн сэтгэл хөдлөлд анхаарал хандуулдаг.

Багц хэсгийн сэтгэл хөдлөлийн өнгө аясыг олохын тулд сэтгэл хөдлөл (баярлах, жигших, уйлах) эсвэл харилцааг (эцэг, хүү, охин) илэрхийлсэн үгсийг анзаараарай. Бичигчийн болон хүүрнэл дэх дүрүүдийн сэтгэл хөдлөлийг сонсоорой.

► Филиппой 1:1-8 болон Галат 1:1-9 хэсгийг унших. Багц хэсэг бүрийн сэтгэл хөдлөлийн өнгө аяс ямар байна вэ? Эдгээр танилцуулга хэсгээс Паул Филиппой болон Галат дахь чуулгануудтай ямар харилцаатай байсныг та юу гэж дүгнэх вэ?

Номыг бүхэлд нь уншихад юуг анхаарах вэ?

Номыг бүхэлд нь уншихад бид тухайн номын бүтэц, гол сэдвүүдийг анхаардаг. Энэ үе шатанд дараах зүйлсийг ажиглах боломжтой:

Онцолсон зүйлс

Номд юуг онцолсныг бид дараах зүйлсийг ажигласнаар олж мэдэж болно:

Эзлэх хэмжээ

Номд ямар нэгэн сэдвийн эзлэх хэмжээ нь бичигчийн хувьд юу чухал болохыг ихэвчлэн харуулдаг. Эхлэл номын 12-50-р бүлэгт дөрвөн хүний (Абрахам, Исаак, Иаков, Иосеф) талаар өгүүлдэг. Үүнийг Бүтээл, Уналт, Их үер, Бабелын цамхагийн талаарх бүх түүхийг хамруулсан 11 бүлэгтэй харьцуулж болох юм. Ажиглалт хийх үе шатанд эдгээр нарийн ширийн зүйлсийг анзаарах нь хөрвүүлгийн үе шатанд "Яагаад?" гэсэн асуултыг тавихад биднийг бэлтгэх болно.

Нехемиа номыг уншихдаа залбирал энэ номд гол байр суурь эзэлдгийг анзаарч хардаг. Нехемиагийн амьдралын чухал үе шат бүрд тэрээр залбирч байлаа. Үүнийг анзаарснаар бид Нехемиагийн зан чанарыг илүү сайн ойлгох боломжтой.

Зорилгоо дурдсан

Зарим номын бичигч нь бидэнд бичих болсон зорилгоо дурдсан байдаг. Соломон мэргэн ухааны цоморлогоо бичих болсон зорилгынхоо талаар Сургаалт үгс номын эхэнд нэлээн урт өгүүлбэрээр бичсэн байдаг (Сургаалт үгс 1:2-6). Иохан Сайнмэдээгээ бичсэн зорилгоо дурдсан байдаг: "Есүс бол Христ, Бурханы Хүү мөн гэдэгт та нарыг итгээсэй гэсэндээ эдгээр нь бичигдсэн юм. Тийнхүү итгэснээрээ та нар Түүний нэрээр амьтай болох юм" (Иохан 20:31).

Материалын дэс дараа

Түүхэн хүүрнэлд материалын дэс дараа нь бичигчийн зорилгыг харуулж болно. 2 Самуел 1-10 хэсэг нь Давидын ялгуусан хаанчлалын түүхийг хүүрнэдэг. 2 Самуел 11-р бүлэгт Давидын Батшебатай үйлдсэн нүглийг тэмдэглэжээ. Тэр үеэс эхлэн 2 Самуел ном нь Давидын хаанчлалд тохиолдсон зовлон бэрхшээлүүдийг өгүүлсэн. 2 Самуел номын бичигч эдгээр зовлон бэрхшээлүүдийг Давидын нүглийн төлөөх Бурханы шүүлт болохыг харуулдаг.

Нехемиа ном гурван том хэсэгт хуваагддаг. Нехемиа 1-6-д Нехемиа хотын хэрмийг сэргээн босгодог. Нехемиа 7-12-р бүлэгт Йерусалимд буцаж ирсэн цөлөгдөгсдийн жагсаалтыг гаргаж, гэрээг шинэчлэх талаар өгүүлсэн. Нехемиа 13-р бүлэгт Нехемиагийн Йерусалимд хоёр дахь удаагаа буцаж ирсний дараа тохиолдсон асуудлуудыг хөнддөг. Энэхүү дэс дараа нь хэрмийг бодитоор сэргээн босгох ажил нь хангалтгүй болохыг харуулдаг. Иуда цөлөгдөхөд хүргэсэн анхдагч асуудлуудыг шийдвэрлэхийн тулд сүнслэг сэргэлт хэрэгтэй байжээ.

Давтагдаж буй зүйлс

Библийн бичигч материалаа онцлох өөр нэг арга нь давталт юм.

Давтагдсан нэр томъёо ба хэллэгүүд

"Санах" гэдэг үг Нехемиа номд бүхэлдээ давтагддаг. Нехемиа Бурханд "Зарц Моседоо тушаан айлдсан үгээ Та санаач" (Нехемиа 1:8) хэмээн залбирсан. Йерусалимын хүмүүс аюулд өртөхөд Нехемиа тэднээс "Аугаа, аюумшигт ЭЗЭНийг сана" (Нехемиа 4:14) гэж хүсдэг. Нехемиа өөрийг нь болон өөрийнх нь итгэмжит байдлыг санахыг гурван удаа Бурханаас хүсэн залбирсан. Дурсан санах нь Нехемиагийн хувьд чухал байжээ. Бурханы өнгөрсөнд хийсэн зүйл нь ирээдүйд Бурханы итгэмжит байдалд найдах итгэлийг өгдөг.

► Дуулал 119:1-32-ыг унших. Бурханы Үгийн талаар хэлсэн ямар нэг нэр томъёог эшлэл бүрд ашиглажээ. Үүнд үндэслэн дуулаачийн хувьд Бурханы Үг ямар чухал байсан, тэр үүний талаар юу гэж итгэдэг байсныг жагсаан бич.

Дахин дурдагддаг дүрүүд

Үйлс номын гол хэсгүүдэд Барнаб дахин дахин дурдагддаг. Барнабыг дурдах болгонд тэрээр "Тайвшралын хүү" (Үйлс 4:36) хэмээх хочтойгоо нийцсэн амьдралаар амьдарч байгааг хардаг. Барнаб Саулыг элч нарын өмнө авчирч, Саулын итгэлд ирсэн үнэнийг гэрчилдэг (Үйлс 9:27). Барнаб Саултай хамт Антиох дахь чуулганыг бэхжүүлдэг (Үйлс 11:22-26). Паул эргэлзэж байсан ч, Барнаб залуу хүү Иохан Маркийг урамшуулдаг (Үйлс 12:25 ба Үйлс 15:36-39). Барнаб Үйлс номд дахин дахин дурдагдсан нь анхны чуулган хэрхэн итгэгчдийг дагалдуулах Есүсийн захирамжийг биелүүлж байсныг харуулдаг.

Давтагдсан үйл явдал ба нөхцөл байдал

Шүүгчид номд Иошуагийн удирдлага дор агуу ялалтуудыг байгуулж байсан Израилын уналт нийгмийн эмх замбараагүй байдал хүртлээ доройтсон тухай цуврал түүхүүдийг хүүрнэдэг. Израилын хөвгүүд ЭЗЭНий өмнө бузар мууг үйлдэж, дайснууддаа ялагдсан мөчлөг долоон удаа давтагддаг. Тэр болгонд тэднийг аврах шүүгчийг Бурхан босгож байлаа. Энэхүү дахин давтагдах түүх нь үндэстэн аажмаар унаж доройтсоор байсныг харуулдаг.

Чиглэл өөрчлөгдөх

Чиглэл өөрчлөгдөх нь бичигчийн онцлох зүйл өөрчлөгдөхийг хэлнэ. Жишээлбэл, Паулын захидлуудын чиглэл номын дунд хэсэг ойртох үед ихэвчлэн өөрчлөгддөг. Ефес захидал нь Бурхан өөрийн хүмүүсийн төлөө хийсэн зүйлийг онцлох байдлаар эхэлдэг. Ефес захидлын хоёр дахь хэсэг нь Бурханы хүмүүс Түүнд дуулгавартай байж, юу хийх ёстой талаар онцолдог.

Ефес 1-3-р бүлэгт Бурхан өөрийн хүмүүсийн төлөө хийсэн зүйлийг хэд хэдэн үйл үгээр тодорхойлсон байдаг. Бурхан:

- Биднийг ерөөсөн (Ефес 1:3, 6)
- Биднийг сонгосон(Ефес 1:4)
- Биднийг аврахаар төлөвлөсөн (Ефес 1:5)

Ефес 4:1 эшлэлээс эхлэн Паул итгэгчдэд бидний төлөө хийсэн Бурханы авралын үйлсэд зүй зохистой амьдрахыг сануулан бичжээ. Ефес 4-6-р бүлгийн ихэнх үйл үг нь тушаах хэлбэрт байна. Паул бидэнд тушаахдаа:

- Үнэнийг ярь (Ефес 4:25)
- Бурханы Ариун Сүнснийг бүү гашуудуул (Ефес 4:30)
- Хайр дотор яв (Ефес 5:2)
- Хэрхэн алхаж буйгаа хянаж бай (Ефес 5:15)
- Эцэг эхээ хүндэл (Ефес 6:2)
- Бурханы өвч бүрэн зэвсгийг агс (Ефес 6:11)

Бурханы бидний төлөө хийсэн зүйлд баярлах чиглэлээс Түүний нигүүлсэлд хариу үзүүлэн хэрхэн амьдрах ёстой чиглэлийг заасан энэхүү өөрчлөлтийг үйл үгсээс харах боломжтой. Ийм өөрчлөлтүүдийг сайтар ажиглах нь биднийг Ефес захидал дахь Паулын сургаалыг зөвөөр хөрвүүлэхэд бэлтгэх болно.

Утга зохиолын бүтэц

Номыг зохион байгуулах олон янзын арга байдаг ч гурван төрлийн утга зохиолын бүтэц нь танихад хялбар юм.¹⁶

Намтарчилсан бүтэц

Түүхэн номууд нь ихэвчлэн тодорхой хүмүүсийн эргэн тойронд өрнөж буй үйл явдлыг хүүрнэдэг. Хүүрнэл нь хүний амьдралд тохиолдсон үйл явдалд үндэслэгддэг. Жишээлбэл:

¹⁶ Энэ материалыг Howard G. Hendricks ба William D. Hendricks нарын, *Living by the Book* (Chicago: Moody Publishers, 2007) номын 15-р бүлгээс авсан.

Эхлэл 12-50: Дөрвөн агуу хүн	
Бүлэг	Хүн
Эхлэл 12-25	Абрахам
Эхлэл 25-26	Исаак
Эхлэл 27-36	Иаков
Эхлэл 37-50	Иосеф

1 ба 2 Самуел ном нь Израилын анхны хоёр хаан болох Саул, Давид нарын өсөлт, бууралтыг дэлгэрүүлэн өгүүлдэг.

1 ба 2 Самуел: Израилын анхны хаад	
Бүлэг	Хаадын өсөлт/бууралт
1 Самуел 1-8	Эш үзүүлэгч Самуел
1 Самуел 9-12	Саулын өсөлт
1 Самуел 13-31	Саулын уналт ба Давидын өсөлт
2 Самуел 1-10	Давидын амжилтууд
2 Самуел 11-24	Давидын асуудлууд

Газарзүйн бүтэц

Газарзүй нь зарим номын бүтцийг бий болгодог. Өөр өөр газарзүйн байршилд үйл явдлууд өрнөж байгаагаар түүхийг өгүүлсэн байдаг. Библийн атлас эдгээр номын бүтцийг тоймлоход туслах болно.

Гэтлэл: Израилчуудын аялал	
Багц хэсэг	Байршил
Гэтлэл 1:1-3:16	Египет дэх Израил
Гэтлэл 13:17-18:27	Цөл дэх Израил
Гэтлэл 19-40	Синаи уулан дахь Израил

Есүс дагалдагч нартаа "Йерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаарт хүртэл" (Үйлс 1:8) Түүнийг гэрчлэхийг тушаасан. Анхны чуулган энэхүү захирамжийг хэрхэн биелүүлснийг Үйлс номд дэлгэрүүлэн өгүүлдэг.

Үйлс: Сайнмэдээ дэлхий даяар түгсэн	
Бүлэг	Байршил
Үйлс 1-7	Йерусалим
Үйлс 8-12	Иудей, Самари
Үйлс 13-28	дэлхийн хязгаарт хүртэл

Түүхэн ба он цагийн бүтэц

Зарим ном гол түүхэн үйл явдлуудаар, ихэвчлэн он цагийн дарааллаар бичигдсэн байдаг. Эдгээр үйл явдлуудыг тэмдэглэх нь номын тоймыг тодруулдаг.

Иошуа ном Канааныг эзлэн, суурьшсан үйл явдлыг дэлгэрүүлдэг. Иошуа номын бүтэц нь эзлэн авах үйл явдлын үндсэн дарааллаар бичигдсэн.

- Канаанд нэвтэрсэн (Иошуа 1–5)
- Иерихог эзэлсэн (Иошуа 6)
- Аи дахь ялагдал (Иошуа 7–8)
- Шехемд гэрээг шинэчилсэн (Иошуа 9)
- Өмнөд нутгийг байлдан дагуулсан (Иошуа 10)
- Хойд нутгийг байлдан дагуулсан (Иошуа 11–12)
- Газрыг хуваарилж, суурьшсан (Иошуа 13–23)
- Шехемд гэрээг шинэчилсэн (Иошуа 24)

Иоханы Сайнмэдээг бичих болсон зорилгыг номын төгсгөлд дурдсан байдаг. “Энэ номд бичигдээгүй өөр олон тэмдгийг Есүс шавь нарынхаа өмнө үйлдсэн юм. Есүс бол Христ, Бурханы Хүү мөн гэдэгт та нарыг итгээсэй гэсэндээ эдгээр нь бичигдсэн юм. Тийнхүү итгэснээрээ та нар Түүний нэрээр амьтай болох юм” (Иохан 20:30-31). Иоханы Сайнмэдээ нь үүнийг бичсэн зорилгыг гүйцэлдүүлэх долоон тэмдэг гайхамшгийн эргэн тойронд өрнөх байдлаар бичигджээ. Эдгээр долоон тэмдэг нь бүхэл бүтэн номын бүтцийг бүрдүүлдэг:

- Усыг дарс болгосон (Иохан 2:1-12)
- Түшмэлийн хүүг эдгээсэн (Иохан 4:46-54)
- Бетзадад нэгэн хүнийг эдгээсэн (Иохан 5:1-47)
- 5000 хүнийг хооллосон (Иохан 6:1-4)
- Усан дээгүүр алхсан (Иохан 6:15-21)
- Төрөлхийн хараагүй хүнийг эдгээсэн (Иохан 9:1-41)
- Лазарыг үхлээс амилуулсан (Иохан 11:1-57)

Том зургаар харах нь

Энэ хүртэл бид эшлэл бүр дээр томоохон багц хэсэг болон бүхэл бүтэн номыг хамруулан нарийн ширийн зүйлсийг ажигласан.¹⁷ Ажиглалт хийх үе шатны сүүлчийн алхам нь ашиглахад хялбар байдлаар ажиглалтуудаа зохион байгуулах юм. Үүнийг хийх хамгийн сайн аргуудын нэг бол материалыг хураангуйлж, хүснэгтэд оруулах. Энэ нь Бичвэрийн томоохон хэсгүүд хоорондын дотоод холбоо хамаарлыг харуулдаг. Мөн Библи судлалын хөрвүүлгийн үе шатанд бэлтгэхэд энэхүү тодорхой хураангуй нь ашиг тустай.

Энэ хүснэгтийг олон янзаар хийж болно. Хүснэгтэд багтсан ангилал нь таны судалж буй багц хэсгийн бичлэгийн хэв маягаас шалтгаална. Энэ хэсэгт бид Библи судлалд хүснэгт ямар ашиг тустай болохыг харуулж, хэд хэдэн төрлийн хүснэгтийг ашиглах болно.

Хоорондоо холбоотой үйл явдлуудыг харуулах хүснэгт

Өмнө дурдсанчлан бүлгээр хуваасан байдал нь номын бүтэцтэй үргэлж тохироод байдаггүй. Үйл явдлын харилцаа хамаарлыг харуулсан хүснэгт нь олон бүлгийг хамарсан дараалсан үйл явдлуудын нэгдмэл байдлыг харуулах боломжтой. Энэ нь ихэвчлэн үйл явдал хоорондын харьцуулалт эсвэл эсрэгцлийг харуулдаг.

Марк 4:35—Марк 5:42 хэсэгт дараалсан дөрвөн гайхамшгийг танилцуулдаг. Хэрэв та эдгээр дөрвөн түүхийг харьцуулж үзвэл, түүхүүд нь шуурга дэгдэх үеийн Есүсийн дагалдагчдын итгэлгүй байдлыг бусад санаанд оромгүй хүмүүсийн (чөтгөрт эзэмдүүлсэн хүн, цус алддаг өвчтэй эмэгтэй, синагогийн захирагч) итгэлтэй эсрэгцүүлснийг харж болно. Дагалдагч нар эдгээр агуу итгэлийн түүх тус бүрийн гэрч байсныг Марк харуулжээ. Эдгээр дөрвөн түүхийг зэрэгцүүлэн хараарай:

¹⁷ Энэ хэсгийн материал нь Howard G. Hendricks ба William D. Hendricks нарын, *Living by the Book* (Chicago: Moody Publishers, 2007) номын 24-25-р бүлгүүдэд үндэслэгдсэн.

Дөрвөн гайхамшиг		
Гайхамшиг	Хүүрнэлд дурдсан хүмүүс	Итгэлийн үүрэг оролцоо
Шуургыг намжаасан	<ul style="list-style-type: none"> • Есүс • Дагалдагчид 	Дагалдагч нарт итгэл байсангүй (Марк 4:40).
Чөтгөрт эзэмдүүлсэн хүнийг эдгээсэн	<ul style="list-style-type: none"> • Есүс • Чөтгөрт эзэмдүүлсэн хүн • Тосгоны хүмүүс • Дагалдагчид (ажиглаж буй) 	<ul style="list-style-type: none"> • Тэр хүн Есүсийг мөргөн хүндэлж (Марк 5:6), Есүсийг гэрчлэн ярьсан (Марк 5:18-20). • Тосгоны хүмүүс Есүсийг үгүйсгэсэн (Марк 5:10)
Цус алддаг өвчтэй эмэгтэйг эдгээсэн	<ul style="list-style-type: none"> • Есүс • Эмэгтэй • Дагалдагчид (ажиглаж буй) 	Эмэгтэйд итгэл байсан бөгөөд тэрээр Есүст хүрэхийг зорьсон (Марк 5:28, 34).
Иаирын охиныг амилуулсан	<ul style="list-style-type: none"> • Есүс • Иаир ба түүний охин • Гашуудагчид • Петр, Иаков, Иохан 	Иаирд итгэл байсан (Марк 5:23).

Таны ээлж

Матай 13:1-23 эшлэлд үндэслэн хүснэгт бэлтгэ.


1. Хүүрнэлийг гурван удаа унш.
2. Өөрийн олж чадах бүх ажиглалтыг тэмдэглэ.
3. Сургаалт зүйрлэлийн үндсэн санааг хүснэгтэд оруул.

Хүснэгт нь зорилго биш гэдгийг санаарай. Харин энэ нь Бурханы Үгийг судалж, амьдралдаа хэрэгжүүлэхэд танд туслах хэрэгсэл юм. Библи судлалын зорилго нь хувьсан өөрчлөгдөх юм. Энэ сургаалт зүйрлэлийг судлахдаа "Би ямар төрлийн хөрс вэ? Бурханы Үг амьдралд минь үр жимс ургуулахыг би зөвшөөрч байна уу?" гэж асуугаарай.

Матай 13:1-23 – Хөрсний талаарх сургаалт зүйрлэл			
Хөрсний төрөл	Өсөлт	Өсөлтийн саад	Үр дүн
Зам	Өсөлтгүй – үр нь авагдсан	Үнэнийг ухаарах ойлголт байхгүй. Хөрс нь хэтэрхий хатуу	Үр жимсгүй

Таны ээлж

Марк 5:21-43 эшлэлийг унших. Энэ нь хоёр гайхамшгийг агуулсан нэг хүүрнэл юм. Цус алддаг өвчтэй эмэгтэйн түүх нь Иаир болон түүний охины түүхийг зааглаж байна. Эдгээр хоёр хүүрнэлийн харьцуулалт ба эсрэгцэл нь юу вэ? Бүтэц нь дараах байдалтай байна:



Марк 5:21-43: Харьцуулалт ба эсрэгцэл		
	Иаир	Цус алддаг өвчтэй эмэгтэй
Харьцуулалт	Агуу итгэлийг харуулсан	Агуу итгэлийг харуулсан
Эсрэгцэл	Эрх мэдэлтэй хүн	Нэр хүндгүй эмэгтэй
	Олон нийтийн өмнө Есүст хандсан	Хувьчлан Есүст хандсан

Бүтэн номын хүснэгт

Хүснэгт нь бүтэн номыг хураангуйлахад тустай байж болно. Энэ нь номын том зураглалыг харуулдаг. Хүснэгт бэлтгэхийн тулд номыг бүтнээр нь хэд хэдэн удаа уншаарай. Томоохон багц хэсгүүдийг хайж ол. Унших явцдаа давтагдсан үгс, асуулт хариулт болон номын бүтцийг харуулсан бусад харилцаа хамаарлыг тэмдэглээрэй.

1 Петр номыг судлах - Зовж буй ариун хүмүүсийг урамшуулах нь		
Аврал (1:1–2:10)	Захирагдах (2:11–3:12)	Зовлон (3:13–5:11)
<ul style="list-style-type: none"> • Авралын ерөөлүүд • (1:2-12) • Авралын бүтээгдэхүүн (1:13-25) • Авралын үйл явц • (2:1-10) 	<ul style="list-style-type: none"> • Төр засагт (2:13-25) • Гэр бүлдээ (3:1-12) 	<ul style="list-style-type: none"> • Иргэний хувьд (3:13–4:6) • Итгэгчийн хувьд (4:7-19) • Хоньчны хувьд (5:1-11)
Христэд итгэгчийн хувь тавилан	Христэд итгэгчийн үүрэг	Христэд итгэгчийн сахилга бат

1 Петр захидлын гурван томоохон хэсэг нь хоорондоо холбоотой. Бид Эцэгийн хүсэлд захирагдах хүртэл (2:11–3:12) зовлонг хэзээ ч ойлгохгүй (3:13–5:11). Бид Түүний аврах хүчийг мэдэхээс нааш (1:1–2:10) Эцэгт хэзээ ч захирагдаж чадахгүй.

Таны ээлж

Ефес захидлыг судлах хүснэгт бэлтгэ. Энэ хүснэгт нь танд Паулын захидалд өгүүлсэн дөрвөн сэдвийг харахад туслах болно. Нэг жишээ өгөгдсөн. Хийж дуусгаад дараах асуултыг асуугаарай:

- Сэдэв бүрийн хоорондын харилцаа хамаарал нь юу вэ?
- Эдгээр сэдвүүдийн аль нэг нь бусдаасаа илүү давамгайлж байна уу?
- Сэдэв бүр номын ерөнхий бүтэцтэй хэрхэн холбогдох вэ?

Сэдэв	Сэдвийн эшлэл	Паулын сургаалын хураангуй
Нигүүлсэл		
Сатан	2:1-2	
Бидний алхаа		
Залбирал		

3-р хичээлийн гол санаанууд

(1) Та багц хэсэг, дараа нь бүхэл бүтэн номыг судалснаар ажиглалт хийх үйл явцыг үргэлжлүүлнэ. Библи анх бүлэг, эшлэлд хуваагддаггүй байсан. Текстийг судлахдаа төрөлх хуваалтыг дагаж буй эсэхээ сайтар шалгаарай.

(2) Багц хэсгийг уншихдаа дараах зүйлсийг ажиглана:

- Ерөнхийгөөс тодорхой руу чиглэх харилцаа
- Асуулт ба хариултын хэсгүүд
- Харилцан яриа
- Сэтгэл хөдлөлийн өнгө аяс

(3) Бүтэн номыг уншихдаа дараах зүйлсийг ажиглана:

- Онцолсон зүйлс. Бичигч дараах зүйлсээр онцлон харуулж болно:
 - Эзлэх хэмжээ
 - Зорилгоо дурдсан
 - Материалын дэс дараа
- Давтагдаж буй зүйлс
 - Давтагдсан нэр томъёо ба хэллэгүүд
 - Дахин дурдагддаг дүрүүд
 - Давтагдсан үйл явдал ба нөхцөл байдал
- Чиглэл өөрчлөгдөх.
- Утга зохиолын бүтэц.
 - Намтарчилсан бүтэц
 - Газарзүйн бүтэц
 - Түүхэн ба он цагийн бүтэц

(4) Бичвэрийн хэсэг болон бүтэн номын хүснэгт хийх нь бүтцийг тодруулахад тусалдаг.

3-р хичээлийн даалгавар

1-р хичээл дээр та энэ курсын туршид судлах Бичвэрийн багц хэсгийг сонгосон. Энэ хичээлээр үзсэн алхмуудын дагуу сонгосон Бичвэр дээрээ аль болох олон ажиглалт хийгээрэй. Та эшлэлийг хөрвүүлэх эсвэл номлолын тоймыг хараахан бэлтгэх болоогүй гэдгээ санаарай. Та тухайн хэсгийн нарийн ширийн зүйлсийг ажиглах үе шатанд байна. Хэрэв танд ашиг тустай бол ажиглалтаа нэгтгэсэн хүснэгт бэлтгээрэй. Хэрэв та бүлгээр судлал хийж байгаа бол дараагийн уулзалтаар ажиглалтаа хуваалцана уу.

4-р хичээл

Хөрвүүлэг: Танилцуулга

Хичээлийн зорилго

- (1) Бичвэрийг зөв хөрвүүлэхийн ач холбогдлыг ойлгох.
- (2) Библийн хөрвүүлэг хийхэд тулгардаг бэрхшээлийг таних.
- (3) Буруу хөрвүүлэг хийхэд хүргэж болзошгүй нийтлэг алдааг мэдэж авах.
- (4) Библийн хөрвүүлэг хийх өөр өөр үзэл бодлыг хүндэтгэх, даруу байдлыг сахих.

Танилцуулга

1-р хичээл дээр гарсан Самуелын жишээг санаж байна уу? Самуел өдөр бүр Библи уншдаг байсан ч уншсан зүйлээсээ Бурханы дуу хоолойг сонсдоггүй байжээ. Юу буруу байсан бэ? Самуелд уншсанаа хөрвүүлэх үйл явц байгаагүй. Тэр уншдаг ч ойлгодоггүй байжээ.

Үйлс 8-р бүлэгт уншдаг ч ойлгохгүй байсан өөр нэг хүний түүхийг өгүүлдэг. Эртний чуулганы диакон Филипийг Ариун Сүнс Йерусалимаас Газа руу хөтөлдөг цөлийн зам руу удирдсан. Тэнд тэрээр Йерусалимын сүмд мөргөл үйлдээд буцаж явсан Этиопийн нэгэн түшмэлтэй таарчээ. Тэр түшмэл аялж явахдаа Исаиа номоос уншиж байв.

“Хуулийг тань мөрдөж,
Бүхий л зүрхээр сахин
биелүүлэхийн тулд
Ухаарал юугаа наддаа
хайрлаач!”
- Дуулал 119:34

Филип тэр түшмэлээс "Та уншиж байгаагаа ойлгож байна уу?" (Үйлс 8:30) гэж асуусан. Түшмэл хариуд нь "Хэн нэгэн зааж өгөхгүй бол би хэрхэн чадах билээ?" (Үйлс 8:31) хэмээн хэлсэн. Филип Бурханы Үгийг тайлбарлаж өгөхөд тэр хүн Есүсийг Бурханы Хүү гэдэгт итгэж, шинэ итгэгч болж баптисм хүртжээ.

Уншсанаа хэрхэн хөрвүүлэхээ мэдэх нь маш чухал. Дараагийн хэдэн хичээлээр бид Бичвэрийг хөрвүүлэх үйл явцыг судлах болно. Бид хөрвүүлэх практик алхмуудад суралцана.

Хөрвүүлгийн ач холбогдол

Шүүх хуралдаан дээр гурван шүүгч ажлынхаа талаар ярилцаж байна. Эхний шүүгч, "Гэм буруутай хүмүүс байдаг, гэмгүй ч хүмүүс байдаг. Би тэднийг хэн болохыг нь тогтоодог" гэж хэлэв. Энэ шүүгч туйлын үнэн байдагт итгэдэг ажээ. Гэм буруутай хүмүүс, гэмгүй хүмүүс гэж байдаг бөгөөд шүүгчийн үүрэг бол үнэнийг зарлах явдал юм.

Хоёр дахь шүүгч, "Гэм буруутай хүмүүс байдаг, гэмгүй ч хүмүүс байдаг. Би хүнийг гэм буруутай эсэх, гэмгүй эсэхийг ялгахыг хичээдэг" гэж хэлэв. Энэ шүүгч туйлын үнэн байдгийг мэддэг ч хэн нэгний талаарх өөрийн бодол нь алдаатай байж болохыг мэддэг ажээ.

Гурав дахь шүүгч, "Намайг шийдвэрээ гаргах хүртэл шүүгдэгч нь гэм буруутай эсвэл гэм буруугүй" гэж хэлсэн. Энэ шүүгч туйлын үнэнд итгэдэггүй. Өөрийнх нь мэдэгдэл ямар нэгэн зүйлийг үнэн болгодог гэж тэр боддог ажээ.

Харамсалтай нь, олон итгэгчид Бичвэрт туйлын утга санаа байхгүй гэж үздэг. Тэд "Таны хувьд үнэн байж болох зүйл миний хувьд үнэн биш байх боломжтой" гэж хэлдэг. Энэ үзлийн дагуу уншигч бүр өөрийн "үнэн"-ийг бүтээдэг. Библид өгүүлсэн зүйлсийг тэд хүссэн утгаараа ойлгож болно гэж үздэг.

Дээр өгүүлсэн хоёр дахь шүүгчийн адил Христэд итгэгчид хоёр чухал үнэнийг ойлгох хэрэгтэй:

1. Бичвэрийн агуулдаг утга санаа нь туйлын бөгөөд текст дэх Бурханы үнэнийг ойлгохыг хичээх нь бидний ажил юм.
2. Бидний ойлголт хязгаарлагдмал. Үүнээс болж бидний хөрвүүлэг буруу байх боломжтой. Бид даруу байх учиртай.


Ажиглалт хийх үе шатанд бид "Текстээс би юу харж байна вэ?" гэж асуусан. **Хөрвүүлгийн** үе шатанд бид "Текст ямар утгатай вэ?" гэж асуудаг. Дараа нь бид Бичвэрийг амьдралдаа **хэрэгжүүлэх** талаар авч үзэх болно.

Бид хөрвүүлгийн үйл явцыг "Бичигч юу хэлэхийг зорьсон бэ?" гэсэн асуултаар эхлүүлдэг. Энэ нь биднийг "Энэ Бичвэр надад ямар утга санааг харуулж байна вэ?" гэж асуухад бэлтгэдэг.

Зөв хөрвүүлэг хийхэд тулгардаг асуудлууд

Библи зэрэг эртний текстийг хөрвүүлж буй орчин үеийн уншигчдад олон бэрхшээл тулгардаг. Биднийг анхны бичигчээс тусгаарлаж буй цаг хугацаа, орон зай нь хөрвүүлгийг хүндрүүлдэг. Бид өөр хэлээр ярьдаг. Бидний соёл Библийн бичигчдийн соёлоос өөр.

Библийг хөрвүүлэх нь¹⁸



Энэ зураг бидний өнөөгийн цаг үед зориулан Библийг хөрвүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг харуулж байна. Библи нь эртний ертөнцийнхөнд (1) зориулагдан бичигджээ. Анхны уншигчид нь өнөөгийн уншигчийнхаас өөр ахуй соёлд амьдарч байсан. Тэдний ертөнцийг өнөөгийн биднээс тусгаарлаж буй гол (2) нь Библийг ойлгоход хүндрэл үүсгэдэг. Энэ гол нь бидний ахуй соёл болон Библийн ертөнцийн хоорондын ялгааг харуулдаг. Орчин үеийн уншигч болон анхны бичигчийн хооронд ямар ялгаа байна вэ?

Хэлний ялгаа

Библи еврей, грек, арамей гурван хэл дээр бичигдсэн. Өнөөдөр бидний ихэнх нь Библийг төрөлх хэл дээрээ уншдаг. Энэ нь бичигч болон бидний хооронд орон зай үүсгэдэг. Хоёр дахь хэлээр ярьдаг хэн бүхэн хэлний бэрхшээлийг ойлгодог.

Ахуй соёлын ялгаа

Хэлний бэрхшээлтэй адил ахуй соёлын ялгаа нь мөн хүндрэл үүсгэдэг. Бичвэрийн хүмүүн бичигчид нь бидний цаг үеэс ихээхэн ялгаатай ахуй соёлд амьдарч байжээ. Бид Бичвэрийг судлахдаа "Библийн дамжуулж буй сургаалыг илүү сайн ойлгож, хөрвүүлэхэд надад туслах эртний ертөнцийн соёлын талаар би юу мэдэх ёстой вэ?" гэж асуух хэрэгтэй юм.

¹⁸ Зураг: Anna Boggs, "Interpreting the Bible", <https://www.flickr.com/photos/sgc-library/52377290578> хаягаар орж үзэх боломжтой, licensed under CC BY 2.0. Concept from J. Scott Duvall and J. Daniel Hays, *Grasping God's Word* (Grand Rapids: Zondervan, 2012).

Танил биш газарзүй

Библийн үйл явдлууд бодит хүмүүсийн амьдралд, бодит газар оронд тохиолдсон. Газарзүйг сайн ойлгох тусам бид өөрсдийн ертөнц болон тэдний ертөнцийг хувааж буй голыг гатлахад төдий чинээ сайн байх болно.

Иерихо болон Йерусалимын хоорондох зам аюултай, уулархаг газраар дайрдгийг мэдсэнээр тахилч болон левичүүдийн болгоомжлолыг тайлбарлаж чадна (Лук 10:31-32). Мөн шархдаж гэмтсэн харь хүнийг аврахын тулд өөрийн аюулгүй байдлыг эрсдэлд оруулсан самари хүний энэрэнгүй сэтгэлд талархахад тусалдаг (Лук 10:33-34).

Уншигчид "Марк 6-р бүлэгт Есүс 5000 хүнийг хооллосоны дараа Марк 8-р бүлэгт 4000 хүнийг хооллох Түүний чадварт дагалдагч нар яагаад эргэлзэх болов?" хэмээн асуудаг. Үүнд газрын зураг хариулдаг. Марк 7-р бүлэгт Есүс харь үндэстнүүд суурьшсан Декаполь руу аялсан байдаг. Дагалдагч нар "Есүс эдгээр хүмүүсийг хооллож **чадах уу?**" гэж асуугаагүй, харин "Тэр тэднийг хооллох **болов уу?**" гэж асуусан юм. Харь үндэстнүүд ижил гайхамшигийг хүртэх зохистой гэдэгт тэд хараахан итгэхгүй байжээ. Есүс бүх хүмүүсийн төлөө ирснийг тэд хараахан ойлгоогүй байв.

	Марк 6	Марк 7	Марк 8
Газар	Галил	АЯЛАЛ	Декаполь
Хүмүүс	Иудейчүүд	-	Харь үндэстнүүд

Марк 4-р бүлэгт Есүс Галил нууранд дэгдсэн шуургыг хэрхэн намжаасан талаар өгүүлдэг. Библийн атласаас харвал Галил нуур нь далайн түвшнээс 210 метрийн нам дор оршдог том нуур юм. Нуурын эргэн тойрон дахь өндөрлөг газрууд нь салхины хөндий үүсгэдэг тул ихэвчлэн хэдхэн минутын дотор хүчтэй шуурга үүсдэг байжээ. Энэ нууранд насаараа загасчилсан дагалдагчид баргийн хүчтэй шуургыг ажрахааргүй хүмүүс байсан. Тийм хүмүүс амиа алдахаас айж байгаа нь энэ нь ердийн шуурга байгаагүй болохыг харуулдаг. Энэ нь ер бусын хүчтэй шуурга байсан хэдий ч, Есүс хэдхэн үг хэлэхэд л нуур нам гүм болжээ. Тэд "Салхи, нуур хүртэл Түүнд дуулгавартай байдаг, Тэр ер нь хэн бэ?" (Марк 4:36-41) гэж хэлсэн нь гайхах зүйл биш юм.

Танил биш утга зохиолын хэлбэрүүд

Утга зохиолын олон төрлийг бид өөрөөр унших ёстой. Ром номыг уншихдаа Бурхан биднийг хэрхэн зөвт болгосон талаарх Паулын баримт нотолгоог анхааралтайгаар унших хэрэгтэй болдог. Сургаалт зүйрлэлийг уншихдаа бид гайхамшигтай хүүрнэлээр дамжуулан сургаал айлдаж буй түүх өгүүлэгчийг сонсдог.

Дүгнэлт

Зургийг дахин хараарай. Хэл, ахуй соёл, газарзүй, утга зохиолын гол биднийг тусгаарлаж байгаа ч, Библи бүх ахуй соёлд хамаатай мэдээг агуулдаг. Энэ бол голын

дээгүүрх гүүр (3) юм. Гүүр нь Библийн заадаг зарчмуудаас бүрддэг. Эдгээр зарчмууд нь бүх цаг үеийн бүх ахуй соёлд үнэн байдаг.

Газрын зураг (4) нь биднийг Библийн түүхэнд хаана байгаагаа бодож үзэхэд тусалдаг. Христийн ирэлт Хуучин гэрээний олон эш үзүүлэг, хуулийг биелүүлсэн. Үүнийг санаснаар Бичвэрийн эдгээр хэсгийг хэрхэн хөрвүүлж, хэрэгжүүлэхэд өөрчлөлт ирдэг.

Эцэст нь бид өнөөгийн ертөнцөд (5) хүрэлцэн ирдэг. Энэ алхмаар бидний олж мэдсэн зарчим нь (3) өнөөгийн ертөнцөд хэрхэн хэрэгжих вэ гэдгийг асуудаг.

Бид дараагийн хичээлүүдээр энэ зургийг дахин ашиглах болно. Өнөөдрийн хувьд та эдгээр алхмуудыг мэдсэн байх хэрэгтэй.

Библийг хөрвүүлэгчдийн гаргадаг нийтлэг алдаа

Библийг хөрвүүлэгчдийн гаргадаг хэд хэдэн нийтлэг алдаа бий.

Текстийг буруу унших

Зарим номлогчид Паулыг "Мөнгө бол бүх бузар муугийн үндэс" гэж хэлсэн хэмээн номлодог. Гэхдээ Паул тэгж хэлээгүй! Тэр "Учир нь мөнгөнд дурлах нь хамаг муугийн үндэс мөн" (1 Тимот 6:10) гэж хэлсэн. Мөнгөтэй байсан ч түүнд дурлахгүй байх боломжтой, мөнгө багатай байсан ч мөнгөнд дурлах боломжтой. Паулын сэрэмжлүүлэг нь гол төлөв мөнгөний тухай биш, харин мөнгөнд дурлаж, зүрх сэтгэлээ эзэмдүүлэх талаар байжээ.

Зарим итгэгчид Дуулал 37:4 хэсгийг "Бурхан миний зүрхний хүслийг надад өгөхөө амлаж байна. Би баян болохыг хүсэж байна, тиймээс Бурхан намайг баян болгоно" гэж буруугаар уншдаг. Дуулаач "ЭЗЭНд баярлагтун Тэр чамд зүрхний чинь хүслийг өгнө" гэсэн юм. Энэ дуулалд хэрэв бид Эзэнийхээ дотор баярлавал бидний баяр хөөрийг буюу Эзэнийг өгнө хэмээн амласан юм. Хожим нь Есүс хэрэв бид зөвт байдлын төлөө өлсөж, цангагч хүмүүс бол бид зөвт байдлаар цадах болно (Матай 5:6) хэмээн амласан байдаг. Энэ нь санхүүгийн хөгжил дэвшлийн талаарх амлалт биш, харин илүү сайн зүйлийн буюу сүнслэг хөгжил дэвшлийн талаарх амлалт юм.

Энэ курс хичээлээр бидний сурсан эхний алхам нь ажиглалт байсан. Бидний ажиглалт үнэн зөв байх ёстой, эс бөгөөс бидний хөрвүүлэг буруу байх болно. Текстийг буруу уншихаас болгоомжил. Нэгэн хүн Библи судлалын эхний гурван алхмыг ийнхүү хэлсэн байдаг:

1. Текстийг унших.
2. Текстийг дахин унших.
3. 2-р алхмын дараа текстийг дахин унших!

Текстийг гуйвуулах

Түүхийн туршид хуурамч багш нар өөрсдийн алдааг зөвтгөх гэж Бичвэрийг гуйвуулсаар ирсэн. Паул зарим хүмүүс зөвхөн итгэлээр зөвтгөгдөх тухай түүний сургаалыг

санаатайгаар нүгэл үйлдэх хүслээ зөвтгөх гэж гуйвуулахыг сэрэмжлүүлсэн байдаг (Ром 6:1-2). Зарим үед хүмүүс боолчлолыг өмгөөлөхөд эсвэл төр засаг нь үндэстний цөөнхийг устгахыг зөвтгөхийн тулд Бичвэрийг ашиглаж байжээ. Өнөөдөр зарим сайнмэдээг тунхаглагчид Бурханы амлалтыг Бичвэрийн үнэнд үл нийцэх хөгжил дэвшлийн сайнмэдээ болгон гуйвуулж байна.

Петр өөрсдийгөө сүйрэлд хүргэхээр Бичвэрийг гуйвуулдаг хүмүүсийн талаар сэрэмжлүүлсэн байдаг (2 Петр 3:16). Үүнтэй адилаар Иаков багшлах хүмүүсийн хүлээх хариуцлагын талаар анхааруулсан (Иаков 3:1). Библийг заадаг хүмүүс бид худал хуурмаг санааг дэмжихийн тулд Бичвэрийг гуйвуулахгүй байхад маш болгоомжтой хандах ёстой.

Төсөөллийн утга нэмэх

Өмнө өгүүлсэн гурван шүүгчийн түүх нь Библийг хөрвүүлэгчдийн гаргадаг өөр нэг нийтлэг алдааг харуулдаг: Энэ нь Бичвэрийн утга нь уншигчийн төсөөллөөс үүдэлтэй гэсэн санаа юм. Зарим хүмүүс зөвхөн "Бичвэрийн утга санаа надад юуг **мэдрүүлж** байна вэ?" гэж асуудаг. Сэтгэл хөдлөл, мэдрэмж чухал боловч Бичвэрийн эцсийн үнэн бичигчийн бичсэн зүйлд агуулагддаг бөгөөд түүний бичсэн зүйлийн талаар би ямар мэдрэмжтэй байгаагаас хамаардаггүй.

Өөртөө хэт итгэлтэй байх

Хөрвүүлэгч өөрийнхөө талаар хэзээ ч алдаа гаргахгүй гэж бодвол өөрийн бодол үндэслэлдээ хэт найдах болно. Бид текстийн утгын талаар дүгнэлтэд хүрэхийн тулд Үгийг судалдаг хэдий ч, дүгнэлт маань буруу байх үед алдаагаа хүлээн зөвшөөрөх даруу хандлагатай байх учиртай. Хэн ч бүх хариултыг мэдэхгүй.

Хөрвүүлэгч даруу чанар маш чухал. Библийг судалж байхдаа бурханлаг итгэгчид ч санал зөрөлддөг хэсгүүдийг бид олж харна. Энэ нь аль нэг тал нь санаатайгаар Бичвэрийг гуйвуулсан гэсэн үг биш юм. Харин энэ нь Бичвэрийн үнэний төлөө өөрсдийгөө зориулсан хоёр талын хоорондох чин сэтгэлийн зөрөлдөөн байх боломжтой. Бид өөрсдийн хөрвүүлгийн талаар даруу байдлыг сахиж, бусад хүмүүсийн өөр үзэл бодлыг хүндэлж хүлээцтэй байх ёстой.

Таны ээлж

Хүмүүс Библиэс эш татаж байна гэж бодоод буруу зүйлийг хэлдэг зарим жишээг доор дурдлаа. Анхааралтай уншихын ач холбогдлыг илүү сайн ойлгохын тулд жишээ бүрээс гуйвуулсан текстийг олж, Библид үнэндээ юу гэж бичсэн байгааг тэмдэглээрэй. Эхний жишээг танд зориулан бүтнээр нь оруулсан.

Зарим хүмүүс хэлэхдээ	Библи хэлэхдээ
"Мөнгө бол бүх бузар муугийн үндэс."	"Учир нь мөнгөнд дурлах нь хамаг муугийн үндэс мөн" (1 Тимот 6:10).
"Ажил бол хараал юм."	
"Чиний дааж чадахаас илүүг Бурхан хэзээ ч өгөхгүй."	

4-р хичээлийн гол санаанууд

(1) Хөрвүүлгийн алхамд "Текст ямар утгатай вэ?" гэж асуудаг.

(2) Хөрвүүлгийг хүндрүүлдэг зарим бэрхшээлүүд нь:

- Хэлний ялгаа
- Ахуй соёлын ялгаа
- Танил биш газарзүй
- Танил биш утга зохиолын хэлбэрүүд

(3) Буруу хөрвүүлэг хийхэд хүргэдэг зарим нийтлэг алдаанууд:

- Текстийг буруу унших
- Текстийг гуйвуулах
- Төсөөллийн утга нэмэх
- Өөртөө хэт итгэлтэй байх

5-р хичээл

Хөрвүүлэг: Хам сэдэв

Хичээлийн зорилго

- (1) Бичвэрийг хөрвүүлэхэд түүхэн ба соёлын нөхцөл байдал үнэ цэнтэй болохыг ойлгох.
- (2) Бичвэрийн багц хэсгийн түүхэн ба соёлын нөхцөл байдлыг олж мэдэхийн тулд асуултуудыг ашиглах.
- (3) Нэг эшлэл эргэн тойрны хам сэдэвтэйгээ хэрхэн зохицож байгааг таних.
- (4) Хам сэдвийг судлахад гаргадаг нийтлэг алдаанаас зайлсхийх.

Танилцуулга

► Та өөрийн төрөлх хэл дээрээ олон утгатай ямар нэгэн үг хэлнэ үү? Хэн нэгэн тухайн үгийг хэлэхдээ аль утгаар нь хэрэглэж байгааг та хэрхэн мэдэх вэ?

Библийн хөрвүүлгийн хамгийн чухал талуудын нэг нь бидний судалж буй хэсгийн хам сэдэв юм. Энэ хичээлээр бид Бичвэрийн багц хэсгийн түүхэн ба соёлын хам сэдэв болон эшлэлийн эргэн тойронд буй Библийн хам сэдвийг судлах болно.¹⁹

Түүхэн ба соёлын хам сэдэв

► 2 Тимот 4:6-22 эшлэлийг унших.

Паул Тимотод "Өвлөөс өмнө ирэхийг хичээ" (2 Тимот 4:21) хэмээн бичжээ. Дараах нөхцөл байдлын дагуу Паулын хүсэлтийг анзаараарай:

- Паул Ромын шоронд байна. Тэр удахгүй итгэлийнхээ төлөө амиа өгнө.
- Тимот хэдэн зуун километрийн зайд орших Ефес хотод үйлчилдэг.
- Намар тэнгисээр аялах нь аюултай байсан бөгөөд харин өвөл ямар ч боломжгүй байжээ. Тимот өвлөөс өмнө очихын тулд энэ захидлыг хүлээн авсан даруйдаа явах ёстой байж.


Түүхэн хам сэдэв нь Паулын хүсэлтийн цаана буй сэтгэл хөдлөлийг ойлгоход тусалж байна. Паул зүгээр л "Боломжтой үедээ ирээрэй" гэж хэлээгүй. Тэр сүнслэг хүүгээсээ "Би үхэхээсээ өмнө чамайг дахин хармаар байна. Хэрэв чи өвөл хүртэл хүлээвэл аялах боломжгүй болно. Хэтэрхий оройтохоос өмнө ирээч" хэмээн гуйж байна. Та түүхэн хам сэдвийн талаар юу ч мэдэхгүй байсан ч захидлын утга санаа бол хэвээрээ л байна. Гэхдээ түүхэн хам сэдэв нь Паулын хүсэлт яаралтай байгааг харуулдаг.

¹⁹ Энэ хичээлийн ихэнх материалыг J. Scott Duvall ба J. Daniel Hays, *Grasping God's Word* (Grand Rapids: Zondervan, 2012) номын 6-7-р бүлгүүдээс авсан.

Түүхэн ба соёлын хам сэдэв нь чухал ач холбогдолтой. Учир нь Бурхан дэлхийн хүн бүр ойлгож чадах ганцхан хэл дээр Библийг өгөөгүй. Бичвэрийн талаарх дараах хоёр чухал зүйлийг анзаараарай:

1. Бичвэрийн зарчмууд нь цаг үргэлж, газар сайгүй, хүн бүрийн хувьд үнэн байдаг.
2. Бичвэрийн зарчмууд нь тодорхой цаг үед, тодорхой газарт, тодорхой хүмүүст өгөгдсөн.

Библийг хөрвүүлэх нь²⁰



1	Тэдний суурин	Бичвэрийн анхдагч мэдээ, сургаал
2	Гол	Эртний ертөнц ба бидний ертөнцийг тусгаарладаг түүхэн ба соёлын ялгаа
3	Гүүр	Текстэд зааж буй зарчим
4	Газрын зураг	Шинэ гэрээний холбоо хамаарал (Хуучин гэрээний багц хэсгүүдийн хувьд)
5	Бидний суурин	Зарчмыг өнөөгийн ертөнцөд хэрэгжүүлэх

²⁰ Зураг: Anna Boggs, “Interpreting the Bible”, <https://www.flickr.com/photos/sgc-library/52377290578> хаягаар орж үзэх боломжтой, licensed under CC BY 2.0. Concept from J. Scott Duvall and J. Daniel Hays, *Grasping God’s Word* (Grand Rapids: Zondervan, 2012).

Бичвэрийн түүхэн ба соёлын нөхцөл байдлыг сайн ойлгох тусам Библийн нийтлэг зарчмуудыг төдий чинээ сайн ойлгодог.

Түүхэн ба соёлын хам сэдвийг судлахдаа бид анхны сонсогчдод зориулсан мэдээ сургаалыг ойлгохын тулд Библийг "тэдний суурин" газарт уншдаг. Дараа нь бид эртний ертөнц болон бидний ертөнцийг тусгаарлаж буй "гол" буюу ахуй соёлын ялгааг авч үздэг. Библийн ертөнцийг сайн ойлгох тусам Бурханы Үг өнөөгийн бидний ертөнцөд хэрхэн ярьж байгааг илүү тод сонсох боломжтой болдог.

Бичвэрийг анхдагч хам сэдвийн хүрээнд унших нь чухал юм. Учир нь энэ нь Библийн хөрвүүлгийн чухал зарчмын суурь болдог: **Өнөөдөр Библийн текстийг хөрвүүлэхэд хүчин төгөлдөр байгаа аливаа хөрвүүлэг нь текстийн анхдагч мэдээ сургаалтай нийцэх ёстой.** Би текстийн анхдагч мэдээ сургаалтай зөрчилдөх утга санааг хайж болохгүй.

Түүхэн ба соёлын хам сэдэв гэж юу вэ? Түүхэн ба соёлын хам сэдэв гэдэг нь бидэнд текстийг өөрийг нь ойлгоход тусалдаг текстийн гадна байгаа зүйл юм. Үүнд дараах асуултуудын хариулт багтана:

- Цөлд израилчуудын амьдрал ямар байсан бэ? (Гэтлэл—Дэд хууль хам сэдэв)
- I зууны үеийн Палестины ахуй соёл ямар байсан бэ? (Сайнмэдээний хам сэдэв)
- Галат болон Филиппой хотод Паулыг ихэд бухимдуулсан хуурамч багш нар хэн байсан бэ?

Түүхэн ба соёлын хам сэдвийг судлахдаа асуух зарим асуултууд:

(1) Библийн бичигчийн талаар бид юу мэддэг вэ?

Бурхан хүмүүсээр дамжуулан айлдсан тул бичигчийн талаарх мэдлэг нь Бурханы Үгийг илүү сайн ойлгоход тусалдаг.

Паулын захидлуудыг уншихдаа итгэгч болохоос өмнөх түүний амьдралыг санах хэрэгтэй. Тэр "Махбодод түшиглэх шалтгаан гэвэл надад ч бий" (Филиппой 3:4-6) гэж бичсэн бөгөөд фарисайчууд Хуулийг нарийн чанд сахидаг байсныхаа төлөө өндөр хүндлэл хүлээдэг байсныг бид мэдэх хэрэгтэй юм. Тэдний хоёр нүүр гаргаж, Есүсийг хүлээн авахаас татгалзсаныг бид мэддэг. Түүнчлэн Бурханы хуулийн нарийн ширийн зүйлийг ч тэд хайрладаг байсныг мөн санах хэрэгтэй.

Нөгөөтэйгүүр, Паул өөрийгөө нүгэлтнүүдийн "эхнийх" гэж тодорхойлсон байдаг (1 Тимот 1:15) Ингэхдээ Паул чуулганыг хавчиж, Христэд итгэгчдийг үхэлд хүргэж байснаа санаж байв. Энэ нь Дамаск руу явах замд Христтэй уулзахаас өмнөх түүний амьдралын дурсамж юм.

Гэтлэл номыг уншихдаа Мосе Фараоны ордонд ямар эрх эдэлж байсныг мэдэх хэрэгтэй. Ордон дахь тансаг амьдралыг нь бодож үзвэл Еврей 11:25 эшлэлд Мосегийн тухай хэлсэн зүйлийг бүр илүү гүнзгий ойлгоно. "Нүглийн цаг зуурын зугаанаас Бурханы хүмүүсийн хамт ад үзэгдсэн нь дээр гэдгийг тэр сонгосон юм." Залуухан Мосед

олгогдсон боловсрол, ахуй соёлын боломж бололцоог нь харвал Бурхан агуу үндэстнийг удирдуулахаар үйлчлэгчээ бэлтгэж байсныг ч бид олж хардаг.

(2) Библийн сонсогчдын талаар бид юу мэддэг вэ?

Библийн бичигчийн талаар суралцахын зэрэгцээ анхны сонсогчдын талаар аль болох ихийг мэдэж авах хэрэгтэй.

1 ба 2 Шастир номд багтсан ихэнх материал нь Самуел болон Хаадын номд давтагдсан байдаг. Яагаад? Шастир ном нь израилчууд цөллөгөөс буцаж ирсний дараа бичигджээ. Бурхан Израилыг яагаад шүүлтийн зовлонд оруулсан талаар Хаад номд өгүүлдэг бол, Бурхан ард түмэндээ санаа тавьсан хэвээр байсныг Шастир номд харуулдаг.

Йерусалим бүслэгдэж, сүйрч байсан тэдгээр өдрүүдэд Иеремиа номлож байлаа. Түүний шүүлтийн тухай мэдээг уншихдаа амлагдсан шүүлт нь тун удахгүй болохыг санах хэрэгтэй. Гэсэн хэдий ч Иеремиа номоос Бурханы амлалтыг ч бид уншдаг: "Учир нь та нарт зориулж байгаа төлөвлөгөөнүүдийг Би мэдэх бөгөөд тэдгээр нь та нарт ирээдүй ба найдварыг өгөх гай гамшгийн бус, сайн сайхны төлөөх төлөвлөгөөнүүд юм" гэж ЭЗЭН тунхаглаж байна" (Иеремиа 29:11). Энэ амлалт хүмүүсийг харь улсад олзлогдохын өмнө иржээ. Бурханы ард түмэндээ зориулсан төлөвлөгөөнд тэднийг гэмшилд авчрах шүүлтүүд багтдаг.

1 Иохан захидал нь зөвхөн сүнслэг зүйл л сайн, харин махбод, биет зүйлс бузар муу гэсэн худал сургаалтай тулгарч байсан итгэгч хүмүүст зориулагджээ. Хуурамч багш нар Есүс жинхэнэ хүн байгаагүй, харин зөвхөн хүн шиг харагдаж байсан гэж сургаж байв. Иохан уншигчдадаа Есүс бие махбодтой байсныг сануулж бичсэн. "Эхнээсээ байсан бөгөөд бидний сонсож, нүдээрээ үзэж, харж, гараараа барьж үзсэн амийн Үгийн тухай" (1 Иохан 1:1).

Хуурамч багш нар мөн аврал нь цөөн хэдэн хүнд илчлэгдсэн нууц мэдлэгээр дамжин ирдэг хэмээн сургаж байлаа. Бурханыг үнэхээр таньж мэдэхийн тулд бид дуулгавартай байх ёстойг Иохан бичжээ. "Бид Түүний тушаалуудыг сахивал, үүгээрээ бид Түүнийг таньснаа мэднэ" (1 Иохан 2:3). Мөнх амийг өгдөг тэрхүү мэдлэг нь хайрыг агуулдаг. "Бид ах дүүсээ хайрладаг учраас үхлээс аминд шилжсэнээ мэднэ" (1 Иохан 3:14).

(3) Номын түүхэн нөхцөл байдлын талаар бид юу мэддэг вэ?

Нэгэн номлогч "Өнөөдөр би Христэд итгэгч хүн хэрхэн эхнэр авах ёстой талаар номлоно. Шүүгчид 21:20-21-д хэлсний дагуу бид хөрш зэргэлдээ суурин руу явж, бутанд нуугдах хэрэгтэй. Тосгоны залуухан бүсгүйчүүдийн нэг нь зөрж өнгөрөхөд түүнийг барьж аваад гэртээ авчрах хэрэгтэй. Энэ бол эхнэрээ сонгох Библийн загвар юм" хэмээн заасан гээд төсөөлөөд үз дээ. Бичвэрийг хэрэгжүүлж буй түүний арга барилд та эргэлзэх болно!

Номлогчийн хэрэгжүүлэлтэд юу буруу байна вэ? Шүүгчид номд Бениамин овгийн эрчүүд нэг удаа ийм аргаар эхнэр авсан гэж өгүүлсэн байдаг. Ингэхдээ Израилын нэг овгийг

авч үлдэх сайн зорилгын төлөө ингэсэн гэж өгүүлдэг. Гэсэн хэдий ч номлогч түүхэн хам сэдвийг үл тоомсорлож байна. Энэ түүх нь Шүүгчид номын төгсгөлд гардаг бөгөөд Израил Бурханы төлөвлөгөөнөөс эмх замбараагүй байдал руу хэрхэн унаж доройтсоныг харуулдаг. Гэрлэлтийн талаарх Бурханы төлөвлөгөөг бус, харин Бурханы хүмүүс Түүний эсрэг босоход юу болдгийг энэ түүх харуулдаг.

Заримдаа бид бичигч эсвэл сонсогчдын талаар бага мэдээлэлтэй байдаг ч, ерөнхий түүхэн нөхцөл байдлын талаар мэддэг. Бид Рут номыг хэн бичсэнийг мэдэхгүй ч, үйл явдлууд нь шүүгчид захирч байсан өдрүүдэд болсныг мэддэг (Рут 1:1). Энэ нь Израилд нийгмийн ёс бус байдал ноёрхож байсан цаг үе юм (Шүүгчид 21:25). Израил Бурханд итгэмжгүй хандсаныг моаб бэлэвсэн эмэгтэй Рутын итгэмжит байдалтай эсрэгцүүлж Рут номд өгүүлжээ.

Энэ хүүрнэлд Боаз хэрхэн хувиа бодолгүй Руттай гэрлэж, Наомигийн нас барсан хөвгүүдэд хууль ёсны өв залгамжлагчийг бий болгосон талаар мөн өгүүлдэг. Ойрын хамаатан-өв золигчийн хувьд Боаз Наомигийн төлөө хүү өгөхдөө өөрийн өв залгамжлах эрхээ золиосолжээ. Ийнхүү Боаз Давидын удам угсаанд байр суурийг эзэлсэн юм (Матай 1:6, 16).

Иона номыг хөрвүүлэхэд түүхэн нөхцөл байдал чухал:

- Ниневе нь Израилын хамгийн аюултай дайсан Ассирын нийслэл хот байв.
- Ионаг Ниневед номлож байсан тэр үед Амос болон Хосеа нар Бурханы Израилын дээрх шүүлт Ассираар дамжин ирнэ хэмээн сэрэмжлүүлж байлаа.

Хүний өнцгөөс харвал Ионагийн ассирчуудад номлохоос татгалзсаныг ойлгох боломжтой. Бүх хүмүүсийг ялгаварлалгүйгээр хайрладаг Бурханы үзэл бодлыг Иона ном харуулдаг.

(4) Номын ахуй соёлын нөхцөл байдлын талаар бид юу мэддэг вэ?

Бичвэрийн түүхэн ба соёлын хам сэдэв нь Библийн ертөнц дэх ахуй соёлын ёс заншлыг мөн авч үздэг. I зууны үеийн Палестин дахь ёс заншлыг мэдсэнээр бид Есүсийн заасан сургаалт зүйрлэлүүдийг шинээр харж ойлгох боломжтой:

- Сайн самари хүний тухай сургаалт зүйрлэл нь (Лук 10:30-35) иудей сонсогчдыг гайхшруулж байсан. Шашны удирдагчид шархадсан аялагч хүнд туслаагүйд Есүсийг сонсогч хүмүүс төдийлөн гайхаагүй. Харин түүнд тусалж, аврах нэгнийг гарцаагүй рабби эсвэл фарисай хүн байх гэж тэд хүлээсэн. Гэтэл тэдний жигшдэг самари хүнийг хайр энэрлийн үлгэр жишээ болгон Есүс сургажээ.
- Ачлалгүй хүүгийн тухай сургаалт зүйрлэлийг уншихдаа (Лук 15:11-32) иудей эцэг хүн нэр төрөө эрхэмлэдэг гэдгийг санаж байх хэрэгтэй. Сонсогчдын хувьд эцэг нь хүүгээ буцаж ирэхийг зөвшөөрөхгүй, эсвэл түүнийг боол болгохыг зөвшөөрнө хэмээн хүлээж байсан. Гэтэл эцэг нь төөрөлдсөн хүүгээ буцаж ирэхэд баярласандаа нэр төрөө хөсөр хаяж хүү рүүгээ гүйжээ. Энэ үйлдэл нь маш

цочирдом байсан тул зарим дорно дахины соёлд энэ хүүрнэлийг "Гүйж буй эцгийн сургаалт зүйрлэл" хэмээн нэрлэдэг. Үүнтэй адилаар бидний тэнгэрлэг Эцэг биднээс уучлал эрэхийг хүлээхийн оронд, Тэрээр тэрслүү нүгэлтнүүдийг эрж хайдаг. Энэ бол бидний Эцэгийн хэмжээлшгүй агуу хайрын дүр зураг юм.

Паулын захидлуудыг I зууны ахуй соёлын нөхцөл байдлыг харгалзан унших хэрэгтэй. Ефес 5:21–6:9 хэсэг нь Паулын уншигчдын хувьд цочирдом мэдээ байсан. Эхнэр хүн нөхөртөө захирагдах ёстой гэсэн Паулын тушаал нь хэвийн сонсогдож байсан байх. Харин нөхрүүдэд Христ өөрийгөө золиослосон үлгэр дуурайлыг дагах ёстой хэмээн тушаах нь Ром гаралтай сонсогчдын ой тойнд багтахгүй байжээ. Хүүхдүүд эцэг эхээ дуулгавартай дагах ёстойг ойлгож болох байсан ч, хүүхдүүдээ уурлуулахгүй байхыг Ромын ертөнц дэх эцгүүдэд хэн ч урьд хожид хэлж байсангүй.

Паул Филиппойчуудад хандан тэнгэрт харьяалалтай иргэд адил амьдрахыг уриалсан байдаг (Филиппой 3:20). Тэр үүнийг иргэншил нь Ромын эзэнт гүрэнд онцгой эрх эдэлдэг Филиппой хотынхонд хандан бичсэн юм. Энэ хот нь тэтгэвэрт гарсан цэрэг армийнхныг суурьшуулахаар байгуулагдсан тул Филиппой хотын иргэд иргэншлээ маш өндрөөр үнэлдэг байжээ. Паул тэдний жинхэнэ иргэншил нь дэлхий дээрх аль нэг хотод биш, харин тэнгэрт байгааг сануулсан юм. Энэхүү түүхэн ба соёлын нөхцөл байдлыг мэдэх нь Филиппой захидлыг илүү сайн ойлгоход тусалдаг.

Түүхэн ба соёлын хам сэдвийг нээж илрүүлэх нь

Бидний үзсэнчлэн, Бичвэрийн багц хэсгийн түүхэн ба соёлын хам сэдвийг судлах нь асуулт асуух байдлаар эхэлдэг. Бид асуултуудынхаа хариултыг хэрхэн олох вэ? Курс хичээлийн хавсралтад бидэнд хариулт өгөх хэд хэдэн Библи судлалын эх сурвалжийг тайлбарласан байгаа. Мөн Shepherds Global Classroom байгууллагын бүтээсэн Хуучин гэрээ болон Шинэ гэрээг танилцуулах курс хичээлүүдийг ашиглахыг зөвлөж байна. Эдгээр курс нь Библийн ном тус бүрийн нөхцөл байдлыг мэдэхэд тусална.

Библийн хам сэдэв

Библийн хөрвүүлэг хийхэд анхаарах өөр нэг чухал зүйл бол эргэн тойрны хам сэдэв юм. "Энэ эшлэл, багц хэсэг, бүлэг, ном Библийн бусад хэсэгтэй хэрхэн холбогдож байна вэ?" гэж асуух нь чухал.

Та урагдсан захидлаас ганц өгүүлбэр бүхий тасархай цаас олсон гэж төсөөлөөд үз дээ. Тасархай дээр "Тийм, 7 бол ОК" гэж бичсэн гэж бодъё. Энэ өгүүлбэр ямар утгатай вэ?

- Магадгүй бичсэн хүн нь хэн нэгэнтэй уулзах цаг товлосон байх. Тэрхүү уулзалтад 19:00 цаг тохиромжтой хэмээн баталсан байж болно.
- Магадгүй бичсэн хүний эхнэр нь "Баасан гарагийн оройн зоогт хэдэн хүн урих вэ?" гэж бичихэд тэр хариуд нь "Долоо (хүн) бол ОК" гэж бичсэн ч байж мэднэ.

- Магадгүй бичсэн хүн номоо 8 доллараар зарах санал тавьсан байх. Хэн нэгэн "Үнийг нь 7 доллар болгож бууруулах уу?" гэж асуухад тэр хариуд нь "Тийм, 7 доллар бол ОК" гэж хэлсэн ч байж болно.

Хам сэдвийг мэдсэний дараа л бид тухайн нэг өгүүлбэрийг ойлгодог. Бид нэг өгүүлбэрийг нийт багц хэсгийн хам сэдвийн хүрээнд уншдаг. Бид багц хэсгийг нийт захидлын хам сэдвийн хүрээнд уншдаг. Хүрээг томруулаад бид хоёр хүний хоорондох цуврал захидлуудын хам сэдвээр ч захидлыг уншиж ойлгох боломжтой.

Бичвэрийг ч мөн ийм байдлаар уншиж болно. Нэг эшлэлийг эргэн тойрных нь эшлэлүүд, бүлэг, номынх нь хам сэдвийн хүрээнд унших ёстой. Хам сэдэв нь тухайн хэсгээс эхлээд бүхэл бүтэн Библийг хамран өргөждөг.


Нэг эшлэлийг зөв ойлгохын тулд бид тухайн эшлэлийн эргэн тойрных нь хам сэдвийг харах ёстой. Дуулал 1:3-д Бурханы хуульд баярладаг хүнд зориулсан гайхамшигтай амлалт өгөгджээ. Тийм хүн усалгаа сайтай, үр жимсээ өгдөг мод адил юм. "Аливаа үйл нь түүнд амжилт авчирна." Зарим хүмүүс үүнийг итгэмжтэй итгэгч хүн бүрд өгөгдсөн эд баялгийн талаарх амлалт гэж үздэг.

Харин та Дуулал 1-ийн үлдсэн хэсгийг уншихад гол онцолж буй зүйл нь эд баялгийн ерөөл биш, харин Эзэний хуулийг даган явдаг хүмүүсийн сүнслэг үр жимсний тухай юм. Энэхүү дуулал "Зөвтийн замыг ЭЗЭН мэддэг, буруутын зам сөнөж мөхдөг" (Дуулал 1:6). гэсэн амлалтаар төгсдөг. Энд Бурханы мэддэг (харж, зөвшөөрдөг) зам болон сүйрэлд хүргэдэг замыг эсрэгцүүлэн харуулжээ.

Дуулал болон Библийг бүхэлд нь уншихад энэхүү мэдээ сургаал нь батлагддаг. Итгэгч хүний хөгжил дэвшил нь эд хөрөнгөөр биш, харин Бурханы таалалд оршдог. Энэ бол жинхэнэ хөгжил дэвшил юм.

Багц хэсгийг хам сэдвийн хүрээнд уншихын тулд гурван алхмыг дагаарай:

1. Номыг хэрхэн багц хэсгүүдэд хуваасныг тодорхойлох. Таны уншиж буй эшлэлийн шууд хам сэдэв нь аль вэ?
2. Багц хэсгийн гол санааг нэг эсвэл хоёр өгүүлбэрээр хураангуйлах. Энэ нь танд бүхэл хэсгийн мэдээ сургаалыг ойлгоход тусална.
3. Номыг бүхэлд нь уншаад "Миний судалж буй багц хэсэг номын мэдээ сургаалтай хэрхэн нийцэж байна вэ?" гэж асуугаарай.



Библи > ном > багц хэсэг ба бүлэг > эшлэл

Библи > Паулын захидлууд > Ром > Ром 12-15-р бүлэг > Ром 12:1-2

Ром 12:1-2 эшлэлд Бурханд өөрсдийгөө бүрэн захируулахыг бидэнд уриалжээ.

Иймд ах дүү нар аа, Бурханы өрөвч сэтгэлээр та нараас хичээнгүйлэн гуйя. Өөрсдийн биеийг Бурханд тааламжтай, амьд, ариун тахил болгож өргө. Ингэх нь та нарын сүнслэг мөргөл мөн. Энэ үеийн явдалд нийцэлгүй, харин оюун санаагаа шинэчилж, өөрчлөгдөгтүн! Тэгвэл Бурханы сайн, тааламжит, төгс төгөлдөр хүсэл юу болохыг таних болно.

Бурханд өөрийгөө бүрэн захируулах нь итгэгч хүний өдөр тутмын амьдралд хэрхэн харагдахыг өгүүлсэн хэсэг (Ром 12-15-р бүлэг) эндээс эхэлдэг. Ойрын хам сэдвээс цааш харвал Ром 12-15-р бүлэг нь бид Бурханы өмнө хэрхэн зөвт болсныг харуулдаг 11 бүлэг бүхий онол сургаалын зааврын дараа ордог.

Ром номын хам сэдвээс гадна, Паулын захидал бүр нь бидний христитгэлийн практик үйл хэрэгт анхаарал хандуулсан байдаг. Эцэст нь Ром 12:1-2 эшлэл нь Бурханд дуулгавартай байх болон өөрийгөө зориулах тухай бүхэл бүтэн Библийн мэдээ сургаалтай яв цав нийцдэг. Жишээлбэл, Ром 12:1-2 эшлэлийн хэллэг нь Леви ном дахь өргөл тахилын дүр зургийг тусгасан байдаг. Библийн өргөн хам сэдвийг илүү ойлгох тусам Паулын хэлсэн үгс улам хүчирхэг болдог.

Таны ээлж

► Дараах эшлэл бүрийг уншаад ойрын хам сэдвийг хараарай. Хам сэдэв нь эшлэлийг ойлгоход хэрхэн нөлөөлж байгааг ярилцаарай.

1. Матай 18:20 эшлэлийг унш. Энэ нь юу гэсэн утгатай вэ?
2. Одоо Матай 18:15-20 багц хэсгийг уншаарай. Энэ нь Матай 18:20 эшлэлийн утгад нөлөөлж байна уу?
1. Ром 8:28 эшлэлийг унш. Энд юуг амлаж байна вэ?
2. Одоо Ром 8:28-30 багц хэсгийг уншаарай. Ром 8:28 эшлэлд амласан "сайн сайхан" нь юу вэ?
1. Илчлэл 3:20 эшлэлийг унш. Хэнийг урьж байна вэ?
2. Одоо Илчлэл 3:14-21 багц хэсгийг уншаарай. Энэ урилга хэнд зориулагдсан бэ?

Хам сэдвийг судлахдаа гаргадаг нийтлэг алдаанууд

Энэ хичээлийг дүгнэхийн тулд бид Бичвэрийн хам сэдвийг судлахдаа хөрвүүлэгчдийн гаргадаг зарим нийтлэг алдааг авч үзэх хэрэгтэй.

Буруу мэдээлэл ашиглах

Нэгэн оюутан Матай 19:23-24 эшлэлээр танилцуулга толилуулжээ. Тэр Есүсийн цаг үед Йерусалим руу орох нэгэн хаалгыг "тэвнийн сүвэгч" гэж нэрлэдэг байсан гэж хэлэв. Энэ хаалга маш намхан байсан тул ачааг нь буулгаж байж тэмээ нүхээр нь багтах боломжтой байсан гэж тэр хэлэв.

Оюутны танилцуулгад хоёр асуудал байна:

1. Есүсийн цаг үед ийм хаалга байсан гэх түүхэн баримт байхгүй. "Тэвнийн сүвэгч" гэдгээр Есүсийн үед ч одоогийнх шиг оёдлын зүүний нүхийг хэлдэг байсан.
2. Нөхцөл байдлын талаарх мэдээлэл буруу байсан учраас оюутан текстийн талаар ташаа дүгнэлт гаргажээ. Түүний танилцуулгын дагуу бид тэнгэрийн хаанчлалд багтахын тулд амьдралдаа байгаа бүх илүү зүйлээс салах ёстой гэж дүгнэхээр байна.

Гэтэл Есүс баян, эрх мэдэлтэй хүмүүс Бурханы хаанчлалд орох нь маш хэцүү гэж заагаагүй. Харин боломжгүй гэж заасан! Дагалдагч нар нь үүнд маш их гайхсан тул "Тэгвэл хэн аврагдаж чадах вэ?" гэж асуусан байдаг.

Есүс "Энэ нь амаргүй, гэхдээ та хангалттай хичээвэл багтаж болно" гэж хариулаагүй. Харин сайнмэдээний сайн мэдээгээр хариулсан юм: "Энэ нь хүмүүст боломжгүй, харин Бурханд бүх юм боломжтой гэж айлдав." Хам сэдвийг судлахдаа буруу мэдээлэл таныг төөрөлдүүлэхээс зайлсхий.

Хам сэдвийн судалгааг мэдээ сургаалаас илүүд үзэх

Хоёр дахь аюул бол хам сэдвийн судалгааг текстийн мэдээ сургаалаас илүү чухал болгох явдал юм. Паул Коринтын итгэгчдэд буруу төрлийн мэдлэг ихэрхэг болгодог бол хайр бусдыг босгон байгуулдаг (1 Коринт 8:1)²¹ хэмээн сургасан. Бид судалж буй текстийнхээ мэдээ сургаалыг орхигдуулж, хам сэдвийн нарийн ширийн зүйлд хэтэрхий их татагдах боломжтой.

Хэн нэгэн самаричуудын ахуй соёлын талаар бүгдийг сурч мэдээд, сайн самари хүний талаарх сургаалт зүйрлэлийн зорилгыг мартвал юу болох вэ: "Явж, үүний адил үйлдэгтүн" (Лук 10:37). Энэ тохиолдолд бидний мэдлэг ямар ч хэрэггүй болно. Бичвэрийн мэдээ сургаалыг ойлгохын тулд суралц. Зөвхөн судлахын тулд л бүү судал.

²¹ Паул мэдлэгийн эсрэг байгаагүй, харин тэр залуу чуулгануудад сайн заавар өгөхийн тулд захидлуудаа бичсэн. Гэсэн хэдий ч коринтчуудын ихэрхүү "мэдлэг" нь босгон байгуулахын оронд, харин сүйрэлд хүргэжээ.

Их мэдлэгтэйгээрээ гайхуулж бардамнахын тулд биш, харин илүү үр нөлөөтэй номлож, заахын тулд судал!

5-р хичээлийн гол санаанууд

(1) Зөв хөрвүүлэг хийхийн тулд бид Бичвэрийн аливаа хэсгийн хам сэдвийг судлах шаардлагатай.

(2) Түүхэн ба соёлын хам сэдэв нь Библийн ахуй соёлын нөхцөл байдлыг авч үздэг. Энэ нь дараах асуултуудыг асуудаг:

- Библийн бичигчийн талаар бид юу мэддэг вэ?
- Библийн сонсогчдын талаар бид юу мэддэг вэ?
- Номын түүхэн нөхцөл байдлын талаар бид юу мэддэг вэ?
- Номын ахуй соёлын нөхцөл байдлын талаар бид юу мэддэг вэ?

(3) Библийн хам сэдэв нь тухайн эшлэл Бичвэрийн бусад хэсэгт хэрхэн нийцэж байгааг авч үздэг.

5-р хичээлийн даалгавар

1-р хичээл дээр та энэ курсын туршид судлах Бичвэрийн багц хэсгийг сонгосон. Сонгосон багц хэсгийнхээ түүхэн ба соёлын, мөн Библийн хам сэдвийг судлаарай. Энэ хичээл дээр үзсэн хам сэдвийн талаарх яриа хэлэлцүүлгээс аль болох олон асуултад хариулж, нэг хуудас тэмдэглэл бэлтгэ.

Дараах асуултуудыг асуугаарай:

- Бичигч нь хэн байсан бэ?
- Тэр хэзээ бичсэн бэ?
- Түүний гарал үүсэл, нөхцөл байдал нь ямар байсан бэ?
- Түүний сонсогчид хэн байсан бэ?
- Тэдэнд ямар асуудлууд тулгарч байв?
- Энэ багц хэсгийн эргэн тойронд буй нөхцөл байдал ямар байсан бэ?
- Энэ ном бичигдэж байсан цаг үед ямар түүхэн үйл явдлууд тохиолдсон бэ?
- Ахуй соёлын ямар хүчин зүйлс номыг тайлбарлахад туслах вэ?

Тус хэсгийн Библийн хам сэдвийг тодорхойлохын тулд өмнө нь болон хойно нь өгүүлсэн бүлгүүдийг уншаарай.

6-р хичээл

Хөрвүүлэг: Утга зохиолын хэлбэрүүд

Хичээлийн зорилго

- (1) Бичвэрт агуулагддаг хэд хэдэн утга зохиолын хэлбэрийн онцлогийг тодорхойлох.
- (2) Утга зохиолын хэлбэр нь текстийн хөрвүүлэгт хэрхэн нөлөөлдгийг тодорхойлох.
- (3) Бичвэрт тэмдэглэгдсэн тодорхой түүхэн үйл явдал нь дагаж хэрэгжүүлэх жишээ мөн эсэхийг ялгаж сурах.
- (4) Бичвэрийн багц хэсгээс бүх цаг үед, бүх хүмүүст хамаатай зарчмуудыг таних.
- (5) Хуучин гэрээний багц хэсгүүдийг өнөөгийн итгэгч хэрхэн ашиглахыг тодруулах.

Танилцуулга

Ангийн удирдагчид өгөх зөвлөмж: Энэ хичээлийн хамрах материал их учраас хичээлийг хоёр хуваан заахыг зөвлөж байна. 2-р хэсгийн хичээлийн дараа суралцагчдад даалгаварыг өгнө.

Утга зохиолын хэлбэрийг мэдэх нь Бичвэрийг зөв ойлгоход тусална.

Библид Давид хонин сүргээ харж хамгаалж байсан тухай (1 Самуел 16:11) өгүүлэхдээ, энэ нь бодит хонин сүргийн талаар хэлж байгааг бид мэддэг. Учир нь тэр хоньчин байсан. Харин Илчлэл номд Иохан луу (Илчлэл 12:3), арслан, баавгай шиг зүйл харсан гэж хэлэхэд, эдгээр амьтад нь ямар нэг зүйлсийг бэлгэдэж буйг бид ойлгодог. Учир нь Илчлэл ном олон бэлгэдлийг агуулдаг.

1 Хаад 5:6 эшлэлд Соломон сүмийн барилгад зориулж хуш мод худалдаж авсан тухай өгүүлэхэд, тэр бодит мод худалдаж авсан гэдгийг бид мэддэг. Харин Дуулал 1:3 эшлэлд зөвт хүн урсгал усны дэргэдэх мод адил гэж өгүүлэхэд, энэ нь харьцуулалт ашиглан илэрхийлж буй санаа болохыг бид ойлгодог. Мөн Исаиа 55:12 эшлэлд модод алгаа таших болно гэж бичигдсэн нь, асар их баяр хөөрийн улмаас байгаль хүртэл баярлан догдолж буйг илэрхийлдэг.

Утга зохиолын хэлбэрийг ойлгох нь Библийн хөрвүүлэгт чухал юм. Яруу найргийн ном (Дуулал) нь захидлаас (Ром) өөр байдлаар утга санааг дамжуулдаг. Эдгээр ялгааг ойлгох нь ном тус бүрийг бичигчийн санаа зорилгыг зөв хөрвүүлэхэд тусалдаг. Энд Бичвэрт багтсан утга зохиолын гол төрлүүдийг танилцуулсан.

Утга зохиолын хэлбэр: Түүх

Библийн ихэнх хэсэг нь түүх юм: Хуучин гэрээний эхний таван ном (Пентатух), Түүхэн номууд, Сайнмэдээний номууд, Үйлс болон бусад богино хэсгүүд нь бодит хүмүүс ба үйл явдлуудын талаарх үнэн зөв, түүхэн тэмдэглэлүүд юм.

(Библид мөн эш үзүүлэгчдийн өгүүлсэн уран сайхны дүрслэл болон Есүсийн заасан сургаалт зүйрлэлүүдийг агуулдаг. Эдгээр нь түүхэн үйл явдлуудтай харьцуулахад өөр байдлаар хөрвүүлэгддэг тул дараагийн хэсэгт ярилцах болно).

Түүхийг уншихдаа асуух асуултууд

Түүхэн Бичвэрийг уншихдаа дараах асуултуудыг өөрөөсөө асуугаарай:

(1) Хүүрнэл нь юуны талаар өгүүлдэг вэ?

Түүхийг уншихдаа бид хүүрнэлийн бүтэц, зохион байгуулалтыг анхаарч хардаг. Жишээ нь, Лукийн Сайнмэдээ Есүсийн Галил дахь үйлчлэлээс эхэлж, дараа нь Түүний Йерусалим руу хийсэн аяллыг харуулж, улмаар Түүний дагалдагчийн талаарх сургаалыг онцолдог. Лук номын төгсгөлд Есүсийн Йерусалимд цовдлогдож, үхлээс амилсан тухай өгүүлдэг. Үйлс номд анхны чуулганы өсөлтийг харуулдаг. Лук газарзүйн дарааллыг ашиглан, сайнмэдээний тархалтыг тайлбарладаг: эхлээд сайнмэдээ Йерусалимд тунхаглагдсан, дараа нь Иудей ба Самариар дамжин, эцэст нь Ром дахь Паулын үйлчлэлээр дэлхийн хязгаарт хүрснийг өгүүлсэн.

(2) Хүүрнэлд ямар хүмүүс оролцож байна вэ?

Библийн түүхэн хүмүүсийн талаар уншихдаа бид тэдний давуу талаас суралцаж, сул талаас нь зайлсхийх сургамжийг авдаг. Бид дараах асуултуудыг тавьж болно: "Нехемиаг юу үр нөлөөтэй удирдагч болгосон бэ?" "Саулын бүтэлгүйтэл, Давидын амжилтын хооронд ямар ялгаа байсан бэ?" "Петр, Паул нар сайнмэдээг тунхаглахдаа ямар арга барил ашигласан бэ?" Библийн түүхэн Бичвэрүүдийг унших нь бидэнд тухайн цаг үеийн хүмүүсийг ойлгож, тэднээс суралцах боломж олгодог.

(3) Түүхэн үйл явдал нь дагаж хэрэгжүүлэх жишээг өгч байна уу?

Түүхийг уншихдаа үйлдлүүд нь бидний дагаж хэрэгжүүлэх жишээ болж байгаа эсэхийг асуух хэрэгтэй. Түүхэн үйл явдал нь Бурхан ард түмнээсээ хүсэж буй загвар жишээг харуулсан байх боломжтой. Харин эсрэгээрээ, түүхэн үйл явдал нь дагах жишээ биш, зүгээр чухал түүхийг өгүүлсэн байж болно.

Нэгэн номлогч Шүүгчид 21-р бүлгийг эхнэр авах арга замын талаар заахдаа ашигласан тухай жишээг та санаж байна уу? Тухайн номлогч "Шүүгчид ном энэ үйлдлийг дагахыг тушааж байгаа юу эсвэл зөвхөн энэ үйлдлийг тайлбарлаж байгаа юу?" гэж асууж үзсэнгүй. Шүүгчид 21-р бүлэг нь Израилын үйл хэргийг тайлбарлаж байгаа бөгөөд ийнхүү үйлдэхийг тушаагаагүй.

Түүхийг уншихдаа бид "Энэ нь дагах жишээ мөн үү?" эсвэл "Энэ нь зүгээр л тодорхойлолт уу?" гэж асуух ёстой. Олон тохиолдолд хариулт нь маш энгийн байдаг. Шүүгчид 21-р бүлэг нь эхнэр хулгайлахыг бидэнд тушаасан гэж хэн ч бодохгүй шүү дээ! Гэсэн хэдий ч багагүй тохиолдолд мөн тодорхойгүй зүйл байдаг. Үйлс ном нь ялангуяа төвөгтэй байдаг. Бурхан анхны чуулганы өдрүүдэд хийсэн гайхамшигийг өнөөгийн чуулганууд хүсэн хүлээх ёстой юу? Сүнсээр дүүрсэн итгэгч хүн бүр өөр хэлээр ярих ёстой юу? гэх мэт.

Багц хэсэг нь бидэнд дагах жишээ өгч буй эсэхийг хэрхэн мэдэж шийдэх вэ? Хэрэв бид энэ асуултанд зөв хариулахгүй бол Шүүгчид болон Үйлс зэрэг түүхэн номуудыг буруу уншина. Хэрэв бид энэ асуултанд зөв хариулахгүй бол хувийн сонирхлоосоо хамааран Библийн нарийн ширийн зүйлийг онцолж, эсвэл үл тоомсорлох болно. Дараах зарчмыг санаарай: **Хэрэв түүхэн багц хэсэг бидэнд дагах жишээ өгч байгаа бол бид үүний талаарх тодорхой зааварчилгаа, эсвэл бусад багц эшлэлд давтагдсан жишээг олох боломжтой.**

Жишээлбэл, Үйлс ном нь анхны Христэд итгэгчид сайнмэдээг түгээхдээ маш их хүсэл эрмэлзэлтэй байсныг харуулдаг. Бид үүнийг дагах жишээ гэдгийг мэднэ, учир нь Матай 28:19-20 эшлэл бидэнд дагалдагчдыг бэлтгэхийг тушаадаг. Үйлс ном нь чуулган дахь Ариун Сүнсний үйл ажиллагааг харуулдаг. Бид үүнийг чуулганы амьдралын хэвийн нэг хэсэг байх ёстойг мэднэ, учир нь Есүс Ариун Сүнсээр дагалдагчдынхаа үйлчлэлийг хүчирхэгжүүлнэ гэж амласан (Үйлс 1:8). Хэрэв бид сайнмэдээг түгээж чадахгүй эсвэл үйлчлэлдээ Ариун Сүнсний хүчийг харуулж чадахгүй бол бид Үйлс номын загварт нийцэхгүй байна. Эдгээр хүүрнэлүүд нь чуулганы жишээ юм.

Үйлс ном нь Христэд итгэгчид бүх зүйлийг хамтаар эзэмшиж, айлын гэрт мөргөл хүндэтгэл өргөдөг байсныг мөн өгүүлдэг. Эдгээр зан үйлийг Библид тушаасан уу? Үгүй. Петр Ананиад хэлсэнчлэн эд баялгаа хуваалцах нь албадлагын бус, сайн дурын үйлдэл байсан (Үйлс 5:3-4). Үүнтэй адилаар, Библи биднийг айлын гэрт мөргөж хүндэтгэхийг тушаадаггүй.²²

Эдгээр зан үйлийг Бичвэрт тушаагаагүй учраас үүнийг чуулганы түүхийн хэсэг болохоос, дагах жишээ биш хэмээн бид дүгнэх боломжтой. Үйлс нь түүхийн тодорхой нэгэн цаг үеийг тодорхойлдог ч, бүх цаг үед хэрэгжүүлэх тушаал биш юм.

²² Өнөөдөр дэлхийн зарим оронд итгэгчид олон нийтийн барилгад цугларахаас айлд мөргөл хүндэтгэл өргөх нь илүү аюулгүй гэж үздэг. Энэ нь нийтлэг тушаал биш, харин орон нутгийн нөхцөл байдалд үндэслэсэн юм.

(4) Энэ түүхэн үйл явдал ямар зарчмуудыг зааж байна вэ?

Паулын хэлснээр, Библийн түүх нь биднийг зааварчлахын төлөө өгөгдсөн юм (1 Коринт 10:11). Энэ нь Бурхан хүмүүний түүхэнд хэрхэн ажилладаг, Бурханд юу таалагддаг эсвэл таалагддаггүйг харуулдаг. Уншигч бид түүхэн хүүрнэлээс зарчмуудыг олох ёстой.

"Израилын ард түмэн Бурханы эсрэг гомдоллож, шийтгүүлсэн. Та нар Бурханы эсрэг гомдоллож болохгүй" гэж хүүрнэлд ховор өгүүлдэг. Харин Израил Бурханы эсрэг гомдоллосон гэж бидэнд хэлдэг бөгөөд бид тэдний нүглийн үр дагаврыг харж, заагдсан зарчмыг ойлгох ёстой. Шууд тушаахын оронд түүх нь дагах эерэг жишээ, зайлсхийх сөрөг жишээг харуулдаг. Иошуа номоос Бурханыг дуулгавартай дагах нь ялалтад хөтөлдөг гэдгийг харж болно; Шүүгчид номоос дуулгаваргүй байдал нь эмх замбараагүй байдалд дагуулдгийг харж болно.

Үйлс ном

Үйлс ном нь Есүсийн дэлхий дээрх амьдралын дараахан өрнөсөн үйл явдлын түүхэн тэмдэглэл юм. Шинэ гэрээний уншигчдын хувьд Үйлс ном нь чуулгануудад бичигдсэн захидлуудын хам сэдвийг өгүүлдэг.

Үйлс ном нь Ариун Сүнсээр хүчирхэгжсэн чуулганыг сайнмэдээг түгээх үүрэг даалгавраас нь юу ч зогсоох боломжгүй байсныг харуулдаг. Чуулган нь онол сургаалын асуудал, дотоод хуваагдал, хуурамч сургаал заадаг багш нар, зохион байгуулалтын асуудлууд, хоёр нүүртнүүд, чөтгөрийн эсэргүүцэл, нийгэм болон засаг төрийн хавчлага, аяллын үеэрх гамшиг сүйрэл зэрэгтэй тулгарч байжээ. Гэсэн хэдий ч чуулган баяр хөөртэй, ялалттайгаар урагшилсан. Ариун Сүнс чуулганыг хүчирхэгжүүлсэн учраас хувь хүмүүс болон хамт олон сайнмэдээгээр өөрчлөгдөж байлаа.

Лук Үйлс номыг бичсэн зорилго нь сайнмэдээг дэлхий даяар түгээх үүргээ чуулган итгэлтэйгээр үргэлжлүүлэхэд дэм өгөх байв. Энэхүү зорилго нь номын туршид дараах зүйлсээс харагддаг. Бусад ижил төстэй зүйлүүдийг ч нэмж болно.

- Дагалдагчид нь сайнмэдээг дэлхийн хамгийн алслагдсан хязгаарт хүргэнэ хэмээн Есүс хэлсэн байдаг (Үйлс 1:8).
- Пентэкостын өдөр сайнмэдээг номлоход Ариун Сүнс дагалдагчдыг хүчирхэгжүүлж, 3000 хүн итгэжээ (Үйлс 2:41).
- Хүмүүс өдөр бүр чуулганд нэмэгдсээр байсан (Үйлс 2:47).
- Иудейн удирдагч Гамалиел Бурханы ажлыг зогсоох боломжгүй гэж хэлсэн (Үйлс 5:39).
- Хавчигдсан итгэгчид Йерусалимыг орхин, сайнмэдээг түгээсэн (Үйлс 8:1, 4).
- Хавчигч байсан удирдагч итгэлд ирж, хамгийн агуу сайнмэдээг тунхаглагч болсон (Үйлс 9:13-22).

- Паул болон бусад хүмүүс тухайн цаг үед мэдэгдэж байсан дэлхий ертөнц даяар илгээлтийн аяллыг хийжээ (Үйлс 13-21).
- Паул удирдагчдад номлосон (Үйлс 24-26).
- Паул эзэнт гүрний нийслэл Ромд номлосон (Үйлс 28).

Үйлс номын хэрэгжүүлэлт

Заримдаа уншигч нь Үйлс ном бидэнд илгээлтийн ажил хэрхэн хийх, баптисм хүртээх, чуулганыг зохион байгуулах, Ариун Сүнснийг **хэрхэн** мэдрэх талаар заадаг гэж үздэг. Үйлс ном нь анхны чуулган эдгээр зүйлийг хэрхэн хийсэн талаарх түүхийг тэмдэглэсэн хэдий ч, бичигч нь Үйлс номыг чуулганы үйлчлэлийн гарын авлага байлгах зорилгоор бичээгүй юм.

Бид Үйлс номд бичигдсэн бүх зүйлийг чуулган хийх ёстой гэж үзэх ёсгүй. Харин чуулган зовлон бэрхшээлтэй хэрхэн тулгарч байсныг харахдаа бид маш их зүйлийг сурч болно.

Үйлс ном нь чуулган сайнмэдээг улам бүр алслагдсан газарт хүргэж, үргэлж урагшилж, Ариун Сүнсний хүч, мэргэн ухаанаар бүх асуудлыг даван туулж, практик асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай бүтцийг хөгжүүлэх ёстойг бидэнд харуулдаг.

Утга зохиолын хэлбэрүүд: Хуучин гэрээний хууль

Хуучин гэрээний хуулийн үнэ цэн

Зарим итгэгчид Хуучин гэрээний христитгэлийн зарчмуудыг дүрсэлдэг түүхэн хэсгийг эс тооцвол бусад нь бага ач холбогдолтой гэж боддог. Тэд Хуучин гэрээний хуулиуд өнөөгийн итгэгчдэд ямар ч хэрэгжүүлэлт болохгүй гэж үздэг.

Элч Паул итгэгчдэд хандан Хуучин гэрээний хуулийн өөрчлөгдсөн хэрэглээний талаар хэд хэдэн удаа бичсэн байдаг. Тэрээр Христийн үхэл хуулийн буруутгалыг үгүй болгосон тул бид хуулийн ёс заншлыг дагадаггүй итгэгчдийг шүүх ёсгүй юм хэмээн өгүүлсэн байдаг (Колоссай 2:14-17). Тэрээр элч нарыг цаашид Иудейн ёс заншлын дагуу амьдрах шаардлагагүй болсон гэж хэлсэн (Галат 2:14-16). Тэрбээр харь үндэстэн пасторыг хөвч хөндүүлэхийг шаардахад татгалзжээ (Галат 2:3). Тэрээр хүн бүр Иудейн хоолны дэглэм, онцгой өдрүүдийн талаар өөрийн мөс чанараа дагахыг зөвлөөд, итгэгчид эдгээр шаардлагын талаар бие биенээ шүүх ёсгүй гэж хэлсэн (Ром 14). Паул итгэгч хүн хуулийн хувьд үхсэн бөгөөд хуулийн тодорхой шаардлагыг биелүүлж бус, харин зорилгыг нь биелүүлэх байдлаар Бурханд бид үйлчилдэг хэмээжээ (Ром 7:4, 6). Хамгийн чухал нь тэрээр хуулийн үйлсээр хэн ч зөвтгөгдөхгүй гэж хэлсэн (Ром 3:20).

Хуучин гэрээний хууль нь итгэгч хүний хувьд чухал хэвээр байгааг харуулсан олон хэсгийг Библи бидэнд харуулдаг. Хуучин гэрээний хууль нь Бурханы мөн чанарыг илэрхийлдэг тул Бурханд хайртай хүн түүний хуульд хайртай байдаг (Дуулал 1:2, Дуулал 119:7, 16, 70-г үз). Паул хууль нь ариун, зөв, сайн гэж хэлсэн (Ром 7:12). Тэрээр мөн "Бичвэр бүр Бурханы амьсгалснаар байгаа бөгөөд заах, зэмлэх, залруулах,

зөвд чиглүүлэхэд тустай” (2 Тимот 3:16) гэж хэлсэн. Тухайн цаг үед Бичвэр гэдэг нь гол төлөв Хуучин гэрээг хэлдэг байжээ. Паул Тимотод Бичвэрүүд нь авралд хүргэх мэргэн ухааныг өгөх чадалтай хэмээн бичсэн байдаг (2 Тимот 3:15). Эдгээр нь бид итгэгч хүний хувьд Хуучин гэрээний аль ч хэсгийг орхигдуулах ёсгүй гэдгийг хэлж байна. Хэдийгээр Бурханы хуулийг сахиснаар бид аврагдахгүй ч, Түүнийг баярлуулахын тулд бидэнд хандсан Бурханы хүслийг ойлгож мэдэхийг бид хүсдэг (2 Коринт 5:9-10).

Хуучин гэрээний хуулиудын ангилал

Хуучин гэрээний хуулийг итгэгчид өнөөдөр хэрхэн ашиглах талаар ойлгоход туслах үүднээс бид зарим хуулийн ангиллыг тодруулж байна.

Ёслолтой холбогдох хуулиуд нь тахил өргөх, зан үйл, хоолны дэглэм, онцгой өдрүүдийн талаар байжээ. Паул эдгээр хуулиуд нь Христээр биелэлээ олсон гэж хэлсэн юм (Колоссай 2:16-17). Еврей ном Хуучин гэрээний ёслолуудын утга учрын талаар маш олон хэрэгжүүлэлтийг өгүүлдэг. Жишээлбэл, эртний сүмд хэрэглэгддэг зүйлсийг цусаар ариусгадаг байсан нь Христийн цусыг бэлгэддэг бөгөөд энэ нь итгэгчдийн ариусгадаг (Еврей 9:14, 21-24).

Иргэний хуулиуд нь Израил үндэстний хувьд өгөгджээ. Иргэний хуулиудыг хувь хүмүүс иргэд бус, харин томилогдсон эрх мэдэлтнүүд хэрэгжүүлдэг байв. Жишээлбэл, илбэ ховс, хараал жатга хийдэг хүмүүсийг цаазаар авах ёстой байжээ (Гэтлэл 22:18). Гэхдээ шүүх хурал, цаазаар авах ялыг хувь иргэд бус, харин тогтоосон эрх бүхий хүмүүс гүйцэтгэдэг. Дэд хууль 17:2-12 эшлэл нь орон нутгийн засаг захиргаа гэрчүүдийг сонсож, шударга ёсыг тогтоох үйл явцыг тайлбарладаг. Илүү ноцтой хэргүүдийг дээд шатны шүүх авч хэлэлцдэг байв.

Өнөөдөр улс үндэстний хуулиуд өөр байж болох бөгөөд хувь итгэгч нь эртний Израилын иргэний хуулийг хэрэгжүүлэхэд хувийн хариуцлага хүлээх ёсгүй юм. Гэсэн хэдий ч эдгээр хуулиуд бидэнд Бурханы зөв шударга байдал, Түүний хүмүүсээс хүсдэг зөв шударга байдлын талаар зааж сургадаг. Жишээлбэл, Гэтлэл 22:18-д өгөгдсөн хууль нь хүн илбэ ховс, хараал жатга хийх нь буруу гэдгийг бидэнд хэлдэг. Бусад иргэний хуулиуд нь Бурхан үндэстнээс ядуусыг хамгаалж, бүх хүмүүст ялгаварлалгүй хандаж, шударга бус явдлаас урьдчилан сэргийлэхийг хүсдэг гэдгийг бидэнд хэлж өгдөг (Дэд хууль 24:14-15, 17-22).

Библийг хөрвүүлэгч нь эхлээд Хуучин гэрээний иргэний хуулийн зарчмыг ойлгохыг хичээгээд дараа нь итгэгч хүн энэ зарчмыг өнөөдөр хэрхэн хэрэгжүүлэх ёстойг авч үздэг. Бид "Бурханы санааг чилээсэн зүйл юу байсан бэ? Бурханы зорилго юу байсан бэ? Бурханы хувьд юу үнэ цэнтэй гэдгийг энэ хууль харуулж байна вэ?" гэж асуух нь тустай юм. Дараа нь бид өнөө үед Бурханыг баярлуулахуйц хэрэгжүүлэлт нь юу болохыг анхаарч үздэг.

Ёс суртахууны хуулиуд нь зөв амьдралын төлөөх Бурханы байнгын шаардлагыг сануулдаг. Ёс суртахууны хуулиуд нь шударга байдал, бэлгийн харилцаа, шүтээн шүтэх болон бусад асуудлын талаар өгүүлдэг (Гэтлэл 20:4-5, 13-16). Ёс суртахууны хуулиудын олонх нь Шинэ гэрээнд давтагдсан байдаг. Ёс суртахууны хуулиуд нь өнөөгийн улс үндэстнүүдийн иргэний хуулиудын үндэс суурь болдог боловч улс үндэстнүүдийн хуулиуд Бурханы хуулийг бүрэн эсвэл тууштайгаар дагадаггүй. Бурханы хүмүүст зориулсан хуулиуд нь нийгмийн шаардлагаас хавьгүй өндөрт байдаг.

Хуулиудыг ангилсан бидний ангилал төгс биш юм. Хуучин гэрээний багц хэсгүүд заримдаа дээрх гурван ангиллын бүх хуулиудыг болон ангилахад хэцүү хуулиудыг багтаасан байдаг. Хэдийгээр төгс биш ч, энэ ангиллын систем нь Хуучин гэрээний хуулиуд Шинэ гэрээний итгэгчдэд хэрхэн хамааралтай болохыг ойлгоход тусалдаг.

Хуучин гэрээний хуулийг хөрвүүлэх нь²³

Хуучин гэрээний хуулийг судалж байхдаа судалж буй хуулийнхаа илүү өргөн хам сэдвийг авч үзээрэй. Эргэн тойрных нь хүүрнэлийг анзаараарай. Хууль нь түүний ойрын хам сэдэвт хэрхэн нийцэж байна вэ?

Дараа нь эдгээрийг асуу:

(1) Энэ текст анхны сонсогчдын хувьд юу гэсэн утгатай байсан бэ?

Израилчууд хуулийг хэрхэн хөрвүүлж байсныг ойлгохын тулд дараах асуултуудыг асуу:

- Хууль ба эргэн тойрны эшлэлүүдийн хооронд холбоо байна уу?
- Хууль нь Израилын түүхтэй холбоотой тодорхой нөхцөл байдалд хариу үйлдэл үзүүлж байна уу?
- Хууль нь Хуучин гэрээний тахилын системтэй холбоотой юу?

(2) Библийн цаг үеийн сонсогчид болон бидний цаг үеийн хооронд ямар ялгаа байна вэ?

Бидний ертөнц болон Хуучин гэрээний хооронд Шинэ гэрээ болон бидний ертөнц хоорондынхоос илүү их ялгаа байдаг. Жишээлбэл:

- Бид цаашид нэг төвлөрсөн Сүмд очих шаардлагагүй. Ариун Сүнс итгэгч бүрийн дотор оршдог.
- Бид золиос тахилаар дамжуулан Бурханд хандах шаардлагагүй. Христ бүгдийн төлөө нэг удаа үхсэн (Еврей 10:10).

²³ Энэ хэсгийг J. Scott Duvall ба J. Daniel Hays нарын *Grasping God's Word* (Grand Rapids: Zondervan, 2012) номоос авсан.

- Бурханы Үг бол манай улс үндэстний хууль биш. Бид энэ дэлхий дээрх төр засгуудын дор амьдардаг.

(3) Энэ текстэд ямар зарчмуудыг зааж байна вэ?

Хуучин гэрээний хуулийн шаарддаг тодорхой үйлдэл өнөөдөр шаардлагагүй байж болно. Бид хуулийн зааж буй байнгын зарчмыг хайх ёстой. Энэ бол Бичвэрийг эртний ертөнцөөс өнөөгийн ертөнц рүү шилжүүлдэг гүүр юм. Энэ зарчим нь Хуучин гэрээний сонсогчид болон орчин үеийн сонсогчид аль алинд нь хамааралтай юм.

Зарчмыг 1-2 өгүүлбэрээр илэрхийл. Зарчим нь үнэхээр Библийнх мөн гэдгийг батлахын тулд дараах асуултуудыг асуу:

- Энэ зарчмыг хууль тодорхой харуулж байна уу?
- Энэ зарчим бүх цаг үе, бүх газрын хүмүүст хамаарах уу?
- Энэ зарчим Бичвэрийн бусад хэсэгтэй нийцэж байна уу?

(4) Шинэ гэрээнд энэ зарчмыг ямар нэгэн байдлаар авч ашигласан уу?

Дээрх гурван үндсэн асуулт нь Бичвэрийн аль ч хэсгийг хөрвүүлэхэд ашиг тустай байдаг. Хуучин гэрээний текстийг судлахдаа энэ сүүлчийн асуултыг хөрвүүлэх үйл явцад нэмэх ёстой. Хэрэв та Хуучин гэрээний багц хэсгээс бүх нийтэд хамаатай зарчмыг олсон бол энэ зарчим нь өнөөдөр ч хүчин төгөлдөр хэвээр байна. Гэсэн хэдий ч Шинэ гэрээний хэрэгжүүлэлт нь Хуучин гэрээний цаг үеэс өөр байдлаар харуулж болно.

Жишээлбэл, Гэтлэл 20:14 эшлэлд "Чи бүү завхайр" гэж тушаадаг. Уулан дээрх сургаалдаа Есүс үүнийг зөвхөн үйлдлээс гадна бодолд хүртэл хамааруулж өргөжүүлсэн байдаг (Матай 5:28). Есүсийн сургаал нь Гэтлэл 20:14 эшлэлийн зарчмыг хүчингүй болгоогүй бөгөөд харин түүний хэрэгжүүлэлтийг гүнзгийрүүлсэн.

Утга зохиолын хэлбэр: Яруу найраг

Библи олон яруу найргийг багтаасан ном. Иов, Дуулал, Сургаалт үгс, Соломоны дуун зэрэг номууд нь бараг бүхэлдээ яруу найргийн хэлбэрээр бичигдсэн бөгөөд Номлогчийн үгс ном зарим яруу найргийг агуулдаг. Мөн эш үзүүлэгчдийн номуудад олон яруу найраг багтдаг. Яруу найраг нь хүчтэй сэтгэл хөдлөлийг илэрхийлэхэд ашигладаг бичгийн хэлбэр юм. Энэ нь түүхэн үйл явдлын нарийн ширийн зүйлсийг дамжуулах эсвэл логик оюун дүгнэлт үүсгэх зорилгогүй юм. Яруу найргаас бид найрагчийн зүрх сэтгэлийг сонсдог. Ялангуяа яруу найрагт нь илэрхийлэгдсэн сэтгэл хөдлөлд бид мэдрэмжтэй ханддаг.

Яруу найраг нь ихэвчлэн дүрслэл, хэлц хэллэг ашигладаг бөгөөд үүнийг шууд утгаар нь ойлгох шаардлагагүй юм.

Дуулал дахь яруу найргийн жишээ: "[Бурхан] Та тэдний нүүр өөд сумаа онилон бэлэн болгоно" (Дуулал 21:12). Бурханд харвах нум сум байхгүй гэдгийг бид шууд утгаар нь ойлгож байна. Бичигч энд Бурхан өөрийн дайсан байхаар сонгосон хэнийг ч ялах

чадвартай гэдгийг өгүүлж байна. Бичигч итгэгчдийг Бурханы ялалтад итгэл төгс байхыг ятгаж байна.

Яруу найраг нь ихэвчлэн Библийн өөр хэсэгт байгаа энгийн үнэнийг төсөөлөл ашиглан ойлгуулах зорилготой байдаг. Хэрэв Бичвэрийн энгийн хэсэгт үүнийг заагаагүй бол яруу найргийн хэсгээс бид сургаал эсвэл дагах хэрэгжүүлэлтийг хөгжүүлэх шаардлагагүй юм.

Еврей яруу найраг нь заримдаа дууны хэмнэлийн хэлбэрийг ашигладаг боловч англи хэлний уламжлалт яруу найраг шиг яруу хэмнэлгүй байдаг. Еврей яруу найргийн онцлогийг ойлгох нь үүний яруу сайхныг илүү үнэлэхэд бидэнд тусалдаг.

Еврей яруу найргийн онцлог шинжүүд

Параллелизм

Еврей яруу найраг нь ихэвчлэн параллелизмд суурилдаг. Энэ нь зэрэгцээ хоёр мөр, өгүүлбэрийг хамтад нь ашигладаг. Хоёр дахь өгүүлбэр нь эхний өгүүлбэр дэх зарим утга санааг нэмдэг боловч үргэлж нэмэлт санаа гаргадаггүй.

Параллелизмын гурван төрөл бий:

- Нэг эшлэл ижил утга санааг хоёр аргаар илэрхийлдэг (Дуулал 25:4, Дуулал 103:10, Сургаалт үгс 12:28).
- Нэг эшлэл дэх хоёр зүйл нь хэрхэн бие биенээсээ ялгаатай болохыг харуулдаг (Дуулал 37:21, Сургаалт үгс 10:1, 7).
- Эхний өгүүлбэрт өгүүлсэн утга санааг дараагийн өгүүлбэрт дэлгэрүүлж, нарийн ширийн зүйлсийг харуулдаг (Дуулал 14:2, Дуулал 23:1, Сургаалт үгс 4:23).

Параллелизмыг хөрвүүлэхдээ хоёр дахь мөр нь эхний мөрд ямар утга санааг нэмж байгааг асуу. Энэ нь эхний мөрийн санааг тодруулж байна уу? Эхний мөрийн утга санаатай эсрэгцэж байна уу, эсвэл шинэ мэдээлэл нэмж байна уу?

Дүрслэл, хэлц үг

Библийн бүх ном дүрслэл хэлц үгийг агуулдаг ч эдгээр нь яруу найрагт илүү чухал байдаг. Еврей яруу найрагт орсон дүрслэл хэлц үгүүд нь:

1. Ямар нэгэн байдлаар төстэй хоёр зүйлийг харьцуулах: “ЭЗЭН бол миний Хоньчин” (Дуулал 23:1).
2. Санааг онцлон тэмдэглэхийн тулд хэтрүүлэг ашиглах. Давид уй гашуугаа илэрхийлэхдээ: “Хайлалд минь шөнө бүр ор минь живэв” (Дуулал 6:6).
3. Ямар нэгэн зүйлийн талаар хүнжүүлж ярих: “Мэргэн ухаан гудамжинд дуугаа хадааж, олон хөлийн газар дуугаа өргөнө” (Сургаалт үгс 1:20).

4. Хүний шинж байдлаар Бурханыг дүрслэх: “Түүний мэлмий хүмүүнийг ажиглаж, Түүний харц хүмүүнийг шалгадаг” (Дуулал 11:4).

Яруу найргийн дүрслэл хэлц үгийг хөрвүүлэхдээ энгийн өгүүлбэрт ойлгогдохгүй байсан зүйлийг дүрслэл хэрхэн харуулж байгааг асуу. Жишээлбэл, “ЭЗЭН бол миний Хоньчин” гэдэг нь “Бурхан надад анхаарал тавьдаг” гэдгээс илүү өргөн утгатай. Энэ нь Түүний халамжийн талаар өгүүлдэг ч, энэ нь Түүний хайр, удирдлага, дайснаас хамгаалах хамгаалалт, хайр халамжаас нь холдож төөрсөн үед сахилгажуулалт болдгийг ч өгүүлж байна.

Дуулал ном

Дуулал номын төрлүүд

Хэд хэдэн төрлийн Дуулал бий. Магтаалын Дуулал нь Бурханы шинж чанар, ерөөлүүд, оролцооных нь төлөө Түүнийг өргөмжилдөг (Дуулал 23, 29). Бурханы хуулийн тухай Дуулал нь Бурханы мэргэн ухаан, зөв шударга байдлыг магтдаг (Дуулал 119). Гашуудлын Дуулал нь Бурханд мэдрэмжээ илэрхийлж, Түүний тусламжийг хүсэж, хүсэлд нь захирагддаг (Дуулал 3, 13, 22). Хааны тухай Дуулал нь Бурханыг дээдлэн өргөмжилдөг хааны ачаар үндэстэнд ирдэг ерөөлийг дүрсэлдэг бөгөөд эдгээр Дуулал нь ирээдүйн Мессиагийн хаанчлал руу мөн хандуулдаг (Дуулал 21, 72). Зүхлийн Дуулал нь Бурхан бузар муу хүмүүсийг шүүж, зарц нараа хамгаалахыг гуйдаг (Дуулал 69:21-28, Дуулал 59). Дууллын бусад төрлүүдийг ч нэрлэх боломжтой.

Дуулал номын хэрэгжүүлэлт

Шинэ гэрээ бидэнд Дуулал номыг ашиглах зарим аргыг хэлж өгдөг. Дуулал нь бидний Бурханд хандсан мөргөл хүндэтгэлийг илэрхийлдэг (Ефес 5:19). Энэ нь онол сургаалын болон урамшуулах ач холбогдолтой (Колоссай 3:16).

Дуулалд илэрхийлэгдсэн хандлага бүр нь бидэнд байх ёстой хандлагын жишээ биш юм. Гэсэн хэдий ч бид Дуулал номоос хандлага бүрээ Бурханд захируулах ёстойг сурдаг. Залбирлаараа та мэдэрч буй бүхнээ Бурханд илэрхийлж болно. Цөхрөл, айдас, уур хилэнтэйгээ тэмцэлдэж буй итгэгч хүний итгэлийг Бурхан сэргээж чадна гэдгийг Дуулал ном бидэнд харуулдаг.

Утга зохиолын хэлбэр: Мэргэн ухааны зохиол

Иов, Сургаалт үгс, Номлогчийн үгс, Дуулал болон Иаков захидлын зарим хэсгүүд нь мэргэн ухааны зохиол төрөлд багтдаг. Сургаалт үгс болон Номлогчийн үгс номууд нь амьдралын зарчмуудад суралцаж буй залуу уншигчдад хандан сургаал зааврыг өгдөг.

Иов ном

Иов номын урт багц хэсгүүд нь Иовыг оролцуулаад өөр хэдэн хүний яриаг өгүүлдэг. Ярьж буй хүмүүс нь янз бүрийн үзэл бодлыг илэрхийлдэг. Библийг хөрвүүлж буй хүн тухайн хүмүүсийн яриаг Библийн зарчим болгон заах ёсгүй. Иов ном нь Бурханы үг,

үзэл бодлыг эдгээр ярианаас ялгаж, шүүмжлэлт байдлаар задлан шинжилдэг. Иов 38-42-р бүлэгт Бурхан тэдгээр ярианд хариулдаг бөгөөд Иов 1-2 бүлэг нь Бурханы үзэл бодлыг мөн харуулдаг.

Утга зохиолын хэлбэр: Сургаалт үг

Сургаалт үгс нь амьдралын ажиглалтыг товч бөгөөд тодорхой илэрхийлдэг. Энэ нь ихэвчлэн амьдралд тохиолддог зүйлсийг өгүүлдэг ч бүгдийг хамруулсан гэсэн үг биш юм.

Сургаалт үгийг хөрвүүлэх нь өнгөц харахад амар хялбар байж болох ч энэхүү утга зохиолын хэлбэр нь өөрийн онцлог бэрхшээлийг агуулдаг. Сургаалт үг нь амьдралын талаарх ерөнхий зарчмыг илэрхийлдэг боловч энэ нь бүх нөхцөл байдалд хамаарахгүй. Жишээлбэл, Сургаалт үгс 21:17-д:

Зугаа цэнгэл хөөвөөс хоосрол ирж, дарс, тосонд дурлаваас ядуурал ирнэ.

Үүнийг ерөнхий дүрэм гэж харвал ажил хийхээс илүү зугаа цэнгэлийг хайрладаг хүмүүс ядууралд хүрэх хандлагатай байдаг. Энэхүү ерөнхий дүрэм нь үнэн боловч үүнд хамаарахгүй олон тохиолдол байдаг. Зарим баян хүмүүс өөрөө хөдөлмөрлөж олж аваагүй өв хөрөнгөтэй байдаг. Тэд өдөржин архи ууж, тоглож өнгөрөөдөг боловч баян хэвээр байдаг. Бусад хүмүүс шаргуу хөдөлмөрлөдөг боловч ядуу хэвээр байх нь бий. Сургаалт үг нь бүх хүнд хамаатай дүрэм биш, харин ерөнхий зарчмыг заадаг.

Сургаалт үгс номд төдийгүй Библийн өөр олон хэсэгт сургаалт үгийг агуулдаг. Есүсийн айлдсан сургаалт үгийн жишээ: "...Илд агсагч бүхэн илдээр хөнөөгдөнө" (Матай 26:52). Хүчирхийлэлд өртөж амь эрсдээгүй хүчирхийлэгч хүмүүс байсаар ирсэн. Дахин хэлэхэд сургаалт үг нь ерөнхий ажиглалтын хувьд үнэн боловч бүх нөхцөл байдалд хамаарахгүй.

Сургаалт үгийг хөрвүүлэхдээ бид дараах асуултуудыг асуух ёстой:

(1) Энэ Бичвэр ямар ерөнхий зарчмыг зааж байна вэ?

Сургаалт үгс 21:17 эшлэл дэх зарчим нь шаргуу хөдөлмөр, сахилга батын үнэ цэн юм. Ихэнх сургаалт үг нь нэг догол мөрөнд багтаах боломжтой зарчмыг хураангуйлдаг.

(2) Энэ зарчимд хамаарахгүй тохиолдлууд нь юу байж болох вэ?

Сургаалт үгс 21:17 эшлэлээс бидний өдөр тутмын амьдралд хамаарахгүй олон тохиолдлыг харах боломжтой. Энэ нь зарчимтай зөрчилдөх зүйл биш, харин зүгээр л мэргэн хүн ерөнхий зарчмуудад хамааралгүй тохиолдол байдгийг мэддэг.

(3) Библийн ямар хүмүүс энэ зарчмыг амьдралаараа харуулдаг вэ?

Сургаалт үгийг хөрвүүлэхдээ сургаалт үгийн зарчмыг амьдралаараа харуулдаг Библийн дүрийг харах нь тустай байж болно. Жишээлбэл, Сургаалт үгс номд "Бардам занг шившиг дагалдана даруу занд ухаан оршино" (Сургаалт үгс 11:2) гэж хэлдэг. Саулын

бардам зан, Давидын нүглээ даруухнаар хүлээн зөвшөөрсөн зэрэг нь энэ сургаалт үг бодит амьдралд хэрхэн харагддагийг илэрхийлдэг.

Сургаалт үгс ном

Сургаалт үгс номын ихэнх хэсгийг Соломон бичжээ. Номын илэрхийлсэн зорилго нь бага залуу, төлөвшөөгүй нэгэнд мэргэн ухааныг олж авахад нь туслах, мэргэн нэгэнд бүр ч мэргэн болоход нь туслах явдал ажээ (Сургаалт үгс 1:4-5).

Сургаалт үгс номд гурван төрлийн хүмүүсийн талаар өгүүлдэг. **Гэнэн хүмүүс** нь насанд хүрсэн хэдий ч амьдралын туршлага, ойлголт хараахан байхгүй хүмүүс. Гэнэн хүн мэргэн ухааныг олж, түүнийг сүйрүүлж мэдэх алдаанаас зайлсхийх хэрэгтэй.

Мэргэн хүн нь Бурханы зарчмын дагуу хэрхэн амьдрахаа ойлгодог хүн юм. Хүмүүс мэргэн болохыг хүсвэл Бурханаас эмээх ёстой (Сургаалт үгс 9:10). Мэргэн хүмүүс суралцаар байдаг.

Мунхаг хүн нь мэргэн ухааныг (Бурханы зарчмуудыг) үгүйсгэж, сонсохоос татгалздаг. Тийм хүн муу зан чанарыг харуулж, буруу шийдвэрээсээ болж зовдог. Мунхаг хүн нь ухаан дутмаг нэгэн биш, харин Бурханы чиглүүлэг удирдамжаас татгалзсан учраас амьдралыг ойлгодоггүй.

Сургаалт үгс номын зарим нийтлэг сэдвүүд нь (1) залхуурлын аюул ба ажлын үнэ цэн (2) бэлгийн харилцааны нүглээс үүдэлтэй хохирол сүйрэл, (3) олон төрлийн харилцааны ёс зүй зэрэг юм.

Номлогчийн үгс ном

Номлогчийн үгс номыг Соломон бичжээ (Номлогчийн үгс 1:1).

Номлогчийн үгс номын утга: **Хэрэв** зөвхөн энэ амьдралаар бүх зүйл дуусвал, ямар нэгэн агуу ололт амжилт эсвэл амьдралын зорилго, шударга ёс аль аль нь үгүй.

Номлогчийн үгс ном нь дэлхийн амьдрал яагаад хүмүүст бүрэн дүүрэн сэтгэл ханамж эсвэл зорилгыг өгч чадахгүй байгааг тайлбарладаг.

Энэ амьдралд:

- Шударга ёсыг үл тоомсорлодог.
- Хүн бүр үхэж, мартагдах болно.
- Бузар муу хүмүүс цэцэглэн хөгждөг.
- Мэргэн ухаан хамгийн хүчтэй боловч жигшигддэг.
- Мэргэн ухаан, мэдлэг нь гуниг харууслыг нэмэгдүүлдэг.

Номлогчийн үгс ном бидэнд мөнхийн хараа зорилгын дагуу амьдардаг хүн:

- Баяр хөөртэй байхын зэрэгцээ амьдралын асуудлуудад нухацтай ханддаг.
- Үхэл айсууг санадаг.

- Сайн зүйлээс таашаал авч, тэдгээрээс баяр баясгаланг авдаг ч, Бурханы өмнө хариуцлага хүлээнэ гэдгээ ухамсарладаг.
- Дэлхийн ямар ч зорилгыг хамгийн чухалд тооцдоггүй.

Соломон дараах дүгнэлтэд хүрчээ: Шүүлт байдаг тул бага залуугаасаа Бурханд үйлчилж, Түүний тушаалыг сахь.

Утга зохиолын хэлбэр: Хуучин гэрээний эш үзүүлэлэг

Хуучин гэрээний эш үзүүлэгчдийн номууд нь номлогдсон сургаалын бичмэл цуглуулга юм. 16 эш үзүүлэгчийн номлол сургаалыг Бичвэрт тэмдэглэжээ. Зөвхөн Иеремиа эш үзүүлэгч хоёр номтой. Зарим эш үзүүлэгчдийн ном нь Бичвэрт тэмдэглэгдээгүй (1 Шастир 29:29) бөгөөд ямар ч бичвэр үлдээгээгүй олон зуун эш үзүүлэгчид байжээ.

Бичвэр үлдээсэн 16 эш үзүүлэгчид нь НТӨ 760-460 оны хооронд үйлчилж байжээ (Израил НТӨ 722 онд, Иуда НТӨ 587 онд сүйрчээ). Түүхийн энэ хугацаанд дэлхийн хэд хэдэн эзэнт гүрний сэргэлт ба уналт Израилын улс төр, эдийн засгийн болон шашны амьдралд нөлөөлжээ. Заримдаа Израил, Иуда үндэстний хүмүүсийн олонх нь Бурхантай байгуулсан гэрээгээ зөрчиж, хиймэл шүтээнүүдэд үйлчилж байсан.

Эш үзүүлэгчид Бурханы гэрээг өмгөөлөгчид байв. Тэд ард түмэнд Бурханы шаардлагыг сануулдаг байсан. Олон жилийн өмнөөс Израил Бурханд дуулгавартай байх эсэхээс хамааран ерөөл эсвэл хараалыг хүртэх талаарх амлалт өгөгджээ (Леви 26-р бүлэг, Дэд хууль 28-32). Эш үзүүлэгчид эдгээр амлалтын биеллийг урьдчилан өгүүлжээ. Дуулгавартай байдлаар ирэх амлагдсан ерөөлд амь амьдрал, эрүүл мэнд, хөгжил дэвшил, хөдөө аж ахуйн үржил шим, эрх чөлөө, аюулгүй байдал зэрэг багтдаг. Дуулгаваргүй байдлаар ирэх хараалд үхэл, өвчин, ган гачиг, өлсгөлөн, орон гэр хотуудын сүйрэл, тулалдаанд ялагдах, нутаг орноосоо цөлөгдөх, эрх чөлөөгөө алдах, ядуурал, гутамшиг зэрэг багтдаг.

Эш үзүүлэлэг нь Бурханаас ирсэн мэдээг дамжуулдаг байжээ. Эш үзүүлэлэг нь номлол байсан бөгөөд одоо тулгарч байгаа асуудалд анхаарч, тэр даруй хариу үйлдэл үзүүлэхийг уриалдаг байсан. Эш үзүүлэгчдийн дамжуулах үгс нь ихэвчлэн урьдаас өгүүлэх мэдээг агуулж байлаа. Гэсэн хэдий ч эш үзүүлэгч нь номлогч байв. Түүний дамжуулах үгс нь урьдаас өгүүлэх мэдээ эсэхээс үл хамааран эш үзүүлэлэг байсан юм.

Олон тохиолдолд эш үзүүлэлэгийн доторх урьдаас өгүүлсэн мэдээ хэрхэн, хэзээ биеллээ олсныг бид мэддэггүй. Эдгээр багц хэсгээс суралцахад тэрхүү мэдлэг нь бидэнд шаардлагагүй байдаг. Ихэнхдээ үүний биелэл нь эш үзүүлэгч болон шууд сонсогчдын амьдралд тохиолддоггүй ч, түүний мэдээ сургаалд тэр даруй хариу үйлдэж, хэрэгжүүлэхийн тулд номлодог. Эш үзүүлэгчид хүмүүсийг одоо цагт гэмшиж, Бурханд дуулгавартай байх ёстой шалтгаан болгон Бурханы ирээдүйн хаанчлал руу хандуулж сургамжилдаг (Хабаккук 2:14).

Эш үзүүлэгчдийн мэдээг дамжуулах болон дүрслэх арга нь ихэвчлэн ер бусын, гайхалтай байв. Тэд мэдээг дамжуулахдаа хэлц үг, заримдаа биеийн хэлэмжийг ашигладаг байжээ. **Гэсэн хэдий ч тэд хүмүүсийг шинэ, ер бусын зүйл хийх ёстой гэж номлоогүй, харин Бурханы илчилсэн хуулийг дагах ёстой гэж номлосон.**

Эш үзүүлэгчдийн номлол нь хүмүүсийг гэрээний нөхцөлд (тэдний Бурхантай харилцах харилцаа) буцаан авчрах зорилготой байсан бөгөөд өнөөдөр ч хүмүүсийг Бурхантай харилцах харилцааны нөхцөлд буцаан авчрахын тулд номлож байгаа юм.

Урьдаас өгүүлэх (ирээдүйд болох үйл явдлуудын тухай ч хэлэхдээ) гэдэг нь тэр даруй нөлөө үзүүлэх санаа зорилготой байв. Хүмүүсийг гэмшиж, Бурханд дуулгавартай байхад уриалсан. Энэ зорилго нь өнөөдрийн номлолын зорилготой төстэй юм.

Зарим урьдаас өгүүлэх мэдээ нь нөхцөл болзолтой байв. Сонсогчид гэмшсэнээр урьдаас өгүүлсэн шүүлтээс зайлсхийх боломжтой байсан (Иеремиа 18:7-11, Иеремиа 26:13-19). Ионагийн дамжуулсан мэдээ хэдийгээр өршөөлийг санал болгоогүй ч, Ниневегийн сонсогчид сүйрэлд өртөлгүй өнгөрсөн (Иона 3:4-5, 9-10).

Бурханы эцсийн зорилгын биелэл нь нөхцөл болзолгүй юм. Жишээлбэл, Исаиа 43:5-6 эшлэлд Бурхан өөрийн хүчээр цөлөгдөгсдийг Израилд буцаан авчирна гэж амласан боловч багц хэсэгт Израилын биелүүлэх ёстой шаардлагын талаар өгүүлээгүй. Хэдий тийм боловч эдгээр үйл явдал дахь байр байдал нь өөрийн сонголтоос хамаарна.

Эш үзүүлэгийн номууд нь түүхэн үйл явдлын хэсгүүдийг агуулдаг ч, өгүүлж буй зүйлс нь ихэвчлэн яруу найргийн хэлбэртэй байдаг. Шууд утгаар нь хөрвүүлэх ёстой түүхэн хүүрнэлийг бэлгэдэл агуулсан яруу найргийн багц хэсгүүдээс ялгах нь тийм ч хэцүү биш юм.

Эш үзүүлэгийн номууд дахь чухал нэр томъёо, ойлголтууд

Шүтээн шүтэх: Гэрээний үндсэн зөрчил.

Завхайрал: Ихэвчлэн шүтээн шүтэхтэй хамт үйлдэгддэг нүгэл бөгөөд шүтээн шүтэхийг шилжсэн утгаар ийнхүү илэрхийлдэг.

Үндэстнүүд: Бурхантай гэрээний харилцаанд ороогүй ертөнцийг хэлнэ. Хоёр дэд сэдэв:

1. Үндэстнүүд ихэвчлэн Израилын эсрэг дайсагнадаг.
2. Бурхан Израилаар дамжуулан үндэстнүүдийн дунд өөрийгөө алдаршуулахыг хүсдэг.

Сүм: Бурханы оршихуйн төв. Хоёр дэд сэдэв:

1. Хоёр нүүр гаргадаг мөргөл хүндэтгэл нь Бурханыг гутаан доромжилдог.
2. Дайснууд сүмийг эзлэн авах нь Израилын бүрэн ялагдал, Бурханы оршихуйг алдсаныг харуулдаг байсан.

Газар/Өв: Бурхан израилчуудыг ерөөхийн тулд тавьсан онцгой газар нутаг.

Олзлогдол: Бурханы өгсөн газар нутгаас зайлуулагдах, бусад үндэстнүүдэд боолчлогдох. Олзлогдол нь Израил Бурханы ерөөлийг алдсан гэсэн утгатай.

Бороо (болон холбоотой хэллэгүүд): Бурхан израилчуудад өгсөн газар нутгийг үргэлжлүүлэн ерөөж буйн тэмдэг юм. Бороо хургүй байдал нь Бурханы таалал үгүйг илэрхийлдэг.

Ургац (болон холбоотой хэллэгүүд): Бороо, газар нутаг гэсэн ойлголттой холбоотой Бурханы ерөөлүүд.

Эзэний өдөр: Бузар муу хүмүүсийг устгах Бурханы ирээдүйн, гэнэтийн шүүлт. Шүүлт нь бусад үндэстэнд зориулагдсан гэж Израил бодож байсан бөгөөд шүүлт тэдний дээр ирэхийг сонсохдоо тэд айж цочирдсон.

Морьд: Цэргийн хүчийг төлөөлдөг.

Египетээс чөлөөлөгдсөн: Израилыг үндэстэн болгож, Бурхан тэдний хаан болсон түүхэн үйл явдал. Шүтээн шүтэх нь энэхүү чөлөөлөлтийн дараа байгуулагдсан гэрээг гутаан доромжилсон хэрэг явдал юм.

Эш үзүүлэгийн зохиолыг хөрвүүлэх нь

Эш үзүүлэгийн зохиол нь хөрвүүлэхэд хамгийн төвөгтэй утга зохиолын нэг юм. Эш үзүүлэгийн зохиолыг үр нөлөөтэй хөрвүүлэхийн тулд дараах асуултуудыг асуу:

(1) Эш үзүүлэгч өөрийнхөө цаг үед юуг өгүүлсэн бэ?

Эш үзүүлэгч нь зөвхөн ирээдүйн талаар урьдаас өгүүлдэг гэсэн түгээмэл ойлголтын эсрэг, эш үзүүлэгч эхлээд өөрийн цаг үедээ ярьдаг гэдгийг ойлгох хэрэгтэй.

Жишээлбэл, Амос Бурханд дуулгаваргүй байсан Израил үндэстэнд хандан бичжээ. Ард түмэн хөгжин дэвшиж, үр дагавар нь хамаагүй Бурханы хуулиас татгалзах боломжтой гэж үзсэн. Амос шударга ёс, зөвт байдлыг Израил орхисон тул шүүгдэх болно гэсэн шүүлтийн мэдээг тунхаглажээ (Амос 5:7).

(2) Түүний мэдээнд хүмүүс хэрхэн хариу үйлдсэн бэ?

Амосын мэдээг сонсоод Израилын хариу үйлдэл нь Бетелийн ахлах тахилч Амазиагийн хариу үйлдлээс харагддаг. Тэрээр Амост Иуда руу буцаж, Хойд хаант улсад цаашид номлохгүй байхыг тушаасан (Амос 7:10-13).

(3) Эш үзүүлэгчийн мэдээний аль зарчим нь өнөөгийн бидэнд хамааралтай вэ?

Эртний Израилын төлөөх Бурханы хэм хэмжээ нь шударга ёс, зөвт байдал байсны адил өнөөдөр ч Бурхан өөрийн хүмүүсээсээ шударга ёс, зөвт байдлыг шаарддаг. Бид зөв шударга амьдрах Бурханы дуудлагыг үл тоомсорлочихоод Түүний өргөөнд мөргөл хүндэтгэл өргөх боломжгүй (Амос 5:22-24).

Эдгээр асуултууд нь эш үзүүлэгийн үнэнийг эш үзүүлэгчийн ертөнцөөс бидний ертөнцөд авчирдаг. Эш үзүүлэгчийн ертөнцийг харснаар бидний өнөөдрийн хөрвүүлэгч анх дамжуулсан үг сургаалд үндэслэгдсэн гэдгийг баталгаажуулдаг.

Утга зохиолын хэлбэр: Апокалиптик зохиол

Апокалиптик Бичвэрүүдэд Даниел, Зехариа, Иоел, Илчлэл болон Библийн бусад номын багц хэсгүүд багтдаг.

Апокалиптик зохиолыг бичсэн хүмүүс мэдээг үзэгдэл эсвэл зүүдэндээ хүлээн авдаг байжээ. Энэ нь бэлгэдлийн шинж чанарыг ихээр агуулдаг. Үүнд ихэвчлэн амьтад, хачин жигтэй, араатан амьтдыг бэлгэдэл болгон өгүүлдэг.

Үйл явдлыг цаг хугацааны дарааллаар дүрслэхийн оронд бичвэр нь ижил үйл явдал/орчны талаар олон давтаж, давтах бүрдээ өөр өөр нарийн ширийн зүйлсийг илчилдэг.

Бичвэрийг хөрвүүлэх ердийн арга бол шууд утгаар нь ойлгох юм. Харин бичигч бичвэртээ зориудаар хэлц үг дүрслэл ашигласан бол бид текстийг хөрвүүлэх аргаа өөрчлөх ёстой болдог. Тодорхой дүрслэл ашигласан жишээ нь Даниелын үзэгдэлд гардаг амьтад, араатнуудын дүрслэл байх боломжтой.

- Амьтны бэлгэдлийн жишээ: Даниел 7:3-7, Илчлэл 12:3, Илчлэл 16:13, Зехариа 6:1-3.

Апокалиптик бичвэр нь өнөөгийн ертөнцийн бузар муу, шударга бус байдлыг үл харгалзан, итгэлээ сахихыг ихэвчлэн ятгадаг. Энэ нь бүх дэлхийг хамарсан ширүүн дайн тулаан байдлаар дүрслэгддэг.

Библи дэх апокалиптик бичвэрүүд нь бузар мууг шийтгэж, сайныг шагнах Бурханы эцсийн ялалтыг харуулдаг. Өөрийн хүмүүстээ туслахаар ирдэг хэмжээлшгүй эрх мэдэлт Бурханыг онцлон харуулдаг.

Хөрвүүлэгч бүх бэлгэдлийг ойлгохгүй, тэр ч байтугай урьдаас өгүүлсэн үйл явдлын дарааллыг тодорхойлж чадахгүй байсан ч, апокалиптик бичвэрийн үндсэн мэдээ сургаалыг ойлгох боломжтой.

- Агуу, эцсийн тулааныг дүрсэлсэн багц хэсгийн жишээ: Иоел 2:9-11, Илчлэл 19:11-21, Илчлэл 20:7-9.
- Бурханы эцсийн ялалт, мөнхийн хаанчлалын тухай заадаг багц хэсгийн жишээ: Даниел 7:14, 27, Зехариа 14:9.

Апокалиптик номуудаас гадна Бичвэрийн бусад багц хэсгүүдэд бузар муугийн хүчийг шүүж, зөвт хүмүүсийг аврах Бурханы гэнэтийн оролцооны талаар өгүүлдэг тул тэдгээрийг апокалиптик бичвэр гэж үзэх боломжтой. Эдгээр Бичвэрүүд нь үзэгдлүүд болон амьтны бэлгэдлүүд зэрэг апокалиптик бичвэрийн бусад шинж чанаруудыг

бүгдийг нь агуулдаггүй (Езекиел 37-39, Исаиа 24-27, Матай 24, Марк 13, Лук 21, 2 Тесалоник 2, 2 Петр 3-р бүлгийн жишээ).

Апокалиптик Бичвэрийн ерөнхий хэрэгжүүлэлт

Дэлхийн асуудлын эцсийн шийдэл нь соёлын эсвэл нийгмийн хөгжил биш юм. Энэ нь улс төрийн шинэчлэл эсвэл хувьсгал биш. Шийдэл нь Бурханы оролцоо юм. Тэрээр одоо өөрийн хүмүүстээ итгэл, хүч чадал, өршөөлийг өгсөөр байна. Ирээдүйд Тэр гэнэт ирж, дэлхийг бүрэн өөрчлөх болно.

Итгэгч хүмүүс итгэлээ сахиж тэвчээртэй байх ёстой. Бурханы төлөвлөгөө эсвэл дэлхий дээрх үйл явдлуудыг бүрэн дүүрэн ойлгох шаардлагагүй юм. Итгэлтэй байна гэдэг нь хүмүүс тодорхой шууд үр дүнг урьдаас хэлж чадна гэсэн үг биш. Эцэстээ дуулгавартай байдал нь үнэ цэнтэй гэдгийг жинхэнэ итгэлтэй хүмүүс мэддэг учраас тэд бүх нөхцөл байдалд Бурханыг дуулгавартай дагадаг.

Утга зохиолын хэлбэр: Сургаалт зүйрлэл

Сургаалт зүйрлэл нь сүнслэг үнэнийг байгалийн болон амьдралын нөхцөл байдалтай харьцуулан заах арга юм. Сүнслэг болон байгалийн үнэний хоорондох төстэй байдлыг харуулснаар бид сүнслэг үнэнийг илүү сайн ойлгож чаддаг.

Сургаалт зүйрлэлээр ярих нь Есүсийн заах дуртай аргуудын нэг байжээ (Матай 13:34). Тэрээр 30 сургаалт зүйрлэл хэлж, олон дүрслэл бүхий харьцуулалтыг ашиглажээ.

Сургаалт зүйрлэлээр дамжуулан Есүс залбирлын талаар (сүм дэх фарисай болон татвар хураагч, Лук 18:9-14), хөршөө хайрлах тухай (сайн самари хүн, Лук 10:29-37), Бурханы хаанчлалын мөн чанарын талаар (Матай 13-р бүлэг, сургаалт зүйрлэлүүд), нүгэлтнүүдэд үзүүлсэн Бурханы өршөөлийн тухай (ачлалгүй хүү, Лук 15:11-32) сургасан байдаг.

Сургаалт зүйрлэл нь сонсогчдоо шууд буруутгахгүйгээр зэмлэх боломжийг Есүст олгодог байв. Есүсийн өгүүлсэн сургаалт зүйрлэлүүд сонирхолтой байсан тул сонсогчдын чихийг Түүний үгэнд нээж, тэд гэнэт "Тэр миний тухай ярьж байна!" гэдгийг ухаардаг байжээ. Эш үзүүлэгч Натан ядуу хүний ганц хонины тухай Давидад сургаалт зүйрлэлээр ярих үед мөн тийм зүйл болж байсан (2 Самуел 12:1-10). Натан "Тэр хүн нь та билээ!" гэж хэлэх хүртэл Давид сургаалт зүйрлэл өөрийнх нь тухай байсныг ойлгоогүй.

Сургаалт зүйрлэлийг хөрвүүлэх нь

Хөрвүүлэгч дараах зүйлсийг анзаарах ёстой:

- Сургаалт зүйрлэлийг хэрхэн танилцуулсан бэ?
- Сургаалт зүйрлэлийн дүгнэлт нь юу байв?

- Сургаалт зүйрлэл ямар хариу үйлдэл эсвэл хандлагын өөрчлөлтөд уриалж байна вэ?
- Анхны сонсогчид ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ?

(1) Сургаалт зүйрлэлийг хэрхэн танилцуулсан бэ?

Есүс хүмүүсийн асуулт болон хандлагад хариу болгон сургаалт зүйрлэлээр ярьдаг байсан. Сургаалт зүйрлэлийг ярьсан нөхцөл байдлыг мэдэх нь хөрвүүлэгчид Түүний сургаалыг ойлгоход тусалдаг.

Хэрэв бид сургаалт зүйрлэлийг хөрвүүлэхдээ Есүсийн харилцан яриа болон нөхцөл байдалтай шууд холбож хараагүй бол гол санааг орхигдуулсан байх магадлалтай.

Асуултад хариулт болгон ярьсан сургаалт зүйрлэлүүд. Харилцан ярианы үеэр хуульч Есүсээс “Миний хөрш гэдэг чинь хэн бэ?” гэж асуусан. Есүс “Таны замд байгаа тусламж хэрэгтэй хүн бол таны хөрш бөгөөд энэ бол таны хариуцлага юм” гэж хариулж болох байсан. Үүний оронд Есүс сайн самари хүний сургаалт зүйрлэлийг ярьж, ижил хариултыг шууд бус байдлаар өгчээ.

Августин энэ сургаалт зүйрлэлийг буруу хөрвүүлсэн байдаг. Учир нь тэр хариулт авсан асуултыг хайхралгүй өнгөрөөжээ. Августины хөрвүүлэгч: Есүс (сайн самари хүн) Адамыг (хүн) Сатанаас (дээрэмчид) аварч, аюулгүй байдлын төлөө сүмд (дэн буудал) авчирсан. Есүс Паулд (буудлын эзэн) хоёр денари (энэ амьдрал болон ирэх амьдралын амлалт) төлж, нүглийг (шарх) боож өгчээ. Августины хөрвүүлэгч нь Есүс, хуульч хоёрын яриатай холбоогүй байсан учраас зөв биш юм.

Хандлагад хариулт болгон ярьсан сургаалт зүйрлэлүүд. Лук 15:1-3 эшлэлд “Татвар хураагчид ба нүгэлтнүүд бүгд Түүнийг сонсохоор ойртоцгоов. Фарисайчууд болон хуулийн багш нар дургүйцэн дүнгэнэлдэж

—Энэ хүн нүгэлтнүүдийг хүлээн авч тэдэнтэй хамт хооллодог гэхэд нь Тэрээр ийм сургаалт зүйрлэл тэдэнд айлдав”:

- Хоньчин хонио алджээ. Хонио олоод түүний баярлаж байгааг анзаар!
- Эмэгтэй зоосоо алджээ. Зоосоо олоод түүний баярлаж байгааг анзаар!
- Эцэг хүүгээ алджээ. Хүүгээ олоод түүний баярлаж байгааг анзаар!

Есүс эдгээр гурван сургаалт зүйрлэлээр дамжуулан “Намайг нүгэлтнүүдтэй хооллодог та нар гайхах хэрэггүй. Нэг нүгэлтэн гэмшихэд тэнгэрт баярлаж байгааг анзаар!” гэж хэлж байна.

Сургаалт зүйрлэлийн үндсэн сургамж нь үүнийг өдөөсөн асуулт эсвэл нөхцөл байдалтай шууд холбоотой гэдгийг санаж байх нь маш чухал юм.

(2) Сургаалт зүйрлэлийн дүгнэлт нь юу байв? Сургаалт зүйрлэл ямар хариу үйлдэл эсвэл хандлагын өөрчлөлтөд уриалж байна вэ?

Сургаалт зүйрлэл нь ихэвчлэн нэг гол санааг өгүүлдэг хэдий ч өөр өөр хэрэгжүүлэлт байх боломжтой. Сургаалт зүйрлэлд өгүүлж буй гол дүр болгон нэг сургамжийг дүрслэх боломжтой.

Бид ачлалгүй хүүгийн сургаалт зүйрлэлийн үндсэн сургамжийг аль хэдийн харсан: Гэмшсэн нүгэлтний төлөө тэнгэрт агуу баяр хөөр болдог. Энэ гол санаа нь Есүсийн сургаалт зүйрлэлийг ярихад хүргэсэн нөхцөл байдал буюу фарисайчуудын нүгэлтнүүдийг уучлах хүсэлгүй байдалд өгсөн хариулт юм. Гурван дүр тус бүр нь сургаалт зүйрлэлийн гол санаатай шууд холбоотой нэг сургамжийг заадаг.

Дүр	Сургамж
Ачлалгүй хүү	Гэмшиж Бурханд хандсан нүгэлтнүүд тэр даруй уучлагдах болно.
Хайрладаг эцэг	Уучлах хүсэлгүй байдлын оронд бидний тэнгэрлэг Эцэг уучлалд баярладаг.
Ах	Уучилдаггүй хүнд Эцэгийн адил хайр байдаггүй

Есүс, ахын уучлах хүсэлгүй байдлыг эцгийн уучлалтай эсрэгцүүлжээ. Есүсийн зорилго нь фарисайчуудын уучлах хүсэлгүй байдлыг зэмлэх явдал байв. Тэднийг буруу хандлагадаа гэмшихийг Есүс хүссэн.

Энэ сургаалт зүйрлэлийг номлож буй хүн нүгэлтнийг гэмшихэд ятгах зорилгоор эцгийн хайр, уучлалыг онцолж болно. Эсвэл итгэгч хүн итгэгч бус хүмүүсийг уучлах Бурхантай адил хандлагатай байх талаар номлох боломжтой.

(3) Анхны сонсогчид ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ?

Сургаалт зүйрлэл нь анхны сонсогчид хэрхэн нөлөөлснийг ойлгохын тулд бид тэдний ахуй соёлыг ойлгох ёстой болдог. Есүс ихэвчлэн өөрийн цаг үе, ахуй соёлынхоо тогтсон хэм хэмжээний эсрэг зүйлийг сургаалт зүйрлэлээр ярьдаг байв. Энэ нь тэднийг цочирдуулж байсан.

Жишээлбэл, ачлалгүй хүүгийн тухай сургаалт зүйрлэлийг дахин авч үзье. Есүсийн сонсогчид бага хүү нь өв хөрөнгөө эрт хүсэх нь маш хүндэтгэлгүй зүйл гэж үздэг байсан. Дараа нь хүү өв хөрөнгөө үрэн таран хийжээ. Сонсогчид хүүг буцаж ирэхэд эцэг нь түүнээс татгалзан, нүүр буруулж, бүр зодож хөөж явуулна гэж бодож байсан.

Гэтэл эцэг нь хүүгээ угтахаар гүйснийг сонсохдоо тэд хэрхэн гайхаж цочирдсоныг төсөөлж үзээрэй!

Сайн самари хүний сургаалт зүйрлэлд тахилч, леви хоёр шархадсан хүнд туслахгүйгээр өнгөрөхөд сонсогчид төдийлөн гайхаагүй, учир нь тэд сүмийн удирдагчдыг авлигад идэгдсэн, хоёр нүүртнүүд гэж үздэг байжээ. Харин тэд фарисайчуудыг хүндэтгэдэг байсан бөгөөд тусламж үзүүлэх гурав дахь хүн нь фарисай хүн байх ёстой гэж бодсон. Гэтэл гурав дахь хүн нь самари хүн, угсаа гарал, шашны байр суурийн хувьд дорд хэмээн тэдний жигшдэг хүн тусламж үзүүлснийг сонсоод тэд гайхан цочирдсоныг төсөөлж үзээрэй!

Бид сургаалт зүйрлэлийн ахуй соёлын орчныг сайн ойлгох тусам сургаалыг илүү тодорхой хардаг.

Сургаалт зүйрлэлийн нарийн ширийн зүйлс ба бэлгэдэл

Зарим номлогчид сургаалт зүйрлэл дэх нарийн ширийн зүйл болгоныг бэлгэдэл агуулсан гэж буруу боддог. Жишээлбэл, зарим хүн сайн самари хүний сургаалт зүйрлэл дэх аялагчийг Йерусалимаас Иерихо руу буцахдаа буруу сонголт хийсэн, учир нь тэрээр Бурханы хараасан хот руу явжээ гэж үзсэн. Энэ нь сургаалт зүйрлэлийн сайн хөрвүүлэг биш юм. Учир нь сургаалт зүйрлэлийн зорилго нь хүн хөршөө хэрхэн хайрлах учиртайг ойлгуулах явдал юм. Нарийн ширийн зүйлс нь ямар нэг зүйлийг бэлгэддэггүй.

Номлогч хүн Марк 4:30-32 эшлэл дэх сургаалт зүйрлэлд өгүүлсэн модны дор үүрээ засах шувууд юуг бэлгэдэж байгаа талаар төсөөлж ургуулан бодож болох юм. Гэтэл энд зөвхөн жижиг үр том мөчир болж ургасныг харуулахын тулд мөчир дор нь үүрээ зассан шувуудын талаар дурджээ.

Ачлалгүй хүүгийн талаарх сургаалт зүйрлэлийн нарийн ширийн зүйлсэд бэлгэдлийн утга олох гэж оролдох шаардлагагүй юм. Жишээлбэл, гахайнууд нь бэлгэдэл биш. Хүүгийн муу нөхцөл байдлыг харуулахын тулд гахайг дурдсан (ердийн нөхцөлд еврей хүү хэзээ ч гахайтай ойрхон байдаггүй байжээ).

Сургаалт зүйрлэлийн нарийн ширийн зүйлс бэлгэдэлтэй байх нь ховор. Сургаалт зүйрлэлд бэлгэдлийн утгыг агуулсан нарийн ширийн зүйлсийн нэг жишээ бол буудай ба үрийн сүүлний тухай сургаалт зүйрлэл юм (Матай 13:38-39). Энэ сургаалт зүйрлэлийн нарийн ширийн зүйлс нь бэлгэдлийн утгатай гэдгийг Есүс тийнхүү хэлсэн учраас бид мэдэж болдог.

Сургаалт зүйрлэлээр номлох нь

Номлогч хүн өөрийн ахуй соёл дахь ижил төстэй нөхцөл байдалдаа сургаалт зүйрлэлийг тохируулж ашиглах боломжтой. Гэсэн хэдий ч тэрбээр сургаалт зүйрлэл анхны сонсогчдын хувьд юу гэсэн утгатай байсныг ойлгоход цаг гаргах ёстой. Эс бөгөөс тэрээр өөрийн сонсогчдод ижил сургаалыг дамжуулж чадахгүй.

Хөрвүүлэгч бусад Бичвэрийн тодорхой хэсгээр дэмжигдээгүй хэрэгжүүлэлт эсвэл онол сургаалын үндэслэл болгон сургаалт зүйрлэлийг ашиглах ёсгүй.

Утга зохиолын хэлбэр: Захидал

Захидлуудын онцлог шинж²⁴

Шинэ гэрээний олон ном нь Паул, Иаков, Петр, Иохан, Иудагийн захидлууд юм. Захидлууд хоорондоо ялгаатай ч, тодорхой шинж чанарууд нь нийтлэг байдаг. Шинэ гэрээний захидлууд нь:

- 1. Эрх мэдэлтэй.** Шинэ гэрээний захидлууд нь зохиогчийн оршихуйг орлодог байжээ. Захидал нь бичсэн хүнийхээ эрх мэдлийг төлөөлдөг бөгөөд үүнийг ихэвчлэн захидал эхлэхдээ дурдсан байдаг.²⁵
- 2. Нөхцөл байдалд үндэслэсэн.** Шинэ гэрээний захидлууд нь ихэвчлэн тодорхой нөхцөл байдал эсвэл асуудлыг шийдвэрлэхийн тулд бичигдсэн байдаг. Жишээлбэл, Галат захидлыг Иудейн шаардлагыг дагаснаар аврагдана гэж итгэдэг чуулганд хандан бичсэн. Энэ захидалдаа Паул итгэгч хүний Христ доторх эрх чөлөөг онцолжээ. Эсрэгээрээ, Коринтын чуулган эрх чөлөөгөө хэтрүүлэн хэрэглэж, бэлгийн харилцааны ёс бус байдлыг өөгшүүлж байлаа. 1 Коринт захидалдаа дуулгавартай дагах нь итгэгч хүний хариуцлага гэдгийг Паул онцолсон.
- 3. Итгэгчдэд хандсан.** Захидлууд нь бүс нутгийн чуулгануудад (Ром), итгэгчдэд хувьчилсан (Филемон) эсвэл ерөнхий байдлаар итгэгчдэд (Иуда) хандан тус тус бичигджээ. Захидлыг хүлээн авагчид нь бүгд Бурхантай харилцах авралын харилцаанд амьдраагүй хүмүүс байлаа. Паул Коринтын итгэгчдийг зарим үйлдэлдээ гэмшихийг ятгасан. Тэр галатчуудыг сайнмэдээнд буцаж ирэхийг уриалсан. Иаков шударга бусаар баяжигчдыг шүүлт хүлээж байгааг анхааруулсан. Захидлууд нь ерөнхийдөө итгэлийн гэр бүлийн хам сэдвийн хүрээнд бичигджээ.

²⁴ Энэ хэсгийн ойлголтуудыг J. Scott Duvall ба J. Daniel Hays нарын *Grasping God's Word* (Grand Rapids: Zondervan, 2012) номоос авсан.

²⁵ Жишээлбэл, Ефес 1:1 эшлэлд Паул элчийн эрх мэдлээ дурдсан: "Бурханы хүслээр Христ Есүсийн элч болсон Паулаас."

Шинэ гэрээний захидлын бүтэц
<p>Оршил</p> <ul style="list-style-type: none"> • Бичигчийн нэр, албан тушаал • Хүлээн авагчид • Мэндчилгээ • Нээлтийн залбирал <p>Үндсэн хэсэг (захидлын үндсэн сургаал)</p> <p>Төгсгөл (дараах зүйлсийг агуулдаг)</p> <ul style="list-style-type: none"> • Аяллын төлөвлөгөө (Тит 3:12) • Танилцуулга ба мэндчилгээ (Ром 16) • Сүүлчийн захиас (Колоссай 4:16-17) • Ерөөлийн залбирал (Ефес 6:23-24) • Төгсгөлийн магтуу (Иуда 24-25)

Захидлыг хөрвүүлэх нь

Та найзаасаа захидал хүлээн аваад нэг дор захидлыг бүрэн уншдаг. Шинэ гэрээний захидлуудыг мөн адил аргаар уншаарай. Бичигчийн дамжуулж буй сургаалыг тоймлохын тулд захидлыг бүтнээр нь унших хэрэгтэй. Уншиж байхдаа ажиглалтын жагсаалт гаргаарай. Та нарийн ширийн зүйлсийг хэдий чинээ их ажиглана, захидлыг хөрвүүлэхэд төдий чинээ сайн бэлтгэгдэх болно.

Библийн захидлуудыг уншихдаа асуух хэд хэдэн асуулт байна:

(1) Захидлын хүлээн авагч нь хэн байв?

Захидлыг хүлээн авсан чуулган эсвэл хүний талаар бид хэдий чинээ их мэднэ, захидлыг төдий чинээ сайн ойлгоно. Паулын захидлыг судлахдаа Үйлс номд тухайн хүлээн авагч чуулгантай холбоотой хэлэгдсэн зүйлсийг уншиж, судлалаа эхлүүлэх нь тустай. Энэ нь ихэвчлэн захидлыг илүү сайн ойлгоход тусалдаг. Жишээлбэл:

- Филиппой дахь чуулган хавчлагын үед байгуулагджээ (Үйлс 16:12-40). Энэ нь хүнд хэцүү нөхцөлд ч баяр хөөртэй байхыг сургасан Паулын захиасыг тодруулж байна.
- Ефес захидал (Паулын бусад захидлуудтай адил) итгэгчдэд хандан бичигджээ. Паул Ефесийн итгэгчдийн төлөө Бурханы бүх дүүрлээр бялхах... (Ефес 3:19) талаар залбирахдаа Бурханы хүүхдүүд Түүний бүрэн дүүрэн байдлыг бүр ч ихээр

хүлээн авах болно хэмээн залбирч байна. Тэр итгэгчдийг "Түүний өмнө... ариун бөгөөд гэм зэмгүй байлгахаар" залбирч байна (Ефес 1:4).

(2) Захидлыг бичсэн хүн хэн байв? Захидлын хүлээн авагчтай ямар холбоотой вэ?

Та шуудангаар захидал хүлээн авахдаа "Хэнээс ирсэн бэ?" гэдгийг мэдэхийг хүсдэг. Бичигчийг хэдий чинээ сайн мэдэх тусам захидал төдий чинээ сонирхолтой болдог. Үүнтэй адилаар бид Библи дэх захидлыг бичигчийн талаар хэдий чинээ их мэдэх тусам түүний дамжуулж буй сургаалыг төдий чинээ сайн ойлгодог.

Элч Иохан захидлууддаа хайрыг онцолдог. Иохан өмнө нь "Аянгын хөвгүүд"-ийн нэг гэдгээрээ танигдсан байв (Марк 3:17). Нэгэн цагт Иохан ахтайгаа хамт Есүсээс тэнгэрээс гал буулгах зөвшөөрлийг асууж байсан юм (Лук 9:54). Харин хожим түүний бичсэн захидлууд нь тэр Пентэкостын үед Ариун Сүнсээр дүүргэгдэн, өөрчлөгдсөнийг харуулдаг.

Петр зовж шаналж буй итгэгчдийг зоригжуулахын тулд захидлуудаа бичжээ. Сатаны дайралттай тулгарахдаа тэднийг зүрх зоригтой байж чадна гэдгийг тэр батлан бичсэн (1 Петр 5:8-9). Петр амьдралынхаа эхэн үед айснаасаа болж, Есүсийг танихгүй хэмээн үгүйсгэж байсан (Марк 14:66-72). Петрийн захидлууд түүний амьдралд тохиолдсон өөрчлөлтийг харуулдаг.

Бичигч болон хүлээн авагчийн хоорондох харилцааг мэдэх нь захидлыг уншихад ихээхэн тус болдог. Паул Филиппой дахь чуулгантай халуун дулаан харилцаатай байсныг түүний захидал дахь баяр хөөрөөс нь хардаг. Нөгөөтэйгүүр Паул болон Коринтын чуулганд бослого дэгдээсэн хүмүүсийн хоорондох зөрчил нь 1 ба 2 Коринт захидал дахь ширүүн зэмлэлд хөтөлсөн байдаг.

(3) Захидлыг бичихэд юу нөлөөлсөн бэ?

Паул захидлуудаа бичихэд хүргэсэн хэд хэдэн нөхцөл байдлыг бид мэддэг. 1 ба 2 Коринт захидал нь Коринтын чуулганд тохиолдсон асуудал, үүнтэй холбоотой асуултад хариулт болгон бичигдсэн юм. Филемон захидал нь оргодол боол Онесимын өмнөөс Паулын гуйсан хүсэлт байдлаар бичигджээ.

Галатынханд хандсан захидал нь захидлын нөхцөл байдлыг ойлгох нь ямар чухал болохыг харуулдаг. Галат захидлын хэдэн эшлэлийг уншсаны дараа та "Галатчууд ямар буруу зүйл хийсэн бэ?" гэж асууж болох юм. Паул "[Христийн] нигүүлслээр та нарыг дуудсан Түүнээс холдож, өөр сайнмэдээ рүү ийм түргэн эргэсэнд чинь би гайхлаа." (Галат 1:6) гэж өгүүлсэн. Эдгээр шинэхэн итгэгчид итгэлээр дамжуулан нигүүлслээр зөвтгөгдөх сайнмэдээг орхисон нь удалгүй тодорхой болдог. Тэд үүний оронд үйлсээрээ зөвтгөгдөх сургаалд итгэх болжээ. Паулын хүсэл тэмүүлэл дүүрэн үгс нь эдгээр шинэхэн итгэгчдийг хайрласан хайраас нь үүджээ. Тэр зөвхөн итгэлээр зөвтгөгдөх сургаалыг тунхаглахын тулд амьдралаа зориулсан юм. Галатчууд үнэнийг орхиж, хуурамч сайнмэдээг хүлээн авч байгаад тэр гайхжээ.

Утга зохиолын хэлбэр: Тайлал

Тайлал нь эмх цэгцтэй сургаал юм. Энэ нь А цэгээс Б цэг рүү логик байдлаар шилждэг. Энэ утга зохиолын хэлбэр нь Шинэ гэрээний элч нарын захидлууд, ялангуяа Паулын захидлуудаас нийтлэг ажиглагддаг. Эдгээр захидлуудад Паул сайн багш хүний хувьд үнэнийг тодорхой байдлаар танилцуулдаг.

Тайлал нь *тиймээс, болон, харин* гэх мэт холбох үгсийг ашигладаг. Энэ нь ихэвчлэн асуулт, хариултыг агуулдаг. Тайлал нь үнэнийг логик арга замаар танилцуулдаг.

Колоссай захидалд Христийн мөн чанарын талаарх Паулын тайллыг харуулсан байдаг. Христ нь хүний уламжлал, гүн ухаан бүгдээс дээгүүр юм хэмээн Паул сургажээ. Паул дараах логик загварыг харуулсан:

1. Паул Христийн давуу байдлын нотолгоог танилцуулсан (Колоссай 1:15-23)
 - Тэр бол... бүх бүтээлийн дээрх Ууган нь мөн.
 - Бүх юмс Түүгээр... бүтээгдсэн байна.
 - Тэрээр... чуулганы тэргүүн.
 - Түүгээр... бүх юмсыг Өөртэйгөө эвлэрүүлсэн.
2. Паул захидлыг бичсэн зорилгоо уншигч нартаа сануулдаг. Өргөмжлөгдсөн Христийн сургаалыг харь үндэстнүүдэд хүргэх нь Паулд даалгагджээ (Колоссай 1:24-2:5).
3. Паул Христийн давуу байдлыг үгүйсгэдэг сургаалын эсрэг сэрэмжлүүлсэн (Колоссай 2:6-23).
 - Бурханы хуулийг сахиснаар аврагддаг гэсэн сургаал
 - Сүнснүүдтэй аюултай байдлаар харилцах зан үйл
 - Сүнслэг үр дүнгийн төлөө бие махбодын сахилга батыг онцлох буруу сургаал
4. Тиймээс Христийн давуу байдлаас болж та нар ингэж амьдрах ёстой (Колоссай 3-4):
 - Христэд захирагдах нь бидний ёс суртахууны зан байдалд нөлөөлнө.
 - Бид цаашид ёс бусаар авирлахгүй (Колоссай 3:1-11).
 - Бид амар тайван, талархалтайгаар амьдрах болно (Колоссай 3:12-17).
 - Христэд захирагдах нь бусадтай харилцах харилцаанд нөлөөлнө (Колоссай 3:18-4:6).
5. Хаалтын мэндчилгээ нь Паул Колоссай дахь итгэгчдэд хувьчлан санаа тавьж буйг уншигчдад сануулдаг (Колоссай 4:7-18).

Паулын захидал нь Христ бол Эзэн бөгөөд захирдаг гэсэн онол сургаалын тайлал юм. Энэ нь Христийн мөн чанарын талаар болон энэхүү үнэн итгэгч бидний амьдралд хэрхэн нөлөөлдөг талаар зааж сургадаг.

6-р хичээл гол санаанууд

(1) Зөв хөрвүүлэг нь бидний судалж буй Бичвэрийн багц хэсгийн утга зохиолын хэлбэрийг ойлгохыг шаарддаг.

(2) Библид агуулагддаг чухал утга зохиолын хэлбэрүүд нь:

- Түүх: бодит хүмүүс ба үйл явдлуудын талаарх үнэн зөв, түүхэн тэмдэглэлүүд юм.

Түүхийг хөрвүүлэхдээ дараах асуултуудыг асуу:

- Хүүрнэл нь юуны талаар өгүүлдэг вэ?
- Хүүрнэлд ямар хүмүүс оролцож байна вэ?
- Түүхэн үйл явдал нь дагаж хэрэгжүүлэх жишээг өгч байна уу?
- Энэ түүхэн үйл явдал ямар зарчмуудыг зааж байна вэ?

- Хуучин гэрээний хууль

Хуучин гэрээний хууль Шинэ гэрээний итгэгчдэд чухал юм. Учир нь:

- Энэ нь Бурханы мөн чанарыг илэрхийлдэг.
- Энэ нь бидэнд авралд хүргэх мэргэн ухааныг өгдөг.
- Энэ нь бидэнд Бурханы хүслийг ойлгож мэдэхэд тусалдаг.

Хуучин гэрээний хуулийн гурван ангиллын талаар мэдэх нь тустай:

- Ёслолтой холбогдох хуулиуд
- Иргэний хуулиуд
- Ёс суртахууны хуулиуд

Хуучин гэрээний хуулийг хөрвүүлэхдээ дараах асуултуудыг асуу:

- Энэ текст анхны сонсогчдын хувьд юу гэсэн утгатай байсан бэ?
- Библийн цаг үеийн сонсогчид болон бидний цаг үеийн хооронд ямар ялгаа байна вэ?
- Энэ текстэд ямар зарчмуудыг зааж байна вэ?
- Шинэ гэрээнд энэ зарчмыг ямар нэгэн байдлаар авч ашигласан уу?

- Яруу найраг

Еврей яруу найргийн онцлог шинжүүд:

- Параллелизм
- Дүрслэл, хэлц үг

- Мэргэн ухааны зохиол: амьдрал хэрхэн явагддагийг зааж сургадаг.
- Сургаалт үг: амьдралын ажиглалтыг товч бөгөөд тодорхой илэрхийлдэг.

Сургаалт үгийг хөрвүүлэхдээ дараах асуултуудыг асуу:

- Энэ Бичвэр ямар ерөнхий зарчмыг зааж байна вэ?
- Энэ зарчимд хамаарахгүй тохиолдлууд нь юу байж болох вэ?
- Библийн ямар хүмүүс энэ зарчмыг амьдралаараа харуулдаг вэ?
- Хуучин гэрээний эш үзүүлэлэг: Бурханаас ирсэн мэдээг дамжуулдаг.

Хуучин гэрээний эш үзүүлэлэгийг хөрвүүлэхдээ дараах асуултуудыг асуу:

- Эш үзүүлэгч өөрийнхөө цаг үед юуг өгүүлсэн бэ?
- Түүний мэдээнд хүмүүс хэрхэн хариу үйлдсэн бэ?
- Эш үзүүлэгчийн мэдээний аль зарчим нь өнөөгийн бидэнд хамааралтай вэ?
- Апокалиптик зохиол

Апокалиптик зохиолыг хөрвүүлэхдээ дараах зүйлсийг санаарай:

- Энэ нь бэлгэдлийн шинж чанарыг ихээр агуулдаг.
- Энэ нь үйл явдлыг дарааллын дагуу үргэлж харуулдаггүй.
- Энэ нь ижил үйл явдал/орчны талаар олон давтаж, давтах бүрдээ өөр өөр нарийн ширийн зүйлсийг илчилдэг.

Апокалиптик зохиолын хамгийн чухал сэдвүүд нь:

- Өнөөгийн ертөнцийн бузар муу, шударга бус байдлыг үл харгалзан, итгэлээ сахих
- Өөрийн хүмүүстээ туслахаар ирдэг хэмжээлшгүй эрх мэдэлт Бурхан
- Сургаалт зүйрлэл: Сургаалт зүйрлэл нь сүнслэг үнэнийг байгалийн болон амьдралын нөхцөл байдалтай харьцуулан заах арга юм. Ихэвчлэн сургаалт зүйрлэлийг хүмүүсийн асуулт болон хандлагад хариу болгон өгүүлдэг байжээ.
- Сургаалт зүйрлэлийг хөрвүүлэхдээ дараах асуултуудыг асуу:
 - Сургаалт зүйрлэлийг хэрхэн танилцуулсан бэ?
 - Сургаалт зүйрлэлийн дүгнэлт нь юу байв?
 - Сургаалт зүйрлэл ямар хариу үйлдэл эсвэл хандлагын өөрчлөлтөд уриалж байна вэ?
 - Анхны сонсогчид ямар хариу үйлдэл үзүүлсэн бэ?
- Захидал

Шинэ гэрээний захидлууд нь:

- Эрх мэдэлтэй
- Нөхцөл байдалд үндэслэсэн
- Итгэгчдэд хандсан

Захидлыг хөрвүүлэхдээ дараах асуултуудыг асуу:

- Захидлын хүлээн авагч нь хэн байв?
 - Захидлыг бичсэн хүн хэн байв? Захидлын хүлээн авагчтай ямар холбоотой вэ?
 - Захидлыг бичихэд юу нөлөөлсөн бэ?
- Тайлал: эмх цэгцтэй сургаал

6-р хичээлийн даалгавар

1-р хичээл дээр та энэ курсын туршид судлах Бичвэрийн багц хэсгийг сонгосон. Таны судалж буй багц хэсгийн утга зохиолын хэлбэр юу вэ? Энэ багц хэсгийг илүү их ойлгохын тулд хичээл дээр үзсэн материалыг ашигла. Утга зохиолын тодорхой нэг хэлбэртэй холбоотой хөрвүүлгийн асуултуудад хариулаарай.

7-р хичээл

Хөрвүүлэг: Үгийн судлал

Хичээлийн зорилго

- (1) Гүн гүнзгий үгийн судлал хийхийн ач холбогдлыг ойлгох.
- (2) Үгийн судлал хийхэд гаргадаг нийтлэг алдаанаас зайлсхийх.
- (3) Үгийн судлал хийх үйл явцыг ойлгож, хэрэгжүүлэх.
- (4) Библи дэх дүрслэл хэлцийг таних.

Танилцуулга

Библийн утга санаа нь баялаг боловч харамсалтай нь, зарим хүмүүс Бичвэрийн утгыг ойлгохгүй уншдаг.²⁶ Библи нь ном, бүлэг, багц хэсэг, эшлэл, үгсээс бүрддэг. Үгийн утгыг ойлгох нь бидний судалж буй багц хэсгийг зөв хөрвүүлэхэд тусалдаг. Энэ хичээл нь үгсийг хэрхэн судлах тухай юм. Библийн тодорхой хам сэдвийн хүрээнд үг нь ямар утгатай болохыг ойлгохын тулд бид үгийг судалдаг.

Заримдаа хүмүүс Библийн грек, еврей үгсийг Библи судлах эх сурвалжийн тусламжтайгаар судалдаг. Ийм төрлийн үгийн судлалд зориулсан эх сурвалжууд зарим хэл дээр хангалттай байдаггүй учраас бид тэдгээрийг энэ хичээлд авч үзэхгүй. Харин бидний эх хэл дээр орчуулсан Библийн орчуулга дахь үгсийг хэрхэн судлах талаар суралцах болно.

Бид үгийн судлал хийх гурван алхамт үйл явцыг ашиглах болно:

1. Судлах үгсийг сонгох.
2. Сонгосон үг тус бүрийн боломжит утгыг жагсаах.
3. Сонгосон үг нь хам сэдвийн хүрээнд ямар утгатайг ялгах.

Үгийн судлал хийхэд гаргадаг нийтлэг алдаанууд

Үгийн судлалыг эхлүүлэхдээ бид зарим алдаанаас зайлсхийх хэрэгтэй. Эдгээр алдаанууд нь ихэвчлэн буруу хөрвүүлэг хийхэд хүргэдэг.

Үгийн хуучирсан утгыг хайхрахгүй өнгөрөөх

Заримдаа үгийн хэрэглээ нь цаг хугацааны явцад өөрчлөгддөг. Хэрэв бидний хэрэглэж байгаа Библийн орчуулгыг олон жилийн өмнө хийсэн бол Библийн зарим үгийн утга өнөөдрийн утгаас өөр байж болзошгүйг анхаарах хэрэгтэй. Хэрэв тухайн үгийн хэрэглээ өнгөрсөнд ямар байсныг ойлгохгүй бол бидний судалж буй багц хэсэгт юу хэлж байгаа

²⁶ Энэ хичээлийн ихэнх нь материалыг J. Scott Duvall ба J. Daniel Hays нарын *Grasping God's Word* (Grand Rapids: Zondervan, 2012) номын 9-р бүлгээс авсан.

талаар буруу дүгнэлт хийх боломжтой (Библийн саяхны орчуулга уншиж байгаа бол энэ нь тийм ч их асуудал болохгүй).

► Таны төрөлх хэлэнд өмнө нь өөр утгатай байсан үгсийн талаар ярилц.

Үгийг бүх хам сэдэвт ижил утгатай гэж үзэх

Библийн бичигчид нэгээс илүү олон утгатай үгсийг ашигласан байдаг. Нэг ижил үгийг өөр хам сэдэвт өөр утгаар ашиглах боломжтой. Бидний судалж буй эшлэлд аль утга нь зөв болохыг мэдэхийн тулд үгийг ашиглаж буй хам сэдвийг харах ёстой.

Үгийн судлал хийх үйл явц

Алхам 1: Судлах багц хэсгээсээ үгсийг сонгох

Библийн бүх үгийг бид гүнзгий судлах шаардлагагүй. Заримдаа үгийн утга нь тодорхой байдаг. Жишээлбэл, Давид таван чулуу авсан гэж Библид бичсэнийг (1 Самуел 17:40) бид утгыг нь олохын тулд чулуу гэдэг үгийг судлах шаардлагагүй.

Судлах үгсийг сонгохдоо дараах зүйлсийг анзаараарай:

- Багц хэсгийн утгад чухал ач холбогдолтой үгс
- Давтагдсан үгс
- Хэлц үг
- Тодорхой бус, тайлбарлахад төвөгтэй үгс

► Ром 12:1-2 эшлэлийг уншаад судлах чухал үгсийг дугуйлаарай. Тухайн үгийг сонгосон шалтгаанаа үгийн хажууд тэмдэглэ:

- 1 = Чухал ач холбогдолтой үг
- 2 = Давтагдсан үг
- 3 = Хэлц үг
- 4 = Тодорхой бус, тайлбарлахад төвөгтэй үг

Иймд ах дүү нар аа, Бурханы өрөвч сэтгэлээр та нараас хичээнгүйлэн гуйя.

Өөрсдийн биеийг Бурханд тааламжтай, амьд, ариун тахил болгож өргө. Ингэх нь

та нарын сүнслэг мөргөл мөн. Энэ үеийн явдалд нийцэлгүй, харин оюун санаагаа

шинэчилж, өөрчлөгдөгтүн! Тэгвэл Бурханы сайн, тааламжит, төгс төгөлдөр хүсэл

юу болохыг таних болно.

Таны тэмдэглэсэн байж болох зарим үгсийг харвал:

- 1 = Чухал үг: *хичээнгүйлэн гуйя, өргө, нийцэх, өөрчлөгдөгтүн, шинэчлэл*
- 2 = Давтагдсан үг: энэ багц хэсэгт байхгүй байна
- 3 = Хэлц үг: *амьд, ариун тахил*
- 4 = Тодорхой бус, тайлбарлахад төвөгтэй үг: *сүнслэг мөргөл*

Алхам 2: Сонгосон үг тус бүрийн боломжит утгыг жагсаах

Ихэнх хэлэнд олон янзаар хэрэглэгддэг, маш олон утгатай үгс байдаг. Сонсогч нь хам сэдвийн тусламжтайгаар өгүүлэгч ямар утгаар хэлж байгааг ихэвчлэн мэддэг. Заримдаа сонсогч хам сэдвийг харгалзан үзэхгүй, өгүүлэгчийн хэлэх гэсэн утгыг буруу ойлгосноос болж, хошин эсвэл ноцтой үл ойлголцол бий болдог.

► Үгийн утгыг буруу ойлгосноос болж хэн нэгэн алдаа гаргаж байсан тохиолдлыг санаж байна уу?

Энэ хоёр дахь алхмаар бид тухайн үгийн байж болох бүх хэрэглээг бодож үзэх хэрэгтэй. Хэрэв Библийн орчуулга маань хуучин бол тухайн үг өнгөрсөнд нэмэлт утгаар хэрэглэгдэж байсан эсэхийг мөн бодож үзэх хэрэгтэй.²⁷ Хэрэв бидэнд толь бичиг байгаа бол энэ нь бүх боломжит утгыг жагсаахад тусална. Хэрэв бусад хүмүүстэй хамт судалж байгаа бол тэд бидний бодож үзээгүй утгыг олоход тусалж магадгүй юм.

Боломжтой бол Библийн бусад орчуулгыг харж, тэнд ижил үгийг ашигласан эсэхийг шалгаарай.²⁸ Хэрэв орчуулга өөр үг ашигласан бол үгсийг харьцуулж, ялгаа нь юу болохыг олж мэдээрэй. Үгс нь ижил утгатай байна уу? Үгүй бол тэнд ямар ялгаа байна вэ? Өөр үгийг ашигласнаар тухайн багц хэсгийн утга өөрчлөгдсөн үү?

► Ром 12:1-2 эшлэлээс бидний судлахаар тэмдэглэсэн үгсийн нэг нь "Өргө" юм. "Өргө" гэдэг үгийн бүх боломжит утгын жагсаалтыг хамтран гаргацгаая.

Алхам 3: Сонгосон үг нь хам сэдвийн хүрээнд ямар утгатайг ялгах

Үгийн янз бүрийн хэрэглээг харж, боломжит утгуудын жагсаалт гаргасны дараа та судалж буй багц хэсэгт тухайн үг ямар утгатай болохыг олж мэдэхэд ойртсон байна. Хам сэдэв таныг чиглүүлэх болно. Бичигч цөөн хэдэн хүн л мэдэх боломжтой далд утга санаагаар бичээгүй гэдгийг сана. Бичигч нь уншигчийг ойлгоосой хэмээн хүссэн.

Бид 5-р хичээлээр хам сэдвийн чухал ач холбогдлыг харсан тул энэ материалыг нарийвчлан дахин авч үзэхгүй. Хам сэдвийн үүргийг нэгтгэн хэлэхэд: Бид үгийг хамгийн сайн тодорхойлохын тулд түүний эргэн тойронд буй эшлэл, бүлэг болон номыг хардаг.

²⁷ Хэрэв бид Библийн хуучин орчуулгыг ашиглаж байгаа бол Библийн шинэ орчуулгыг харах нь тухайн агуулга дахь үгийн боломжит утгын талаар ойлголт өгч болох юм.

²⁸ Библийг өөр хэл эсвэл өөр хувилбараар уншиж болох вебсайтуудын жагсаалтыг хавсралтаас үзнэ үү.

Хам сэдвийг харж, үгийн утгыг олж мэдэхэд туслах асуултууд бий.

(1) Багц хэсэгт үгийг судлахад туслах эсрэгцэл эсвэл харьцуулалт байна уу?

► Иохан 3:16 эшлэлийг унш. "Бурхан ертөнцийг үнэхээр хайрласан учраас цорын ганц Хүүгээ өгсөн. Тиймээс Хүүд итгэдэг хэн ч мөхөхгүй харин мөнх амьтай болно." Хамтдаа "мөхөх" гэдэг үгийн бүх боломжит утгын жагсаалтыг гаргацгаая (Хэрэв танд толь бичиг байгаа бол ашиглаж болно). Одоо, эшлэлд өгөгдсөн эсрэгцлийг авч үзье. "**Мөхөх**" нь "мөнх амьтай" байхтай эсрэгцэж байна. Таны жагсаалтаас "мөхөх" гэдэг үгийн аль утгыг Есүс энэ өгүүлбэрт хамгийн ихээр хэлэхийг хүссэн бэ?

(2) Бичигч энэ үгийг бусад хэсэгт хэрхэн ашигласан бэ?

"Ертөнц" гэдэг үгийг Иохан 3:16 эшлэлд мөн дурдсан байдаг. "Ертөнц" гэдэг үг нь хэд хэдэн утгатай байж болно:

- Биет, нүдэнд харагдах ертөнц
- Бүх хүмүүс
- Мэдэгдэж буй соёл иргэншилт үндэстнүүд
- Бурханыг үгүйсгэдэг ерөнхий тогтолцоо, нийгэм

Бичвэрийн олон янзын хэсэгт эдгээр утга санааг илэрхийлэхийн тулд бичигчид "ертөнц" гэдэг үгийг ашигласан. Иохан 3:16 эшлэл дэх "ертөнц" гэдэг үг ямар утгатай болохыг ойлгохын тулд Иохан энэ нэр томъёог хэрхэн ашигласныг бусад жишээнээс харах хэрэгтэй юм.

- Иохан 1:10, "Тэрээр ертөнцөд байсан, ертөнц Түүгээр буй болсон боловч ертөнц Түүнийг таниагүй юм." Энэ эшлэлд Есүсийн тухай өгүүлж байна. Ертөнц түүнийг мэдсэнгүй.
- Иохан 7:7, "Ертөнц та нарыг үзэн ядаж чадахгүй. Харин ертөнцийн үйлс муу муухай гэдгийг Би гэрчилдэг тул Намайг үзэн яддаг." Есүс энэ эшлэлд өгүүлж байна. Ертөнц түүнийг үзэн яддаг.
- Иохан 14:17, "Тэр бол үнэний Сүнс бөгөөд Түүнийг харахгүй мэдэхгүйгээсээ болж ертөнц Түүнийг хүлээн авч чадахгүй. Харин Тэр та нартай хамт байх бөгөөд та нарын дотор байх тул та нар Түүнийг мэднэ." Ертөнц үнэний Сүнсийг хүлээн авдаггүй.
- 1 Иохан 2:15-17, "Ертөнц хийгээд ертөнцөд байгаа юмсад бүү дурла. Хэн нэг нь ертөнцөд дурладаг бол түүнд Эцэгийн хайр алга. Учир нь ертөнцөд байгаа бүхэн тухайлбал, махбодын хүсэл тачаал, нүдний хүсэл тачаал, амьдралын бардамнал нь Эцэгээс бус, харин энэ ертөнцөөс ирдэг юм. Ертөнц хийгээд түүний хүсэл тачаал өнгөрнө. Харин Бурханы хүслийг үйлдэгч нь мөнхөд оршино."

Ертөнцийн үнэт зүйлс, эрмэлзэл нь бүхэлдээ Бурханы эсрэг байдаг.

Элч Иохан "ертөнц" гэдэг үгээр ихэвчлэн Бурханыг үгүйсгэдэг ерөнхий тогтолцоо, нийгмийг илэрхийлж хэлдэг байжээ. Энэ нь Есүсийн амлалт хүрээгээ тэлж байгааг харуулдаг: Бурхан өөрөөс нь тусгаарлагдсан харь хүмүүсийг маш ихээр хайрлаж, бүгдийг нь аврахын тулд Хүүгээ өгсөн юм.

(3) Үгийн утгын талаар хам сэдэв юуг харуулж байна вэ?

► Лук 1:68-79 багц хэсгийг үз.

Лук 1:71 эшлэлд Захариа Израил "*аврагдах*" талаар залбирчээ. Тэр юуны тухай өгүүлж байна вэ? Энэ эшлэлийн "*аврагдах*" гэсэн үг ямар утгатай вэ?

Авралын тухай ойлголтыг Бичвэрт олон утгаар илэрхийлсэн байдаг. Энэ нь дараах санааг нарийвчлан хэлсэн байх боломжтой:

- Дайснаас эсвэл аюулаас чөлөөлөх
- Өвчнөөс чөлөөлөх
- Нүглээс чөлөөлөх

Ойрын хам сэдэв нь (Лук 1:68-74) "*аврагдах*" гэдэг нь дайснаас чөлөөлөх тухай хэлж байгааг харуулдаг. Чөлөөлөгдөх (*аврагдах*) нь Бурханы Абрахамд өгсөн амлалтыг гүйцэлдүүлдэг (Лук 1:73).

Хэдэн эшлэлийн дараа Лук "Аврал"-ыг илүү гүн утгаар илэрхийлсэн байдаг (Лук 1:77). Ариун Сүнсний удирдлагаар Захариа хүүгээ Хамгийн Дээд Нэгэний эш үзүүлэгч гэж дуудагдах болно гэдгийг харсан. Захариагийн хүү Эзэний хүмүүст тэдний нүглийн уучлалаар дамжуулан *авралын* мэдлэгийг өгөх болно. Энд "Аврал" нь нүглийг уучлахтай холбоотой байдлаар бичигджээ.

Энэ залбиралд "Аврал" нь өөр өөр утгаар илэрхийлэгдсэн байна. Бид утгыг хам сэдвээс нь тодорхойлдог.

Дасгал ажлууд

Ангийн удирдагчид өгөх зөвлөмж: Эдгээр дасгалыг хийх хангалттай цагийг ангид гаргаарай. Хэрэв танай ангийн хичээл нэг цаг үргэлжилдэг бол эдгээр дасгалд бүтэн нэг хичээлийн цагийг зарцуул. Дасгал бүрд зориулсан тодорхой хугацааг зааж өгсөн байгаа. Ангид хамтдаа дасгал ажлыг хийх нь суралцагчдад сурсан зүйлээ хэрэгжүүлэхэд тусална. Бусад хүмүүстэй хамт үгийн судлал хийх нь ганцаараа судлал хийхдээ бодож үзээгүй өнцөг, нарийн ширийн зүйлсийг харахад тусалдаг.

Жижиг бүлгээр дасгал хийхдээ гурван сурагчийг нэг бүлэг болгоно. Сүүлийн таван минутад бүлгүүд хамтдаа цугларч, юу сурснаа ярилцана.

► **Жижиг бүлгээр хийх дасгал (20 минут)** Бүлгийнхэнтэйгээ нэг үг янз бүрийн утгаар хэрэглэгдсэн хэд хэдэн эшлэлийг хайж олно. Энд танд туслах хэдэн санаа байна: *байшин, үзэгдэл, өдөр, жимс*. Ижил үгийг өөр өөр байдлаар хэрэглэсэн зарим эшлэлийг

олсны дараа тухайн үгийг хэрэглэж болох бүх утгын жагсаалтыг гаргаарай. Үгийн судлал нь эшлэл тус бүрийг зөв хөрвүүлэхэд хэрхэн тусалдаг вэ?

► **Бүлгүүд хамтдаа хийх дасгал (10 минут).** Одоо Ром 12:1 эшлэл дэх "өргө" гэдэг үгийн боломжит утгын жагсаалтаа эргэж хараарай. Дээрх асуултуудыг ашиглан энэ үг эшлэлд аль утгаар хэлэгдсэнийг ялгаж тань.

► **Жижиг бүлгээр хийх дасгал (30 минут).** Бүлгийнхэнтэйгээ үгийн судлал хийх үйл явцыг хийж бататгаарай. Та Ром 12:1-2 эшлэлийн сайтар судлах ёстой үгсийг аль хэдийн тэмдэглэсэн байгаа. Эдгээр үг тус бүрийн боломжит утгыг жагсааж, тухайн хам сэдэвт эдгээр үгс ямар утгатай болохыг тодорхойлно уу.

Онцгой тохиолдол: Дүрслэл, хэлц үг

6-р хичээл дээр бид дүрслэл, хэлц үгийн талаар товчхон авч үзсэн. Үгийн судлалыг хэчнээн нарийн хийсэн ч бичигчийн дүрслэл, хэлц үгийг буруу ойлгосон бол бидний дүгнэлт буруу байх болно. Хэлц үгийн шууд утга биш, харин тэдгээрийн бэлгэдэж буй санаа нь чухал байдаг.²⁹

Бид бүгдээрээ дүрслэл, хэлц үг ашигладаг. Америк найз тань цэцэрлэгийнхээ зургийг үзүүлж байна гэж төсөөлж үзье. Та цэцэрлэгийг гайхан, найзаасаа "Ийм сайхан ургамлыг яаж ургуулсан юм бэ?" гэж асуув. Тэр хариуд нь "Би ногоон эрхий хуруутай" гэж хариулсан. Энэ нь шууд утгаараа түүний эрхий хуруу ногоон өнгөтэй гэсэн үг биш. Харин тэрээр "Би ургамал ургуулах ер бусын чадвартай" гэсэн утга бүхий америк англи хэлний хэлц үгийг ашиглажээ.

► Таны төрөлх хэлэнд шууд утгаас нь өөр зүйлийг илэрхийлдэг ямар ямар хэллэгүүд байдаг вэ?

Заримдаа өөр зүйлийг төлөөлүүлж хэлэхэд үгийг ашигладаг. Энэ нь үг хэд хэдэн утгатай байхаас өөр юм. Жишээлбэл, Библид зарим хүмүүсийг "ноход" гэж нэрлэсэн байдаг (Илчлэл 22:15). Энэ нь хүнд байх ёсгүй, харин нохойн гаргадаг зарим шинжээр нь хүмүүсийг шүүмжилж байгаа хэрэг юм. *Нохой* гэдэг үг нь бидний нохой гэж нэрлэдэг амьтныг хэлдэг боловч бэлгэдлийн утгаар хүмүүсийг ч ийнхүү хэлдэг. Есүс Симоныг Петр гэж нэрлэсэн бөгөөд энэ нь *хад* гэсэн утгатай бөгөөд хүнд байх ёстой сайн шинжийг агуулдаг (Матай 16:18). Есүс *хад* гэдэг үгийн энгийн утгыг ашиглан, Симонд хад шиг зарим шинж байсныг илэрхийлжээ.

Есүс Херодыг үнэг гэж дуудсан байдаг (Лук 13:32). Есүс ямар амьтны талаар хэлснийг ойлгохын тулд *үнэг* гэдэг үгийн өөр өөр утгыг судалж, хам сэдвийг харах шаардлагагүй. Энэ нь шилжсэн утгаар хэлэгдсэн бөгөөд Есүс Херодыг *үнэг* гэж дуудахдаа юу хэлэхийг

²⁹ Энэ хэсгийн материалыг Howard G. Hendricks ба William D. Hendricks нарын *Living by the Book* (Chicago: Moody Publishers, 2007) номын 36-р бүлгээс авч тохируулсан болно.

зорьсныг бид ойлгохыг хичээдэг. Херод ухаантай боловч муу зан чанараас нь болж түүнд итгэж болохгүй гэсэн санаагаар Есүс хэлсэн болов уу.

► Танай соёлд хүнийг шүүмжлэхдээ ямар нэг амьтнаар төлөөлүүлж хэлдэг үү?

Хэлсэн зүйл нь шууд утгаар ойлгогдох уу эсвэл шилжсэн утгатай юу гэдгийг бид яаж мэдэх вэ? Дараах хоёр зааврыг анзаараарай:

- 1. Бичвэрт хэлэгдсэний дагуу шилжсэн утгыг ашиглах.** Эхлэл 37-р бүлэгт хоёр зүүдний талаар өгүүлдэг. Библид зүүдээр ихэвчлэн шилжсэн утга санааг дамжуулдаг. Үүнээс болж Иосефын зүүдийг шууд утгаар нь сүрэл нь өөр сүрэлд бөхийж, нар, сар, одод Иосефт бөхийж байгаагаар ойлгож болохгүй. Үүний оронд энэ нь зүүд гэж бичигдсэн учраас бид үүнийг шилжсэн утгаар нь хэрэглэх учиртай. Энэ тохиолдолд хөрвүүлэг нь Эхлэл 37:8, 10 эшлэлд өгөгджээ.
- 2. Шууд утга нь ойлгомжгүй, авцалдаагүй тохиолдолд шилжсэн утгыг ашиглах.** Илчлэл 1:16 эшлэлд Эзэн амандаа хоёр талдаа иртэй хурц илдтэйгээр үзэгдсэн. Дүрслэлээр дүүрэн номд энэ нь Есүсийн бодит дүр төрх байх магадлал маш бага юм! Илчлэл номыг үргэлжлүүлэн харвал, Есүсийн хоёр талдаа иртэй хурц илд нь бузар муугийн хүчний эсрэг Бурханы бүрэн төгс ялалтыг бэлгэдсэн утга санаатай тохирч байгааг харж болно.

Бурхан үнэнийг нуухын тулд биш, харин дамжуулахын тулд өөрийн Үгийг өгсөн гэдгийг санаарай. Библид шилжсэн утгаар хэлэгдсэн үгсийн ихэнх нь тодорхой байдаг. Бид 6-р хичээл дээр хэлц үгийн жагсаалт гаргасан. Эдгээр нь танд шилжсэн утга бүхий үг хэллэгийг хэрхэн хөрвүүлэх талаар сайн ойлголт өгөх болно. Хэлц үгийг таньсны дараа "Бурхан яагаад энэ төрлийн дүрслэлийг өгсөн бэ? Энэ дүрслэлээр ямар үнэнийг харуулахыг зорьсон бэ?" хэмээн асуугаарай.

Заримдаа шилжсэн утгатай үг тогтсон бэлгэдэл болох нь бий. Есүсийг "Миний хоньд дууг минь сонсдог" гэж өгүүлэхэд (Иохан 10:27) сонсогчид нь Түүнийг дагадаг хүмүүсийг хэлж байгааг мэддэг байсан бөгөөд энэхүү бэлгэдлийг Библийн өөр цаг үед ч ашигладаг байжээ (ж.нь, Дуулал 23). Илчлэл 5-р бүлэгт Иудагийн овгийн Арслан Бурханы сэнтийн өмнө гарч ирдэг. Библийн толь бичиг "Иудагийн овгийн Арслан" гэдгийг Мессиад оноосон нэр өргөмжлөл хэмээн тайлбарладаг. Үүнийг мэдэх үедээ бид "Иохан яагаад энэхүү нэр өргөмжлөлийг ашигласан бэ? Энэ нэр өргөмжлөл нь Есүсийн тухай бидэнд юу хэлж байна вэ?" хэмээн асуух боломжтой. Хэлц үгийг таних нь Есүсийн золилтын хүч чадлын талаарх Иоханы дүрслэлийг ойлгоход бидэнд тусалж байна.

Библийн бичигчид заримдаа дүрслэл, хэлц үгийг ашигладаг нь бид Бичвэрийг хэзээ ч шууд утгаар нь тайлбарлах ёсгүй гэсэн үг биш юм. Харин дүрслэл, хэлц үгийг заримдаа ашигладаг гэдгийг мэдсэнээр бид текстийг бичигчийн хэлэхийг зорьсон санаагаар ойлгох учиртай. Бид бичигчийн хэлэхийг зориогүй зүйлийг Библийн үг хэллэгээр гуйвуулж төсөөллөө ашиглах ёсгүй.

Дүгнэлт

Сургаалт үгс номыг бичигч мэргэн ухааныг эрэн хайдаг хүнд дараах амлалтыг өгчээ: “Цалин цагаан мөнгө мэт үүнийг эрж, нууц эрдэнэ мэт түүнийг хайваас ЭЗЭНээс эмээхүйг чи ойлгоно Бурханы тухай мэдлэгийг олж авна (Сургаалт үгс 2:4-5). Бурханы Үгээс илүү мэргэн ухааны агуу эх сурвалж үгүй. Бичвэрийг судалснаар та өнө мөнхийн шагналыг хүлээн авах болно.

7-р хичээлийн гол санаанууд

(1) Үгийн судлал гэдэг нь хам сэдвийн доторх утгыг олж мэдэх зорилгоор багц хэсэг дэх чухал ач холбогдолтой үгсийг судлах явдал юм. Үгийн судлал нь бидний судалж буй багц хэсгийг зөв хөрвүүлэхэд тусалдаг.

(2) Үгийг судлахад гаргадаг нийтлэг хоёр алдаанаас зайлсхийх:

- Үгийн хуучирсан утгыг хайхрахгүй өнгөрөөх
- Үгийг бүх хам сэдэвт ижил утгатай гэж үзэх

(3) Үгийн судлал хийх үйл явц:

- Судлах үгсийг сонгох.
 - Багц хэсгийн утгад чухал ач холбогдолтой үгс
 - Давтагдсан үгс
 - Хэлц үг
 - Тодорхой бус, тайлбарлахад төвөгтэй үгс
- Сонгосон үг тус бүрийн боломжит утгыг жагсаах.
- Сонгосон үг нь хам сэдвийн хүрээнд ямар утгатайг ялгах.

(4) Үгийн хам сэдвийн хүрээнд утгыг ялгахад туслах асуултууд:

- Багц хэсэгт үгийг судлахад туслах эсрэгцэл эсвэл харьцуулалт байна уу?
- Бичигч энэ үгийг бусад хэсэгт хэрхэн ашигласан бэ?
- Үгийн утгын талаар хам сэдэв юуг харуулж байна вэ?

(5) Дүрслэл, хэлц үгийг судлахдаа анзаарах зүйлс:

- Бэлгэдэл санаа нь чухал ач холбогдолтой.
- Шилжсэн утга бүхий үг, хэллэг, зураглал нь өөр ямар нэг зүйлийг төлөөлдөг.
- Дүрслэл, хэлц үг нь төлөөлдөг зүйлийн шинж чанарт анхаарал хандуулдаг.
- Бид текстийг бичигчийн хэлэхийг зорьсон санаагаар ойлгох учиртай – шуут утга байна уу, шилжсэн утга байна уу ялгаагүй.

(6) Бичвэрийн мэдэгдлийг шилжсэн утгаар хөрвүүлэхдээ:

- Бичвэрт хэлэгдсэний дагуу шилжсэн утгыг ашиглах.
- Шууд утга нь ойлгомжгүй, авцалдаагүй тохиолдолд шилжсэн утгыг ашиглах.

7-р хичээлийн даалгаврууд

(1) 1-р хичээл дээр та энэ курсын туршид судлах Бичвэрийн багц хэсгийг сонгосон. Тухайн хэсгээс судлах нь чухал гэж бодож буй үгсийн жагсаалтыг гарга. Чухал ач холбогдолтой үгс, давтагдсан үгс, хэлц үг, тодорхой бус эсвэл тайлбарлахад төвөгтэй үгсийг хайж олоорой. Эдгээр үг тус бүрийг энэ хичээл дээр тайлбарласан үйл явцын дагуу судал. Үг тус бүрийн боломжит утгын жагсаалтыг гаргаарай. Хам сэдвийг анзаар. Таны судалж буй багц хэсгийн хам сэдвийн хүрээнд үг тус бүрийн утгыг ялгаарай.

(2) Саяхан судалсан үг тус бүрийн талаар бодож үз. Судалж буй үг тус бүрээр гаргасан боломжит утгын жагсаалтаа үз. Судалж буй үгийн утгыг буруу ойлгох нь багц хэсгийг буруу хөрвүүлэхэд хэрхэн хүргэж болох байсан бэ? 2-4 өгүүлбэрээр эргэцүүлэн бич.

8-р хичээл

Хөрвүүлэг: Ерөнхий зарчмууд

Хичээлийн зорилго

- (1) Библийн хөрвүүлэг хийх үндсэн зарчмуудыг ойлгох.
- (2) Бичвэрийг судлахдаа эдгээр зарчмуудыг хэрэгжүүлэх.
- (3) Эдгээр зарчмуудыг дагаагүйгээс үүдэх онол сургаалын алдаанаас зайлсхийх.

Танилцуулга

Энэ хичээлийн зарчмууд нь Бичвэрийг судлах үндэс суурь болдог. Эдгээр нь ухаант мэргэн Библийн багш нарын боловсруулсан судлал хийх зарчмууд юм. Эдгээр зарчим нь таны Библи судлах аргачлалын үндэс байх учиртай. Эдгээр зарчмыг ойлгоход цаг гарган, тэдгээрийг судлалдаа хэрэгжүүлээрэй.

Бичигчийн санаа зорилгыг анхаарч үзэх

Бичигч уншигчдадаа ямар нэгэн зүйлийг хэлэхийг зорьсон байгаа. Тэрхүү хэлэхийг зорьсон утга нь бичсэн зүйлийнх нь жинхэнэ утга юм. Хөрвүүлэг гэдэг нь бичигчийн хэлэхийг хүссэн мэдээ сургаалыг ойлгохын тулд хийж буй ажил юм. Бид Бичвэрийг бичигчийн хэлэхийг зорьсон утгаас өөр мэдээ сургаалын материал болгон хэзээ ч ашиглаж болохгүй.

Бичвэрийн мэдэгдэл бичигчийн хэлэхийг зорьсноос илүү утга учиртай байж чадна. Абрахам Исаакт "Бурхан хургаар хангана..." гэж хэлэх үедээ (Эхлэл 22:8) Бурхан Абрахамын үгийг Есүсийн ирэлтээр дамжуулан илүү агуу байдлаар биелүүлнэ гэдгийг ойлгож ухаараагүй байж болох юм. Мосе Абрахамын эдгээр үгсийг бичихдээ энэхүү мэдэгдлийн бүрэн утгыг ойлгоогүй ч байж магадгүй. Гэсэн хэдий ч энэ мэдэгдлийг Есүсийн ирэлттэй холбон хэрэглэх нь Мосегийн санаа зорилгоос тэс өөр гэсэн үг биш юм. Харин энэ нь Бурхан бидний авралд хэрэгтэй зүйлийг хангадаг гэсэн зарчмын илүү том, бүрэн дүүрэн утга санаа юм.

Библийг бичсэн хүн бүр анхны уншигчид нь түүний дамжуулж буй сургаалыг практик байдлаар хэрэгжүүлэхийг зорьж байсан. Өнөөгийн бидний сургаалын хэрэгжүүлэлт нь анхны уншигчдын хэрэгжүүлэлтээс өөр байж болох ч, энэ нь ижил зарчмыг баримталдаг. Бид Библийн зарчмыг өөр нөхцөл байдалд хэрэглэж байгаа тул бидний үйлдэл өөр байх боломжтой. Жишээлбэл, израилчуудад хандан байшингийнхаа дээвэр дээр хашлага хийхийг зааварчилсан байдаг (Дэд хууль 22:8). Тэр цаг үеийн байшингийн дээвэр нь хавтгай байсан бөгөөд дээврээ амьдрах талбайнхаа нэг хэсэг болгон ашигладаг байжээ. Хэрэв та дээр нь хүмүүс алхахаар хавтгай дээвэртэй байшинд амьдардаггүй л бол аюулгүй байдлыг хангаж дээвэртээ хашлага хийх

шаардлагагүй юм. Гэсэн хэдий ч өмч хөрөнгө маань бусад хүмүүст хохирол учруулахгүй байх зарчмыг бид хэрэгжүүлэх ёстой.

Хөрвүүлэгч нь багц хэсгийн нарийн ширийн зүйлсийг өөрийн төсөөллөөр хөрвүүлэг болгон хөгжүүлж болохгүй. Энд Есүсийн заасан сайн самари хүний тухай түүхийг төсөөллөөрөө хөрвүүлсэн жишээг танилцуулж байна (Лук 10:30-35):

Самари хүн бол сайнмэдээг тунхаглагч, шархадсан хүн бол итгэлд ирсэн нүгэлтэн, харин дэн буудал нь чуулган, харин хоёр зоос нь баптисм болон хайрын зоогийн ёслол юм.

Энэ хөрвүүлэг нь Есүсийн хөршүүдээ хайрлах тухай хэлэхийг зорьсон санааг хайхрахгүй өнгөрөөж байна (Лук 10:27-29, 36-37): Бид тусламж хэрэгтэй хүмүүст хайрыг харуулахын тулд байгаа.

Төсөөллийн хөрвүүлэгт гурван асуудал байдаг:

1. Тэдгээр нь хөрвүүлэгчийн үзэл бодлоос урган гарсан.
2. Тэдгээр нь сайн хөрвүүлгийн зарчимд суурилагагүй.
3. Тэдгээрийг үндсэн, ойлгогдохуйц аргачлалаар цэгнэж үзэх боломжгүй.

Дүгнэлтээс биш, текстээс эхлэх

Билгүүн хүрэх газраа олохын тулд газрын зургийг харсан ч дараа нь тэр "Энэ газрын зураг буруу байна" гэж хэлэв. Түүнтэй хамт явсан аялагч "Газрын зураг буруу гэдгийг чи яаж мэдэж байна вэ?" гэхэд Билгүүн итгэлтэйгээр "Би явах замыг мэднэ. Газрын зураг буруу байна" гэж хариулав. Хэдэн цагийн дараа тэд бүрэн төөрч, Билгүүн ч ялагдлаа хүлээн, газрын зургийг ойлгож дагахыг хичээж эхлэв. Түүний алдаа юу байсан бэ? Тэр дүгнэлтээс эхэлсэн. Өөрийнх нь хариулт зөв гэж тэр баттай байсан учраас газрын зураг өөр хариулт өгөхөд сонсохоос татгалзжээ.

Зарим хүмүүс Библийг ийм байдлаар уншдаг. Нэгэн номлогч өөрт нь таалагдаагүй Бичвэрийн эшлэлийг уншсан байна. Тэр "Энэ юу гэсэн утгатайг би мэдэхгүй, гэхдээ хэлсэн утгатай нь адилгүй байна" гэж хэлжээ. Тэр дүгнэлтээс эхэлж ("Би энэ сургаалтай санал нийлэхгүй байна"), улмаар Бичвэрийг уншжээ. Түүний дүгнэлт Бичвэртэй нийцэхгүй байгаа учраас тэрээр Бичвэрийг үл ойшоохоор шийдсэн байна ("Хэлсэн утгатай нь адилгүй байна").

Бичвэрийг хөрвүүлэхийн тулд бид Бичвэрээс эхэлж, дараа нь дүгнэлтээ гаргах ёстой. Бидэнд бүгдэд маань тодорхой таамаглал бий. Бид тодорхой үзэл бодлоос эхэлдэг. Энэ нь зүгээр. Харин бидний таамаглал Бичвэрийн тодорхой сургаалыг үл тоомсорлоход хүргэх үед асуудал үүсдэг. Бид дүгнэлтээс бус, харин текстээс эхэлж байгаагаа шалгах хэрэгтэй. Бидний таамаглал текстийг үл ойшоохыг бид зөвшөөрч болохгүй.

Жишээ

"Тиймд тэнгэрлэг Эцэг чинь төгс байдаг шиг та нар мөн төгс бай" (Матай 5:48).

Зарим хүмүүс "Хэн ч төгс биш!" гэж хэлдэг. Тиймээс тэд Есүсийн тушаалыг үл ойшоодог. Тэд өөрсдийн дүгнэлтээс эхэлдэг ("Хэн ч төгс биш!") бөгөөд Есүс юу гэж хэлэхийг зорьж байгааг ойлгохыг хичээдэггүй.

Матай 5:48 эшлэлийг судлахдаа бид "Есүсийн 'төгс' гэж хэлсэн нь ямар утгатай вэ? Бид ямар байдлаар тэнгэрлэг Эцэг шигээ байх ёстой вэ?" гэж асуух хэрэгтэй. Матай 5:48-ын өмнөх эшлэлүүд хариултыг өгдөг: Бид тэнгэр дэх Эцэг шигээ дайснуудаа хайрлаж, тэдэнд сайн зүйл хийх ёстой. "Тэрээр муу хүн дээр ч, сайн хүн дээр ч нараа мандуулдаг" (Матай 5:45).

Бичвэр нь Бичвэртэйгээ зөрчилддөггүй

Хэрэв бид энгийн зохиолчийн номыг уншвал энэ нь тодорхой хэмжээнд өөртэйгөө зөрчилдөж байгааг харах боломжтой. Хоёр зохиолчтой ном бол зарим асуудлаар бие биетэйгээ зөрчилдөх магадлалтай. Гэсэн хэдий ч Библи бол Бурханы Үг бөгөөд энэ нь өөртэйгөө зөрчилддөггүй.

Бурхан өөрчлөгддөггүй (Иаков 1:17). Тиймээс Түүний Үг хэдэн зуун жилийн туршид олон хүмүүн бичигчдээр бичигдэж ирсэн ч найдвартай хэвээр байдаг. Бурханы Үг өөртэйгөө зөрчилддөггүй.

Энэхүү зарчим нь Бурханы амьсгалтай холбоотой онол сургаалын зайлшгүй үр дүн юм: "Бичвэр бүр Бурханы амьсгалснаар байгаа..." (2 Тимот 3:16-17). Хэрэв Бичвэрийн бүрэн дүүрэн эх сурвалж нь Бурхан өөрөө бол Библи өөртэйгөө зөрчилдөх боломжгүй. Энэ нь Библийн сайн хөрвүүлэгт чухал юм. Хоёр багц хэсэг бие биетэйгээ зөрчилдөж байгаа мэт санагдах үед бид Бичвэрийн аль нэгийг нь буруу ойлгосон эсэхээ шалгах хэрэгтэй. Бид эшлэл бүрийг бүрэн гүйцэд ойлгох үед хоёр эшлэл аль аль нь үнэн гэдгийг харах болно.

Жишээ

"Хүн хуулийн үйлсээр бус харин итгэлээр зөвтгөгддөг гэж бид үздэг" (Ром 3:28).

"...хүн хуулийн үйлсээр бус, харин Христ Есүст итгэх итгэлээр зөвтгөгддөг" (Галат 2:16).

"Хүн зөвхөн итгэлээр бус, үйлсээр зөвтгөгддөгийг та нар харж байна" (Иаков 2:24).

Зарим уншигчид Паул, Иаков хоёр итгэл, үйлсийн үүрэг оролцооны тал дээр санал зөрөлдсөн гэж үздэг. Паул, хүн хуулийн үйлсгүйгээр зөвтгөгддөг гэж батлан хэлдэг. Иаков, хүн зөвхөн итгэлээр бус харин үйлсээр зөвтгөгддөг хэмээн бичжээ.

Эдгээр эшлэлийн хам сэдвийг харахгүй бол Иаков Паултай зөрчилдөж байна гэж бодоход хүрнэ. Гэсэн хэдий ч эшлэл тус бүрийн хам сэдэв Паул, Иаков нар юуны талаар өгүүлж буйг харуулдаг. Паул хүн хэрхэн аврагдаж, зөвтгөгдөх тухай ярьж байна. Хүн итгэлээр зөвтгөгддөг. Иаков хүн аврагдсанаа хэрхэн харуулдаг талаар өгүүлж байна.

Хүн зөвтгөгдсөнөө үйлсээрээ харуулдаг. Паул, Иаков хоёулаа хүн итгэлээр зөвтгөгдөж, дараа нь үйлсээрээ зөвтгөгдсөнөө харуулдаг гэдэгтэй санал нийлэх байсан.

Бичвэр нь Бичвэрээ хамгийн сайн хөрвүүлдэг

Энэ зарчим нь өмнөх зарчимтай нягт холбоотой. Бичвэр өөртэйгөө зөрчилддөггүй тул бид утга нь тодорхой бус багц хэсгийг ойлгохын тулд энгийн утгатай багц хэсгийг ашиглах боломжтой. Бид тайлбарлахад төвөгтэй эшлэлийг хөрвүүлэхдээ утга санаа нь тодорхой эшлэлийг ашигладаг. Бид тайлбарлахад илүү төвөгтэй эшлэлийн хөрвүүлэгт тохируулж, энгийн утгатай эшлэлийг гуйвуулдаггүй.

Хөрвүүлгийн сурах бичигт үүний талаар хэлэхдээ: “Библийн аль нэг хэсэгт бүдэг байгаа зүйл нь өөр нэг хэсэгт ихэвчлэн тодорхой байдаг.”³⁰ Бид Бичвэрийг бүхэлд нь судалснаар энгийн утгатай багц хэсгүүд нь тайлбарлахад төвөгтэй багц хэсгүүдийг гэрэлтүүлэх боломжийг олгодог.

Жишээ

“Тийм биш бол үхэгсдийн төлөө баптисм хүртэгч нь юу хийж байгаа хэрэг вэ? Хэрэв үхэгсэд огт амилуулагдахгүй юм бол юунд тэдний төлөө хүмүүс баптисм хүртдэг вэ?” (1 Коринт 15:29).

Энэ эшлэлээс болж зарим хүмүүс баптисм хүртээгүй нас барсан хүмүүсийн төлөө амьд хүмүүс баптисм хүртэх ёстой гэж боддог. Гэсэн хэдий ч Библийн аль ч хэсэг ингэж хийх талаар бидэнд хэлдэггүй. Паул уншигчдынхаа хэрэгжүүлж байсан ёс заншлыг дурдсан боловч, энэ заншил нь яг юу байсныг бид мэддэггүй.

Бичвэр нь Бичвэрийнхээ хамгийн сайн хөрвүүлэгч юм. Энэ зарчим нь 1 Коринт 15:29 эшлэлийг хөрвүүлэх чиглүүлгийг бидэнд өгдөг. Бид Матай 28:19, Үйлс 2:41, Үйлс 8:12, Үйлс 19:5 эшлэлүүдийг уншихдаа баптисм нь амьд итгэгчдэд зориулж хийдэг байсныг олж хардаг. 1 Коринт 15:29 эшлэлд нас барагсдын төлөө баптисм хийхийг тодорхой тушаагаагүй бөгөөд нэгэнт анхны чуулган амьд итгэгчдэд баптисм хийх тогтсон ёсыг үйлдэж заншсан байсныг бусад эшлэлүүд харуулдаг. Тэгэхээр 1 Коринт 15-р бүлэгт хэлснийг нас барагсдад баптисм хийх тушаал гэж үзэх шалтгаан байхгүй юм.

Бичвэр нь ойлгогдохоор бичигдсэн

Бурханы Үгийн утгыг хөрвүүлгийн энгийн аргыг ашиглан өөрөөс нь олж болно. Бурханы Үгийг нууц кодоор бичээгүй.

Чуулганы эхэн үеэс сайнмэдээний бүх үнэн зөвхөн чуулганы онцгой гишүүдэд бус бүх хүнд нээлттэй байдлаар илчлэгдсэн юм. Зөвхөн дагалдагч нарт зориулсан нууц сургаал гэж байхгүй гэдгийг Есүс хэлж байсан (Иохан 18:20). Элч Паул Тимотод Паулын олон

³⁰ Walter Kaiser and Moises Silva, *An Introduction to Biblical Hermeneutics* (Grand Rapids: Zondervan, 1994), 132.

нийтэд заасан үнэнийг бусдад заахыг даалгасан (2 Тимот 2:2). Хэрэв хүмүүс үнэнийг харж чадахгүй байгаа бол энэ нь зориудаар нуусных биш, харин Сатан тэднийг сохолсон учраас тэр юм хэмээн Паул тайлбарлажээ (2 Коринт 4:1-6). Чуулганы үүрэг даалгавар нь Бурханы үнэнийг нээлттэй хуваалцах явдал байсаар иржээ.

Бичвэрийн ихэнх хэсгийн утгыг олж мэдэхийн тулд сайтар судлах шаардлагатай нь үнэн боловч, түүний үнэн биднээс нуугдмал байдаггүй. Бичвэрийн үндсэн үнэнүүд утга нь тодорхой бус эшлэлүүдэд нуугдаж хоцроогүй юм. Дуулаач, "Таны үг миний хөл дэх дэнлүү, Миний зам дахь гэрэл" (Дуулал 119:105) хэмээжээ. Бурханы Үгийн зорилго нь биднийг чиглүүлэх болохоос үнэнийг нуух явдал биш юм.

"Өвөрмөц хөрвүүлгүүд ихэвчлэн буруу байдаг."

- Gordon Fee,
How to Read the Bible

Бурханы Үгийн мэдээ сургаалыг тайлахын тулд ямар нэгэн онцгой түлхүүр шаардлагагүй. Библийн нууц кодыг тайлж байна гэж хэлдэг номуудад бүү итгэ. Бид Түүний Үгийг ойлгож чадахын тулд Бурхан ярьсан.

Жишээ

Хэдэн жил тутамд хэн нэгэн "Есүс ирэх жил ирнэ гэдгийг Бурхан надад илчилсэн" гэж олонд зарладаг. 1987 онд хэвлэгдсэн алдартай номд 1988 онд Есүс ирнэ хэмээн урьдчилан таамаглажээ. Зохиолч нь эртний еврей үндэстний баяруудыг судалснаар энэ баримтыг олж мэдсэн хэмээн мэдэгдэж байв. Үүнийг бичсэн зохиолч дараа жил нь 1989 онд шүүрэлт болохыг урьдаас өгүүлсэн ном бичсэн байна. Библийг тайлах нууц эсвэл чухал сургаалууд нь далд аргад үндэслэгддэг гэж ярьдаг хүмүүст бид итгэж болохгүй. Есүс хэлэхдээ, "Харин тэр өдөр, цагийг хэн ч эс мэднэ. Тэнгэрэлч нар ч, Хүү ч мэдэхгүй. Зөвхөн Эцэг л мэднэ" (Матай 24:36).

Библийн тушаал нь Библийн амлалтыг илэрхийлдэг

Энэ зарчим нь хэрэв Бурхан тушаавал үүнд нь дуулгавартай байх боломжийг ч Тэр олгодог гэдгийг хэлж байна.

"Хүү минь, намайг баярлуулахын тулд хоёр минутын дотор хоёр километр гүйгээд ир" гэж хэлэх эцэг хүн байна гээд төсөөлж үзье. Хэсэг хугацаанд хүү нь чадах чинээгээрээ хичээж магадгүй, гэхдээ тэр эцгийнхээ хүлээлтийг хэзээ ч биелүүлж чадахгүй. Эцэст нь хүү урам хугарч, оролдохоо болино. Энэ хүн сайн эцэг мөн үү?

Зарим хүмүүс Бурханыг ийм бодит бус эцэг гэж төсөөлдөг. Бурхан "ариун байгтун"³¹ гэж хэлэхэд тэд "Бид түүний тушаалыг биелүүлж чадахгүйг Тэр мэднэ шүү дээ" гэж хэлдэг.

³¹ Бурхан энэ тушаалыг ганц удаа бус, олон удаа тушаасан байдаг (Леви 11:44, 45, Леви 20:7, 1 Петр 1:16-г үзнэ үү).

Жон Калвин бид "...хүмүүсийн хүчийг Бурханы [тушаалаар] хэмжиж чадахгүй" гэж хэлсэн байдаг.³² Бурхан хүний хүчээр биелүүлж чадахгүй тушаалыг өгдөг бөгөөд аврагдсан хүмүүстээ дуулгавартай байх хүчийг ч өгдөг хэмээн Калвин итгэдэг байжээ. Жон Веслей Бурханы Үгэнд хэлэгдсэн тушаал бүрийг амлалт гээд үүгээр Бурханы хүч итгэгчийн дотор биелэх болно хэмээн заасан.

Хүн Бурханы тушаалыг өөрийн төрөлх хүчээр биелүүлж чадахгүй. Харин бид Бурханы тушаалыг Түүний хүчээр биелүүлж чадна. Хайр энэрлээр дүүрэн тэнгэрлэг Эцэг маань хүүхдүүддээ тушаалыг нь биелүүлэх хүчийг өгдөг. Хайр энэрлээр дүүрэн Эцэг хүүхдүүддээ боломжгүй тушаалыг өгч урмыг нь хугалдаггүй. Бичвэрийн тушаал бүрийг тушаалыг биелүүлэх нигүүлсэл дагалдаж байдаг.

Есүс "Чи Эзэн Бурханаа бүх зүрх, бүх сэтгэл, бүх оюун ухаанаараа хайрла" гэж тушаасан (Матай 22:37). Энэ нь тушаал ба амлалт аль аль мөн. Бурханыг хуваагдаагүй зүрхээр хайрлах тушаал нь хэрэв бид Түүнд итгэж найдвал хуваагдаагүй зүрхийг бидэнд өгнө гэсэн Түүний амлалтыг илэрхийлж байна.

Жишээ

"Тиймд тэнгэрлэг Эцэг чинь төгс байдаг шиг та нар мөн төгс бай" (Матай 5:48).

Есүс бүх талаараа төгс байх тухай биш, харин хайрлах талаар хэлж байгааг бид хам сэдвээс нь ойлгодог. Энэ нь өөрсдийн хүчин чармайлтаар биелүүлдэг зүйл ч биш гэдгийг бид ухаардаг. Биднийг төгс байхыг тушаадаг Бурхан бол тушаалаа биелүүлдэг Бурхан мөн. Дуулаач "Хүч чадлаар намайг бүсэлдэг Бурхан замыг минь төгс болгодог" (Дуулал 18:32) хэмээн гэрчилжээ.

Есүсийн тушаалыг зөвөөр ойлгох учиртай. Үүнийг Есүсийн сургаалын ойрын хам сэдэв болон төгс (хуваагдаагүй) зүрх, ариун (тусгаарлагдсан) хүмүүсийн талаарх Библийн сургаалын гэрэлд унших ёстой. Үүнийг ойлгосны дараа Есүсийн тушаал нь хүний хэрээс хэтэрсэн стандарт бус, харин нигүүлслийн амлалт болохыг хардаг.

Библийг харах гурван линз

Евангелийн Христэд итгэгчдийн хувьд бид Библийг онол сургаал болон практикийн эцсийн эрх мэдэл хэмээн хүлээн зөвшөөрдөг. Авралд шаардлагатай бүх мэдлэгийг Библи агуулдаг.


Гэсэн хэдий ч бид уншсан зүйлээ янз бүрийн утгаар хөрвүүлдэг гэдгээ ялгадаг байх нь чухал. Ихэнх евангелчүүдийн хувьд Библийг гурван линз ашиглан уншдаг. Эдгээр линз нь Бичвэрийн эрх мэдлийг ямар ч байдлаар орлуулдаггүй. Харин тэдгээр нь зүгээр л Бичвэрийг уншиж, ойлгох арга зам юм.

³² John Calvin's 1 Тесалоник 5:23 эшлэлийн тайлбар, *The Epistles of Paul to the Romans and Thessalonians*.

Бичвэрийг бүрэн ойлгохын тулд бид гурван линзийг бүгдийг нь ашиглах ёстой. Хэрэв аль нэг линзийг үл ойшоовол бид Бичвэрийг буруу хөрвүүлэх боломжтой. Эдгээр линзийг ашиглан Библийг унших нь Бурханы Үгийн мэдээ сургаалыг илүү сайн ойлгоход тусалдаг.

Эдгээр линз Библитэй хэрхэн холбоо хамааралтай болохыг харахад дараах зураг танд тусалж болох юм. Бид линзээр дамжуулан Библийг хардаг.³³

БИБЛИЙГ ХАРАХ ГУРВАН ЛИНЗ



Линз 1: Уламжлал

Бичвэрийг харах эхний линз бол уламжлал юм. Уламжлалын линз нь "Түүхийн туршид итгэгчид энэ Бичвэрийг хэрхэн ойлгож ирсэн бэ?" гэж асуудаг. Уламжлал нь түүхийн туршид бусад Христэд итгэгчдэд байсан ойлголттой харьцуулан, бидний текстийг ойлгох ойлголтыг шалгадаг.

Уламжлал нь анхны чуулганы итгэлийн тунхгууд, өнгөрсөн цаг үед итгэгчдийг нэгтгэж байсан агуу онол сургаалууд болон өмнөх үеийн сургаалуудыг тус тус багтаадаг. Уламжлал нь чуулганы түүхийн туршид Библи хэрхэн хөрвүүлэгдэж ирснийг харуулдаг.

Чуулганы уламжлал нь бүх асуудлын талаар санал нийлэхгүй байж болно. Хамгийн найдвартай уламжлал бол хаа сайгүй, бүх цаг үеийн туршид чуулганы зааж сургаж

"Уламжлал бол үеэс үе дамжин Сүнсний зааж сургаж ирсэн үйл хэргийн үр жимс юм... Энэ нь алдаагүй бус, гэхдээ [чухал бус] биш бөгөөд бид үүнийг үл ойшоовол өөрсдийгөө ядууруулна."

- J.I. Packer,

"Upholding the Unity of Scripture Today"

³³ Энэ дүрслэлийг Danny Coleman's веблогоос авч тохируулсан:

<https://dannycoleman.blogspot.com/2013/02/quadrilateral-lenses.html>. Pixabay-аас Wolfgang Eckert-ийн Библийн зургийг авч ашигласан. <https://pixabay.com/illustrations/a-book-bible-literature-pages-6402285/>

ирсэн зүйл юм. Бие даасан урсгал чиглэлийн уламжлалыг ч үүнд авч үздэг. Гэхдээ үүнийг даяар чуулганы уламжлалтай адил тэнцүү эрх мэдэлтэйд тооцдоггүй.

Бурхан өөрийн Үгийг ойлгоход бидэнд туслахын тулд уламжлалаар дамжуулан ярьдаг. Хэрэв таны хөрвүүлэг хэний ч харж байгаагүй утга санааг Бичвэрт тулгаж байвал та алдаа гаргажээ гэж үзэх хэрэгтэй!

Линз 2: Учир шалтгаан

Учир шалтгаан бол бидний ашигладаг хоёр дахь линз юм. Энэ линз нь "Энэхүү Бичвэрийн хамгийн үндэслэлтэй ойлголт нь юу вэ?" гэж асуудаг. Учир шалтгааны линз нь Бичвэрийг уншихдаа ойлгохын тулд оюун ухаанаа ашиглахыг биднээс хүсдэг. Бичвэр нь оюун ухаанаар учир шалтгааны үүднээс ойлгогддог гэдгийг энэ нь харуулдаг. Бид Бичвэрийг ойлгохын тулд учир шалтгааныг ашигладаг. Гэхдээ бид учир шалтгааныг ашиглан үнэнийг баталж чадахгүй ч үүнээс болж Бичвэрийн үнэнийг үгүйсгэх ёсгүй юм. Олон хүн гайхамшигийг учир шалтгааны эсрэг зүйл гэж боддог учраас Библид бичигдсэн гайхамшигийг үгүйсгэдэг. Гэсэн хэдий ч гайхамшиг нь учир шалтгааны эсрэг биш бөгөөд Бурхан гайхамшиг үйлдэх хүчтэй гэдгийг бид оюун ухаанаараа ойлгодог.

Зарим итгэгчид учир шалтгааныг ашиглахыг эсэргүүцдэг. Нүглийн уналтаас болж бидний оюун ухаан ч гажуудсан тул бид Бурханы Үгийг ойлгохын тулд оюундаа найдаж болохгүй гэж тэд мэтгэлцдэг. Хүний оюуны чадавхи хэмжээ хязгаартай нь үнэн. Гэсэн хэдий ч Паулын жишээг харвал, тэр мэтгэлцэхдээ учир шалтгааныг тогтмол ашиглажээ. Жишээлбэл, Ром номд Паул уншигчдыг авралын агуу үнэний талаарх логик ойлголт руу хөтлөх хэд хэдэн асуултыг тавьсан байдаг. Хэдийгээр бидний учир шалтгаан хэзээ ч эцсийн эрх мэдэл болохгүй ч, Бичвэрийн учир шалтгааны үндэслэлийг үл ойшоох ёсгүй.

Линз 3: Туршлага

Туршлага бол сүүлчийн линз юм. Энэ линз нь "Миний ойлголт бусад итгэгчдийн туршлагатай нийцэж байна уу?" гэж асуудаг. Хувийн туршлагыг туйлын үнэнээс дээгүүр тавьж итгэж болохгүй. Гэхдээ туршлага нь уламжлал, учир шалтгаантай тэнцвэржих үед үнэ цэнтэй болдог.

Эдгээр линз тус бүр чухал юм. Хэрэв бид зөвхөн уламжлалыг ашиглавал, чуулганы сургаалыг эрх мэдлийн хувьд Бичвэртэй тэнцүү гэж үздэг Ромын католикчуудын алдааг давтах болно. Хэрэв бид зөвхөн учир шалтгааныг ашиглавал, оюун ухааныг эцсийн эрх мэдэл гэж үзэх боломжтой. Хэрэв бид зөвхөн туршлагыг ашиглавал, бидний хөрвүүлэг хязгаарлагдмал байх бөгөөд хувь хүний мэдрэмж, харах өнцөг, үзэл бодолд суурилах болно. Эдгээр линз нь Бичвэрийг ойлгоход туслах арга хэдий ч Бичвэрийн эрх мэдэлтэй зөрчилдөх хэмжээнд тэдгээрийг ашиглах ёсгүй юм.

Жишээ

"Иймд би Эцэгийн өмнө өвдөг сөгдөж... Та нар Бурханы бүх дүүрлээр бялхах болтугай" (Ефес 3:14, 19).

Паул Ефесийн итгэгчдийг Бурхантай харилцах харилцаандаа илүү гүнзгий өсөхийн төлөө залбирчээ. Тэр тэдний төлөө "Бурханы бүх дүүрлээр бялхах болтугай" хэмээн залбирсан. Хэрэв бид энэхүү залбирлыг дээрх гурван линзийн тусламжтай уншвал юу олж мэдэх вэ?

Уламжлал. Бурхан итгэгчдэд илүү дотно харилцаа алхааг амладаг болохыг бүх цаг үеийн Христэд итгэгчид зааж сургасаар иржээ. Бурхан итгэгчдийн төлөө энэхүү зорилгоо хэрхэн биелүүлдэг талаарх нарийн ширийн зүйлс дээр бүх итгэгчид санал нийлдэггүй ч чуулганы түүхийн туршид олон янзын чуулганы төлөөлөл болсон итгэгчид Бурхан өөртэйгөө илүү дотно харилцаатай байлгахар хүүхдүүдээ дууддаг гэдэгтэй санал нийлдэг.

2-р зуунд Irenaeus бидний төлөөх Бурханы зорилгын талаар "бид Бурханы дүр төрхөөр, Түүнтэй адил байхаар бүтээгдсэн" хэмээн бичжээ.³⁴ Irenaeus итгэгч бүр Бурханы бүх дүүрлээр бялхаж чадна гэж итгэдэг байжээ. 4-р зуунд Ниссагийн Грегори зэрэг Дорнодын зохиолчид итгэгч хүн Бурханы бүх дүүрэн байдлаар улам бүр дүүрсээр байх ёстой хэмээн сургажээ. 17-р зуунд Францын католик Франсуа Фенелон Бурханы нигүүлслийн хүчээр бид "Есүс шиг амьдрах, Түүн шиг бодох" чадвартай гэж бичжээ.³⁵ Бурханы нигүүлслээр бид Түүний дүр төрхтэй нийцэж чадна.

Учир шалтгаан. Паулын залбирлыг уншихдаа бидний учир шалтгаан "Энэ залбирлыг хөрвүүлсэн миний хөрвүүлэг Бичвэрийн бусад багц хэсэгтэй нийцэж байна уу?" гэж асуудаг. Энэ залбирлыг итгэгчдийн гүн гүнзгий амьдралын амлалт гэж хөрвүүлэх нь үндэслэлтэй юу? Бусад Бичвэрээс Ром 12:1, 1 Тесалоник 5:23 болон бусад текстэд гүн гүнзгий амьдрал нь итгэгчдийн төлөө боломжтой болохыг бид олж хардаг. Бурханы бүх дүүрлээр бялхах нь үндэслэл бүхий юм.

Туршлага. Түүхийн туршид итгэлийн агуу амьдралаар амьдарсан хүмүүсийн туршлага нь гүн гүнзгий амьдралын төлөөх тэдний цангааг харуулдаг. Христийг бүрэн дагадаг итгэгч хүн бүр Бурханыг илүү ихээр хүсэмжилдэг. Итгэгчдийн агуу амьдралын гэрчлэл нь Бурханы нигүүлслээр тэрхүү цангаа тайлагддаг гэдгийг харуулдаг.

Маргаантай багц хэсгүүдийг авч үзэхдээ асуух асуултууд

Чуулгануудын дунд өөрөөр тайлбарлагддаг, заримдаа найзуудын дунд маргаан үүсгэдэг Бичвэрийн багц хэсгүүд байдаг. Та эдгээр багц хэсгээс аль нэгийг харахдаа зөвхөн өөрийн үзэл бодлыг хамгаалахын оронд дараах асуултуудыг асууж үзээрэй:

- Би дүгнэлтээс эхэлж байна уу? Би Бичвэрийг уншихаасаа өмнө Бичвэр юу гэж өгүүлж байгаа талаар бодож шийдвэрээ гаргасан уу?

³⁴ William M. Greathouse, *From the Apostles to Wesley* (Kansas City: Beacon Hill Press, 1979), 38-д дурдсанчлан

³⁵ *From the Apostles to Wesley*, 85

- Энэ Бичвэрийн талаарх миний хөрвүүлэг бусад Бичвэрийн хэсгүүдтэй зөрчилдөж байна уу?
- Бусад эшлэлүүд энэ хэсгийг илүү тодорхой ойлгоход ойлголтыг өгч байна уу?
- Миний хөрвүүлэг далд утга санаа сургаалд үндэслэгдсэн үү эсвэл би энэ хэсгийг аль болох тодорхой байдлаар хөрвүүлж байна уу?
- Энэ багц хэсэгт тушаал байна уу? Хэрэв тийм бол тушаалаар илэрхийлэгдэж буй амлалт нь юу вэ?
- Христийн чуулганы үе дамжин зааж ирсэн уламжлал энэ хэсгийн талаар юу гэж хэлдэг вэ?
- Энэ багц хэсгийн тодорхой, учир шалтгааны үндэслэлтэй ойлголт юу вэ?
- Бусад итгэгчдийн туршлага энэ багц хэсгийн талаар юу гэж хэлдэг вэ?

Эдгээр асуулт нь багц хэсгийн талаарх таны хөрвүүлэгтэй бүрэн санал нийлэх баталгааг өгөхгүй ч, эдгээр нь хөрвүүлэгтэй санал нийлэх хэсгийг олоход тусалж болох юм. Хэрэв үгүй бол, эдгээр асуулт нь Бурханы Үгийн эрх мэдэлд үнэнч, чин сэтгэлээсээ дагадаг итгэгчдэд Бичвэрийн зарим хэсгийг хөрвүүлэхдээ санал нэгдэхгүй байх шалтгааныг ч тодруулахад тус болж магадгүй юм.

8-р хичээлийн гол санаанууд

- (1) Библийн хөрвүүлгийн үндсэн зарчмуудыг ойлгосноор та судлах явцдаа буруу дүгнэлт хийхээс сэргийлнэ.
- (2) Дүгнэлтээс биш, текстээс эхлэх. Өөрийн урьдач таамаглалаас болж текстийг үл ойшоохгүй байх.
- (3) Бичвэр нь Бичвэртэйгээ зөрчилддөггүй. Хэрэв хоёр багц хэсэг хоорондоо зөрчилдөж байгаа мэт санагдвал та тэдгээрийн аль нэгийг буруу ойлгосон эсэхээ шалгаарай.
- (4) Бичвэр нь Бичвэрийнхээ хамгийн сайн хөрвүүлэгч юм. Энгийн утгаар ойлгогдох багц хэсгүүдийг төвөгтэй хэсгийг хөрвүүлэхэд ашиглаарай.
- (5) Бичвэр нь ойлгогдохоор бичигдсэн. Текстийн энгийн утгыг хайж олох.
- (6) Библийн тушаал нь Библийн амлалтыг илэрхийлдэг. Тушаалыг өгсөн Бурхан биднийг дуулгавартай байхад хүчирхэгжүүлдэг.
- (7) Авралд шаардлагатай бүх мэдлэгийг Библи агуулдаг.
- (8) Бид Бурханы Үгийг ойлгоход туслах гурван линзээр Бичвэрийг хардаг:
 - Уламжлал: түүхийн туршид бусад Христэд итгэгчдэд байсан ойлголт
 - Учир шалтгаан: текстийн утгыг учир шалтгаанд үндэслэн ойлгох
 - Туршлага: Итгэгчдийн сүнслэг туршлага

9-р хичээл

Хэрэгжүүлэлт

Хичээлийн зорилго

- (1) Библийн хэрэгжүүлэлтийг хуурамч зүйлсээр орлуулахгүй байхад анхаарах.
- (2) Текстийн хөрвүүлгээс хэрэгжүүлэлт рүү шилжих үйл явцыг дагах.
- (3) Текстийн хэрэгжүүлэлтийг олохын тулд асуух тодорхой асуултуудыг мэдэх.
- (4) Бичвэрийн сонгосон багц хэсгүүдэд эдгээр алхмыг туршиж дадлагажих.

Танилцуулга

► Таны одоо хийж байгаа Библи судлал дахь **хөрвүүлэг** ба **хэрэгжүүлэлт** хоорондын холбоо хамаарлын талаар ярилц. Та номлох эсвэл заах үед аль нь илүү хялбар вэ? Текстийг хөрвүүлэх үү, эсвэл өнөөгийн ертөнцөд хэрэгжүүлэх нь үү? Та Бичвэрийг судлахдаа эсвэл номлол сонсох үедээ өөрийн амьдралдаа тусгах хэрэгжүүлэлтийг олж чаддаг уу?

Дөлгөөн "Пастор аа, бид уулзаж болох уу? Надад Библийн талаар томоохон асуулт байна" гэж хэлэв. Тухайн долоо хоногийн сүүлээр пастор Дөлгөөнтэй уулзаж, түүнд тулгарч буй асуудлыг хөндсөн хэд хэдэн Бичвэрийг харцгаажээ. Хэдэн минутын дараа Дөлгөөн Библиэ хаагаад, "Би үнэнээ хэлье. Би Библи юу гэж хэлдгийг аль хэдийн мэднэ, гэхдээ би үүнийг хийхийг хүсэхгүй байна. Энэ нь надад хэтэрхий хүнд байна" гэж хэлэв.

Дөлгөөний асуудал нь хөрвүүлэг биш, харин хэрэгжүүлэлт байжээ. Бичвэр юу гэж хэлж байгааг ажиглаж, түүний утгыг хөрвүүлэх нь хангалтгүй бөгөөд бид үүнийг өөрсдийн амьдралд хэрэгжүүлэх ёстой. Библи судлах үйл явц хөрвүүлгийн үе шатаар дуусах нь түгээмэл байдаг.

Бид текст юу гэж хэлж байгааг харах ажиглалтаар эхэлдэг. Тэгээд энэ нь юу гэсэн утгатай болохыг хөрвүүлэх үе шатаар үргэлжлүүлдэг. Улмаар текстийг өөрсдийн амьдралд хэрэгжүүлснээр бид дуусгах учиртай. Бид энэ үйл явцыг гурван асуултаар нэгтгэн дүгнэж болно:

"Учир нь үгийг сонссон атлаа эс үйлдэгч нь төрөлх царайгаа толинд харж байгаа боловч, өөрийгөө харчхаад эргэхдээ ямар байснаа даруй мартдаг хүнтэй адил юм."

- Иаков 1:23-24

- Текст юу гэж хэлж байна вэ? (Ажиглалт)
- Текст юу гэсэн утгатай вэ? (Хөрвүүлэг)
- Текст миний амьдралд хэрхэн ажилладаг вэ? (Хэрэгжүүлэлт)

Хэрэгжүүлэлтийг орлуулдаг зүйлс

Дуулаач Эзэний хуульд баярлаж, хуулийг бясалгадаг хүний талаар "Урсгал усны дэргэд тарьсан мод адил ургацын цагт үр жимсээ гаргадаг" (Дуулал 1:2-3) хэмээн бичжээ. Сатан биднийг Библиэс хол байлгахыг хичээдэг. Хэрэв бид Бурханы Үгийн хоол тэжээлээ авч чадахгүй бол бидний сүнслэг байдал суларч, үхэх болно гэдгийг тэр мэддэг.³⁶

Хэрэв Сатан биднийг Бурханы Үгээс хол байлгаж чадахгүй бол биднийг үнэнийг амьдралдаа хэрэгжүүлэхээс хол байлгахыг оролддог. Бид Бурханы Үгээр амьдрахгүй л бол бидэнд үр жимс байхгүй. Хэрэв Сатан биднийг Библи уншихаас хол байлгаж чадахгүй бол тэр биднийг хэрэгжүүлэлтийг орлуулдаг зүйлсээр уруу татах болно.

Бид хэрэгжүүлэлтийг хөрвүүлгээр орлуулдаг

Бичвэрийн хэсгийг сайтар судалж, түүний утгыг үйлдэл болгохгүйгээр тодорхойлох боломжтой. Ядуу хүний хонийг хулгайлсан баян хүний тухай Натаны сургаалт зүйрлэлийг сонсоод Давид зөв хөрвүүлсэн. "ЭЗЭН амьд! Үүнийг үйлдэгч нь үхэг. Тэр хүнд өрөвдөх сэтгэл байсангүй. Ийм хэрэг үйлдсэн учраас охин хурганы төлөө тэрээр дөрөв нугалж төлөх ёстой гэв" (2 Самуел 12:5-6).

Давидын хөрвүүлэг зөв байжээ. Тэр Эзэний нэрээр хариулсан; тэр шударга ёсыг шаардсан; тэр нөхөн төлбөр шаардсан. Давидын хөрвүүлгийг хэн ч буруутгахааргүй харагдаж байна. Гэхдээ Давид сургаалт зүйрлэлийг өөрийн амьдралдаа хэрэгжүүлж чадсангүй. Харин эш үзүүлэгч хэрэгжүүлэлтийг "Тэр хүн нь та билээ!" (2 Самуел 12:7) хэмээн хэлжээ.

Энэ бол номлогч, багш нарын хувьд онцгой аюул юм. Бид өөрсдийн дуулгаваргүй байдлыг үл тоомсорлож бусдад Бичвэрийг зааж чадна. Иаков дуулгавартай байдал үгүй хөрвүүлгийн эсрэг сэрэмжлүүлэг өгчээ. "Тиймд зөвийг үйлдэхийг мэддэг хэрнээ эс үйлддэг бол энэ нь түүнд нүгэл болно" (Иаков 4:17). Бид Бичвэрийг зөв хөрвүүлсний дараа үүнийг үйлдэл болгохоо мартаж болохгүй. Бид хэрэгжүүлэлтийг хөрвүүлгээр орлуулж болохгүй.

Бид бүрэн дуулгавартай байдлыг хэсэгчилсэн дуулгавартай байдлаар орлуулдаг

Бид Бичвэрийн багц хэсгийг судалж, түүний утгыг тодорхойлохдоо биднийг бүрэн өөрчлөх хэмжээний бус хэрэгжүүлэлтийг олж авах боломжтой. Бид Бичвэрт дуулгавартай байх талбаруудыг олж болох ч, амьдралынхаа хамгийн гүн, далд хэсэгт буй дуулгаваргүй байдлыг үл ойшоож болох юм.

³⁶ Энэ хичээлийн материалыг Howard G. Hendricks ба William D. Hendricks нарын *Living by the Book* (Chicago: Moody Publishers, 2007) номоос авч тохируулсан болно.

Магадгүй бид Ефес 4:29 эшлэлийг судалж байсан байх. "Амнаас чинь ямар ч ялзарсан үг бүү гараг. Харин хэрэгтэй үед нь бусдыг босгон байгуулах тустай үг хэл. Тэгвэл энэ нь сонсож буй хүнд нигүүлсэл өгнө." Хэрэгжүүлэлтийн үе шатанд бид өөрсдийн амьдралын чухал харилцаануудыг шалгадаг. Бид ийнхүү асуудаг:

- "Миний номлолууд цуглааныг маань босгон байгуулж байна уу?" "Тийм ээ, би итгэмжит пастор."
- "Би хүүхдүүдээ урамшуулах үгсийг хэлдэг үү?" "Тийм ээ, би хайр халамжтай эцэг эх."
- "Би хань ижлээ босгон байгуулдаг уу?" "Үгүй ээ, би харилцахдаа ихэвчлэн сөрөг байдаг."

Таны хань ижилтэйгээ харилцах харилцаа бол Бурханы Сүнс таныг өөрчлөхийг хүсэж байгаа талбар юм. Сатан таныг энэхүү текстийн хань ижилтэйгээ харилцах амьдралыг өөрчлөх хэрэгжүүлэлтийг амьдралын бусад дуулгавартай байдлаар орлуулахад уруу татдаг. Тэр таныг бүрэн дуулгавартай байдалд өөрийгөө зориулахын оронд хэсэгчилсэн дуулгавартай байдлыг хүлээн авахад уруу татдаг.

Бид гэмшлийг шалтгаар орлуулдаг

Нэгэн хуульч Есүсээс "Багш аа, мөнх амийг өвлөн авахын тулд би яах ёстой вэ?" гэж асуусан (Лук 10:25). Хуульч хариултыг нь аль хэдийн мэддэг байжээ: "Чи Эзэн Бурханаа бүх зүрх, бүх сэтгэл, бүх хүч, бүх оюун ухаанаараа хайрла. Мөн хөршөө өөрийн адил хайрла" (Лук 10:27).

Хуульч Бичвэрийг ойлгосон. "Харин тэр өөрийгөө зөвтгөх гэж Есүст 'Миний хөрш гэдэг чинь хэн бэ?' гэжээ" (Лук 10:29). Түүний асуудал нь хөрвүүлэг биш, харин хэрэгжүүлэлт байжээ. Хайр байхгүй байдлаа тэр ухаарсан.

Магадгүй Бурханы Сүнс танд "Үг яриа чинь хань ижлийг чинь босгон байгуулж чадахгүй байна; энэ нь харилцааг сүйтгэх боломжтой" гэж хэлсэн байж магадгүй. Та Үгийг уншсан; та Үгийг хөрвүүлсэн; одоо та Үгийг хэрэгжүүлэх цаг болжээ. Гэтэл та "Миний хань үргэлж сөрөг ханддаг. Хэрэв би түүнд сөрөг байдлаар ханддаг бол энэ нь миний хань хэтэрхий сөрөг байдаг учраас тэр юм. Энэ миний буруу биш ээ!" гэж бодсон байж болох юм. Ингэвэл та юу хийж байна вэ? Та Бурханы Үгэнд дуулгаваргүй байснаа гэмшихийн оронд өөрийнхөө зан байдлыг зөвтгөж байна гэсэн үг.

Бид хувьсан өөрчлөлтийг сэтгэл хөдлөлөөр орлуулдаг

Иаков Үгийг сонсоод үүнийг хэрэгжүүлдэггүй хүний тухай бичсэн (Иаков 1:23-24). Заримдаа хүн Үгийг сонсоод үнэхээр догдолдог ч, жинхэнэ өөрчлөлтийг орлож, сэтгэл хөдлөл нь хариу үйлдэхийг тэрээр зөвшөөрдөг. Пастор нь тодорхой сэдвээр номлол хийхэд хүмүүс "Энэ номлол намайг ятгасан" гэж хэлдэг ч, тэдний амьдралд удаан үргэлжлэх хувьсан өөрчлөлт харагддаггүй. Үүнээс болж олон пасторууд урам хугардаг.

Магадгүй та гэрлэлтийн семинар дээр Ефес 4:29 эшлэлийг зааж байгааг сонссон байх. Семинарын төгсгөлд шийдвэр гаргах цаг болоход та ханьдаа "Намайг уучлаарай. Би эерэг үгээр ярихыг хүсэж байна. Би илүү хичээх болно!" гэж хэлсэн ч байж болох юм. Гэсэн хэдий ч та удалгүй хатуу, сөрөг үгсээ хэлж, өвдөлттэй харилцааны хуучин зуршил руугаа буцаж ордог.

Юу болсон бэ? Сэтгэл хөдлөлийн хариу үйлдэл байсан, гэхдээ жинхэнэ өөрчлөлт байгаагүй. Энэ нь аюултай. Учир нь олон удаагийн бүтэлгүйтлийн дараа хувьсан өөрчлөгдөх нь боломжгүй гэдэгт бид итгэж эхэлдэг. Үнэнд сэтгэл хөдлөлөөр хариу үйлдэх нь жинхэнэ өөрчлөлт, дуулгавартай байдлыг дагалдах ёстой бөгөөд энэ нь Ариун Сүнсний ажилд өөрсдийгөө захируулах үед л боломжтой болдог.

Бичвэрийг хэрэгжүүлэх алхмууд

Толинд өөрийгөө хараад төд удалгүй ямар харагдаж байснаа мартдаг хүнийг дүрсэлсний дараа Иаков амьдралдаа Бичвэрийг зөв хэрэгжүүлдэг хүний талаар өгүүлжээ. "Тиймээс мартамхай сонсогч бус, хэрэгжүүлэгч байж, эрх чөлөөний хууль болох төгс хуулийг няхуур үзэн, түүгээр байдаг хүн нь үйлсдээ ерөөгдөх болно" (Иаков 1:25). Үгийг сонсох нь хангалтгүй, бид Үгийг хэрэгжүүлэх ёстой. Бичвэрийг зөвөөр хэрэгжүүлэхэд юу шаардлагатай вэ?

Бичвэрийг зөвөөр хэрэгжүүлэхийн тулд та гурван зүйлийг хийх ёстой.

Алхам 1: Бичвэрийн утгыг мэдэх

Ажиглалт, хөрвүүлгийн хичээлүүд яагаад чухал байгаа шалтгаан бол энэ юм. Хэрэв бид текстийг мэдэхгүй л бол бидний хэрэгжүүлэлт зөв байж чадахгүй. Бид "I зууны Христэд итгэгчид энэ Бичвэрийг өөрсдийн ертөнцөд хэрхэн хэрэгжүүлсэн бэ?" гэсэн асуултаар хэрэгжүүлэлтийн алхмыг эхлүүлдэг.

Жишээлбэл, Паул "Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна" (Филиппой 4:13) гэж бичсэн байдаг. Зарим багш нар үүнийг "Христ надад хүч өгдөг" учраас би хүссэн бүхнээ биелүүлж чадна гэсэн амлалт хэмээн тайлбарладаг. Тамирчид "Би өнөөдрийн тоглолтод ялна, учир нь "Би Христээр бүхнийг хийж чадна" гэж тунхагладаг. Итгэлээр эдгээх чадвартай гэгддэг хүмүүс сонсогчдод "Хэрэв танд хангалттай итгэл байвал та эдгэрэх болно. Учир нь "Та Христээр бүхнийг хийж чадна" гэж батлан хэлдэг. Хөгжил дэвшлийн хуурамч сайнмэдээг номлогчид "Бурхан таныг баян болгохыг хүсэж байна. Та зөвхөн Бурхантай хамтран ажиллах хэрэгтэй. Та 'Христээр бүхнийг хийж чадна'" гэж зарладаг.

"Филиппой дахь Христэд итгэгчид энэ эшлэлийг хэрхэн хэрэгжүүлсэн бэ?" гэж асууснаар энэ нь энэ дэлхийн амжилтын тухай амлалт биш, харин сүнслэг тэвчээртэй холбоотой амлалт байсныг бид олж мэддэг. Энэ үед Паул Ромд баривчлагдсан, түүний сонсогчид хавчлагад өртсөөр байв. Дэлхийн ололт амжилтыг олж авсан талаар энд хэлээгүй, харин тэр итгэл, дуулгавартай байдлаар бүх нөхцөл байдлыг тэсвэрлэж чадсан хэмээн хэлжээ. Паул бүх нөхцөл байдалд сэтгэл хангалуун байхыг сурсан. Учир

нь Христээр дамжуулан Бурхан түүнийг хийхийг хүссэн зүйлийг хийж чадсан юм. Энэ нь тав тухтай амьдралын тухай биш, харин бэрхшээл зовлонтой тулгарсан ч сэтгэл хангалуун байдлаа алдахгүй байх тухай юм.

Алхам 2: Бичвэр амьдралд хэрхэн хэрэгждэгийг ойлгох

Паул Тимотод бусдад үр нөлөөтэй үйлчлэхийн тулд өөрийгөө мэдэх ёстойг анхааруулсан. "Өөртөө ба сургаалдаа анхаар. Эдгээрт туйлбартай бай. Ингэснээр чи өөрийгөө болон сонсогчдоо хэн хэнийг нь аварна" (1 Тимот 4:16). Тимот өөртөө болон номлодог онол сургаалдаа анхаарлаа хандуулснаар сонсогчдод үр нөлөөтэй үйлчилж чадах байв.

Би текстийг болон анхны уншигчдад энэ нь хэрхэн хэрэгжсэнийг мэдсэнийхээ дараа өөрийгөө болон текст миний амьдралд хэрхэн хэрэгждэгийг мэдэх ёстой. Магадгүй би өөрийгөө харахдаа, Бурхан намайг ерөөж, туслаасай гэж ихэнхдээ хүсэн хүлээдэггүй ч байж болох юм. Филиппой 4:13 эшлэл надад амьдралын бэрхшээлийг итгэлтэйгээр даван туулахыг сануулдаг. Учир нь "намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна."

Одоо хэрэгжүүлэлт тодорч, тодорхой болж байна. Энэ эшлэлийн хажууд би "Христийн үнэт зүйлсийг эсэргүүцдэг орчинд ажиллаж байхад минь Бурханы нигүүлсэл намайг итгэмжит байхад хүчирхэгжүүлнэ гэдэгт би итгэж найдах болно. Би Христээр бүхнийг хийж чадна" хэмээн бичих боломжтой. Энэ нь эшлэлийг 1-р зуунаас 21-р зуунд авчирдаг.

Бичвэрийн зөв хэрэгжүүлэлт нь бодит амьдрал дээр хэрэгжих болно. Бурханы Үг амьдралын бүх талбарыг хамардаг. Би Бичвэрийг хэрэгжүүлэхдээ "Энэ текстийн 'шашны' хэрэгжүүлэлт юу вэ?" гэж асуудаггүй. Харин "Энэ текст амьдралын бүх салбарт хэрхэн хэрэгжих вэ?" хэмээн асуудаг.

Жон Веслей "Христийн сайнмэдээ шашныг бус, харин хамтын харилцааг таньдаг. Энэ нь хувьчилсан ариун байдлыг бус харин хамтын ариун байдлыг таньдаг " гэж бичсэн байдаг."³⁷ Бид нийгмээс нуугдсан лам нар шиг биш, харин бусадтай харилцдаг итгэгчид адил сайнмэдээний амьдралаар амьдардаг. Бид бусдаас тусгаарлагдах замаар бус, харин чуулганы хамт олны нөхцөл байдал дунд ариун байдалд өсдөг.

Өмнө нь бид Ефес 4:29 эшлэлийг харсан. Би энэ эшлэлийн хэрэгжүүлэлтийг авч үзэхдээ үүнийг бусад итгэгчидтэй харилцах харилцаандаа хэрэгжүүлэх ёстой: "Миний үг яриа итгэгчдийг босгон байгуулж байна уу, эсвэл тэднийг нурааж байна уу?" Би энэ эшлэлийг гэр бүлийн харилцаатайгаа холбох ёстой: "Миний үг яриа гэр бүлийг минь босгон байгуулж байна уу, эсвэл хань ижил, хүүхдүүдийнхээ итгэлийг сулруулж байна уу?" Би энэ эшлэлийг ажилтайгаа холбох ёстой: "Би эерэг үг хэлдэг ажилтан уу, эсвэл

³⁷ John ба Charles Wesley нарын 1739 оны *Hymns and Sacred Poems* хэвлэлийн өмнөх үг.

сөрөг санаа бодлыг түгээдэг үү?" Ефес 4:29 эшлэл амьдралын бүх салбартай холбогдож байна.

Ийм учраас эзэдтэйгээ зөв харилцаанд байдаг боолууд бидний Аврагч Бурханы сургаалыг бүх талаар хүндэтгэлтэйгээр харуулдаг хэмээн Паул бичсэн юм (Тит 2:10). Бичвэрийг няхуур хэрэгжүүлэх үед бидний эргэн тойрны хүмүүс сайнмэдээнд татагддаг.

Алхам 3: Бичвэрт дуулгавартай байх

Библи судлалын эцсийн зорилго бол өдөр тутмын хэрэгжүүлэлт юм. 2 Тимот 2:3-6 эшлэлд Паул Христэд итгэгчдийг цэрэг, гүйгч, тариачин хэмээн тодорхойлсон байдаг. Эдгээр дүрслэл нь зорилгодоо тууштай байгаа хүнийг харуулдаг. Цэрэг тулалдааны үеэр амрахгүй; гүйгч уралдааны дундуур зогсохгүй; тариачин ажил нь дуусах хүртэл газар хагалахаа зогсоохгүй. Христитгэлийн амьдрал тэвчээрийг шаарддаг. "Өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе" (Еврей 12:1).

Та Бичвэрийг судлахдаа "Энэ үнэнийг хэрэгжүүлэх ёстой миний амьдралын талбар юу вэ?" гэж асуугаарай. Үнэнийг амьдралдаа системтэйгээр хэрэгжүүлэхэд туслахыг та Бурханаас хүс. Ийнхүү үйлдэх үед Бурхан танд үнэнийг илүү их илчлэх болно. Та сүнслэг хоол тэжээлийг бүр ихээр хүсэмжлэх байдлаа хөгжүүлэх болно.

Хэрэв Бурхан Ефес 4:29 эшлэлээр дамжуулан таны үг яриаг өөрчлөгдөхийг ятгавал та бусдыг босгон байгуулах үгийг хэлж хэвшихэд өөрийгөө зориулах ёстой. Энэ нь өдөрт нэг удаа хэн нэгний амьдралд нигүүлслийн үг хэлэх боломж олгохыг Бурханаас хүсэх гэх мэт энгийн байж болно. Энэ нь таны харилцаанд бусдыг гэмтээх үг яриа гарах үед найзыгаа танд сануулж хэлж байхыг хүсэх ч байж болно. Энэ нь Бурханы Үгийг өдөр бүр хэрэгжүүлэх арга зам болдог.

Коллежид сурдаг нэгэн залуу амьдралынхаа тодорхой талбарт сорилттой тулгарч тэмцэлддэг байв. Одбаяр хөгжим сонирхдог байсан бөгөөд зарим дуу бичлэг нь түүний сул тал болж, уруу татагддаг байжээ. Одбаяр уруу татлагыг ялахыг хүсдэг байсан ч Бичвэрийг тууштай хэрэгжүүлдэггүй байлаа.

9-р сард сургууль дээр нь сэргэлтийн цуглаан болдог бөгөөд Одбаяр тэр үед Бурханы өмнө очин шийдвэр гаргажээ. Тэрээр дотуур байранд өрөөндөө буцаж ирээд зохисгүй санагдсан хөгжим бичлэгүүдээ гарган хаяв. Хэдэн долоо хоног тэрээр сайн гэрчлэлтэй амьдарсан ч хэсэг хугацааны дараа тэр шинэ хөгжим бичлэгүүдийг худалдан авчээ. Удалгүй тэрээр урам хугарч, 11-р сар болоход "Би буцаад уначихлаа" гэж хэлэх болно.

2-р сар гарахад сургууль дээр нь Библийн конференц болно. Одбаяр Бурханы өмнө очоод шийдвэрээ гаргана. Тэр бичлэгүүдээ хаяж, хэдэн долоо хоног сайн гэрчлэлтэй амьдарна. Харин 4-р сар гарахад тэр дахин хөгжим бичлэгүүдээ худалдан авч, үйл явц дахиад эхэлнэ!

Одбаярт юу хэрэгтэй байсан бэ? Илүү сайн хөрвүүлэг үү? Үгүй! Тэр өөрийнхөө сул талыг сайн мэдэж байсан. Оюун бодлоо цэвэр байлгах талаар Библи юу гэж хэлснийг тэр

мэддэг байсан. Тодорхой төрлийн хөгжим түүний сүнслэг алхаанд хэрхэн нөлөөлдгийг тэр мэддэг байсан. Одбаярын асуудал нь хөрвүүлэг биш, тэр зүгээр л мэддэг зүйлээ хэрэгжүүлэх хэрэгтэй байв.

Та амьдралынхаа аль талбарт хэрэгжүүлэлт хийх хэрэгтэй байна вэ?

Асуух асуултууд

Та Бичвэрийг амьдралдаа хэрэгжүүлэх арга замыг хайхдаа эдгээр таван асуултыг асуух нь тустай байж болно.

(1) Зайлсхийх ёстой нүгэл байна уу?

Олон итгэгчид Бичвэрийн шаардлагад нийцэхгүй байгаа амьдралынхаа талбарыг олж харахдаа цөхөрдөг. Бурхан бидний амьдрал дахь нүглийн талаар Үгээрээ дамжуулан ярих үед бид цөхрөх ёсгүй. Харин үүний оронд, бид Түүний Үгийг хүсэлтэйгээр дагах ёстой.

(2) Хүлээн авах ёстой амлалт байна уу?

Заримдаа хэрэгжүүлэлт нь зүгээр л Бурханы амлалтыг хүлээн авах байдаг. Бид амлалтыг зөвөөр хөрвүүлэхэд анхаарах ёстой. Зарим амлалтыг тодорхой хувь хүмүүст эсвэл Израил үндэстэнд өгсөн байдаг. Бид амлалтыг хам сэдвээс нь салгахгүй байхад анхаарах ёстой. Гэсэн хэдий ч бид тухайн амлалтыг Библийн хам сэдэвт нь няхуур хөрвүүлж, бүх итгэгчдэд өгөгдсөн амлалт гэдгийг мэдвэл тухайн амлалтыг өөрсдийн амьдралдаа хүлээн авах боломжтой.

(3) Хийх ёстой үйлдэл байна уу?

"Би Бичвэрийн энэ багц хэсгээс болоод юу хийх ёстой вэ? Энэ багц хэсэг ямар үнэнийг зааж байна вэ? Энэ нь миний онол сургаалд алдаа байгааг анхааруулж байна уу? Би Бичвэртэй нийцүүлэхийн тулд бодлоо өөрчлөх хэрэгтэй юу? Энэ Бичвэрийн багц хэсгээс болоод би ямар үйлдэл хийх хэрэгтэй вэ?" гэж асуугаарай.

Нэг жишээ бол залбирал юм. Бид Давид, Паул, Нехемиа, Есүсийн залбирлыг уншихдаа өөрсдийн залбирлын амьдралын загварыг олж хардаг. Паул эсвэл Есүсийн залбирлыг хуулбарлахаас илүү залбирахыг хэрхэн сурах вэ! Би үүнийг уншихдаа залбирлыг өөрийн амьдралдаа нийцүүлэх байдлаар үйлдэж чадна.

(4) Дуулгавартай дагах тушаал байна уу?

Паулын захидлын 2-р хагас нь ихэвчлэн тушаалуудаас бүрддэг. Эдгээр тушаал нь ихэвчлэн маш энгийн бөгөөд шууд утгаар хэлэгдсэн. Заримдаа Христэд итгэгчид аль хэдийн мэддэг зүйлийнхээ энгийн хэрэгжүүлэлтийг үл ойшоон, гүн гүнзгий үнэнийг эрж хайдаг!

Нэгэн хүн илэрхий үнэнийг үл тоомсорлож, гүн гүнзгий үнэнийг хайх аюулын талаар бичсэн байдаг. Шинэ гэрээний грек хэл дээрх анхны судлалынхаа талаар тэр ярьсан.

Матай 16:24 эшлэлд Есүс "Хэн нэг нь Миний араас дагахыг хүсвэл тэр өөрийгөө үгүйсгэн, загалмайгаа авч Намайг дага" гэж хэлсэн. Эх грек хэл дээр, гайхмаар өөр утга байхгүй. Грек хэлэнд энэ эшлэл яг сонсогдож байгаа шигээ адил утгатай. Утгыг нь ойлгоход хэцүү биш, харин дуулгавартай дагахад л хэцүү юм."³⁸

Заримдаа надад хэрэгтэй зүйл нь маш энгийн бөгөөд "Тийм ээ, Эзэн. Би дуулгавартай дагах болно" гэсэн үг байдаг.

(5) Дагах үлгэр дуурайл байна уу?

Бичвэрийн ихэнх хэсэг намтрыг агуулдаг. Бид намтрыг уншихдаа "Дагах үлгэр дуурайл байна уу?" гэж асуудаг.

Бид Эхлэл 18-р бүлгээс Абрахамын тухай уншихдаа Абрахамын загварыг дагаж, дэлхий ертөнцийн төлөө зуучлан залбирах боломжтой. Нэгэн багш Нигери улсад хичээл зааж байв. Нигери нь Муслим болон Христэд итгэгчдийн хоорондох зөрчилдөөнд ихээр өртсөн улс юм. Оюутнуудын нэг нь ангийнхаа хүүхдүүдээс "Бид тэдний төлөө залбирахаас илүүтэй яагаад муслимчуудтай тэмцдэг вэ? Бурхан тэднийг авралд авчирч чадна гэдэгт бид итгэдэг үү? Хэрэв тийм бол бид Абрахамын үлгэр дуурайлыг дагаж, тэдний авралын төлөө зуучлах ёстой!" гэж асуув. Энэ бол хэрэгжүүлэлт юм.

Үүнийг хэрэгжүүлэх нь

Бид Ром 12:1-2 эшлэл дээр ажиглалт хийж байсан. Бид эдгээр эшлэл дэх чухал нэр томъёоны талаар үгийн судалгаа хийсэн. Бид Паулын дамжуулсан сургаалыг зөв хөрвүүлэхийн тулд түүхэн ба соёлын, Библийн хам сэдвийг судалсан.

Одоо бид хамгийн чухал алхмыг хийхэд бэлэн боллоо. Та Ром 12:1-2 эшлэлийг амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэх вэ?

► Өмнөх хичээлүүдээр Ром 12:1-2 эшлэлийн талаар хийсэн тэмдэглэлээ эргэн хараарай. Дараа нь энэ текстийг амьдралдаа хэрэгжүүлэх гурван тодорхой зүйлийг жагсаан бич.

► Хэрэв та энэ хичээлийг бүлгээр судалж байгаа бол өөрийн хэрэгжүүлэлтийг бүлэгтэйгээ хуваалцаарай. Хэрэв та тэдэнтэй дараа нь дахин уулзах бол хариуцлагатай харилцааг бий болгоорой. Зарим шийдвэр зориулалт гаргахдаа бүлгийнхээ хүмүүсийг таны хэрэгжүүлэлт ямар байгаа талаар асууж шалгахыг хэлж болно.

Дүгнэлт

Энэ курс нь Библийг бусдад заахын тулд хөрвүүлэх тухай юм. Энэ нь Бурханы Үгийн үйлчлэгчид бидний хийх ёстой дуудлага юм. Гэсэн хэдий ч үүнийг хийхэд аюул байгааг анзаарах ёстой. Хэрэв бид анхаарал болгоомжгүй хандвал Библийг зөвхөн номлох, заах

³⁸ Andy Crouch-ийн "Information and Formation" 2014 оны 3-р сарын *Christianity Today* сэтгүүлээс авч тохируулсан. Онлайн хаяг: <https://www.christianitytoday.com/ct/2014/march/information-and-formation.html>.

зорилгоор л судлах болно. Бид Библийн үнэнийг өөрсдийн амьдралдаа хэрэгжүүлэхдээ алдах болно.

Библи судлал нь зөвхөн сурч, заах зорилготой биш юм. Бурханы Үгийг бие махбодыг тэжээдэг хоолтой зүйрлэх боломжтой. Идэх нь өдөр тутмын болон урт хугацааны үр нөлөөг авчирдаг. Та нэг эрүүл хоолоор холестериноо бууруулахгүйн адил Бурханы Үгтэй нэг өдөр хамт байснаар сүнслэг хүч бий болохгүй. Бие махбодын эрүүл мэндийг бий болгохын тулд тогтмол эрүүл хоолны дэглэм шаардлагатай бөгөөд сүнслэг хүчийг бий болгохын тулд Үгийн урт хугацааны хоолны дэглэм шаардлагатай. Гэсэн хэдий ч өдрийн хоолтой адил Үг нь тухайн өдөр танд тулгарч буй бүх зүйлд чухал ач холбогдолтой бөгөөд сайн өглөөний цай нь хүнд өдрийн ард гарахад тусалдагтай адил юм.

Пастор, багш, чуулганы удирдагчдын хувьд бид өөрсдийн сүнслэг амьдралаа өдөр бүр тэжээн тэтгэх ёстой гэдгийг хэзээ ч мартаж болохгүй. Бусдад заахаар хичээн зүтгэхдээ бид өөрсдийн зүрхийг Бурханы Үгийн талхаар тэжээхээ мартаж ёсгүй. Бид өөрсдийгөө тэжээн тэтгэх үед л сая Бурханы хүмүүст үйлчлэхэд шаардлагатай сүнслэг хүчийг олж авдаг.

Паул энэ аюулыг сайн мэддэг байсан. Тэр бусдад номлоод өөрөө тэнцэхгүй үлдэх аюулын талаар сэрэмжлүүлсэн байдаг (1 Коринт 9:27). Өөрсдийн зүрх сэтгэл дэх Бурханы нигүүлслийг үгүйсгээд бусдад заах нь ямар аймшигтай хэрэг вэ. Бусдад заахын тулд судал, гэхдээ зүрхэнд чинь Бурхан ярихыг сонсохын тулд мөн судал.

Үүнийг хэрэгжүүлэх нь

► Лук 14:25–17:10 багц хэсэгт цуврал сургаалт зүйрлэл болон зааврыг танилцуулжээ. Есүс Йерусалим руу сүүлчийн удаа аялахдаа дагалдагч нартаа эцсийн зааврыг өгсөн. Та Есүсийн сургаалыг уншихдаа эдгээр эшлэлээс тодорхой хэрэгжүүлэлтийг олж мэдээрэй. Таны асуулт:

- Зайлсхийх ёстой нүгэл байна уу?
- Хүлээн авах ёстой амлалт байна уу?
- Хийх ёстой үйлдэл байна уу?
- Дуулгавартай дагах тушаал байна уу?
- Дагах үлгэр дуурайл байна уу?

9-р хичээлийн гол санаанууд

(1) Бурханы Үгийг зөв хөрвүүлэх нь хангалтгүй. Харин бид үүнийг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэх ёстой.

(2) Сатан биднийг хэрэгжүүлэлтээ өөр зүйлсээр орлуулахад уруу татдаг:

- Бид хэрэгжүүлэлтийг хөрвүүлгээр орлуулдаг.
- Бид бүрэн дуулгавартай байдлыг хэсэгчилсэн дуулгавартай байдлаар орлуулдаг.
- Бид гэмшлийг шалтгаар орлуулдаг.
- Бид хувьсан өөрчлөлтийг сэтгэл хөдлөлөөр орлуулдаг.

(3) Бид Бичвэрийг амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд гурван алхмыг дагах ёстой:

- Бичвэрийн утгыг мэдэх.
- Бичвэр амьдралд хэрхэн хэрэгждэгийг ойлгох.
- Бичвэрт дуулгавартай байх.

(4) Амьдралдаа Бичвэрийг хэрэгжүүлэх арга замыг олохын тулд эдгээр асуултыг асуу:

- Зайлсхийх ёстой нүгэл байна уу?
- Хүлээн авах ёстой амлалт байна уу?
- Хийх ёстой үйлдэл байна уу?
- Дуулгавартай дагах тушаал байна уу?
- Дагах үлгэр дуурайл байна уу?

9-р хичээлийн даалгавар

1-р хичээл дээр та энэ курсын туршид судлах Бичвэрийн багц хэсгийг сонгосон. Ажиглалт, хөрвүүлэг хийхдээ бэлтгэсэн тэмдэглэлээ ашиглан, судалж буй Бичвэрийнхээ практик хэрэгжүүлэлтийн алхмуудыг жагсаан бич.

10-р хичээл

Бичвэрийн хэсгийг судлах дасгал ажил

Хичээлийн зорилго

- (1) Сонгосон Бичвэрийн хэсгүүдэд хөрвүүлгийн алхмыг хэрэгжүүлэх дасгал хийх.
- (2) Бичвэрийн хэсгийг нарийвчлан судалсан талаар бичгийн ажил эсвэл аман танилцуулга бэлтгэх.


Танилцуулга

Ангийн удирдагчид өгөх зөвлөмж: Энэ хичээлийн дасгал ажлыг хийхэд ангид хангалттай цаг гаргаарай. Нэгээс илүү хичээлийн цаг шаардлагатай бол үүнийг гаргана уу.

Энэ курсээр бид ажиглалт, хөрвүүлэг, хэрэгжүүлэлт гэсэн Библийн хөрвүүлгийн алхмуудыг үзсэн. Бид мөн Библийн хөрвүүлэг хийхэд гаргадаг нийтлэг алдаанаас зайлсхийх талаар суралцсан. Бид Бичвэрийг судлах чухал зарчмуудын талаар ярилцсан. Бид алхам бүр дээр дасгал ажил хийсэн. Энэ хичээлээр бид бүх үйл явцыг эргэн харах болно. Дараа нь ангид нийтээр Хуучин гэрээ болон Шинэ гэрээний багц хэсгүүдийг ижил үйл явцын дагуу хамт судлах болно. Та үүнийг хийх өөрийн ур чадвараа ч дадлагажуулна. Улмаар та 1-р хичээл дээр эхлүүлсэн курсын төслөө дуусгах болно.

Эхлэхийн өмнө дараах зургийг хараарай:

Библийг хөрвүүлэх нь³⁹



1	Тэдний суурин	Бичвэрийн анхдагч мэдээ, сургаал
2	Гол	Эртний ертөнц ба бидний ертөнцийг тусгаарладаг түүхэн ба соёлын ялгаа
3	Гүүр	Текстэд зааж буй зарчим
4	Газрын зураг	Шинэ гэрээний холбоо хамаарал (Хуучин гэрээний багц хэсгүүдийн хувьд)
5	Бидний суурин	Зарчмыг өнөөгийн ертөнцөд хэрэгжүүлэх

Энэ хичээлийн дараагийн хэсэгт Библийн хөрвүүлгийн бүх үйл явцыг эргэн харна. Хөрвүүлгийн үйл явцын алхам бүрд хөрвүүлэгчид зөв дүгнэлтэд хүргэх асуултуудыг асуух ёстой.

Эдгээр асуулт нь хөрвүүлгийн зарчмуудад тулгуурладаг. Үйл явц болгонд асуух ёстой асуултуудыг жагсаасан байгаа. Өгөгдсөн жишээнүүд нь асуултуудыг хэрхэн ашиглах, тэдгээр нь зөв хөрвүүлэгт яагаад хэрэгтэй болохыг харуулна.

Асуултуудын багцыг хөрвүүлэгт ашиглах багажны хайрцаг гэж үзэх хэрэгтэй. Барилгачин хүн тодорхой барилгын төсөлд бүх багажаа ашиглах шаардлагагүй байдаг

³⁹ Зураг: Anna Boggs, “Interpreting the Bible”, <https://www.flickr.com/photos/sgc-library/52377290578> хаягаар орж үзэх боломжтой, licensed under CC BY 2.0. Concept from J. Scott Duvall and J. Daniel Hays, *Grasping God’s Word* (Grand Rapids: Zondervan, 2012).

шиг энд байгаа бүх асуулт бүх хэсэгт хамаарахгүй. Хэрэв хариулт нь байхгүй мэт санагдах, эсвэл ямар нэгэн утга нэмэхгүй тохиолдолд асуултыг багц хэсэгт хамааралгүй гэж үзэх боломжтой.

Ажиглалт: Түүхэн ба соёлын хам сэдвийг ойлгох

Бичигч

- Бичигч нь хэн байсан бэ?
- Түүний үүрэг оролцоо нь ямар байсан бэ?
- Хүлээн авагч хүмүүстэй ямар харилцаатай байсан бэ?

1 Тимот 5:20: "Нүгэл үйлдсээр байгаа хүмүүсийг бүгдийн өмнө зэмлэ"

1 Тимот захидлыг бичигч элч Паул нь Тимотын багш байв. Энэ нь залуу пастор Тимотод Паулын өгсөн заавар юм.

Эдгээр зүйлийг ойлгох нь Паулын заавар нь итгэгч хүн бүрд шууд хамааралгүй байж болохыг ойлгоход тусалдаг.

Анхны сонсогчид

- Тэд хэн байсан бэ?
- Тэд ямар хүмүүс байв?

Филемон захидал нь нэг итгэгчид хувьчлан бичсэн захидал юм.

Еврей захидал нь хавчигдаж буй иудей итгэгчдэд зориулагджээ.

Нөхцөл байдал

- Энэ Бичвэр нь авралын түүхийн аль үед бичигдсэн бэ?

2 Шастир 7:14: "Нэрээр минь дуудагдсан Миний хүмүүс өөрсдийгөө даруу байлган залбирч, нүүрийг минь эрэлхийлж, хорон муу замуудаасаа эргэх аваас, Би тэнгэрээс сонсож, тэдний нүглийг уучлан, тэдний газар нутгийг эдгээнэ."

"Миний хүмүүс" гэдэг нь Бурханы ард түмэн болох тодорхой нэг үндэстнийг хэлж байна.

"Тэдний газар нутгийг эдгээнэ" гэсэн амлалт нь чуулганд шууд хамааралгүй байж болно.

- Ахуй соёлын нөхцөл байдал ямар байсан бэ? Хэрэв боломжтой бол анхдагч соёлыг судлахын тулд Библийн толь бичгийг ашиглана уу. Энэ нь тэдний соёл болон бидний соёлыг харьцуулах/эсрэгцүүлэх боломжийг олгоно.

2 Коринт 13:12: "Ариун үнсэлтээр харилцан мэндчилээрэй."

Тухайн цаг үед Христэд итгэгчид ариун үнсэлтээр мэндчилэх нь тэдний соёлын нэг хэсэг байжээ.

- Тухайн үеийн үйл явдлууд юу байсан бэ?
- Чуулганы нөхцөл байдал ямар байсан бэ? (Зөвхөн Шинэ гэрээний багц хэсгүүдэд)

Ажиглалт: Утга зохиолын хам сэдвийг ойлгох

Номын болон багц хэсэг дэх утга зохиолын хэлбэрийн шинж чанарыг авч үзнэ.

- Энэ ном/багц хэсгийн утга зохиолын хэлбэр юу вэ?
- Энэ утга зохиолын хэлбэрийн шинж чанарууд юу вэ?

Дуулал 124:4-5:

- Утга зохиолын хэлбэр: Яруу найраг
- Шинж чанар: Параллелизм

Илчлэл 12:3:

- Утга зохиолын хэлбэр: Апокалиптик зохиол
- Шинж чанар: Амьтад нь бэлгэдлийн шинжтэй

Ажиглалт: Номын сэдвийг ойлгох

- Бичсэн зорилго нь юу байсан бэ? Бичигчийн онцолж буй зүйл, бичигч санаа зовнилоо илэрхийлсэн байдал, тайлбар өгсөн, эсвэл уншигчдыг уриалсан зүйлсийг хайж олоорой.

1 Коринт 7:1: “Эм хүнд хүрэхгүй байх нь эр хүнд зүгээр...”

1 Коринт захидал нь Коринтын чуулганд Паулын өмнө нь асуулт асууж бичсэн захидалд хариу болгон бичигдсэн захидал юм.

- Хүлээн авагчдын асуудал/хэрэгцээ юу байсан бэ?

1 Коринт 1:10: “Ах дүү нар аа, та нар бүгд адил юм ярьж, хоорондоо хагаралдалгүй, харин адил бодол, адил шүүлт дотор нэгдэн нягтрахыг бидний Эзэн Есүс Христийн нэрээр би та нараас хүсэмжлэн гуйя.”

Хагаралын талаар захидлын туршид яригджээ.

- Бичигч хүлээн авагч хүмүүст юу хэлж байсан бэ? Бичигчийн ажиглалтын дараа өгсөн тушаалууд нь бичигч тэднээс юу хүлээж байсныг тодорхой харуулдаг. Тэдгээр нь энэ багц хэсгийг хэрхэн хэрэгжүүлэх ёстойг бидэнд харуулдаг.

Ажиглалт: Багц хэсгийн эхлэл ба төгсгөлийг тодорхойлох

Ихэвчлэн гэхдээ үргэлж биш, бүлгийн хуваалт нь багц хэсгийн төгсгөл эсвэл эхлэлийг таних тэмдэг болдог. Заримдаа бүхэл бүтэн бүлэг нэг багц хэсэг байх боломжтой. Зарим

тохиолдолд бүлгийн хуваалт нь буруу хийгдсэн байдаг бөгөөд үүнийг багц хэсгийн хуваалт болгон ашиглах шаардлагагүй байдаг. Шилжилтийн мэдэгдлээр тэмдэглэгдсэн сэдвийн өөрчлөлтийг анзаараарай. Хэрэв та багц хэсэгт хэтэрхий их хэсгийг хамруулбал тухайн багц хэсэгт нэг үндсэн сэдэв байхгүй байх боломжтой. Хэрэв та багц хэсгийг хангалттай хамруулахгүй бол тухайн багц хэсгийн бүрэн утга санаа харагдахгүй байх боломжтой.

- Энэ багц хэсэгт ямар эшлэлүүд багтсан бэ?

2 Коринт 7:1: "Хайртууд минь, эдгээр амлалт байгаа тул бид..."

Энэ нь өмнөх бүлгийн төгсгөлд байрлах 2 Коринт 6:14-18 эшлэлийн нэг хэсэг юм.

Исаиа 52:13-15 эшлэл нь Исаиа 53-р бүлэгт байдаг багц хэсэгтэй ижил юм.

Ажиглалт: Тухайн багц хэсэг номтой хэрхэн холбогдож байгааг ойлгох

- Энэ нь илүү томоохон сэдэвтэй нийцсэн хүүрнэл мөн үү?

Шүүгчид 17:5: "Мика гэгч нь бурхдын өргөөтэй байсан бөгөөд ефод болон гэрийн шүтээнүүдийг хийж, хөвгүүдийнхээ нэгэнд сахил хүртээн, өөрийнхөө тахилч болгожээ."

Нэгэн хүн өөрийн гэсэн тахилч, шүтээнүүдтэй байжээ. Энэ эшлэл болон Шүүгчид 17-18-р бүлгийн эргэн тойронд өрнөх хүүрнэл нь Шүүгчид номын ерөнхий сэдвийг харуулж байна. "Хүн бүр өөр өөрийн нүдэнд зөв зүйтэй гэж үзсэнээ үйлдэж байлаа" (Шүүгчид 17:6, Шүүгчид 21:25).

- Энэ нь дараа хэрэгжүүлэлттэй холбоотой теологийг харуулж байна уу?
- Энэ нь номын өмнөх багц хэсгүүдийн хэрэгжүүлэлт мөн үү?

Ефес 4-6-р бүлэг нь гол төлөв Ефес 1-3-р бүлэгт заасан теологийн практик хэрэгжүүлэлт болдог.

Ефес 4:1-д өгүүлсэн "Иймд" гэдэг үг нь теологийг зааж байгаад практик хэрэгжүүлэлтийг заах шилжилтийг харуулдаг.

Ефес 4:1: "Иймд та нар дуудагдсан тэрхүү дуудлагадаа зүй зохистой явахыг... би хичээнгүйлэн ятгая"

Ажиглалт: Бичвэрийн багц хэсгийн бүтцийг анзаарах

- Зарим материал зөвхөн үндсэн сургаалд бэлдэж байна уу?

Марк 2:2: "Олон хүн цугларснаас үүд хавиар нь хүртэл зайгүй болов."

Эдгээр нарийн ширийн зүйлс нь уншигчийг дээврээс бууж буй хүний тухай сонсоход бэлтгэдэг.

- Санаа бодлыг цаг хугацааны дараалалтай холбохын тулд ямар үгсийг ашигласан байна вэ?

Матай 24-р бүлэгт "Тэгэхэд" гэсэн үгийг олон дахин ашигласан байдаг.

- Асуулт тавьсан уу эсвэл асуудлыг гаргаж ирж байна уу?

Ром 6:1: "Тэгвэл бид юу гэх вэ? Нигүүлслийг ихэсгэх гээд бид нүгэлдээ байсаар байх уу?"

- Санаа бодлыг логиктой холбохын тулд ямар үгсийг ашигласан байна вэ?

Логик дарааллыг харуулахын тулд Ром 6-р бүлэгт "Учир нь" гэсэн үгийг олон дахин ашиглажээ.

- Харьцуулалт эсвэл эсрэгцэл ашигласан уу?

Ром 6:19: "Та нар өөрсдийн эрхтнүүдийг ёс бус явдалд хүргэх цэвэр бус, ёс бусын боол болгон өргөж байсан бол одоо өөрсдийн эрхтнүүдийг ариусалд хүргэх зөвт байдлын боол болгож өргө."

Өнгөрсөн дэх боолчлол (ёс бус, хууль бус байдал) болон одоогийн боолчлолыг (зөвт байдал) хооронд нь эсрэгцүүлсэн.

- Давталт эсвэл ижил төстэй нэр томъёо ашигласан уу?

Ром 6-р бүлэгт давтагдсан/ижил төстэй нэр томъёо: *үхэх, үхсэн, үхэгсэд, үхэл, цовдлогдсон, оршуулагдсан, хүчингүй болгохын тулд.*

Эдгээр нь бүгд эцсийн, дуусгавар болсныг тодорхойлдог үгс юм.

- Жагсаалт (тоочих) байна уу?

1 Тимот 4:12: "Харин чи итгэгчдэд үг, зан байдал, хайр, итгэл хийгээд цэвэр ариунаараа үлгэр дуурайл бол."

- Ямар дүрслэл эсвэл хэлц үг ашигласан байна вэ?

Ром 6-р бүлэгт цовдлолыг хэлц үг болгон ашигладаг.

- Зорилгодоо хүрэх арга замыг дүрсэлсэн үү?

Ром 8:13: "Харин та нар Сүнсээр биеийн үйлсийг үхэлд хүргэвэл амьдрах болно."

"Сүнсээр" – арга зам

"биеийн үйлсийг үхэлд хүргэвэл" – зорилго

"амьдрах болно" – эцсийн зорилго

- Мэдэгдэл эсвэл шаардлагын үндэслэлийг өгсөн үү?

Ром 6-р бүлэгт дэвшүүлж буй санаагаа тайлбарлахдаа "учир нь" гэсэн үгийг олон дахин ашигласан байдаг.

- Оргил цэг эсвэл эргэлтийн цэг байна уу? Энэ асуултыг ялангуяа хүүрнэлээс их асуудаг.

Матай 21:33-41 хэсэгт өгүүлсэн зүйрлэлд 38-39-р эшлэл нь оргил цэг юм.

- Шалтгаан ба үр дагаврыг дүрсэлсэн үү?

Галат 5:16: "Харин би та нарт хэлье. Сүнсээр яв, тэгвэл та нар махбодын хүслээ гүйцэлдүүлэх гэхгүй."

Шалтгаан: "Сүнсээр яв"

Үр дагавар: "та нар махбодын хүслээ гүйцэлдүүлэх гэхгүй."

- Тухайн хэсэг нь өмнөх эсвэл дараагийн хэсгээ хураангуйлж байна уу?

Шүүгчид 2:11-23 хэсэг нь Шүүгчид номыг хураангуйлдаг.

Ефес 5:1 эшлэл нь Ефес 4:25-32 хэсгийг хураангуйлдаг.

- Тухайн хэсэгт өөр Бичвэрийг эш татсан, дурдсан хэсэг байна уу? Шинэ гэрээний бичигчид Хуучин гэрээнээс эш татаж, дүрслэлүүдийг олон удаа ашигласан байдаг.

Ром 12:1: "Иймд ах дүү нар аа, Бурханы өрөвч сэтгэлээр та нараас хичээнгүйлэн гуйя. Өөрсдийн биеийг Бурханд тааламжтай, амьд, ариун тахил болгож өргө. Ингэх нь та нарын сүнслэг мөргөл мөн."

Энэ эшлэл дэх тахил гэдэг үг Хуучин гэрээний ямар нэг зүйлийг хэлсэн үгэн зураглал юм.

Ажиглалт: Чухал нэр томъёог анзаарч, судал

- Энэ хэсэгт ямар чухал нэр томъёо байна вэ?

1 Коринт 2:14-15 эшлэл дэх чухал нэр томъёо:

- *төрөлх хүн*
- *Сүнслэг хүн*

Ром 8-р бүлгийн чухал нэр томъёо:

- *махбод*
- *Сүнс*

- Эдгээр нь энэ хам сэдэвт юу гэсэн утгатай вэ? Нэр томъёо бүр дээр үгийн судлал хий.

Ажиглалт: Өгүүлбэр бүрийг задлан шинжил

- Энэ юу гэсэн утгатай вэ? Өгүүлбэр яг юуны талаар хэлж байгааг өөрийн үгээр бич.
- Яагаад үүнийг оруулсан бэ? Яагаад энд байрлуулсан бэ? Энэ өгүүлбэр байхгүй бол ямар ялгаа гарахыг бодож үз.

Хөрвүүлэг: Дамжуулж буй сургаалыг хураангуйлах

Одоо та эшлэл болон багц хэсгийн нарийн ширийн зүйлсийг анхааралтай ажигласан тул бичигчийн анхны сонсогчдод хандсан сургаалыг хураангуйлна уу. **Эшлэлийн хураангуй нь нэг өгүүлбэр** байж болно. Багц хэсгийн **хураангуй нь хэд хэдэн өгүүлбэр** эсвэл бүр **хэд хэдэн догол мөр** байх боломжтой.

Энэ алхмын зорилго нь бичигчийн анхны уншигчдад юу хэлж байсныг энгийнээр тодорхойлох юм. Энэ нь төсөөлөх эсвэл бүтээлч байх цаг биш юм. Та номлож, заахдаа сургаалыг хүмүүст хүргэх аргыг боловсруулахдаа бүтээлч байж болно, гэхдээ одоо та Бичвэрийн утгыг олохыг хичээж байна. Утга нь таны төсөөллөөс бус Бичвэрээс гарах ёстой.

- Бичигч анхны уншигчдад юу хэлж байсан бэ?

1 Коринт 1:10-13 эшлэлийг дараах байдлаар хураангуйлах боломжтой: "Онол сургаал болон нөхөрлөлд хамтдаа санал нэгдэж, эсрэг бүлгүүдэд хуваагдахгүй байхыг хүсье. Би Хлоегийн гэр бүлээс та нарын маргалдаж байгаа талаар сонссон. Та нар янз бүрийн удирдагчдыг дагахаар сонгож байгаа ч, харин зөвхөн Христ та нарын төлөө нас барсан билээ.

Та хураангуйгаа дахин шалгаж үзээрэй. Та ажиглалтаас гаргаж авсан материалаасаа дараах асуултуудыг асууж болно:

- Би Бичвэрийн анхны сонсогчдын нөхцөл байдлыг хангалттай авч үзсэн үү?
- Бичигчийн санааг чилээсэн болон энэ хэсгийг бичих болсон зорилго юу байв?
- Багц хэсэгт хийсэн миний хөрвүүлэг номын сэдэвтэй нийцэж байна уу?
- Багц хэсэгт хийсэн миний хөрвүүлэг номын үүрэг оролцоог харуулж байна уу?
- Багц хэсгийн онцолж буй бүтэц миний хураангуйтай нийцэж байна уу?
- Багц хэсэг дэх өгүүлбэр бүрийн утга миний хураангуйг дэмжиж байна уу?
- Би бичигчийн ашиглаж байгаа чухал нэр томъёог зөвөөр хөрвүүлж байна уу?

Хөрвүүлэг: Зарчмыг тодорхойлох

Энэ багц хэсгээс бүх цаг үе, бүх хүмүүст хамаарах нэг зарчмыг олоорой (Багц хэсэг хэд хэдэн зарчмыг зааж болох ч, дасгал хийхийн тулд нэгийг сонгоорой). Үүнийг нэг өгүүлбэрээр илэрхийл.

Ефес 4:25 эшлэлд байгаа зарчмуудын нэг нь: "Бүх харилцаандаа үнэнийг хэл."

Дараа нь таны зарчим текстийн анхны уншигчдад зориулсан сургаалыг зөв тусгаж байгаа эсэхийг шалгаарай:

- Энэ зарчим текстэд тодорхой заагдсан уу?
- Энэ зарчим бусад Бичвэртэй нийцэж байна уу?
- Энэ зарчим бүх цаг үе, бүх хүмүүсийн хувьд үнэн үү?

Зарчмыг бусад үнэнтэй холбох:

- Бичвэрийн өөр хэсэгт үүнтэй холбоотой ямар үнэн илчлэгдсэн бэ?
- Энэ үнэн бидний мэдлэгт юу нэмэрлэж байна вэ?
- Миний хөрвүүлэг Бичвэрийг бүхэлд нь хамруулж харвал засаж залруулахаар байна уу?
- Энэ үнэн өөр багц хэсэгтэй зөрчилдөж байгаа мэт санагдаж байна уу? Хэрэв тийм бол тэдгээрийг эвцэлдүүлэх боломжтой юу?

Хэрэгжүүлэлт: Орчин үеийн хэрэгжүүлэлт бий болгох

Таны олсон зарчмыг янз бүрийн аргаар хэрэгжүүлж болно. Нэг тодорхой орчин үеийн хэрэгжүүлэлт бий болгоорой.

- Энэ үнэнийг ямар тодорхой, орчин үеийн нөхцөл байдалд хэрэглэж болох вэ?
- Энэхүү зарчим нь хэзээ, хаана, хэнд хамаатай вэ?
- Энэ үнэнийг үзэл баримтлалын хувьд төдийгүй үйлдлээр хэрхэн хэрэгжүүлж болох вэ?
- Хэрэв би энэ багц хэсгийг үнэхээр нухацтай авч үзвэл, миний амьдралд ямар өөрчлөлт гарах вэ?

Бурханы Үгийг өдөр тутмын амьдралдаа хэрэгжүүлэхэд Ариун Сүнснээс танд удирдамж өгөхийг хүсээрэй.

Захидлуудыг хөрвүүлэх дасгал ажил

Шинэ гэрээний захидлуудыг хөрвүүлэхдээ бид захидлын талаар аль болох их зүйлийг ажигласнаар судлалаа эхлүүлдэг. Бид захидлын дамжуулж буй сургаалыг тодорхойлохын тулд судлалаа үргэлжлүүлдэг. Улмаар бид зарчмуудыг өөрсдийн амьдралд хэрэгжүүлснээр судлалаа дуусгадаг. Энэхүү хөрвүүлгийн аялал нь биднийг захидлын анхны хүлээн авагчдын ертөнцөөс орчин үеийн уншигчдын ертөнцөд хүргэдэг.

Хамтдаа хийх дасгал ажил

► Ангиараа хамтдаа 1 Иохан 2:15-17 эшлэл дээр хөрвүүлгийн үйл явцын дагуу ажилла. Дээр дурдсан асуултууд, хөрвүүлгийн үйл явцаас гадна утга зохиолын хэлбэр болох Шинэ гэрээний захидлын онцлогуудыг авч үзэхээ мартуузай (6-р хичээлийг үз).

Бие даан хийх дасгал ажил

► Суралцагч бүр эдгээр багц хэсгийн нэгийг сонгож хөрвүүлгийн үйл явцын дагуу ажилла. Дараа нь суралцагчид дүгнэлтээ бүлгийн бусад гишүүдтэйгээ хуваалцаарай.

- Ром 13:8-10
- Ефес 6:18-20
- 2 Тимот 4:6-8
- Иаков 3:13-18
- 1 Петр 2:9-10

Хуучин гэрээний хуулийг хөрвүүлэх дасгал ажил

Хуучин гэрээний хуулийг хөрвүүлэхдээ бид эхлээд энэ нь анхны сонсогчдод юу гэсэн утгатай байсныг ойлгох ёстой. Бид тэдний нөхцөл байдал болон бидний нөхцөл байдлын ялгааг, ялангуяа бид Шинэ гэрээний дор амьдарч байгаа зэрэг нөхцөл байдлын ялгааг авч үзэх ёстой. Хуучин гэрээний хуулиас бүх цаг үеийн, бүх хүмүүст хамаарах зарчмыг бид олж мэдэх ёстой. Дараа нь бид энэхүү зарчмыг амьдралдаа хэрэгжүүлж чадна.

Хамтдаа хийх дасгал ажил

► Ангиараа хамтдаа Тооллого 15:37-41 эшлэл дээр хөрвүүлгийн үйл явцын дагуу ажилла. Дээр дурдсан асуултууд, хөрвүүлгийн үйл явцаас гадна утга зохиолын хэлбэр болох Хуучин гэрээний хуулийн онцлогуудыг авч үзэж, 6-р хичээлийн асуултуудыг ашиглахаа мартуузай.

Бие даан хийх дасгал ажил

► Суралцагч бүр эдгээр багц хэсгийн нэгийг сонгож хөрвүүлгийн үйл явцын дагуу ажилла. Дараа нь суралцагчид дүгнэлтээ бүлгийн бусад гишүүдтэйгээ хуваалцаарай.

- Леви 19:9-10
- Гэтлэл 20:4-6
- Гэтлэл 22:10-13
- Дэд хууль 14:1-2

10-р хичээлийн даалгавар

1-р хичээл дээр та дараах Бичвэрийн багц хэсгүүдийн нэгийг сонгосон.

- Дэд хууль 6:1-9
- Иошуа 1:1-9
- Матай 6:25-34
- Ефес 3:14-21
- Колоссай 3:1-16

Одоо та хөрвүүлгийн аяллын алхам бүрийг дадлагажуулсан тул сонгосон Бичвэрийн багц хэсгээ сайтар судална уу. Судлалаа дуусгаад дараах хэлбэрүүдийн аль нэгээр бэлдэнэ үү:

1. Хэрэв та энэ курсыг бүлгээр судалж байгаа бол судлал ажлаа хуваалцаж танилцуулга хийнэ. (1) Ажиглалтаа харуулж, (2) текстээс зарчмуудыг зааж, (3) текст өнөөгийн итгэгчдэд хэрхэн хамаатай болохыг харуулна уу.
2. Хэрэв та ганцаараа судалж байгаа бол (1) ажиглалт, (2) текстэд заасан зарчмууд, (3) өнөөгийн итгэгчдэд зориулсан хэрэгжүүлэлт зэргийг багтаан 5-6 хуудас бичнэ үү.

Хавсралт

Библи судлалын багаж хэрэгсэл

Танилцуулга

Библийг хөрвүүлэгчдэд олон янзын эх сурвалжууд тусалдаг. Харамсалтай нь, судлал хийхэд эдгээр эх сурвалж хэлний хүртээмжээс хамаарч харилцан адилгүй байдаг. Энд таны хэл дээр орчуулагдсан эсвэл үгүй ч байж болох олон төрлийн эх сурвалжийг товч тайлбарлая. Зарим эх сурвалж нь хэвлэмэл ном, зарим нь цахим хэлбэрээр болон аль аль хэлбэрээр ч байх боломжтой.

Библи судлалын эх сурвалжийн төрлүүд

Тодорхой үг, эшлэлийг хайх багаж хэрэгсэл

Багц хэсгийг хөрвүүлэх явцад та чухал үгсийг тодруулдаг. Эдгээр үгс таны судалж буй багц эшлэлд болон өөр багц эшлэлд хэрхэн ашиглагдаж буйг харьцуулж харах нь үгсийг судлахын нэг хэсэг байдаг. Үүнийг хийхийн тулд та ижил үгийг ашигласан бусад багц хэсгийн талаар мэдэх хэрэгтэй.

Дараах хоёр багаж хэрэгсэл нь таны судлал хийж буй үг (таны төрөлх хэл дээрх Библийн хувилбарт байгаа) бусад эшлэлд гардаг эсэхийг хайж олоход тусалдаг.

Конкорданс

Конкорданс нь Библийн үгсийн жагсаалт юм. Жагсаалтад байгаа үг тус бүрийн ард тухайн үгийг тэмдэглэсэн эшлэлийн лавлагааг харах боломжтой.

Томоохон конкорданс нь Библийн гол үг бүрийн тэмдэглэгдсэн бүх тохиолдлыг багтаасан байдаг. Багавтар конкордансыг зарим Библийн ард багтаасан байдаг. Эдгээр нь цөөн үгтэй бөгөөд үгсийг агуулсан бүх эшлэлийг багтаадаггүй.

Хэрэв та тэдгээрийн давуу болон сул талыг ойлгосон бол конкорданс нь судлал хийхэд тустай байж чадна. Судлал хийхдээ конкорданс ашиглах санамж:

1. Библи таны төрөлх хэл дээр еврей болон грек хэлнээс орчуулагдсан байж магадгүй. Зарим тохиолдолд олон еврей, грек үгсийг таны төрөлх хэлээр ганц үг болгон орчуулсан байдаг. Хэрэв таны Библид ижил үг хоёр өөр эшлэлд ашиглагдсан бол тэдгээр үгсийг эх хэл дээрээ нэг ижил үг гэж бодох ёсгүй.
2. Хэдийгээр таны Библийн олон хэсэгт ашиглагдсан үг нь еврей эсвэл грек хэл дээрээ ижил үг биш байх боломжтой бөгөөд таны Библи дэх энэ үгийн энгийн хэрэглээ нь Библийг орчуулсан цаг үеийн энгийн хэрэглээний жишээ байж болно. Тиймээс танд тухайн үгийг олон янзаар ашигласан жишээ байна. Энэ нь үгийн боломжит бүх утгыг жагсаахад танд тустай.

3. Зарим конкорданс бүртгэлтэй үг бүрийн хажууд эх еврей эсвэл грек үгийг хамтад нь харуулдаг. Энэ нь таны хэл дээрх тухайн үгийг агуулсан эшлэлүүдэд энэ үг ижил еврей эсвэл грек үгээс орчуулагдсан эсэхийг мэдэхэд тусалдаг.
4. Эх хэлний үгсийг харуулсан конкорданс нь толь бичигтэй адил тодорхойлолтыг ч багтаасан байдаг. Гэсэн хэдий ч, конкорданс, толь бичиг нь ихэвчлэн үгийн хэд хэдэн боломжит утгыг өгдөг тул бичигч ямар утгыг санаатайгаар хэрэглэснийг тодорхойлохын тулд та хам сэдвийг үзэх хэрэгтэй.

Библийн программ, Вебсайт

Хэрэв таны хэл дээрх Библи интернетэд эсвэл цахим хэлбэрээр байдаг бол тухайн үгийг хайхад, вебсайт эсвэл програм нь тухайн үгийг агуулсан бүх эшлэлийг танд харуулах болно.

Библийн толь бичиг

Библийн толь бичиг нь:

1. Нэр томъёо, газар, хүмүүсийн талаарх үндсэн мэдээллийг өгдөг.
2. Толгой үгсийг агуулсан эшлэлийн жишээг өгдөг.
3. Олон хэсэгт байгаа тухайн үгийн өөр өөр утгыг тайлбарласан байх боломжтой.

Библийн толь бичиг нь заримдаа ном хэлбэрээр хэвлэгддэг. Хайлт хийх боломжтой Библийн толь бичиг нь Библи судлалын вебсайтууд эсвэл Библийн цахим программд багтсан байдаг.

Библийн гарын авлагууд

Библийн гарын авлага нь бичигч болон түүхийн талаарх үндсэн мэдээллээр дамжуулан Библийн ном тус бүрийг танилцуулдаг.

Хэрэв таны хэл дээр Библийн гарын авлагууд байхгүй бол Shepherds Global Classroom байгууллагаас гаргасан Хуучин гэрээ болон Шинэ гэрээг танилцуулсан үнэ төлбөргүй курсуудыг ашиглахыг зөвлөж байна. Эдгээр курс нь Библийн ном тус бүрийн талаарх үндсэн мэдээллийг өгдөг.

Библийн атлас

Библийн атлас нь Библид дурдагдсан газар бүрийн газрын зураг, малтлага хийгдсэн хотуудын зураг, эртний ертөнцийн талаарх нийтлэлүүдийг агуулдаг.

Газрын зураг болон үүнтэй төстэй мэдээллийг зарим вебсайтад байршуулсан байдаг.

Библийн орчуулгууд

Хэрэв таны хэл дээр нэгээс олон Библийн орчуулга байдаг бол таны судлах эшлэлийг хэд хэдэн хувилбараар унших нь ашиг тустай. Библийн вебсайт эсвэл цахим программ ашиглан та олон орчуулгыг зэрэгцүүлэн харах байдлаар эшлэлийг харьцуулж болно.

Библийн өөр өөр хувилбарууд нь өөр өөр орчуулгын философид үндэслэгдэж хийгддэг. Зарим орчуулгын багууд еврей эсвэл грек эх Бичвэрийн хэлзүйн болон өгүүлбэрийн бүтцийг хадгалахыг оролддог. Тэд аль болох эх үгсийн дарааллыг хадгалж, өгүүлбэрийг эх хувилбартай ижил байдлаар хуваадаг. Бусад орчуулгын багууд утга санааг шинэчлэгдсэн хэл дээр буулгахыг оролддог бөгөөд заримдаа ойлголтыг илүү сайн илэрхийлэхийн тулд өгүүлбэрийн бүтцийг өөрчлөх тохиолдол бий.

Та багц хэсгийг судлахдаа эх хэлний бүтцийг нягт дагасан орчуулгаар эхлүүлэх нь хамгийн сайн. Дараа нь та харьцуулахын тулд илүү дасан зохицсон орчуулгуудыг харж болно.

Олон хэл дээр Библийн олон хувилбарыг багтаасан үнэгүй ашиглаж болох гурван вебсайт:

- <http://www.biblegateway.com>
- <https://www.faithcomesbyhearing.com/audio-bible-resources/bible-is>
- <https://www.bible.com/>

Библийн тайлбарууд

Библийн тайлбарууд нь Библийн эшлэл болон багц хэсэг бүрийн тайлбар тэмдэглэл юм. Тайлбарууд нь хэвлэмэл ном, Библи судлалын вебсайтууд эсвэл Библи судлалын цахим программ хэлбэрээр байх боломжтой. Зарим тайлбар номууд нь зөвхөн Библийн нэг номыг хамруулдаг бол зарим нь олон ном, бүх Библийг ч хамруулсан байдаг. Тайлбарууд нь зохиогчдынхоо теологийн чиг хандлагыг тусгадаг учраас та ялгаж чаддаг байх ёстой.

Библийн нэмэлт мэдээлэл

Библийн нэмэлт мэдээллийг агуулсан ном, тайлбарууд нь Библийн түүхэн ба соёлын хам сэдвийг харуулдаг. Библийн ертөнц дэх ёс заншлыг мэдсэнээр та Бичвэрийн дамжуулж буй сургаалыг илүү сайн ойлгодог.

Жишээлбэл, Есүсийн сургаалт зүйрлэлүүд нь түүний амьдарч байсан цаг үеийн ахуй соёл дахь зан заншлуудад суурилсан байдаг. Мосе гол төлөв Израилын хөрш зэргэлдээ үндэстнүүдийн хиймэл шүтээний зан үйлд хариу болгон номуудаа бичжээ. Паулын бичвэрүүд нь олон бурханыг шүтдэг ертөнцөд амьдарч байсан Христэд итгэгч хүмүүст хандан бичигджээ. Бид энэхүү нөхцөл байдлыг ойлгосноор Бичвэр дэх сургаалыг хөрвүүлэхэд илүү сайн сургагдах болно.

Судлал Библи

Сайн судлал Библид Библи, тайлбар, Библийн гарын авлага, конкорданс, атлас бүгд багтсан байдаг. Судлал Библи нь таны судлах ажлын сайн эхлэл юм. Энэ нь хэвлэмэл эх сурвалж хэдий ч, өмнө нь дурдсанчлан зарим Библи судлалын вебсайтууд эсвэл цахим программ нь олон талаараа ижил, адилхан байдлаар ашиглах боломжтой байдаг.

Санал болгох эх сурвалжууд

1-р хичээл

Энэхүү курсын туршид ашигласан эх сурвалжуудыг жагсаав.

Библи. *Ариун Бичээс Нийгэмлэг, Ариун Библи 2019*

Carson, D.A. *Exegetical Fallacies* (2nd edition). Ada: Baker Books, 1996.

Duvall, J. Scott and J. Daniel Hays. *Grasping God's Word: A Hands-On Approach to Reading, Interpreting, and Applying the Bible*. Grand Rapids: Zondervan, 2012.

Fee, Gordon D. and Douglas Stuart. *How to Read the Bible for All Its Worth*. Grand Rapids: Zondervan, 2003.

Hendricks, Howard G. and William D. Hendricks. *Living by the Book*. Chicago: Moody Press, 2007.

Klein, William W., Craig L. Blomberg, and Robert L. Hubbard, Jr. *Introduction to Biblical Interpretation*. Nashville: Thomas Nelson, 1993.

Virkler, Henry A. and Karelynn Ayayo. *Hermeneutics: Principles and Processes of Biblical Interpretation*. Ada: Baker Books, 2007.

Zuck, Roy B. *Basic Bible Interpretation*. Colorado Springs: David C. Cook, 1991.

2-р хичээл

Эдгээр эх сурвалжуудыг цахим хэлбэрээр үнэ төлбөргүй ашиглах боломжтой.

Аудио Библи. www.faithcomesbyhearing.com

Библийн толь бичгүүд. www.biblestudytools.com/dictionaries/

Библи унших хуваарь. www.bible.com

Библийн орчуулгууд. www.biblegateway.com

Онлайн Библийн атлас. www.bibleatlas.org

4-р хичээл

Эдгээр онлайн хичээлүүд нь танд Библийн хөрвүүлгийн талаар илүү гүнзгий ойлгоход тусална.

Dr. Walter Martin. "Biblical Hermeneutics One by Dr. Walter Martin." Available at www.youtube.com/watch?v=mJQGVzILN-Y

Seven Minute Seminary. "Why Bible Background Matters." Available at www.youtube.com/watch?v=-wiIK8A2EFk

Seven Minute Seminary. "The Role of Archaeology in Biblical Studies." Available at www.youtube.com/watch?v=Dm3HILoNOak

Даалгаврын тэмдэглэл

Суралцагчийн нэр _____

Дараах хүснэгтэд даалгавар бүрийг бүрэн хийж дуусгасан өдрөө тэмдэглээрэй. Сорилд 70% эсвэл түүнээс дээш оноо авсан суралцагчийн даалгаврыг бүрэн гүйцэтгэсэнд тооцно. Shepherds Global Classroom байгууллагаас гэрчилгээ авахын тулд бүх даалгаврыг амжилттай гүйцэтгэсэн байх ёстой.

Хичээл	Даалгаврууд	
1		
2		
3		
5		
6		
7		
9		
10		

Shepherds Global Classroom байгууллагаас төгсөлтийн гэрчилгээ авах өргөдлийг манай www.shepherdsglobal.org вебсайтаар орж бөглөх боломжтой. Суралцагчдынхаа өмнөөс өргөдөл илгээсэн багш, сургагч багш нарт SGC-ийн ерөнхийлөгч төгсөлтийн гэрчилгээг цахим хэлбэрээр илгээх болно.